

С.ДАШДООРОВ СУДЛАЛ ТӨВ

**С.ДАШДООРОВЫН
УРАН БҮТЭЭЛ
СУДЛАЛ**

АНХДУГААР БОТЬ

**УЛААНБААТАР ХОТ
2016 ОН**

DDC
900
Л-462

С.ДАШДООРОВЫН УРАН БҮТЭЭЛ СУДЛАЛ

ISBN 978-99962-2-454-6

Редактор: Д.Маралгоо
Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г.Хулан
Хавтасны дизайн: Р.Батболд
Цаасны хэмжээ: 70x100x16
Хэвлэлийн хуудас: 14.5
Хэвлэсэн тоо: 500 ш



“Соёмбо принтинг” ХХК-д
хэвлэв.

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хувилан олшруулахыг хориглоно.

ГАРЧИГ

1. ХХ ЗУУНЫ МОНГОЛ ТУУЛЬСЫН ГАРАМГАЙ ТӨЛӨӨЛӨГЧ.....	5
2. ӨМНӨХ ҮГ.....	9
3. Д.Батбаяр. ДАШДООРОВЫН ГУРВАН НЭЭЛТ.....	11
4. Х.Чойдогжамц. ЗОХИОЛЧ С.ДАШДООРОВЫН БҮТЭЭЛ-ҮҮДЭД ШИНЭЭР ХАНДАХУЙ.....	14
5. Жа.БАЯРАА. МАНДАХ НАРНЫ НААГУУРХ МАНАН ХЭЗЭЭ АРИЛАХ ВЭ.....	24
6. П.Батхуяг. НАЙМАН ТҮМ ДӨРВӨН МЯНГАН ШАЛТГААН БУЮУ БУУЖ МОРДОХ ХОРВОО.....	34
7. Т.Доржсүрэн. СОРМУУНИРШИЙН ДАШДООРОВЫН “ХҮЛЭГ” НАЙРАГЛАЛЫН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ МИНЬ.....	44
8. О.Сундуй. “СЭРГЭЛЭН БАГАЧУУД” СЭТГЭЛД ХОНОГШИХЫН УЧИР.....	57
9. С.Ариуннандин. “ТОВИЙН ӨНДӨР” УУЛТАЙ ТАНИЛЦСАН МИНЬ.....	66
10. Ц.Буянхишиг. С.ДАШДООРОВЫН “НУУР НУУРЫН ШУВУУД” НОМ ДАХЬ АВИА, ДҮРС ДУУРАЙХ ҮГСИЙН ТУХАЙ.....	70
11. Э.Дашзэвэг..... С.ДАШДООРОВ АБУГАЙ... ТИЙМ ӨНДӨР ХҮН ҮҮ... ТИЙМ НАМХАН ХҮН ҮҮ.....	80
12. Н.Заяа. БУУЖ МОРДОХ ХОРВОО.....	86
13. Б.Монголхүү. АЛИМНААС НЬ АМСАЖ, ДААГАНД НЬ СУНДАЛДАХУЙ..	94
14. Г. Наранцэцэг /ХУД-ийн ГХГС-тай 18-р сургуулийн багш/..... "ДУРСАМЖИЙГ ДУРААРАА НЭЭХҮЙ".....	98
15. Ц.Ням-Осор. ШУУРГАНААР ТӨРӨГСӨД.....	100
16. СУИС-ТУС-ийн Өлзийгийн Оюунгэрэл. ДУТУУ АЛХАМЫГ ТАНЬ ДҮҮРГЭХ ГЭЖ ҮЛГЭР ҮҮССЭН БОЛОВ УУ?.....	104
17. Б.Хишигсүх. ЗОХИОЛЧ С.ДАШДООРОВЫН ДЭЛГЭЦИЙН УРЛАГТ ЭЗЛЭХ БАЙР СУУРИЙН АСУУДАЛД.....	110

18. Д.Хүдэрмөнх. ДООРОВ НАЙРАГЧ ДОРНОДЫН УТГАЗОХИОЛЫН “ШКОЛЬ”-Д “ХҮЛЭГ” НАЙРАГЛАЛАА “МАСТЕРСКАЯ”ХИЙСНЭЭРЭЭ ХИЧЭЭЛ ЗААВ 121
19. Б.Хүрэлбаатар. “АРДЫН АВЬЯАСЛАГ ЗОХИОЛЧИЙН АМЬДРАЛ, УРАН БҮТЭЭЛЭЭС ТӨРСӨН БОДРОЛ, ТЭМДЭГЛЭЛ”..... 125
20. Б.Тогооч. С.ДАШДООРОВЫН “БУУЖ МОРДОХ ХОРВОО” ЗОХИОЛЫН ДҮР, АГУУЛГА, УТГА САНАА, УРАН САЙХАН, МОНГОЛЫН УТГА ЗОХИОЛЫН ХӨГЖИЛД ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР, НЭРТ ЗОХИОЛЧ Т.ЮМСҮРЭНГИЙН “НУТГИЙН ЦЭНХЭР ЗЭРЭГЛЭЭ”БҮТЭЭЛЭЭС ЯЛГАРАХ ОНЦЛОГ 131
21. Д.Төрбат. “ГОВИЙН ӨНДӨР”-ИЙН ГОЛ ХҮМҮҮС..... 144
22. Л. Туяа. САЙХАН ХҮҮХНҮҮДИЙН ДУНД, САЛХИ ШИГ ХУЙЛАРЧ ЯВСАН, СОРМУУНИРШИЙН ДАШДООРОВ 170

XX ЗУУНЫ МОНГОЛ ТУУЛЬСЫН ГАРАМГАЙ ТӨЛӨӨЛӨГЧ

Сормууниршийн Дашдооров уран үгийн их дархан, XX зууны дунд үеийн монгол уран зохиолын их өрнөлтийн үеийн гарамгай төлөөлөгчдийн нэг төдийгүй орчин үеийн монгол туульс, яруу найраг, жүжиг киноны бүх салбарт өөрийн дэг, арга барил, **ур чадвараараа** танигдаж шалгарсан нэр хүндтэний нэг юм.

Үүнийг эл номд орсон судлал шүүмжлэлийн уралдаанд ирүүлсэн олон тооны бүтээлүүд нотолж байна. Хэдийвээр ертөнцийн жамаар жанч халсаар олон оныг үдсэн ч түүний нэр алдар, үйл бүтээл, туурвил зохиол нь монгол уншигчид төдийгүй гадаад ертөнцөд ч ихээхэн нэр хүнд олсонд оршино. Зохиолчийг залгамжлан үлдсэн үрс хойчис нь тал нутгийн их зохиолчийн бүтээл туурвилыг баринтаглан барихдаа уншигч олны сэтгэл оюунд өнө баг хоногшсон олон сайхан бүтээл хийгээд түүнд шингэсэн уран сайхны онцгой мэдрэмж, **шийдэл** бүхий ур зүй, түүнийгээ илтгэсэн байгалиас эхтэй төгс төгөлдөр уран чадвар, найруулгын маягуудын эв донжийг гайхалтай зохируулж урласан, уран сайхны ертөнц нь жинхэнэ монгол хүн, **монгол амьдрал, монгол бүхнийг хураан цогцлоосон** /өөрийн цаг үеийн/ төгс төгөлдөр амьд баатрууд, түүнийг илэрхийлсэн эрхэмсэг дээд хэл найруулга сэлт бэлхнээ гэрчлэх билээ.

Миний бие 1978 онд МУИС-д элссэн цагаас МЗЭ-ийн Хороогоор гүйдэлтэй болж, нэрт шүүмжлэгч Ц.Мөнхийн өрөөгөөр эргэлдэх болсон ахуйдаа эл зохиолчтой ойр дотно танилцаж, хээ шаагүй яриа хөөрөөг сонсож асан нь надад уран бүтээлийн агуу их нууцлаг мөртөө ил ертөнцийг ойлгож танихад минь үгүйлшгүй их үлгэр дууриал болж, “Утга зохиол урлаг” сонин, “Цог” сэтгүүлд сарвай муу “шүүмж”-үүдээ нийтлүүлж олноо хүргэхэд цаг үргэлж ээлийн гараа сунгаж асан ахын ачийг ямагт санаж явдаг нэгэн.

XX зууны дунд мөчлөгт хамаарах эл Их туурвигчийн цаг үед манай үндэстний уран зохиол нэгэн их шинэ давалгаа үүсч, түүний зарим чиг хандлагууд нь улам тодорхой болж, эдүгээ ч улам үргэлжилж байна. Эл шинэчлэлийн үзэл санааны гэгээ зугуухан хүрээгээ тэлж асан цаг үед нэр нөлөөтэй асан уран бүтээлчдийн нэг бол С.Дашдооров мөн. XX зууны дэлхий нийтийн оюун санааны өөрчлөлт, шинэ үзэл санааны хандлага манай улс үндэстний сэтгэлгээнд хэрхэн тусаж байсан нь тухайн үеийн уран зохиолын туурвил зүйн эрлүүдээс тод харагддаг. Тэрхүү давалгаан дунд зохиолч С.Дашдооров өөрийн үзэл-философитой байж бүтээлдээ монгол хүмүүсийн

үндэсний онцлог бүхий ахуй амьдрал хийгээд сэтгэл, сэтгэлгээ, түүний орчил хүрээнээ бий болсон өөрчлөлтүүд, ХХ зууны эхэн үеийн оргилсон халуун хувьсгалт үзэл санаа хийгээд буй болсон шинэ нөхцөл байдалтай нүүр тулаад, эргэлзэнгүй зогсож асан тухайн цаг үеийн монгол хүний зан төрх, сэтгэл зүйн хам шинжийг уран сайхны аргаар илүү дутуугүй нарийн сайн нээн илэрхийлж чадсан юм. Уран зохиол нэг үзэл суртлын нөлөөнд баригдмал асан тэртээ он жилүүд хэдийгээр социалист үзэл суртлын нөлөөнд баригдмал, нэг хэв загвар, сэтгэлгээнд баригдмал асан ч үндэстний уламжлал, сэтгэлгээний уугал онцлогоо үгийн урлагтаа хамгийн нарийн нээж, мөнхлөн авч үлдсэн нь манай нийт зохиолчдын зүй ёсны гавьяа. Тэдний дотор зохиолч С.Дашдооров нөлөө бүхий том уран бүтээлчийн нэг байв. Түүний зохиолууд, түүнд амилсан уран дүрүүд нь бидний танил, эрхэм дотны хүмүүс шиг монгол хүнд нэн зохицолтой, ойр ойлгомжтой байсан нь зохиолчийн туурвил зүйн үндсэн гол онцлог, язгуур мөн чанар нь билээ.

Ардын уран зохиолч, төрийн шагналт С.Дашдооров агсны 80 насны ой тохиож буй энэ он манай олон туршлагатай судлаачид, залуу эрдэмтэд, шүүмжлэгчид түүний уран бүтээл рүү хандаж өөрсдийн үнэлэлт дүгнэлтийг өгч байгаа нь зүй ёсны үйл бөгөөд уран зохиол судлал, зохиолчийн намтар, уран бүтээл судлал, цаашлаад С.Дашдооров судлалыг эрчимжүүлэх, шинээр нээх, тайлахад шинэ алхам болж байна. Тухайлбал зохиолч Д.Батбаяр, Д.Цэдэв нарын манай ахмад зохиолч- уран бүтээлчид, залуу судлаач шүүмжлэгч П.Батхуяг, Х.Чойдогжамц нар зарим зохиол бүтээлийнх нь талаар хүүхдийн зохиолч О.Сундуй, залуу зохиолч Э.Амарзаяа нар хүүхдэд зориулсан зохиол бүтээлийнх нь тухайд мөн өөр бусад олон судлаачийн дурсамж дурдатгал, тайз дэлгэцийн уран бүтээлүүдийнх нь талаарх санал дүгнэлтүүд эл номд багтан орсон нь судлаачийн байр суурь ур чадварын түвшинг илтгээд зогсохгүй, судлагдахуун болсон зохиолч С.Дашдооров гуайн уран бүтээлийн онцлогууд хийгээд өөрийнх нь олон талт үйл ажиллагаа, уран бүтээл дэх олон өнгө төрх, ялгарлууд, өөрийгөө цаг үетэйгээ хөл нийлүүлэх гэсэн эрмэлзлэг, уран бүтээл бүрдээ шинэчлэл, шинэтгэл чанаруудыг тод илтгэдэг онцгой чанар, чадварыг онцлон тэмдэглэх учиртай.

Тодруулбал зохиолч С.Дашдооровын богино хэлбэрийн зохиолууд дотор томоохон байртай “Бууж мордох хорвоо” өгүүллэгийнх нь талаар шүүмжлэгч судлаач П.Батхуяг, Х.Чойдогжамц нар, том хэмжээний бүтээлүүдээс нь “Товийн өндөр” роман, “Нар хиртсэн жил” кино зохиолуудынх нь талаар Төрийн шагналт зохиолч Д.Төрбат, доктор

Б.Хишигсүх нар өөрсдийн санал бодлоо бичсэн нь өвөрмөц төдийгүй шинэ сэдвүүдийг хөнджээ. **Ахмад яруу найрагч Б.Монголхүү “Алимнаас нь амсаж, дааганд нь сундалдахуй”**, хүүхдийн зохиолч О.Сундуй “Сэргэлэн багачууд сэтгэлд хоногшихын учир” зэрэг өгүүллүүдэд зохиолчийн хүүхдэд зориулсан бүтээлүүдийнх нь тухайд шинэ санаа, санал дүгнэлтүүд гаргаж, зохиол бүтээлийнх нь уран сайхны ертөнцийг бүхэлд нь хамааруулж эрэлхийлсэн хүүхдийн уран зохиолын судлал шүүмжлэлийн ажил зогсонги шахуу асан орхигдсон орон зайг нөхөж, улмаар судлаачид тэр бүр хөндөөгүй асуудлыг, **зохиолч С.Дашдооровын уран бүтээл** дэх өөр нэг нууцлаг, мартагдсан байдлыг тодруулах чигт эрэлхийлсэн нь сайшаалтай юм.

Уралдаанд ирүүлсэн нийт бүтээлийг ийн хураан эмхэтгэж олны хүртээл болгож буй нь зөвхөн С.Дашдооров судлал төдийгүй манай орчин үеийн уран зохиол судлал, зохиолчийн лаборатори, өвийн судлалд ч чухаг ач холбогдолтой чухаг ажил болох нь эргэлзээгүй. Өнгөрөгч зуунд амьдарч, бүтээн туурвиж байсан уран бүтээлчдээ нэг үзэл суртлын хүлээснээс ангид зөвхөн урлаг, уран бүтээл болох талаас нь судлан уншигч олноо утга агуулгыг нь шинээр нээн тайлбарлах, тайлан судлах хэрэгцээ шинэ зууны эхэнд жам ёсоороо бий болсон. Энэ шаардлагад зохиолч С.Дашдооров агсны ойн үйл ажиллагаа бүрнээ нийцэж байгаа бөгөөд түүний уран бүтээлийн тухайд үе үеийн судлаач- эрдэмтэд өөр өөрийн үзэл, онолын үүднээс үнэлж цэгнэн, санал дүгнэлтийг гаргаж буй нь бүр ч их үнэ цэнтэй юм.

Тиймээс залуу судлаачид, утга зохиол судлалын эрдэмтэд зөвхөн насны ой, уралдаан хэмээн ойлголгүй, ХХ зууны монгол уран зохиолын том төлөөлөгч зохиолч С.Дашдооровын уран бүтээлийг цаашид үргэлжлүүлж судлах эх үндсийг тавьж буй, ялангуяа уран бүтээлийг нь орчин үеийн шинэлэг үзэл, онол- арга зүйг ашиглан зохиолч С.Дашдооровын уран сайхны ертөнцийг нарийн нямбай, гүнзгийрүүлэн задлан шинжлэх, **зохиолчийн** уран дүр бүтээх арга барил, маяг, зохиолчдын уран бүтээлийн өв, сан хөмрөг, урлан, **туурвил зүйгээр** хязгаарлахгүй арга барил, ур зүйн онцлог, хувь зохиолчийн дотоод сэтгэлийн урамс, сэтгэлгээний галбир хийгээд өнгө аясын өвөрмөц нууцсыг хам цогцоор тайлан нээж, эл уран бүтээлчийн ур зүйн үндсэн хэв маяг, онцлогууд, бүтээл туурвилын өвийг уншигч олноо таниулан сурталчлах ажлыг гал таслалгүй чинагш үргэлжлүүлэн хийнэ гэдэгт итгэлтэй байна. Судлаач шүүмжлэгчдийн ур чадвар, бичлэг сэтгэлгээ, мэдлэгийн цар хүрээг сорьсон энэ нэгэн удаагийн уралдаанаар хязгаарлалгүй “Төрийн шагналт, Ардын уран зохиолч Сормууниршийн Дашдооров” судлалын шав суурийг энэхүү шүүмжлэл- судлалын уралдаанаар тавьж байна хэмээн хэлж болно.

Анд нөхөд, ахан дүүс, зохиолч нөхдийнх нь бичсэн эл дурсамж, уран сайхны шүүмжлэл, дурсамж дуртгалын эмхэтгэл бүтээл ХХ зууны Монгол уран зохиолын гарамгай төлөөлөгчдийн нэг, билэгт зохиолч Сормууниршийн Дашдооровын гэгээн дурсгалд зориулагдмуй.

МУИС-ийн Профессор Д.Галбаатар

ӨМНӨХ ҮГ

Бидний хайртай аав, Ардын уран зохиолч, төрийн шагналт Сормууниршийн Дашдооровын 80 жилийн ой 2015 онд тохиосон билээ. Бидний аав албан ёсоор 1935 онд төрсөн гэх бүртгэлтэй ч өөрөө бол ам цагаан хулгана жилийн хаврын эхэн сар буюу 1936 онд төрсөн гэж хуучилдаг байв. Яагаад 1935 он болгосноо сургуульд орох гэж насаа нэмсэн юмаа гэж бидэнд ярьж байсан юм. Өөрөө хулгана жилтэй гэж ярих дуртай, хувьдаа өөрийгөө 1936 оных гэж явдаг байлаа. Бид ч аавынхаа энэ сэтгэлийг санан, 80 насны ойг 2015 оноос эхэлж 2016 он дамнуулан, ойн арга хэмжээг тэмдэглэж байна. 2012 онд үр хүүхдүүд бид аавынхаа роман, өгүүллэг тууж, шүлэг найраглалын гурван ботийг эмхэтгэн гаргаж уншигчдын хүртээл болголоо. Мөн 2015 онд аавынхаа ойн арга хэмжээний эхлэл болгож төрсөн нутаг Дэлгэрхангай сумын С.Дашдооровын нэрэмжит ерөнхий боловсролын дунд сургуулийн номын санд гадаад хэлний ном сурах бичиг хандивлаж, Шинэ Монгол сургуультай хамтран ажиллах эхлэлийг тавьж, тус сургуулийн үйл ажиллагааг дэмжин туслах ажлаа эхлүүлсэн юм.

2015 оны 11 дүгээр сард үр хүүхдүүд бид С.Дашдооров судлал төвийг байгуулж, Монголын зохиолчдын эвлэл, Дундговь аймгийн нутгийн зөвлөл, Дэлгэрхангай сумын нутгийн зөвлөлтэй хамтран 80 жилийн ойн арга хэмжээний талаар олон ажил төлөвлөн хийж буйн нэг нь энэхүү С.Дашдооровын уран бүтээлийн шүүмжийн анхдугаар уралдаан юм. С.Дашдооров зохиолч монголын болон дэлхийн уран зохиолын сан хөмрөгт ямар хувь нэмэр оруулсан, монгол уран зохиолын хөгжилд ямар шинэчлэл авчирсан, монгол хэл хийгээд уран зохиол бүтээх бичлэг сэтгэлгээний онцлог, үгсийн сан, монгол ахуй, монгол хүн, тэр дундаа нүүдэлч малчин ахуйн талаар дэлхийн уран зохиолд оруулсан хувь нэмэр, ямар бүтээл туурвисан зэргийг судалж танихад энэхүү уралдааны зорилго оршиж байв.

Монгол уран зохиолын бүхий л төрөл жанраар бичиж, тэр бүрдээ олны таашаал хүртэж чаддаг цөөн зохиолчийн нэг нь С.Дашдооров. Шүлэг, найраглал, тууж, роман, өгүүллэг, жүжиг, кино, дуурь, хүүхдийн зохиол зэрэг бүх төрөлд түүртэлгүй авьяас билгээ шавхан дайчилсаныг үнэлж МУ-н Төрийн шагнал, Ардын уран зохиолч цол олгосон юм. Үнэхээр л зохиол бичих гэж хорвоод буугаад мордсон хүн гэж бид дотроо бодож явдаг юм. Энэ бүх учир шалтгаанаас улбаалан С.Дашдооровын уран бүтээлийн шүүмжийн уралдаанд ирүүлсэн бүтээлээс роман, кино, өгүүллэг, тууж зэрэг олон жанрыг шинжилэн судалсан байдлыг та үзэх болов уу.

Ялангуяа улам бүр бүдгэрсээр буй нүүдэлчдийн ахуй, соёлын талаар дэлхийн соёл, уран зохиолд үлдэх, судлагдахуун болохуйц бүтээл туурвил С.Дашдооровт олон юм. Түүнийг бид судлан гаргаж, шинэ үеийнхэнд танилцуулах, гадаад хэлээр хэвлүүлэх зэрэг ажлын эхлэл нь энэ уралдаан байв. Уралдаанд ирсэн бүтээлийг бид Монгол улсын гавьяат багш МУИС-ийн профессор, хэл бичгийн шинжлэх ухааны доктор профессор Д.Галбаатар, доктор дэд профессор Д.Сумъяа, С.Дашдооров судлал төвийн төлөөлөл Д.Маралгоо нарын шүүгчийн бүрэлдэхүүнтэй шүүн дүгнэлээ.

Бид уралдаанд ирсэн бүтээл бүрийг шинэлэг өнгө аяс, өвөрмөц өнцөг, хандлага, өнөөгийн хөгжил дэвшлийн өндөрлөгөөс харсан байдал, зохиолчийн бүтээлийн онцлог, шинж чанар, задлан шинжилсэн байдал, судалгаа шүүмжлэлийн арга зүйг хэрэглэсэн, задлан шинжилгээ, дүгнэсэн арга, уг сурвалж, найруулга, бүтээлч эрэл зэргийг үндэслэн дүнгээ гаргав.

С.Дашдооров судлал төвөөс бид цаашдаа шүүмжийн бүтээлийг дэмжиж, цаашид үргэлжлүүлэн зохион байгуулж байх болно.

Бидний ажлыг дэмжиж гүн туслалцаа харамгүй үзүүлсэн Соёл урлагийн их сургууль, Монголын зохиолчдын эвлэл, Дэлгэрхангай сумын С.Дашдооровын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн хамт олон, Шинэ Монгол сургууль, МУИС-ийн багш Д.Галбаатар, Д.Сумъяа болон зохиолч Д.Батбаяр нарт талархал илэрхийлье.

Эцэст нь С.Дашдооровын талаар зохиолч Д.Батбаярын бичсэн “С.Дашдооровын гурван нээлт” буюу “Бууж мордох хорвоо” ботийн өмнөх үгийг энд дахин таны мэлмийд толилуульж байна.

Уншигч авгай таны билэг авьяас, оюуны мэлмий үргэлж хурц байхыг хүсэн ерөөе.

*С.Дашдооровын үр хүүхдүүд
С.Дашдооров судлал төв*

ДАШДООРОВЫН ГУРВАН НЭЭЛТ¹

Төрийн шагналт зохиолч Дармаа Батбаяр

Шинжлэх ухаанд байдаг нээлт гэдэг ухагдахуун урлаг, уран зохиолд ч байдаг. Ялгаа гэвэл шинжлэх ухааны нээлтийг нээсэн даруйд шинэ нээлт гэж дэлхий нийтээр хүлээн зөвшөөрдөг бол урлаг уран зохиолд хийгдсэн шинэ нээлтийг нэгэн үед бүү хэл хэдэн үе өнгөртөл хүлээн зөвшөөрөхгүй байх нь олонтаа. Ялангуяа монгол шиг монгол хүний 290 гаруй жилийн турш дорд үзсээр ирсэн улс оронд ухаантан билэгтэнийхээ бүтээл туурвилыг шинэ сэргэг, содон гайхамшиг бүтээл туурвил хэмээн үзэх харах явдал нүдний гэм байсан цаг хараахан улираагүй байна.

Тийм учраас оюун санааны хүрээнд гарсан шинэ нээлт, гарч байгаад сэргэг соргог бүхнийг “нүдэн балай, чихэн дүлий” өнгөрүүлдэг нь бидний гэм биш зан. Энэ зан биднийг бусдын суртал, бусдын үнэлэмж цэнэлэмжээр өнөө хүртэл явуулж байгаагаас болоод хэн нэгнийг нээлт хийж үү үгүй юү гэж харж үзэхийн оронд “Хоцрогдсон буурай бүдүүлэх монгол орны хүн” нээлт хийх гэж байхгүй гэсэн үзэл баримтлал нь харах нүд, сонсох чихийг бөглөсөөр ирсэн нэн харамсалтай.

Гэтэл язгуураасаа хүчирхэг явсан тоотой хэдхэн үндэстэнд байдаг бүтээлч ген монгол хүнд байсаар байсан хийгээд одоо ч байж байна. Ийм бүтээлч ген байгаа учраас сортоотой судлаач эрдэмтэд нүүдэлчдийн соёл хэмээх агуу их ухааны зах сэжүүрээс амсмагцаа “нүд нь бүлтийж чих нь дэлдийж” байгаа билээ. Өрнө дахинд сул хөгжсөн ч гэсэн харьцуулсан уран зохиол судлаачдынх нь хэн нэг нь нүүдэлч малчин монголчуудын уран зохиолыг шимтэн судалдаг юм гэхэд ухааных нь шигшүүрт гарцаагүй тээглэх хүн бол Сормууниршийн Дашдооров.

Гачлантай нь С.Дашдооровын зохиол бүтээлийг ойлгоод түүний нээсэн нээлтийг илрүүлтэл дор хаяад 20-30 жилийн зай бий байх. Магадгүй бэлчээрийн мал аж ахуй эрхэлсэн нүүдэлч малчин хүн “Өдрийн од” болох цагт сая түүний бүтээл туурвил уруу хушуурагсад шөнийн одод шиг олширч мэднэ. Хойч өдөр, хожмын маргааш яадаг байлаа ч өнөөдөр би С.Дашдооровын гурван нээлтийн талаар цухас төдий дурдсу.

Анхны нээлтээ Дашдооров Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын бага сургуульд 1943 онд орсноосоо хойш 3 жилийн дараа буюу 1946 онд “Үг хөгжим” хэмээх хичээл дээрээ Дэлгэрхангай уулаа магтсан шүлэг бичсэн бөгөөд тэр шүлгэндээ “Дэлгэрхангайн уулан дээр гарвал

¹ С.Дашдооров “Бууж мордох хорвоо” (2012 он) ботийн өмнөх үг

Дэлхийн юм бүгдээрээ харагдана” гэж бичсэн юм.

Жинхэнэ насаараа 1936 оны 03 сарын 07-нд төрсөн учраас энэ үед дөнгөж арав хүрч байж. Мэдээж тэр үеийн хөдөөгийн багш нар дотор энэ гайхамшигт мөрийг яруу найргийн нээлт гэж олж харах нь бүү хэл шүлэг гэж хүлээж авсан хүн байгаагүй бололтой юм билээ. Харин ч доог тохуу хийх шалтаг болгон “Яана гэнээ?! “Дэлгэрхангайн уулан дээр гарвал Дэлхийн юм бүгдээрээ харагдана гэнээ. Хи хи, ха ха гэдэг байж. Энэ ч бас хэр юм. Энэ үеийн яруу найргийн үндсэн сэдэв нь “агуу их эх орны дайн”, “ачит орос хүн”, “шалгарсан манлай Маршал Чойбалсан” байсан цаг. Эх нутгийнхаа уул усыг магтах явдал бараг тээртэй байсан үе. С.Дашдооров ч өөрөө тэр үед тоогоогүй нь дурсамжнаас нь ч илт бөгөөд “Шинэ сурагч”, “Сэргэлэн багачууд” хэмээн анхны номууддаа ч оруулаагүй байдаг юм. Хожим хойно 1959 онд Оросын Москва хотноо орших Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургуулийн оюутан болж, дэлхийн сонгодог уран зохилтой танилцсанаасаа хойш

“Дэлгэрхангайн уулан дээрээс

Дэлхийн юм харагдана” хэмээн засч шинээр бичсэн нэгэн шүлгэндээ шигтгээ болгон хатгасан байдаг.

Нялх балчиртаа бичсэн энэ хоёр мөр яруу найргийн мөр мөн болохыг анзаарсан хэрэг.

С.Дашдооровын монголын яруу найрагт хийсэн хоёр дахь нээлт бол

*Монгол- Бичихэд хэдий богинохон ч

Мориор давхиад гүйцэшгүй

Уудам дэлгэр орон оо!

Монгол- Хэлэхэд хэдий амархан ч

Мохож цуцаж үзээгүй

Зон олны минь алдар аа! хэмээн 60-70-аад оны оюутан сурагчдын цээжээр мэддэг энэ шүлгээр эхэлдэг “ Монгол” хэмээх найраглал юм. Өнгөрсөн зууны 30-40-өөд онд цаазлан хориглож, 50-иад онд нугачин дарж байсан монголчуудын улс, үндсээ гэсэн үзлийг сэрээсэн юм. 1959 онд ноороглож дуусгаад 1960 онд анх хэвлэгдэж тархсан энэ найраглал монголчуудын хувьд өөрийгөө хэн болохыг нь нээсэн нээлт байлаа. Үндэсний үзлээр ангаж цангаж байсан оюунтан, сэхээтнүүд бахархан уншдаг, омогшоодог зохиол байсан төдийгүй “Би хаана төрөө вэ”, “Тусгаар тогтнол”, “Есөн эрднийн эх орон” зэрэг иргэний уянгын том том дуулиантай найраглал шүлгүүдийг араасаа төрүүлсэн монгол хэмээх ойлголт, ухагдахууны түүчээ нь байлаа. “Хүлэг”

найраглал бол зөвхөн монголын яруу найрагт хийсэн нээлт биш юм. Энэ найраглал бол 1960-аад оны сүүлч 1970-аад оны эхэнд дэлхийн яруу найрагт гарсан шинэ нээлт байлаа. Үүнийг тухайн цагт нь бүү хэл одоо ч нээлт гэдгийг нь хүлээн зөвшөөрөөгүй буюу зөвшөөрүүлээгүй байгаа билээ. Энэ нь нэгд дэлхийн олон арван сая хүн ярьдаг гол гол хэлээр орчуулаагүйтэй, хоёрт монголыг сонирхож байгаа дэлхийн соёрхол нь оюуны үнэт зүйлст бус байгалийн эрдэс баялаг байгаатай холбоотой. Гэвч энэ бол өнөө маргаашийн дүр төрх болохоос алс хэтийн явдал мөр биш нь тодорхой.

“Дэлгэр хангайн уулан дээрээс

Дэлхийн юмс харагдана” гэдэг энэ гайхамшигт мөрүүд бол “Монголоос дэлхий харагдана гэсэн санаа байсан төдийгүй энэ шүлгээрээ С.Дашдооров өөрийгөө өөртөө нээсэн юм. Түүний өөртөө нээсэн нээлт бол нүүдэлч малчин монголчуудын морин дэл дээр бүтээсэн их өв соёл байлаа. Энэ их өвийг л С.Дашдооров нээхийн төлөө насан туршдаа зүтгэсэн бөгөөд нөр их зүтгэлийнхээ төлөө энэ том том найраглалуудаасаа гадна “Дэнсмаа”, “Тэмээ”, “Хойтон жилийн наадам”, “Байц цохио баясан инээдэг юм”, “Монгол зан” гэх мэтийн жинхэнэ монгол шүлгүүдээ бичсэн юм.

С.Дашдооров амьд сэрүүндээ яруу найргийн 9 ном хэвлүүлсэн. Тэр номууд доторх шүлгүүд бараг бүгдээрээ хөдөө нутаг, мал, малчны тухай байдаг. Тэрбээр 1961 онд хэвлүүлсэн “Талд татсан солонго” номондоо:

“Талын тухай шүлгээс минь

Тааны үнэр ханхлахгүй бол

Бичсэн шүлэг минь шүлэг биш

Би өөрөө шүлэгч биш” гэж “тунхагласан” байдаг юм. Үнэхээр ч түүний шүлгээс адуу янцгааж, таана үнэртдэг юм. Монголын агуу их хээр тал, тэнд бэлчсэн мал сүрэг, малчин хүний дуулж яваа уртын дууг хүн төрөлхтөнд Сормууниршийн Дашдооров хэмээх билэг авьяастан цоо шинээр дахин нээж өгөх цаг айсуй.

2012.03.17

ЗОХИОЛЧ С.ДАШДООРОВЫН БҮТЭЭЛҮҮДЭД ШИНЭЭР ХАНДАХУЙ

Х.Чойдогжамц /СУИС/

*“...Бэлгэдэлт амьдралаар амьдрах гэдэг чинь л өөрөө ер бусын
иргэншүүлэх үйлчлэлтэй байдаг зүйл...”
/К.Г.Юнг “Бэлгэдэлт амьдрал”^{1/}*

1. Бидний цаг хугацаа

“Хэрэв та эл туужийг анхааралтай уншваас өөрийнхөө хэдэн танилыг олж үзэж мэднэ. Өгүүлэх нь...” гэсэн тун “ноцтой” үгээр С.Дашдооровын “Холын цэнхэр уулс” тууж эхэлдэг. Зураач Тавхай төрсөн нутагтаа ажлын шугамаар ирээд нэгэн үдэшлэгт холбоо тасарсан багийн найз Чимгээг олж хараад “бүхий л мах цогцсоороо “Чимгээ” гэж дуу алдаж, зүрхээ дэнслүүлдэг”. Улмаар арваад жилийн өмнөх анхны дурлалын эзнээ санан дурсана. Анхны захиа, анхны учрал гээд сэтгэлийн угдах нандин орон зайдаа эргэн ЗОРЧИНО. Мөн Чимгээг нь холбож өгнө гээд булаачихсан Дорж найзыгаа бодно. Нээрэн ч бага нас, бодох санах юмгүй явсан үед тохиолдсон явдал, хэлсэн үг сэлт хэзээ хойно ч санаанаас гарахгүй санагдан байх мөртөөн өчигдөр оройн уншсан ном, үзсэн киноны нэр, явдлыг мартчихдаг шүү дээ. Дээрх өгүүлбэрт буй “ХЭДЭН ТАНИЛАА ОЛЖ ҮЗЭЖ МЭДНЭ” гэсэн үг онцолж унших нэгэн уншигчид бус нийт уншигчид, нийт хүмүүст хандаж зохиолч өөрийн эрхгүй зохиолынхоо эхэнд шигтгэсэн хандал юм. Тиймээс ч зохиолч туужаа дотор нь “Чимгээ”, “Дорж”, “Уулзалт”, “Уулзалтын дараа”, “Хонгорзул” хэмээн сонирхолтойгоор ангилан тодотгон бичжээ. Бидний амьдралд давтагдан улбирдаг сэдэв, учрал, жам ёсны гэмээр урсгалыг ХЭВ ШИНЖИТ дүрүүдээрээ ДАМНУУЛАН залуу нас, хайр сэтгэлийн тухай үнэн түүхээ өгүүлэхдээ амьдралын үнэнийг нухацтай эргэцүүлсэн бодролоор сүлсэн байдаг. (Дүрүүдийнхээ нэрээр нэрлэж зохиолынхоо хэв шинжийг бүрэлдүүлснийг л харахад “ноцтой”). Бага нас, эх нутаг, өв уламжлал, шашин шүтлэг, анхны дурлал, өсвөр нас гээд ямар ч хүнд ухамсартай болон ухамсаргүй зөн мэдрэмж(инстинкт), гүн дурсамж үлдээдэг архетиплаг өгөгдөлтэй өгүүлэмжүүд(К.Г.Юнг энэ бүгдийг БЭЛГЭДЭЛТ АМЬДРАЛ гэж тодорхойлсон) байх ба аль ч үндэстний уран зохиолд түгээмэл мөн

¹Орч. А.Энхбаатар

чанартай илэрдэг байна. Зохиолын дээрх өгүүлбэрийг залгаад “Би багаасаа холын цэнхэр ууланд гарахсан гэж боддог болжээ. Чингээд хол ойр аян замд гарах, ямар нэг бүтээлээ эхлэхдээ холын цэнхэр уул руу гарлаа гэж бодож заншсан байв...” гэж өгүүлдэг. 1968 онд буюу уран бүтээлийнх нь эхэн үед “БИЧИГДСЭН” энэ тууж С.Дашдооровын хүүрнэл зохиолд үнэхээр том орон зайг эрт эзэлсэн гэж хэлмээр байна. Судлаачид энэ зохиолыг “Амьдрал гэгч хөл тавьж үзээгүй алсын цэнхэр уул шиг үл мэдэгдэм нууцыг хадгалсан ээдрээт орчлон гэдгийг эргэцүүлэн дүйлгэж, УЧИР ЗҮЙН НАРИЙН ХОЛБООНД үзүүлжээ” гэж тодорхойсон нь мөн сонирхолтой юм. Ингээд зохиолын задлан шинжилгээнд буюу хэдэн танилаа олж үзэцгээх үү дээ!

Швейцарын сэтгэл зүйч, гүн сэтгэгч К.Г.Юнг нэгэн үеийн эрдэмтэн З.Фройдын сэтгэц задлагийн (психоанализ) буюу “хувийн ухамсаргүй”-н тухай онолыг “хамтын ухамсаргүй” хэмээх ойлголтоор баяжуулснаараа цааш алхсан байдаг. Хамгийн чухал нь “архетип” гэх ойлголтыг дэвшүүлсэн юм. “Юнгийн томьёолсноор, хамтын ухамсаргүй нь архетипуудаас тогтоно. Хүний төрөлх зөн совин буюу инстинкүүд нь архетипуудтай тун ойрхон, өөрөөр хэлбэл тэдгээр инстинкүүдийн ухамсаргүй дүр нь архетип юм. Инстинктээр хийгдэж байгаа бүхнийхээ хөтөлбөр загварыг хүмүүс дураараа сонгож авдаггүй, энэ нь бидэнд анхнаасаа өгөгдсөн байдаг. Домог зүй, бөө мөргөл, төрөх үхэх тухай ойлголт, эцэг эх болох тэмүүлэл, бэлгийн дур хүсэл энэ бүхэнд архетипууд л илрэн гардаг байна”².

Олон жилийн хойно дахин уулзаад Чимгээг Дорж хэдэн хүүхэдтэй нь хаяад явсан, Дангаа гэх хижээл эртэй суусныг мэддэг. УУЛЗАЛТЫН ДАРАА Чимгээд өөрийг нь зурсан хөрөг зургаа дурсгаж (үнэндээ зураг бүртээ Чимгээг дүрсэлдэг), буудлын үйлчлэгчдээс нөхөр нь “хэцүү” гэж дуулаад тэднийхийг заалган очиход цоожтойн хажуугаар дурсгасан зургаа хогийн саванд хэвтэж байхыг хардаг. Хэдий сэтгэл нь хөндүүрлэсэн ч энэ учрал өөрийн эхнэр Хонгорзулыг илүүтэй хайрлан халамжлах хүслийг төрүүлж байдгаараа ихээхэн сонин шугам илэрч байна. Энэ содон санаа Нобелийн шагналт Японы зохиолч Я.Кавабатагийн “Канар бялуухай” өгүүллэгт (Орч. Б.Баясгалан) мөн хөндөгдсөн байдаг. Эхнэрээ өөд болоход нууц амрагтаа гол баатар дурсгасан бялуухайнуудыг тань эхнэртэйгээ хамт оршуулчих уу? гэсэн захиа бичиж, эхнэр минь байсан учраас би таньтай уулзаж, таныг санадаг байж хэмээн амьдралаа эрсхэн ухаардаг юм. Маргааш нь буцахдаа төрөлх нутгийнхаа аж байдлыг хараад Хонгорзулыгаа энд авчрах юмсан, илүү ихээр хайрлах юм сан гэж чин сэтгэлээсээ уялдаг. Зохиолын төгсгөлд

2Г.Аюурзана “Орчин цагийн аугаа их сэтгэгчид”, УБ., 2010, 142 т.х

“Урагшаа харвал их тэнгэрийн хаяанаа холын цэнхэр уулс сүүмэлзэнэ. Тэр ууланд түргэн хүрч орой дээр нь гарахсан гэж сэтгэл сэвэлзэв. Надад тэр холын цэнхэр уулс Хонгорзулын сэтгэл хоёр хамт байгаа юм шиг санагдана” гэж уншихуй дор “холын цэнхэр уулс, Хонгор амьдрал(зул) хоёр хамт байгаа юм шиг”(Япон ардын зүйр үгэнд “Амьдрал бол салхин дундах зул” гэсэн үг байдаг аж. Зохиолчид маань мөн “Салхин дундах зул” нэртэй жүжиг бийг санахад гэмгүй) гэсэн бодомж төрдөг. Учир нь Тавхайд энэ уулзалтаас өмнө Хонгорзул нь эхнэр биш, “нууц амраг” шиг санагдаж, “сална даа” гэсэн бодолтой явдаг асан. Харин уулзалтын дараа холын цэнхэр ууланд гарах хүсэл нь бага насны нандин дурсамжаар, гунигт төгсгөлөөр сэдэрч, сэтгэлдээ мөнхөлж явсан “үнэн” балран амьдрал гэгчийг мөнөөр нь эргэцүүлсэн нүүдэл Хонгорзул дээрээ бууж байна. Чухамдаа Тавхай санаж явсан холын цэнхэр уулаасаа гунигтай “бууж” буй нь үнэн боловч Хонгорзул үүнийг өргөж өгч байна. Ингэхээр “Тавхайн сэтгэл, Хонгорзул хоёр хамт байгаа юм шиг” санагдахыг, бүр чинадаа “Тавхайн сэтгэл, хонгор амьдрал хоёр хамтдаа” болж буй ухаарлыг илгээхийг зохиолч зорьсон болов уу? гэж таамналаа. Үүнийг зохиолд байгаа Хонгорзултай холбоотой бас нэгэн ноцтой өгүүлбэр болох “Говь өөртэйгөө тэнцэх хүнийг үгүүлүүлж чаддаг ажээ” гэснээс тэмтэрч болох ба “Говь” хэмээх үгнийхээ цаана Тавхай маань өөрөө оршиж байгаа билээ.

Эцэсдээ хамгийн чухал санаа нь “Бага нас минь, багын дэврүүн сэтгэл минь баяртай” хэмээх өгүүлбэртээ хураагджээ. Дэлгэн задалвал бага нас, шилжилтийн үе, “шинэ” амьдрал гэсэн цаг хугацааны дэвсгэртэй “гурвал” сэдвийг үзүүлсэн хэв шинжит нийтлэг дүрүүдийг “холын цэнхэр уул”, “зураг” зэрэг бэлгэдэлд шингээн тусгасан гэмээр. Гэхдээ энд хэв шинжит дүр хэмээх ойлголтыг архетип(уугаль дүр) дүрээс арагш буюу архетип дүрийн загварууд хэв дардас болон улбирсан “нийтлэг” дүрүүд гэж ойлгож байна. Ойлгомжтой тайлбарлахын тулд бусад төсөөтэй өгүүлэмжтэй зохиолуудтай харьцуулан үзье. С.Эрдэнэ “Наран тогоруу”, Х.Кортасер “Тоглоом дууслаа” (орч Д.Оюунчимэг), Д.Энхболд “Буйлс дахин цэцэглэнэ”, Э.Мүнро “Эрвээхэй өдөр” (Б.Баясгалан) зохиолуудын үйл явдал, утга санаа ерөнхийдөө хоорондоо таацдаг ХЭДЭН ТАНИЛУУД байх нь хачин тохиол шүү. Уншигчид сайн мэдэх тул хоёр зохиолын агуулгыг товчхон яриад бусдыг хүснэгтээр үзүүлье. “Наран тогоруу” өгүүллэгийн охин “Амьдрал үлгэр байдаг нас өнгөрчээ” гэж найз хөвгүүнээ төв рүү сургуульд явахад нь харуусан, магад буцаж ирэхгүйг нь зөнгөөрөө мэдрэн байдаг. Нутгийнх нь илч гэрлийг тээн яваа тогоруудтай хамт тэр хоёрын “наран нас” нисэн одох аж. Үнэн хэлдэг хүнд цэвэр

өнгөрсөн цаг дээр бичигдсэн зохиол. Яагаад гэвэл тэр хоёрын уулзалтыг одоо цагт бичсэн ч дотроо өнгөрснийг, өөрчлөгдсөнийг, өөрчлөгдсөөр байгаа цаг хугацааны тухай л бодол хөврөнө. С.Дашдооровын “Холын цэнхэр уулс” туужаас хамгийн анхаарал татдаг нь “Уулзалтын дараа” хэмээх хэсэг. “... Миний гол гонсойн харласныг хэлээд баршгүй. Тэгээд л өнөө л багынхаа зангаар ойрхи хэц хяр руу гарч, чимээгүй дүнсийх хад цохио руу чулуу шидэн зугаацаж сэтгэлээ тайтгаруулмаар санагдав. Гэвч надад тэгж явах зав даан ч алга байлаа...” гэсэн гуниглал “үлгэр үнэхээр дууслаа” хэмээн шивнэх шиг, бага нас, бэлгэдэлт амьдрал руугаа хандсан, зорчсон, бусад зохиолтой “танил” санааны зурвас ажиглагдана. Харин Х.Кортасерийн “Тоглоом дууслаа” өгүүллэгт галт тэрэгний замын хажуугийн дов дээр галт тэрэг өнгөрөх үесд хөшөө, баримал болж тоглон харуулдаг гурван охин гардаг. Удаах тоглоомын үеэр нэг охинд нь галт тэрэгний цонхоор нэгэн залуугаас захиа ирснээр тэдний тоглоом “жирийн” үргэлжлэхээ больдог. Захианы эзэн охин саа өвчтэй тул тэр залуутай уулзаж чадахгүй, харин хариу захиа найз нараараа өгүүлж, түүнийг нь дамжуулсан найзууд буцах замдаа “маргаашнаас тоглоом дууслаа” хэмээн ярилцан тоглохдоо хэрэглэдэг эд зүйлсээ далдлан хурааж буйгаар төгсөнө. Жишээ нь хүүрнэгч охинд нэгэн шөнө аймшигт төмөр зам зүүдлэгддэг. Төмөр замууд хэрсэн талд тал талаас нь ойртон ирэх галт тэрэг, гэрлүүд. Аль зүгээс аль нь ирэх бол гэж тааж ядахын зэрэгцээгээр яаж ч ирсэн өөрийг нь дайрчих бүрэн боломжтой байна. Энэ бол яахын аргагүй нас, сэтгэхүйн онцлог, тэмүүлэл “шүглэсэн” цаг хугацааны тухай совинт зүүд биш гэж үү.

	Бага насыг үзүүлсэн цаг хугацааны хэв шинжит дүрийн илрэл, бэлгэдэл	Шилжилтийн үеийг үзүүлсэн цаг хугацааны хэв шинжит дүрийн илрэл, бэлгэдэл	<i>“Шинэ” амьдралыг үзүүлсэн хэв шинжит дүрийн цаг хугацааны бэлгэдэл, илрэл</i>
С.Эрдэнэ “Наран тогоруу”	Үлгэр	Төв рүү сургуульд явах	Алс нисэх наран тогоруу, дурлал
Х.Кортасер “Тоглоом дууслаа”	Тоглоом	Эрэгтэй хүнээс захиа ирэх	Дайраад өнгөрөх галт тэрэг, дурлал, зүүд
С.Дашдооров “Холын цэнхэр уулс”	Зураг	Дахин учрах, сэтгэлээсээ “арчих”	Холын цэнхэр уулс, дурлал, хожмын уулзалт

Д.Энхболд “Буйлс дахин цэцэглэнэ”	Тоглоом	Төв рүү сургуульд явах	Хөх нүдэт зараа, уяаны тасархай, дахиж ах дүү “хэвээрээ байхгүй” гэсэн зөнт айдас, Буйлс дахин цэцэглэнэ, нөхөрлөл
Э.Мүнро “Эрвээхэй өдөр”	Бэлэг, зүүлт	Эмнэлэгт хэвтэхээр явах	Төрсөн өдөр, отгон цас, томдсон халаад, нөхөрлөл

“Холын цэнхэр уулс”-ын Тавхай, Чимгээ, Дорж, Хонгорзул, “Нарантогоруу”-гийн хүү, охин, “Тоглоом дууслаа”-гийн Летисия, Олондо, Э.Мүнро “Эрвээхэй өдөр”-ийн Майра, Хелэн, “Буйлс дахин цэцэглэнэ”-ийн ах, дүү нар бол “хамтын ухамсаргүйн” биежилтээр бий болсон архетип дүрүүдийн хувиарал мөн юм. Тавхайгийн дүр сайхан хүүхэн, гүнж, лусын дагина, үлгэрийн хатан гэх мэтээр архетиплагдаж ирсэн хүн төрөлхтөний хэв шинжит дүртэй давхцаж байна. Хүслэн болсон мэдрэмжээ “хүртээгүй” мэт санагдан мөрөөдөлт дүрээ байнга зурсаар эцэстээ учиртал найдвар нь нурсан. Тэгээд өөрийн бүтээсэн дундуур атлаа дүүрэн ертөнцийг эргэцүүлж түүнд дотор том хэрнээ бага хэмээн санаж явсан Хонгорзулыгаа гэнэт олж харах, амьдарснаа хайрлах мэдрэмж ч тодорхой нэгэн үет цаг хугацааны архетиплаг шинжтэй мэт. Бид бүхний амьдралд, чухамдаа сэтгэцийн гүн дэх бэлгэдэлт амьдралд маань залуу насанд учирсан Чимгээ, Дорж, Тавхай, Хонгорзул нарын уг дүрүүд “бидний цаг хугацаа” болон нууцхан цохилсоор байдаг. Бүр байсаар, оршихон орчсоор, уулзалдаж, уулзалтын дараа харин...

2. Нүүдэлчид юуг ч тайлбарладаггүй юу?

“...Ирж буцахын хорвоод хүмүүн бид бие биендээ бэлэг бус уу”
/Б.Золбаяр/

Зохиолч Л.Дашнямын “Цөллөг” туужид говьд харангадсан залууг нэгэн бүсгүй гэртээ авчирахад ээж нь юу ч болоогүй мэт, бараг болох л ёстой байсан шиг хүлээн авч асардаг. Тэрээр гэрийнхэн өөртэйн байтугай бие биетэйгээ ч үг солихгүйгээр ойлголцоод, “ярилцаад” байгаад гайхаж цөхнө. Бодлоо уншилцаад буй мэт энэ далдхан харилцаанаас мань эр “Говийнхон ер нь юуг ч тайлбарладаггүй юм болов уу?” гэсэн дүгнэлт хийн сууна. Ганцхан говийнхон ч биш нүүдэлчид ерөөс юуг ч тайлбарладаггүй гэж би хэлмээр байна...

“...Хүн өөрсдөө мэдэхгүйгээс биш, бие биедээ хичнээн их өртэй байх юм бэ дээ. Өвгөний замд хонь мал байлгая гэж бодсон маань онох нь онож...Хэн намайг тийн хичээснийг мэдэв л гэж. Мэдээд ч яах юм билээ. Бас мэдүүлээд ч яах юм билээ...” Монголын утга зохиолын дүнжигэр ноён оргилуудын нэг С.Дашдооровын “Бууж мордох хорвоо” хэмээх гайхамшигт өгүүллэгийн дээрх төгсгөлийг мэдэхгүй уншигч ховорхон биз. Хэн, хэзээ, хаанаас ирээд ямар тус дэм болсны өчүүхэн ч ул мөргүй ОРШИН АМЬДРАХ хүсэл сэтгэлийнцаананүүдэлчдийн сэтгэлийн нүүдэл шингэсэн байдгийг

“...Миний Монгол-
Бичихэд хэдий богинохон ч
Мориор давхиад гүйцэшгүй
Уудам дэлгэр орон оо!..”

хэмээн шүлэглэсэн шигээ хичнээн тавиун дэлгэр үзүүлсэн бэ? Зохиолч Төгөө өвгөн өөд одсон Ангаагийнхаа нэгэн тусыг санахдаа “Хэзээ нэгэн цагт энэ хүнийг нэг баярлуулна гэж бат санажээ” гэж бичсэн байдаг. “Ангаа ч өөрөө хүний тусыг эрж хүүе хаая гэж хошуу цорвойдоггүй эр” явжээ. Энд мөнөөх л тайлбарладаггүй харилцаа явж байгаа биз. “Голоодоо нүхтэй”, “Голоодоо нүхтэй юм бол” гэсэн өвөрмөц хэллэг манай ард түмэнд байдаг. Эсрэгээр “голоодоо нүхгүй”, “гол нь харласан”, “дотор нь харласан” гэж ярилцацгаана. Чухамдаа “гол”, “дотор” гэсэн үгсийн цаана ухамсар сэтгэхүйтэй холбогдсон бодож тунгаах гэсэн ОЮУН УХААНЫ талыг төлөөлүүлсэн бус дотоод СЭТГЭЛ ЗҮРХНИЙ чинад утгыг илэрхийлэхийг зорьсон санагддаг юм. Яагаад гэж үү?

“...Цаад америкууд чинь галзуу амьтад гэж надад пуэло омгийн индианууд хэлдэг юм байна. Би ч мэдээж хэрэг гайхасхийн “Яагаад?” гэж асуулаа. “Яагаад гэвэл цаадуул чинь толгойгоороо боддог юм. Эрүүл бид чинь толгойгоороо бус зүрхээрээ боддог юм шүү дээ гэсэн билээ”/К.Г.Юнг “Бэлгэдэлт амьдрал” УБ., 2011, 5-тал/

Бүдүүлэг ард түмний баларлаг яриа хэдий ч нэгийг өгүүлээд байна шүү! Ухамсар тархинд байдаг. Задлаад үзвэл ухамсар нь хаана? Сэтгэл гэдэг эрхтэн байдаг гэх. Чухам хаана буй? /Чээжинд юм уу? хэхэ/ Ямартай ч би Төгөө өвгөний дээрх бодлыг голоодоо нүхтэй монгол хүний уужим сэтгэлийн гүн тунаа гэж итгэл төгс хэлнэ.

Жишээ нь зохиолч Д.Цэнджавын “Тэнгэрт хальсан тоос” туужид нэг уяанд морио уяж, олон жил уралдсан хоёр андын зөрчлийг дүрсэлсэн нь сонин. Дамдин нь Галшаргын зартай хурдан азаргыг үнэ хөөрөгдөн авч улмаар

өөрийн дэвэргэн зангаас болж багын анд Базарын хүү Чулуунд “Уяа уяандаа наадья” гэж битүү үг хаядаг. Хэдий хоёул хоёр талд эв эвдрэлцсэн байдалтай, эхнэр хүүхдүүд нь энэ харилцааг элдэв зуурын үгээр улам зузаатгах боловч цээжин цаанаа нэг нэгнээ “эрсэн”, “ээрсэн” бодолд хатацгаана. Туужийн эхэнд ганцхан удаа хальтхан уулзаад салсан найз эрчүүдийг зохиолч зохиолынхоо туршид дахин учруулахгүйгээр бодлоор нь сэтгэлийнх нь чинадад буурь сэлгүүлэхийн зэрэгцээгээр эвлэрүүлнэ. Мөн дээрх Дамдины “Уяа, уяандаа наадья” гэх үгийн хариуд Базар нэг уулзаад явахдаа “Холоос харахад нутгийн хэдэн толгод мөн ч намхан байна даа” хэмээн чангахан хэлчихдэг энэ хоёр өгүүлбэрээр жишээлэхэд л энэ туужийн амин судсыг тэмтэрч болмоор. Ингэж тун сонин хэрнээ ургаажин монгол ухааныг ширээсийг урлаж чаддаг нь язгуурын монгол нүүдэлчин ахуйг, тал нутгийн амьсгалыг нэвт мэдэрдэг зохиолчдын ертөнцөөс л гарах мэт ээ. Талтайгаа, морьтойгоо, хүнтэйгээ амьсаж нүүдэг нүүдэлчдийн сэтгэлийн нүүдлийг энэ мэт нандин үзүүлсэн П.Лувсанцэрэн “Ус шиг цэнхэр”, Д.Намдаг “Үрэгдсэнийг хүлээгч”, Б.Явуухулан “Тэхийн зогсоол”, С.Эрдэнэ “Өвгөн шувуу”, С.Дашдооров “Уртын хөндийд”, “Хатан туулын ус”, “Оосор бүчгүй орчлон”, Д.Батбаяр “Цахилж яваа гөрөөс”, С.Пүрэв “Уулын намар”, Ж.Дашзэвгэ “Илүү гэр”, П.Баярсайхан “Хөгшид”, Ц.Түмэнбаяр “Буруу энгэртэй дээл” зэрэг олон сайхан туурвил алийг хэлж барах билээ.

С.Дашдооровын зохиолын нэрнээс авахуулаад үг, өгүүлбэр бүхэнд монгол амьдрал ухаарал шигтгээ мэт гялалздаг. “Хөх өвсний сөл”, “Морин жим”, “Тэнгэрийн дуун”, “Энх улирал ханхлахад” зэрэг гарчгийг нь тайлж ухахаас эхлүүлэн язгуурын танивар дохио агуулсан цараатай бүтээлүүд бий. Жишээ нь: “Хөх мичин жилийн зун” өгүүллэг төгсөл байна. “...Тэд тийн хөх мичин жил наадамлаад, аавынхаа шаардсанаар, тун ч удалгүй өмнө зүг нүүж, Их Галын арван зургаадах буудал дээрээ хүрч, өвлийн хатууг үзэлгүй, өнтэй сайхан өвөлжиж, өнчин ишигний гарзгүй, тахиа жилийн зуны эхээр нутагтаа эгэн ирсэн гэх бөгөөд хожим нь хэдэн суманд алдартай хурдан хээр морьтой болсон гэдэг билээ. Харин, яахаараа зээр өндөр газар салхи татан зогсдог, хийгээд ямархан шинж хээр үрээний төвөргөөнөөс дуулдсаныг лавлаж асууна, асууна гэж санасан авч мартсаар өвгөн эцгээ өөд болгосондоо ах дүү хоёр их л гэмшин харуусч явдаг байсан, ярьж хөөрч гасалдаг байсан гэлцдэг авай”. Нэгэн дэлгэр зун болсон явдлыг хахир өвөл өнгөрсний дараа зун нэхэн санаж толгойгоо шаан суугаа ах дүү хоёр бол нэгэн зуны наранд бодлоо ээн эргэлдэж, эргэх цагийг эврээн эргэцүүлэх хараагүй хойч үедээ зэм өгсөн монгол ухаарал юм. Өвгөн аав “нар усны харшлаас” болж хараагүй

болсон ч хонины номхон морины гэрийн хаяагаар давхих туурайн чимээг сонсоод, бүтэлгүй хоёр хүүгийнхээ зээр хэрхэн агнасныг дуулаад л “юмхнаар юм хийж” суудаг. Хөх мичин жилийн зун гэхээр ирэх цагийг зөгнөөд байгаа юм шиг, энэ цагийг хэлээд ч байгаа юм шиг. Сайхь өгүүллэгтэй шүүмжлэлт санаагаараа төстэй гэмээр “Бууж мордох хорвоо” өгүүллэгийнхээ санааг барин орчин үеийн амьдралд дүрслэн өгүүлсэн холбож судалж ч болмоор “Мартагдсан өр” гэж өгүүллэг бий. Өнгөц уншихад өчүүхэн зүйлийн тухай мэт боловч *“Дэлгэрхангай уулан дээрээс дэлхийн юмсыг цөм харж”* алсрах зүг бодлоо бэлчээн сэтгэлдээ нүүж явдаг хүмүүс амьдран байгаа хаалга, цоожтой дөрвөлжин өрөө шигээ харь хавчигдмал бодолтой болсныг хаалганы хонх тайлж өгөхөөс эхлээд муу, сайн санаалан хөгшин эцгээ ач зээ нартай нь өөр өрөөнд оруулах, мартагдсан өрөө өгөх гэж нэхэл болоод олон жилийн дараа ирсэн хүнийг элдвээр сэжиглэх зэрэг харьцаагаар үзүүлсэн нь тун ч шүүмжлэлтэй бас шинжлэлтэй. С.Дашдооровын үргэлжилсэн үгийн зохиолууд цаана л нэг тавиухан амьсгалтай, жороон жороо гэдэг шиг бодролын бодрол болсон хүүрнэл шинжтэй бөгөөд төгсгөлдөө санаагаа их зангиддаг. Дээрх өгүүллэгийн төгсгөлд *“...Санамсаргүй хэрнээ сонихон агаар салхи дагуулан ирсэн гэнэтийн зочны ард гэрийн эзэд* алмайрал, олзуурхлын дунд бие биесээ харан үлдсэнээ тус тусын улавчны улаар өсгийгөө алгадан эргэв. Тэднийг тосон гурван тавьтын ногоон дэвсгэртийн булан дэрвийлгэн барьж яах учраа олж ядсан өвгөн, нүд нь бүлтэгнэсэн хэдэн хүүхэд зогсож байлаа.” хэмээн уншиж дуусгаад “тус тусын улавчныхаа улаар өсгийгөө алгадан эргэв” гэж дахин уншихуй сэтгэлийн өр хэмээх үнэт зүйлийг нэхээд тархин дундуур нэгэн зүйлээр(арай ч улавчаар биш л байх) татаад авах шиг зогтусдаг шүү.

“Бууж мордох хорвоо” өгүүллэгийн *“...Бодон бодоход, тэр Ангаа өвгөнд төлөх ёстой өрөө төлөөгүй хүний мөсгүй зан гаргасан мэт заавал түүнийг цайруулахгүй бол сэтгэл ер амрахгүй мэт санагдах ажээ. Тэр, аль цагийн санаж бодож явснаа хүн олонд хэлж ярьсан ч биш гэж нэг бодсон авч, энэ бодол сэтгэлийг нь зогсоон аварч чадахгүйг бас ухаарчээ...”* гэж уншихуй буугаад л мордох ховоод бид хичнээн зүйлийг биендээ тайлбарлах өртэй явцгаадгийг ухааруулна. Мөн *“...Ер нь хөөрөг зөрүүлэн ёсорхон тав арван малаа бөөцийлж өсгөн, хол ойрын хүнд нутаг ус, айл саахалтынхаа нэр төрийг өргөн явах, хүний арчаа овсгоог хэнээс сурч мэдсэн юм бэ, хэн хэлж өгч байсан юм бэ гэж бодоход уйдаж цөхөөгүй нутгийн настан буурал, түшиж тулж явсан мэт санаанд нь цалхийн буухуй зүрх сэтгэл уяран байв...*

Төрийн нуруу төвшин хүн явж дээ...” хэмээх ухаарлыг би Д.Төрбатын зохиол, Ж.Бунтарын найруулсан “Ирж яваа цаг” кинотой хамтатган тайлбарламаар байна. Багаа өвгөн нутгийн цайлган цагаан сэтгэлтэй Шаагиад хийсгэлэн загначих гээд байгааг нь “Одоо нутгийн нурууг та нар л түших цаг ирлээ шүү дээ” гэсэн цомхон үгээр хэлдэг. Хэдэн хонио хэнд нь өгч хариулуулахдаа зовнисон биш ганц охиныхоо хувь заяаг хэнд очихыг зовнисондоо давхар давхар бодолд хатдаг. (Үнэндээ Багаадаа зэмлүүлсэн ч киноны хамгийн гол зангилааг Шаагиа тайлж өгдөг. Өвгөнтэй дээрх асуудлаар юу ч ярилцаагүй мөртлөө шүү). Киноны төгсгөлийн хэсэг үнэхээр сэтгэл хөдлөм. Охин нь аавыгаа асрах минь гэж хонио өгөхөөр туухад “Охин хүн чинь өөрөө очдоггүй юм шүү дээ” гэж эцсийн тамираа шавхан гэрийнхээ дэлгээтэй үүдийг түшин тэсгэлгүй дуу алдан ганц удаа бодол сэтгэлээ дэлгэн хэлэх мөч монгол хүний, нүүдэлчин хүний сэтгэлийн нүүдэл, хэтийн бодол ухаарлыг үүдийг илүү дутуу зүйлгүйгээр бас тайлбаргүйгээр дэлгэн харуулсан сайхан бүтээл болсон. Д.Батбаярын “Цахилж яваа гөрөөс” туужид мөн Дамба, Дэжид, Тогоохүү нарын гурван дүрийн гурван өөр бодол санааг гурвуулаа нэгэн зэрэг үнэн, зөв, “сайн талынх” байж болохыг анхлан нээж урласан гэж боддог. Хэнийг ч буруутгахгүй аргагүйгээр, буруутгаж тайлбарлалгүйгээр зөвтгөлтэй үзүүлсэн шүү.

С.Дашдооровын бүтээлд нэг л тавиухан, тавилхан мэдрэмж давтагдаад байдгийг өмнө дурьдсан бөгөөд энэ санаагаа УРТЫН, УРД ХӨНДИЙ гэсэн үгээр давтамжлан зохиолынхоо хамгийн эгзэгтэй хэсэгт баатрынхаа сэтгэлийн орчил ертөнц болгон улмаар өөрийн гэсэн урлал болгон ашигласан байдгийг ажиглаж болно. Өөрийх нь төрсөн нутагт ч Ар, Өвөр, Урт нэртэй уужим сайхан газар байдаг билээ. Жишээ нь “...Анчид, Уртын хөндийд ирээд нэлээд удлаа...” гэж өрнөдөг “Уртын хөндийд” өгүүллэг “...Нацаг хөсгийн цуваа хөтлөн явна. Өнөө эмнэгшин явсан гунж нь үзтэл унааширсан янзтай, тавхай ч үгүй, өвсөн толгой бут дэрс шүүрэн нарийн шилбээ чөрөлзүүлэн алхах аж...” хэмээн төгсөх нь нэг л тэнүүн, өсгөлүүн, сайхан. “...Зуны турш хөндий, хөндийд цэнхэртэн байсан майхны эзэн дөрөө мултлан бүсгүйн дэргэд байв...” /”Улайран байгаа тэнгэрийн хаяа”/, “...Шагдар тэндээс мордон урд хөндий чиглэн бөг бөг шогшиж явахдаа малд нүдтэй, холч бодолтой энэхүү эгэл хүнийг сэтгэлдээ бишрэн, өөрийгөө их л голж явлаа” /”Далч Самбуу”/, “...Цэргийн гурван жил гэж бодоход зөндөө олон хоног өдөр, давшгүй даваа, туулашгүй хөндий мэт бодогдон, Халиунд хоргодох сэтгэл төрнө...” гэх мэт.

С.Дашдооровын “өндөр сэтгэлтэй” зохиолууд буугаад л мордох ховоод бид хичнээн зүйлийг биендээ тайлбарлах өртэй явцгаадгийг ихээ өндөр дээрээс нүүдэлчдийн сэтгэлийн чинад нүүдэл шингэсэн, нүнжиг оршсон их ухаарлаар “зэмлээд” байх шиггунигтайхан мэдрэмжийг өгөх юм. Тиймээс ч Висс Бильдушников “Түүний өгүүллэг, тууж нь эмгэнэлт явдлыг өгүүлсэн ч өгүүлэмжийн туйлын энгийн шинжтэй, үйл явдлыг дүрсэлж үзүүлсэн байдаг”³ гэсэн биз ээ.

2015.11.25

³“ХХ зууны монгол зохиолчид цуврал-30 С.Дашдооров”, УБ., 2004, 86 т.х

МАНДАХ НАРНЫ НААГУУРХ МАНАН ХЭЗЭЭ АРИЛАХ ВЭ...

*“...Яруу найрагч бүрт ололт байдаг.
Тэр эрчмээрээ явах нь ч бий, үгүй нь ч бий.
Сэтгэлд хүрэх найргийг замд үрвэл юутай харамсам.
Иймээс яруу найрагч хүнд болгоомжтой ханд”
С.Дашдооров*

Авгаржин Жа.БАЯРАА

1. *Аж төрлийн цадиг буюу ГУРВАЛСАН МОРЬТОН*

Түүний нэрийн хуудас бол “Монгол”, “Хүлэг” найраглал, “Говийн өндөр”, “Дуут хонгор манхан” роман, “Гурван найз”, “Нар хиртсэн жил”, “Өндөр ээж”, “Эх бүрдийн домог” кино зохиолууд, “Хөдөөгийн баясгалан”, “Мартагдашгүй намар” киноны дуунууд гээд л хөвөрч өгнө дөө.

Дашдооровыг 1936 оны 3 дугаар сарын 7-нд Дундговь аймгийн Шорвогийн хөх овооны хаваржаанд төрсөн гэдэг. Нэлээд ном зохиол дээр түүнийг 1935 оны 3 дугаар сарын 9-нд төрсөн гэж бичсэн нь бий. “Утга зохиол, урлаг” сонины архивт хадгалагдаж буй өөрийнхөө гараар бичсэн анкет дээр “Дэлгэрхангай сумын “Шорвогийн хөх овоо” гэдэг газар 1935 оны 3 дугаар сарын 9-нд төрсөн, халх монгол” хэмээжхүй. Д.Нямаа найрагчийн дурсамжинд “1940 оны өвлийн эхэн сард хүү алга болжээ. Шөнө болтол хайгаад олсонгүй. Өглөө айлын эмээ бутны ёроолд үс хийсэхийг хараад очтол хүү байж. Байхаар барахгүй өвлийн шөнийг огт ажралгүй унтаж өнгөрөөсөн аж. Хүү зургаан настайдаа Тоорой банди тэргүүтэй домгийг ихэд сонирхон сонсдог байж” гэсэн нь бий.

С.Дашдооров аймаг, сумандаа дунд сургууль дүүргээд, хотод оюутан болжээ. Багшийн сургуульд байхдаа Л.Түдэв, М.Цэдэндорж нартай улам ойртон дотносож, журамт андууд болсон гэдэг. Хичээл дээрээ шүлэг бичсэн хэрэгтэйгээр сургуулиасаа хөөгдөж, нутагтаа нэг хэсэг мал маллаж байв. Захирал нь авьяастай гэдгийг нь мэдэрдэг тул аргадан авчирч, сургуулийг нь төгсгөжээ. 19 настайдаа яруу найргийн “Шинэ сурагч” /1954/, хүүрнэл зохиолын “Талын гэрэл” /1956/ түүврүүд нь хэвлэгджээ. Ийн тэрбээр Монголын утга зохиолд хөтөлгөө морьтой гүйхээрээ орж ирсэн хэрэг.

1957 онд “Бага Нацаг” буюу Төмөрийн Нацагдорж, С.Дашдооров, М.Цэдэндорж нартай хамтран өөрсдийн нөхөрлөлийн бэлгэ тэмдэг “Гурван найз” кино бүтээсэн нь Монголын анхны хүүхдийн уран сайхны кино болж түүхэнд мөнхөрчээ. Д.Сэнгээ зохиолч Дооров зохиолчийг дэмжиж, Орос руу сургуульд явуулсан боловч их гүрний иргэнд “ухамсрын шанаа” өгсөн хэргээр хоёрдугаар курсээ төгсөж чадалгүй төрхөмдөө буцжээ. Буцаад зогсохгүй үндсэрхэг үзэлтэн гэгдэн энхрий хайрт намаасаа хөөгдөв.

Сэхээтэн ховор үед түүнийг төр шууд гудамжинд гаргаад хаячихсангүй. Өмнөговь, Дундговь аймгийг хариуцсан Зохиолчдын хорооны төлөөлөгчөөр гурван жил ажиллуулав. Тийн суух үедээ алдарт “Говийн өндөр” роман нь төрж, Б.Явуухулан найрагч 1961 оны хавар “Талд татсан солонго” шүлгийн түүврийг нь хэвлүүлсэн нь маш урам өгч. Дөнгөж хэвлэгдсэн “Говийн өндөр” романыг уншсан С.Удвал дарга С.Дашдооровыг төд удалгүй говиос татан авчирч, Үргэлжилсэн үгийн секцийн эрхлэгч болгосон түүхтэй. Тэгээд л “Монгол кино” үйлдвэр, Батлан Хамгаалах Яам зэрэг газруудад арав гаруй жил ажиллаж байгаад 1982 онд МЗЭ-дээ эргэн ирж, “Утга зохиол, урлаг” сонинд идэвхийлэн ажилласны дүнд нэгэн оны дараа намын шийтгэл хүчингүй болсноор зохиол бүтээлээ үнэлүүлэх завшаан нээгдсэн гэж болно. “Гурван найз” киноноос хойш арваад жилийн дараа Дооров кино урлагт “Өндөр ээж” киног бүтээв. Түүний дараа “Монгол кино” үйлдвэрт ажиллаж, бүх уран сайхны кинонд редактораар ажилладаг байсан. Тэгээд л бидний одоо ч үзэх дуртай “Нар хиртсэн жил”, “Эх бүрдийн домог”, “Их замын эхэнд”, “Тэнгэрийн муухай арилдаггүй” тэргүүтэй арав гаруй кино зохиол бичиж дэлгэцнээ амилуулснаар хосоор ч тогтохгүй гурвалсан морьтон болсныг урлаг, утга зохиолын ертөнц хүлээн зөвшөөрсөн болой. Тэрбээр Түвдэнгийн Борын дурсгалд зориулсан “Бүргэдийн үхэл” жүжиг бичсэн нь утга зохиолыг хянах газрынханд нэр нь таалагдсангүй. Нэрийг нь өөрчилж “Шуурганаар төрөгсөд” болгосон ч тайзнаа тавигдсангүй. Хожим “Талын цуурай” хэмээх нэртэй кино болсон гэдэг. Зохиолчийн намтар цадигийг хүүрнэвээс үл барагдахын учир уран бүтээлийнх нь тухай энд цухас үгүүлсү.

2. Уран бүтээлийн цадиг буюу МӨНХИЙН ГЭРЭЭС

Тээр жил Горькийн сургуулийн оюутан С.Дашдооров Давид Кугультиновыг /Халимагийн Ардын яруу найрагч/ алгасаны маргааш Москвагийн консул Намсрайдорж түүнийг дууджээ. Тэр хоёр ийнхүү

ярилцсан гэдэг.

-Дашдооров, та нутаг буцах болж дээ.

-Яагаа вэ, авгай хүүхдийн бие муудаа юу?

-Үгүй ээ. Авгай хүүхэд тань сайн. Та зөвлөлтийн хүн зодсон байна шүү дээ.

-Өө муу Хөхөлдэйн Даваа юу?

-Ямар ч гэсэн та хүний эрхэнд халдсан байна.

-“Царцсан” цусыг нь бүлээсгэж, ухаан суулгах л гэсэн юм л даа.

-За та одоо долоо хоногийн дотор сургуультайгаа тооцоо хийгээд буцна шүү.

-Ашгүй дээ, нутгаа санаад байсан юм, баярлалаа. Улсын зардлаар биз дээ.

Ийм нэгэн болсон явдлыг нэрт зохиолч Ж.Лхагва бичиж үлдээсэн байдаг юм. Инээдтэй юм шиг санагдавч угаар нь бодоод үзэхээр С.Дашдооров гэдэг зохиолчийн мөн чанарыг гаргаад тавьчихсан нандин “тодорхойлолт”. Тэр хэзээ ч албан тушаал, алдар нэр хөөцөлдөж явсангүй. Төрийн шагналт яруу найрагч Д.Нямаа тэргүүтнүүд жинхэнэ зохиолч хүний дүр төрхийг түүнээс олж харсан тухайгаа дурссан нь их ээ. Молхи миний хувьд Дооров гэдэг зохиолчийн хүүрнэл зохиол, кино гэхээс илүү яруу найрагт нь хүссэн, эс хүссэн ч ойрхон байж. Тиймдээ ч би эл үгүүллийг бичиглэж сууна. Олон жилийн өмнө дөө.

Би армид алба хааж байхдаа “Утга зохиол, урлаг” билүү, “Улаан од” сонин дээрээс

“Одтой байж од нь харагдахгүй

Тэнгэр байдаг юм

Огт битгий хайхраарай.

Нартай байж илчээ өгдөггүй

Тэнгэр байдаг юм

Найрсаж битгий гуниарай.

Үүлтэй байж бороо оруулдаггүй

Тэнгэр байдаг юм

Үзээгүй юм шиг яваарай” гэсэн мөрүүдийг уншиж, сэтгэл машид баясан цээжилж билээ. Харин хэн зохиосныг нь мэддэггүй. Сүүлд нь С.Дашдооров гэдэг хүн 1960 оны босгонд бичсэнийг нь мэдсэн. Энэ шүлгийг уншихад надад “Залуу байж гал нь харагдахгүй хүн байдаг, битгий тоогоорой. Онгодтой байж

түүнийгээ ашигладаггүй шүлэгч байдаг, бүү нөхөрлөөрэй. Авьяастай байж зохиол бичдэггүй хүн байдаг, таньдаггүй юм шиг байгаарай” гэж зөөлөн шивнэх шиг санагдсан сан. Магадгүй миний оронд инженер, малчин, одон оронч хэн ч байлаа шууд утгаар нь биш танил ертөнцөөрөө хүлээн авч байгаад эл гайхамшигт шүлгийн дотоод нууц орших буй за. Аливаа найрагчийн мөн чанарыг хайрын шүлэг урласан бялдаар нь таньж болно гэдэг.

“Уран цагаан бадамлянхуа цэцэг

Усан цээлийн мандал дээр дэлгэрнэ.

Ганган сайхан цоморлигоо хумин

Гандан гандсаар атираан дээрээ хагдарна.

Яг тэгж, гэнэтийн халуун дурлал

Яруу сайхныг мөрөөдөн зүрх түшин бадарна.

Ухаан санаа эзэгнэн улалзан асавч, яваандаа

Унтран унтарсаар зүүдэнд уусан алдарна” /1979/. Үүн дээр нь Дооров найрагчийн “Анхны хайрын дуу”-г нэмчихэд л хангалттай. Түүний “Гил хар гэзгээ ханхлуулан байж” шүлгийн хувьд жинхэнэ төрмөл найрагчийн шилдэг романтизмын тод жишээ болох байх аа.

“Гил хар гэзгээ ханхлуулан байж

Чи шувуу шиг цээжинд минь шургасан,

Гиюүрсэн салхи дэнжигнэн байж,

Дэрсэн толгой дээр нойрссон,

Саргай тэр шөнийг дагуулаад

Зэлний маань адуу холдоод хоножээ.

Сайхан учралаа бодон бодоход

Зүрхний маань манан арилаад өгчээ.

Холхон чиг газраас

Адуугаа хураах аятайхан ч юм шиг.

Хонгор чамдаа яарахад,

Ахиухан зай таатайхан ч юм шиг.

Нээрэн чи чинь зүрхэн тольтонд

Хийсээд ирэх шиг болохыг яанам.

Нэрийг чинь зөвхөн шивнэхэд

Цэлийсэн талд нисээд буух шиг болно” /1996/ хэмээжихүй. Тэрбээр

60 насандаа ингэж бичиж байсан гэвэл би лав “гайхалтай” хэмээн үгүүлэх байна. Зөвхөн тархиа донсолгож, сэтгэлээ үймүүлсэн сэрлээс л ийм байдгууд оргих байх. Олныг үл нуршин С.Дашдооров идэрхэн 25 настайдаа алдарт “Монгол” найраглал /1960/-аа бичиж, монгол түмний үндэсний үзлийг оволзуулж байсан дээр тогтёё. Түүний эл найраглал Монголын радиогоор орон даяар цацагдаж, өвлийн үдшээр хээр талд

“...Гэгээн сайхан жаргал гэр бүхэнд ирснийг

Дуу хуурынхаа манлайд дуулж би магтах гэсэн юм

Дуулим талаа дүүртэл хуур юугаа татах гэсэн юм” хэмээн дуурсаж байлаа. “Соёл, утга зохиол” сонины 1963 оны нэгэн дугаарт нэрт судлаач, шүүмжлэгч Г.Жамсранжав агсан “Дашдооровын “Монгол” найраглал нь их зохиолчийн “Хуучин хүү”-гийн хэлбэрээр утгыг төгс илтгэжээ” хэмээсэн нь буй. Тухайн үед хамгийн нөлөөтэй гуравхан шүүмжлэгчийн нэг энэ хүн С.Дашдооровын “Говь” шүлгийг ч дуун алдан тосож авсан байдаг нь нэгийг үгүүлэх мэт. За тэгээд цаашилбал

“...Хаан Чингисийн нударга дор Хамаг Монгол нэгдсэнийг

Хөрст дэлхийн элгэнд Хөх Монгол тогтсоныг

Шастир түүхийн хуудсыг шагайж сөхөж үзвэл,

Хүч, бач бүгдийг нь хүүрнээд өгнө, яриагүй”. Орь залуу насандаа “Монгол”-ынхоо салхийг ийн хагалж шуугиулж өгсөн нь олон оны дараа ч нэн тод. Үнэндээ энэ найраглалын дээрх мөрүүд их эзэн Богдын сэдэвт агуу хөлгөн туульсын суурийг тавьсан гэж хэлж болно. Монгол хүн гэдгээрээ бахдах ард олны сэтгэл зүрхийг сэрээсэн гэж тайлбарлаж болно. Чухамдаа “Монгол” найраглалын нөлөө, үзэл санаа хийгээд сэдлэг дор Ардын уран зохиолч П.Бадарч “Есөн эрдэнийн орон” /1971/, Д.Пүрэвдорж “Чингис хаан” /1962/, Р.Чойном “Миний Монгол” /1970-аад он/, Б.Явуухулан “Би хаана төрөө вэ”, “Тэхийн зогсоол” /1969/ хэмээх алдарт бүтээлүүд төрөн жагссан. Харин “Монгол” найраглалын өмнө шинэ Монголын уран зохиолын түүхэнд Д.Нацагдорж “Миний нутаг” /1933/, Ц.Цэдэнжав “Миний нутаг” найраглал гэсэн хоёрхон бүтээл бий. Найраглалд

“...Монгол-бичихэд хэдий богинохон ч

Мориор давхиад гүйцэшгүй удам дэлгэр нутаг

Монгол-хэлэхэд хэдий амархан ч

Мохож цуцаж үзээгүй ард олны алдар” гэсэн нь Нацагдоржийн “Хуучин хүү”-гээр тогтохгүй “Монгол” хэмээх бүтээлдээ С.Буяннэмэхийн

хэлж амжаагүйг төгс төгөлдөр болгосон мэт. Хоёр их гүрний дундах халиуны зулзага бяцхан эх нутгаа өрөвдөж энэлсэн найрагчдын ганихралын дуу тус найраглалд илд мэт гялалздаг. Эрх баригчдыг хэргэм зэргээр шагнаж, шан харамж өгөвч улс маань улам л дордойх. Тэртээ нэгэн цагт Монголыг маань “хонхны дуу”-гаар хүлцэнгүй ноомой болгосон бол цагаан морин жилийн босгонд мөн л “Хонхны дуу”-гаар бадруулж мандуулсан нь түүхэн үнэн. Хүрэл ч бай, хөнгөнцагаан ч бай хонх хэмээгчийн хоёр тал нь ийм буюу.

“...Санаа сайтай ардыг маань сүргээ хариулж явахад нь

Хонх дамар барьсаар нэг хэсэг нь ирж,

Хоргой торго дэлгэсээр нөгөө хэсэг нь морилж,

Хаад ноёдтой нийлж харийн хүмүүс цугларсаар,

Хэргэм зэргээр долдойдож эх оронд минь шургалсаар

Сэрүүн сайхан орныг минь хонхны дуугаар дарж

Сэтгэл цагаан ардыг минь бурханы үгээр хуурч,

Нутагт гээгдсэн гадас шиг дэлхийн хөгжлөөс хоцроож,

Нугад ургасан мод шиг түмний сонороос тасалж,

Торго хамбаар баячуудыг тордож гоёж байсан ч

Тогосны өдөөр ноёдыг шагнаж дэвшүүлж байсан ч

Халх Монгол хэвээрээ, хөгжлийн цуваанаас сүүлдэж

Хамаг ард минь янзаараа, хөөрхий болж үлдсэн юм.

Ноомой бяцхан ардыг маань өрхөө татаад харахад нь

Номхон морио эмээллээд уургаа тулаад мордоход нь

Хүж дэлхийн орнууд яваад өгсөн байж л

Харгуй замын адагт бид үлдээд хоцорч л” хэмээсэн нь хөрш гүрнээ бараалавч хол үл явах. Тиймийн тул гурав дахь хөрш чухал гэсэн хэтийн санаа юм. Харин одоо Монгол улс нэгэн зууны өмнөхөөсөө ч дордож дээ, хөөрхий. Тийм ээ, өвлийн манан, цан хүүрэг. Өтгөн хүйтэн МАНАН. Ядуус гунигт дуугаа орондоо аялан гиншиж хэвтэх нь алин цагт хувирахгүй ангит нийгмийн төрх мөн өө. Эх оронч эцгийн хөвгүүд тэмцэн босовч хорлогдон амиа алдах авай. Монголын төр ширлүүлэн, улмаар хурц нарнаа шарагдах мэт эл гунигт хувь тавилан хэзээ болтол үргэлжлэх бол. Бид зах зээлийн нийгэм гээд зэрлэг капитализмыг сонгосон. Одоо энэ өндөрлөгөөсөө феодализм руу унаад эхэллээ. Энэ нь бидний сонгосон нийгэм журам. Харин одоо зовлон гунигаасаа яаж хагацах вэ, чухам яаж... Үүнийг л яруу найрагчийн зөн ийн

үгүүлэмжлэн хөтөлсөн хэрэг.

“...Мандах нарны наагуурх манан хэзээ арилах вэ?

Мах цусанд шингэсэн зовлон хэзээ тасрах вэ?

Уудам талын хааяагүй уйтгарт дуу уянгална.

Буян жаргал зөгнөсөн буман үлгэр урсана.

Ардын төлөө босож, аавын хөвгүүд тэмцэвч

Арьс ширэнд боогдон аглаг хөдөө хаягдан байж!

Урьдын Монгол яг л тэгж ширлүүлж хаягдсан эр шиг

Уудам Монгол яг л тэгж наранд шарагдан наршиж

Яах ийхээ гайхан эргэж бодож байтал

Ямар замаар хэрхэн зовлон гунигаас гарах вэ” гэж.

Бид өдгөө ч

“Туульсын их баатруудыг

Тулгаа тойрон бахархаж” гадаа хүйтэнд суусаар л байна. Харамсалтай нь Модун хаан, Чингис хаанаа, Батмөнх даян хааныхаа алдар сууг худалдан идэх, нэрээр нь гул барих он жилүүд хэдийнэ дууссаныг “Монгол” найраглал сануулсан хэрэг.

“Үлгэрийн их диваажинг үүдээ сөхөн харъяаа гэж

Тойгтныг урдаа сөхрүүлж байсан ч

Толгойтныг өмнөө сөгдүүлж байсан

Өвөг их дээдсийнхээ омог зоригийг хөвчилж

Өндөр их төрийнхөө сүлд хийморийг өргөж

Нуруун дээрээ сандайлсан харийн түшмэдийг түлхье гэж

Нутаг усаа эзэрхсэн Манжийн амбаныг хөөе гэж

Хошуу нутгаараа хуйларч боссон Монгол минь

Хувь тавилангаа дээдэлж хурайлж өндийсөн Монгол минь

Арван нэгэн онд ард олноороо түрхэрч

Тусгаар Монгол улсаа тунхаглаж бүгдээрээ баясч...” байсан шигээ монгол хүн дээдсийнхээ түүх, газар шороо, эд баялагтаа эзэн нь байж үндэстэнг минь зайдалсан харийнхны бодлогыг сульдаан, хуйлран босоцгооё гэсэн үг чихэнд сонсогдоно.

Чи Азийн эртний буурал талд төрсөн бол, монгол эхийн хэвлийнээс унасан бол газар шороо, тусгаар тогтнолынхо төлөө үхэх зоригтой бай

гэдгийг найрагч гэрээсэлжээ.

“...Буман ээжийн хүү буурал талдаа төрдөг юм

Энэ нутгийнхаа төлөө ээжийн үрс үхэх гэж төрдөг юм

Баян Монгол-Хангай, говь хосолсон

Баялаг дэлгэр нутгаа Азийн цээжинд дэлгэжээ

Баян Монгол-үнэт эрдэнээр гялалзан,

Баяр жаргалын дуу элгэн биеийг нь чимжээ”. Тэгж гэмээнэ монголын баялаг эрдэнэс гялалзан цацарч, бахдам ардын дуу уянгалан дуурсах авай. Монгол минь яагаад оршин тогтноод байна. Нэг том нууц нь бидний тусгаар гэдгийн илэрхийлэл болсон Үндсэн хууль. Энэ л хуулиа улс төрчид маань гадны нүдэн дээр цэлийтэл дэлгээд тайлбарла, сурталчил.

“...Замбутивийн элгэн дээр хувьсгалт Монгол дэвжиж байдгийг

Зарим гүрний ноёнтон эргэж гайхдаг юм гэв үү?

Тэгвэл би, үндсэн хуулиа тэдний өмнө нээмээр байна.

Эрх жаргалаа баталсан Үндсэн хуулийн маань хуудаснаас

Эгэл олон ардын маань баясгалант царай нь тодорно вий!

Энх тунх орны минь газрын зургийг ажвал

Эрхт ардын маань бүтээсэн гайхам бүтээл харагдана вий!”. Тийм ээ Үндсэн хууль бол монголчуудын аз жаргал, эрх чөлөөний цорын ганц баталгаа. Түүнд тэмцлээр олж авсан Монголын маань хувь заяа нэвт шингэсэн байдаг. Нөгөө Гайтав найрагчийн “Улаан туг, залуучууд хоёр ихэр юм” гэдэг шиг Үндсэн хууль, газар нутаг хоёр угтаа эх, үр хоёр юм гэсэн санааг яруу тод зоож мөнхөлсөн нь зохиогчийн агуу их суу билиг гэхээс өөр юу гэх билээ. Уул уурхайг ухаж төнхөх хэрэгтэй. Харин ямар уул хайрханг хэзээ, яаж...

“Хахир харамч уулсын хадан цоожийг нь нээж

Эрдэнэ баялгийг нь булаасан эрхэм үйлсийг магталтай!

Энх сайхан орноо далай тэнгис гэвэл,

Эвхэрч хуйлрах давлагаа нь ажил хөдөлмөр болжээ.

Шинэ Монголын царай шидрүүн ч, бадриун ч байна

Шимтэж хийсэн бүтээл минь шижгэр ч, нижгэр ч байна”. Догшин савдагтай хадан уулсын үүцийг нээж, эрдэнэсийг олдворлох нь хөгжлийн бас нэг эз. Үүнд зөвхөн монгол хүний цуцашгүй хөдөлмөр туйлаас чухал. Үүний тулд шинэ монголчууд эрс шийдмэг, эрч хүчтэй байх учиртай. Хийсэн үйл нь бүтээлч, хүртээмжтэй байх ёстой гэдгийг оюун санаа минь мэдэрч буй.

“...Морио унасан ард-Монгол гэдэг улс гэж

Дуу дууныхаа манлайд дуулж би магтах гэсэн юм.

Дуулим талаа дүүртэл хуур юугаа татах гэсэн юм.

Шинэ Монгол-ажилсаг гараа далайж

Шигтгээ болсон хөгжлөөр эх орноо чимсээр!

Шинэ Монгол-Түмэн эхийгээ унаж,

Шилж сонгосон замаараа тоос босгон тэмүүлсээр” буй Монголоо л дурсанам. Гуравхан сая монголчууд минь түмэн эхээ эмээллэн сойё. Харин хаашаа мордох вэ. Урьд өмнө бид морио эмээллээд, мандах нарны зүг нутаг байгаа гээд баахан давхисан. Дараа нь жаргах нарны зүг бишгүйдээ хатирлаа. Одоо бодох нь ээ, С.Дашдооров амбугайн хэлдгээр “Яасан их тоос шороо босгоо вэ, бид”. Бид Хятад, Оросыг унаж, цаашилбал Япон, АНУ-г хөлөглөж чадахгүй. Унавч удаан тэсэхгүй, толгойгоороо хатуу газар ойчно. Монгол хүнийг бурхан монгол морио л унаж, Монгол газар дээрээ аж төр гэжээ. Өвөг дээдэс морин дээрээ дэлхийг эзэлсний нууцын утга энэ буюу. Тиймдээ ч монголын гарц бол эмээлт хүлэг, морин хуур, урт дуу ч юм билүү.

“Миний Монгол-бичихэд хэдий богинохон ч

Мэтгэж яваад баршгүй уудам дэлгэр орноо!

Миний Монгол-Хэлэхэд хэдий амархан ч

Мятарч цуцаж үзээгүй золбоот ардын үрс ээ!

Уужим холоос гишгэдэлтэй түмэн эхийн давхиа

Улс, улсын хүлгийн дунд хазаар даран тэмүүлж

Далай даян аварга-даамай цуутай ард минь

Эмээл дээрээ бат сууж эрмэг хөлөө чийрэг жийжээ”. Одоо маньгаа хаа хүрэх тухайд, үүгээр тогтохгүй Монгол улс даяаршилд хэрхэн нийлэн найрсах санааг говийн өндөр өндөр бархад шигээ гийгүүлэн жаргаасан билээ. Ийн “Монгол” найраглал эхээсээ хүй таслан мэндэлснээс хойш яг хоёр оны дараа БНМАУ НҮБ-д элсэж, алтан соёмбот Монголын далбаа өрнийн тэнгэрт намирсан нь ерийн нэг хувь тохиол гэж үү. Магадгүй энэ яруу найргийн их эрчим, монгол найрагчийн зөн совин ч юм билүү, хэн мэдлээ. Ямартаа ч

“Монголын далбаа намилзлаа

Ирээдүйн их нийгмийг далай тэнгис гэвэл

Энэ рүү цутгах мөрөнд Монгол улс нийллээ! гэж

Саруул баян талдаа сайхан дуугаа өргөнөм” /1959-1960/ хэмээн

их утга зохиолын нэгээхэн очир эрдэнэ болсон “Монгол” найраглал бараг нэгэн жарны тэртээ ингэж төгсдөг юм аа. Эцэст нь ХХ зууны суут зохиолч С.Дашдооровтой ойр байсан гурван эрхмийн эшлэл, дуртгал болон түүний 1967 оны хавар хэлсэн нэгэн афоризмоор эл бичвэрээ өндөрлөсү.

Урлагийн гавьяат зүтгэлтэн Р.Доржпалам: Дашдооров бид хоёрын нэр холбогдсон бүтээл цаанаасаа отоотой юм шиг гацаанд орчихдог. Аль 1958 онд “Эрдэнэ хайрханы эзэд хэн бэ” зохиолоор хийсэн кино байна. 13 бүлэг киноны зураг авчихаад бүрэн хэмжээний хүүхдийн кино бүтээлээ дээ гэж бодож байтал дээрээс амьдралд нийцэхгүй, үзэл сурталд таарахгүй гэж хасуулсаар таван бүлэг болгоод, сүүлд нь “Энэ ч арай дэндлээ. Хөгжил дэвшил харуулсан зураг нэмж аваад гарга” гээд осолгүй “Гурван найз” нэртэй кино дэлгэцэнд гарсан даа...

Яруу найрагч М.Цэдэндорж: “Говийн өндөр” роман Хэвлэл утга зохиол хянах газрын давааг яаж давсан гэж санана. Ялихгүй юмаар шалтаглаад болдоггүй. Дашдооровыг залуу болохоор эргэлзээд, зарим үгүүлбэр, дүрслэлийг буруутгаж мушгиад. Би авч яваад засаад ирье гээд арваад хоног өнгөрлөө. Өнөөх элдэв тэмдэг тавьж, доогуур зурсан үг, үгүүлбэрийг уншиж үзлээ. Бүгдээрээ зөв байх юм. Тэгээд тэр үг, үгүүлбэрийг гаргахын аргагүй болтол баллачихаад, би гараараа хуучин хэвээр нь дахин сэргээн бичээд, маш сайн заслаа гээд аваад очлоо. Тэд шалгаж үзсэнээ “Ингээд л засчих хэрэгтэй байсан юм шүү дээ. Ёстой сайн редакторлажээ” гээд намайг эг маггүй магтаж, хуудас бүрт нь тамга дарж хэвлүүлэхийг зөвшөөрсөн дөө.

Төрийн шагналт яруу найрагч Д.Нямаа: Би нутагтаа бага эмч байхдаа С.Дашдооровтой танилцсан. Зохиолчдыг амьдрал судлуулахаар томилсон нь тэр. Горькийн сургуулиас хөөгдөөд нутагтаа бараг цөлөгдөөд ирсэн үе. Тэр цөллөг нь надад азтай төдийгүй С.Дашдооровт ч олзтой явдал болсон. Тэндээс мань хүн “Говийн өндөр” романаа олсон. Би С.Дашдооровтой хориод настайдаа танилцсан. Түүн шиг ханхалзах сан гэж бодно. Том биетэй, өргөн цээжтэй, сайхан эр. Түүн шиг ханхалзах гэхээр надад тийм цээж үгүй болохоор инээдэмтэй харагдана. Тэр их аргил бүдүүн дуутай. Тийм болох сон гэж бодовч надаас тийм дуу гарахгүй. Тэгэхээр өөрийнхөө хэмжээгээр дуугарч, ханхалзахаас өөр аргагүйд хүрнэ ээ дээ.

Төрийн шагналт, Ардын уран зохиолч С.Дашдооров:

...Яруу найрагч бүрт ололт байдаг. Тэр эрчмээрээ явах нь ч бий, үгүй нь ч бий. Сэтгэлд хүрэх найргийг замд үрвэл юутай харамсам. Иймээс яруу найрагч хүнд болгоомжтой ханд! /1967.05.26/

НАЙМАН ТҮМ ДӨРВӨН МЯНГАН ШАЛТГААН БУЮУ БУУЖ МОРДОХ ХОРВОО

*/Зохиолч С.Даашдооровын “Бууж мордох хорвоо” үгүүлэгийн
задлан шинжлэл/*

Гарцаагүй Пүрэвхүүгийн Батхуяг

1. Шалтгааны оршил

Эртний Грекийн Демократ хэлсэн гэдэг. Персийн хаан ширээг эзэлснээс шалтгаант тайлбар нэгийг олсон нь дээр. Тэгэхээр Демократын хувьд “ШАЛТГААНТ ТАЙЛБАР” хаан ширээнээс хавьгүй үнэтэй зүйл болж байна. Гэтэл номын хязгаарт хүрсэн мэргэд “ХАМАГ БҮГД ШАЛТГААНААС ХАМААРНА” хэмээн номложээ. Ертөнц бүхэлдээ ШАЛТГААН гэх үзэл ч түгээмэл. Бурханы шашинд ч учир шалтгааны ухаан чухалд тооцогдоно. Шалтгааныг таниваас ертөнцийн жам, амьдралын утга учрыг нээж болно гэж эртнээс үзэж байсан, одоо ч хэвээрээ. Дорны мэргэд зарим талдаа илүү гайхамшигтай. Тэд хүн төрөлхтний оюун сэтгэлгээ нялх цагт шалтгааныг тоолж гаргасан гэнэ. Мэдээж тэр цагт өнөөдрийнх шиг компьютер тооцоо, математик аргачлал, метахэлний орчин, физик логик байсангүй. Гэхдээ л нэг тоо гаргасан байгаа юм. Хэдийгээр үнэн бодитой тоолж тооцоолж гаргасан ТОО гэхээсээ илүү БИЛИГДЭЛ чанартай байсныг үгүйсгэхгүй.

ТӨРӨХ хийгээд ҮХЭХ бол ердөө жам. Нөгөө талаараа хүний амьдралын тухайд төрөх хийгээд үхэх бол ердөө ухамсарлахыг хүссэн цаг хугацаа. Даанч ухамсарлаж амжсан нь цөөхөн. Нарийндаа ШАЛТГААН-ыг таньж мэдсэн нь цөөн гэсэн үг. Мэргэд номложээ. Төрөх хийгээд үхэхийн завсар НАЙМАН ТҮМ, ДӨРВӨН МЯНГАН” шалтгаан буй гэнэ. Одооныхоор 84000 ШАЛТГААНЫ ДОТОР бид амьдарч амьсгалж байдаг ажээ. Амьсгалах гэснээс хүний арьсанд мөн 84000 сүв бий гэнэ. Түүгээрээ сайн муугаа бас гадагшлуулдаг сурагтай. Тэр олон шалтгаанаас дэндүү цөөхнийг таньж мэдээд л бидний ХОРВОО төгсдөг бололтой. Огт таньж мэдэж амжилгүй дуусдаг нь дэндүү олон, таньж мэдсэнээ өөртэйгээ аваад оддог нь ч багагүй.

2. Шалтгаан үүдэхүй

Ер нь уйлахын шалтгаан инээхээс, инээхийн шалтгаан уйлахаас, баярлахын шалтгаан гуниглахаас, гуниглахын шалтгаан баярлахаас,

хайрлахын шалтгаан үзэн ядахаас, үзэн ядахын шалтгаан хайрлахаас, шунахын шалтгаан хоосрохоос, хоосрохын шалтгаан шунахаас, үхэхийн шалтгаан төрөхөөс, төрөхийн шалтгаан үхэхээс, гарч ирэхийн шалтгаан үгүй болохоос, үгүй болохын шалтгаан гарч ирэхээс үүдэх билээ. Эрт цагт Бурхан багшийн сургаснаар **“Бурхан гарч ирэх, алга болох нь шалтгаан нөхцөлийн хуулиар тайлбарлагдана. Тухайлбал шалтгаан нөхцөл нь тохирсон үед “Бурхан гарч ирж, мөн шалтгаан нөхцөл нь тохироогүй үед Бурхан үзэгдэхгүй болно”** хэмээсэн байдаг. Бурханы мөн чанар ч шалтгаанаас шалтгаална. Үүлс хуралдах бороо орохын шалтгаан, хахир хатуу өвөл цагт цас орохын шалтгаан, салхи сэвэлзэх ч шалтгаан. БАЙГАЛЬ бүхэлдээ шалтгаан. Сар нарны тохиол, гараг эрхэс, сансарын хязгааргүй тэр чигтээ шалтгаанаас тогтмой. Хүний бүтээсэн бүхэн Шалтгаан. Бас хүний үгүй хийсэн бүхэн шалтгаан гэж үзнэ. “Үг бол бурхан” хэмээжээ. Тэгэхэрээр ҮГ бас ШАЛТГААН болно. Тэр үгээр амилан бүтээгдэх УРАН ЗОХИОЛ ч шалтгааны урлаг болно. Угтаа **“ҮГС гэдэг нэг үгээр хэлэхэд нэг сав бөгөөд түүнийг үзэж өнгөрүүлсэн үзлүүдээрээ дүүргэдэг. Гэтэл энэ сав хэзээ нэг цагт дүүрч асгардаг. Тиймээс үгс юу үзснийг заахаас бус түүнтэй яг тэнцүү идентитет биш”** гэсэн философи тайлбараас үзвэл хэдий уран зохиол үгсээр оюун санааны илэрхийллийн “ТЭМДЭГТ” хийж байгаа боловч аливаа юмсын учир шалтгааныг тайлахад ҮГС ч хүчин мөхөсдөнө гэсэн үг. Дуулах ч юм уу, хуурдах ч бас шалтгаан. Аялгуу эгшгийг дамжуулахад ч бас хөгжмийн хүчин мөхөсдөнө. Ийм арга барагдмал нөхцлөөс шалтгааныг эрэлхийлэх ҮЙЛ эхэлсэн гэж үздэг.

3. Шалтгаан ба уран зохиол

Тэгвэл уран зохиол ШАЛТГААН-ыг таних, эрэх, тайлах, нээх, түүнийгээ ҮГС-ээр дамжуулан илэрхийлэх ҮЙЛ юм. Харьцангуй явцуу дүгнэлт байсныг үгүйсгэхгүй. Харин хүний сэтгэл, сэтгэлийн олон үзэгдэл чухамдаа нягт сүлжилдсэн шалтгаанууд болой. Тэр л шалтгааны СҮЛЖЭЭС-ийг тайлах эсвэл улам сүлжилдүүлэхэд уран зохиолын туйлын зорилго оршино. Иммануил Кант хэлээ билээ. **“Тэнгэрийг ширтэхдээ би ямар нэг ер бусын зүйл байдаг болохыг, сэтгэл рүүгээ өнгийхдөө ямар нэг нууцлаг зүйл оршиж буйг мэдэрдэг ч, баталж чаддаггүй”** гэжээ. Энэ бол энгийн л илэрхийлэл. Үнэндээ ийм л учир битүүлэг зүйлсийн шалтгаан уран зохиолын нарийн төвөгтэй ҮЙЛ-ийн эрхэнд олон хүмүүсийг унагажээ. Гэтэл өнөөх

1Бурхан багшийн сургаал” 2010 он, орчуулагч М.Шагдарсүрэн
2Э.Фромм ”Бий эсвэл Байх” 2014 он, орчуулагч С.Молор-Эрдэнэ
3 67 дугаар хуудас, “Кант”, 2014 он

хүмүүс нь унасан үйлдээ учиргүй дурлан тэмүүлдэг нь хачирхалтай.

Тийм үйлэнд унаж, шалтгааныг таних, нээх, тайлахын тулд сэтгэлээ бүрэн зориулж амьдарсан монгол зохиолчдын нэг бол С.Дашдооров /1935-1999 / мөн. Түүний яруу найраг, жүжиг-кино, хүүрнэл зохиолын өвөөс “БУУЖ МОРДОХ ХОРВОО” үгүүллэгийг сонгосон нь олны амыг дагасан ч юм уу, нийтийн жишигт таацах гэсэн явдал бус. Монгол хэлт уран зохиолын зарим өвөө илүү нухацтай судлах, тайлбарлах, задлан шинжлэх гэсэн сэтгэлийн үүднээс төрсөн гарсан эрмэлзлэл юм.

4. Шалтгааны эхлэл

Үгүүллэгийн эхний хэсэг Төгөө өвгөн овоон дээр”... гэж өгүүлснээ ийш тийш ямар нэгэн чимээ чагнаж бараа харж сэлвэлзэн харснаа, маанийн шад бувтнан уншив⁴ гэжээ. Одооны өвгөд маань уншихдаа ийш тийшээ сэрэмжлэн харах шаардлагагүй. Харин ХХ зууны сүүл үеийн нийгэм-цагт амьдарч байсан Төгөө өвгөн “**чимээ чагнаж, бараа харж байгаад мааний хэдэн шад бувтнан уншиж**” байгаа юм. Тэр цагт “шашин шүтэх” нь чөлөөтэй байсангүй. “Ханцуй дотроо залбирлаа” гэдэг хэлц ч тэр л цагт гарсан нь тодорхой. Тиймээс л хөөрхий өвгөн тийм хянуур байдлаар маань уншина. Зохиолчийн шалтгааныг нээх чадвар гэдэг энэ. Өвгөн ганцаараа овоон дээр сууж байхдаа тийм хянамгай байгаа байдал нь ялимгүй гунигтай. Монгол үгийн ертөнцөд “зүрхээ үхүүлсэн” гэдэг хэлц байна. Өөрөө бол амьд юм. Харин зүрх нь зүсүүлээд үхчихсэн. Зэрвэс харвал М.Достоевскийн ноён Мышкин /”Солиот” роман/ шиг тийм “сөнөмөл” хүний дүр харагдана. Гэвч манай Төгөө өвгөний дүр бол ялимгүй цагийн дарамтанд “зүрхээ үхүүлсэн” л болохоос СЭТГЭЛ нь үхээгүй. За Мышкин ч ялгаагүй дээ. “**Бид, тэнд сүүлийн удаа хөөргөө зөрүүлэх учиртай байж дээ...**” гэж харууслаа илэрхийлэн үглэж, Хангай өвгөнийг хүндэтгэн явдаг сэтгэлээ нээн мориноос буув⁵” гэдэг. Магадгүй хоёр Орос, эсвэл Герман “сүүлчийн удаа гар барина”, хоёр Хятад, эсвэл Солонгос” сүүлчийн удаа будаа савхдана”, харин хоёр монгол өвгөн “сүүлчийн удаа хөөрөг зөрүүлнэ”. Түүгээр ч барахгүй “хүндэтгэдэг сэтгэлээ илэрхийлж мориноосоо бууна”. Ямар сайхан сэтгэл вэ? Тийм сайхан сэтгэлийг тээж яваа амьд дүр бол Төгөө өвгөн мөн. “БУУНА” гэдэг үг ердөө л зохиолын сэтгэлийг хураангуйлчихаж байгаа юм. Байж боломгүй санагдах ч үндэстэн бүхэнд өөрийн өвөрмөц шалтгаан байгаа юм. Түүнийг тайлж зохиол бичнэ гэдэг энэ.

4С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012 он
5 Мөн дээрх

5. Шалтгааны өрнөл

Зохиолын өрнөл хэсэг”**Нэг их нэр заргүй хэрнээ, түмэнд нүүрийн буянтай хүн байж дээ⁶**” гэсэн сонирхолтой үгүүлбэрээр үргэлжилнэ. Амьдрал олон талаар СОЁЛ юм. Тэгэхээр “нүүрийн буянтай” амьдрах асар том соёл болж таарна. Судлаачийн ийм нэгэн тайлбар бий. **“Соёлд гурван зүйл үнэт чанар байдаг. Үүнд: - нэгдүгээрт, эрхэмнэл, хоёрдугаарт, эрхэмнэлтэй харьцуулахад илрэх юмсын чанар, гуравдугаарт, тийм чанар бүхий юмс хэмээн бид үзэж байна⁷**” гэжээ. Амьдрал- соёл гэдэг логикоор “түмэнд нүүрийн буянтай амьдрах” эрхэмнэл. Нэг талаас үнэт зүйл юм. Монгол хүн амьдралдаа ямар соёлыг эрхэмлэдэг вэ? Ямар үнэт зүйлийг эрхэмлэдэг вэ? гэсэн холбоо асуулт урган гараад түүнд нь зохиолч **“НҮҮРИЙН БУЯНТАЙ АМЬДРАХ”** гэсэн монгол философиор хариулт өгч байгаа юм. Өөр олон тайлбар хэрэггүй. Зохиолчийн амьдралын зам мөр, зарчим ч энэ үгүүллэгт үзэл санааны түвшинд илэрсэн байна. Шалтгаан нь “олонд нүүртэй амьдрах” түүний утга учрыг олж нээхэд оршиж байгаа юм. Ангаа өвгөний насан туршийн гол зарчим төдийгүй монгол хүний амьдралын суурь үзэл баримтлал бол энэ мөн гэсэн зохиолчийн шууд баталгаа ч тодорхой болж байна.

Гэтэл цаана нь өөр бас том шалтгаан байна. **“Төрийн нуруу төвшин хүн явж дээ гэснээ “энэ малд ч мөн нүдтэй сэн..” гэж бахархангуй дуу алдан түрэв⁸**” гэсэн байна. Төрийн нуруу төвшин явах гэдэг нь монгол хүний амьдрахын том учир шалтгаан төдийгүй ТӨР БА ТҮМЭН хэмээх нэгдмэл ойлголтыг ч зохиолч орхигдуулсангүй. Нөгөө талдаа төрийн нуруу төвшин явах малд нүдтэй байх хоёр нь бараг л ижил зиндааны ухаан болж ойлгогдоно. Нүүдэлчдийн амьдралд, суурин иргэдийн зарчмуудын ДУГААРЛАЛТУУД огт тохирдоггүй нь жишээ юм. Төрөх, үхэхийн шалтгаанууд ч мөргөлдөнө. Хайрлал хүндлэл ч ялгаагүй. Огт өөр шалтгаанаас нөхцөлдөн гарсан харилцааны хэлбэрүүд тэднээс биднийг ялгаж байдаг. Судлаачийн анхлан томъёолсноор **“ШҮТЭН ЗАХИРАГДАХ ЁС”** буюу нүүдэлчдийн амьдралын тулгуур зарчмаар авч үзвэл Төгөө, Самбаа хэмээх хоёр өвгөний насаар ялимгүй ах Ангаа өвгөнд хандаж байгаа уламжлалт хандлага, ёс зүй, учир шалтгаан хачирхал төрүүлмээр санагдана. **“Шүтэн барилдах ёсыг тууштай баримтлан...хүмүүс дор дороо өөр өөрийн... харилцан бие бие нөхцөлдүүлсэн үүргийг...”** хүлээдэг тэр л суурь ойлголтуудаар өвгөдийн хоорондын сонин ХАРИЛЦАА-ны шалтгааныг тайлбарлаж болно. Ангаа

6 Мөн дээрх

7 27 дугаар хуудас, Ү.Нямдорж “Соёлын философи, Монголын соёл” 1994 он

8 С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012 он

9 91 дүгээр хуудас, Н.Хавх “Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан” 1995 он

өвгөнийг Төгөө бага залуугаас шүтэн, түүнийг үлгэрлэн захирагдах ч олон талаар өөрийнхөө л амьдралаар амьдарч буйг зохиолч илэрхийлсэн. Зохиолын амьд хийгээд сүнслэг шалтгаан энд нуугдаж байна.

Баримтаар бол Ангаа өвгөний дүрийг их ойрхоноос босгожээ. Ердөө зохиолчийн аав байжээ. **“Дал хүрсэн болов уу гэмээр өвгөн. Тэгсэн хэр нь сая хөдөөнөөс ирэхийнхээ өмнө дөрвөн эмнэг тэмээ сургалаа гэж юман чинээ санахгүй өгүүлж суусан сан”¹⁰** гэсэн зохиолчийн аав Сормууниршийн талаар мэдээлэл байна. Тэгвэл “Бууж мордох хорвоо” үгүүлэгт Ангаа өвгөнийг **“Дал хүрч байхдаа л эмнэг тэмээ сургаад явж байсан юм шүү”¹¹** хэмээх ганц үгүүлбэр буй. Мэдээж тэр цагт дал хүрсэн өвгөд эмнэг тэмээ бүгдээрээ сургадаг байсан нь ховор ҮЗЭГДЭЛ болоод л энэ хоёр / С.Дашдооров, Д.Батбаяр / говийн хүмүүс их онцлон бичээд байгаа юм шүү дээ? Тэгэхээр ямар нэгэн учир холбогдол нь шалтгаандаа байна. Ангаа өвгөний эх дүр Сормуунирш байх шалтгаан, байхгүйгээсээ бараг бараг 100 дахин магадлалтай юм.

6. Шалтгааны хурдасгуур

Биднийхээр үгүүлэгийн “шигтгээ” хэсэг баян Садын зэлэн дээр өрнөнө. Онолын хүрээнд зохиолын зарим хавсарга шинжтэй хэсгүүдийг ХУРДАСГУУР” гэж томъёолох тохиолдол бий. Тэгвэл “Бууж мордох хорвоо” үгүүлэгийн гол хурдасгуур хэсэг нь Хангай, /Ангаа/ баян Садынд давхин ирнэ. Төгөө хань татаж баярлана. Нэг шалтгаан. Гэтэл **“Төгөөгийн бадарч байсан баярын гал унтрах шиг, хор шарын утаа цээжинд уугин баагих шиг болжээ”¹²**. Бас дахиад нэг шалтгаан. Хор шар нь хөдөлнө. Харин удалгүй **“Төгөөгийн нөгөө бухимдал пурхийн арилж, Хангайд тэрхэн зуур жигтэйхэн их баярлажээ”¹³**. Өөр нэг шалтгаан. Тэрхэн зуур жигтэйхэн их баярлаж байна. Баярлахын шалтгаан. Тэгвэл дараагийн хэсэгт **“Төгөө ч бүр баярлаж гүйцэв”¹⁴**. гэжээ. Баярлаж гүйцэхийн шалтгаан. “Баярлаж гүйцэх” ерөөсөө хүний сэтгэлийн хязгаарыг тултал нь илэрхийлсэн үгсийн хоршил мэт санагддаг. Хэрэв анзаарсан бол энэ хэдхэн үгүүлбэрт Төгөөгийн сэтгэлийн ямар олон шалтгаан, ямар хурдан өрнөж байгааг мэдэж болно. Үүнийг л хурдасгуур гэж тодорхойлдог. Тэгвэл ийм хурдасгуурууд “Бууж мордох хорвоо” үгүүлэгийн үйлийн хүрээг илэрхийлэх гол шалтгаан болж байна.

1033 дугаар хуудас, Д.Батбаяр “Монголын өгүүллэг туужийн дээжис-III” 2015 он

11 С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012 он

12 С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012 он

13 Мөн дээрх

14 Мөн дээрх

Энэ тухай судлаач “...өгүүллэгийн амин сүнс “Баян Садын зэлэн дээр” тогтож байгаа юм¹⁵” гэж тодорхойлсон нь дэндүү гэнэн, ил цагаан ажиглалт юм. Угтаа зохиолын гол хэсэг нь илүү бодлогошрохын шалтгаан зохиолын өөр хэсэгт бий. “Хүн өтөлнө гэдэг мөн муухай юм, аа... Унааныхаа нуруунд муу зовлогоо гаргаж чадахаа ч больдог байна шүү... Ингээд унаа унах буян хийсээд өгдөг юм байна¹⁶” гэжээ. Бод доо, монгол хүн л ингэж гансарна. Унаа унах буян хийслээ гэж. Энд л “Бууж мордох хорвоо” үгүүллэгийн олон шалтгааны амин сүнс оршиж байна. Орчин үеийн хандлагаар уран сайхны бичвэр гэдэг үйл явдлын сүлжилдээн бараг биш харин сэтгэлгээний урсгал хэлбэрээр бичигдэнэ гэж үздэг. Төгөө өвгөн овоон дээр бөртөлзсөөр холдон одох морьтой хүний араас хараад бодно. Хэдийнээ болж өнгөрсөн үйл явдлаас зохиол эхэлж байна. Нэг, хоёр, гурав гэх тоон дэс дарааллын эрэмбээр бол нэгдүгээрт байж болох ҮЙЛ, гуравдугаарт эрэмблэгдэж, бүр хоёрдугаарт байж болох ҮЙЛ-ийн дараагаас эхэлж байна. Сонирхолтой нь зохиолын өгүүлэмж хэсгүүд нэг, хоёр, гурав гэсэн өсөх дараалалаар биш учир шалтгаан бүхий тодорхой тэмдэгтүүдээр холбогдоно.

7. Шалтгаан ба тэмдэгт

Үгүүллэгийн билигдэл бүхий зохиомжит хэсэгт “...гарт өртсөн жижиг сажиг чулуу хэд гурваар нь түүн нойтон алган дотроо өнхрүүлэн эрих мэт нэг нэгээр нь имрэн сэлгэсэнээ ганц ганцаар нь эрхий хурууныхаа хумсан дээр гарган нясалж саатав¹⁷” гэсэн нь Төгөөгийн сэтгэлд өрнөж буй хямралыг ЧУЛУУГААР тэмдэгжүүлжээ. Нэг үгээр жижиг чулуунууд Төгөөгийн тархин доторх бодлууд юм. Бодлуудаа нэг нэгээр нь нясалж гүн санаашралд автаад байгааг харуулжээ. ЧУЛУУ ба БОДЛУУД хэмээх семиотикууд зохиолчийн уран бүтээлд нэг бус удаа илэрсэн байна.

1978 онд хэвлэгдсэн шилмэл шүлгийн “Тал бид хоёр/1978/ түүвэрт багтсан “Ерөөл” гэдэг шүлэгт

Талын хүний заншлаар өндөр газар бараадаж

Товцог жаахан толгой дээр жолоо татан буув...

Тохьтой хүний заншлаар чулуу хэдийг шүүрч

Тоорцгийн чинээ овоонд нь ёс гүйцэтгэн шидэв¹⁸ гэжээ. 1967 онд бичсэн энэ шүлгийн хөнгөн ч гэмээр санаа, 1986 онд бичсэн “Бууж мордох хорвоо” 15 88 дугаар хуудас, Д.Төрбаг” Сормууниршийн Дашдооров” ХХ зууны Монгол зохиолчид-30,2004 он

16С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012 он

17С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012 он

18С.Дашдооров” Тал бид хоёр” 1978

үгүүллэгт ЧУЛУУ ба БОДЛУУД тэмдэгтүүдээр яаж гүнзгийрсэнийг харж болно. 19 жилийн дараа чулуу ба бодол хэмээх тэмдэгтүүдийн илэрхийллийн ТЭЭШ хэрхэн хүндэрснийг ч ажиглаж болно. Дээрх харьцуулсан ажиглалт зохиолчийн оюун сэтгэлгээний өсөлт, амьдрал ба эх сурвалжийг илүү судлан сурвалжилж байсны тодорхой баримт баталгаа юм.

8. Шалтгаан ба сэтгэл

Хүмүүний сэтгэл гэдэг уран зохиолд хамаг шалтгааны эх юм. Уран сайхны дүр ч олон талаараа зөвхөн СЭТГЭЛ гэдэг хэмжигдэхүүнд багтах тал байна. Сэтгэл үнэхээр хүний дотоод орон зайн гол хэмжүүр, хэмжигдэхүүн мөн. Гэвч тусдаа бие даасан бус бодол санаа, мэдэрхүй, үйл үйлдлийн цогц харьцангуй түгээмэл учир шалтгааныг хамруулан үзэж болох мэт.

Бурханы шашинд 184 муу сэтгэл буй хэмээжээ. Дорны мэргэд дахиад хүний муу сэтгэлийн шалтгааныг тоолж гаргасан ажээ. Тэр 184 муу сэтгэлээс хамаг өвчин үүднэ гэж үздэг. Хамаг муу өвчний үүдэл хамаг муу сэтгэлийн шалтгаан болно. Муу шалтгаанаас муу үйл шалтгаалан, эцэстээ муу үр боловсорно. Нарийндаа хамаг зүйл сэтгэл дотор л байгаа юм. Гаднах дүр бол яах вэ. Үзэгдэх төдий зүйл. Сав хайрцаг төдий эд.

Тэгвэл Төгөө өвгөний дүрийн гаднах төрх, 60 орчим настай, тамхи татаж суух, хөдөөх хэлхэгэр халхагар нас хэвийсэн өтөл эрийн байдал. Нийтийн төсөөлөл ч ийм. Шалтгаан нь түгээмэл үнэн, түгээмэл учир зүй гэж буй. Энэ тухай алдарт Э.Гомбрих **”түгээмэл үнэн, учир зүй гээч нь үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн анги давхарга ялгалгүй бүх хүнийг нэгтгэх учиртай”¹⁹** гэсэн байдаг. Нууцхан залбирчихдаг, малд хайртай, олон үе дамжсан малчин гээд монгол өвгөдийн нийтлэг дүр байдлыг дүрслэх нэг хэрэг. Тэр нь Э.Гомбрихийн үзснээр хүмүүсийг нэгтгэж буй түгээмэл чанар. Харин “Бууж мордох хорвоо” үгүүллэгт Төгөө өвгөний хэзээ ч давтагдашгүй дотоод өгөгдлүүдийн шалтгааныг зохиолч илүү сонирхолтойгоор дүрсэлсэн байна.

Дүрийн сэтгэлзүйн хэв шинжүүд бодол санаагаар дамжихаас гадна тодорхой шалтгаант үйлдлүүдээр давхар илэрдэг. Санаж сэдсэн сайн ҮЙЛ нь бүтэх эсэхэд эргэлзсэн Төгөө өвгөний дотоод сэтгэлийг **“...гэнэт сэтгэл нь тавгүйрхэн хямарч, зүрх нь гунигтай цохилох шиг болов”²⁰** гэж “сэтгэл тавгүйрэх, зүрх гунигтай болох” шалтгаанд хүргээд талийгаачийг хөдөөлүүлэх замд хонио бэлчээж, цагаан сэтгэлээ дэвсэх ХҮСЭЛ биелэхгүй

19 222 дугаар хуудас, Э.Гомбрих “Дэлхийн бяцхан түүх” 2015 он
20 С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012 он

болов уу гэсэн ЭМЗЭГЛЭЛ-тэй холбосон байна. Төгөө өвгөний дүрийн нандин тал нь энэ юм. Өвгөний сэтгэл амьд, үйл ариун гэдгийг зохиолч “..хэн хэлж өгсөн бэ гэж бодоход уйдаж цөхөөгүй нутгийн настан буурал, түшиж тулж явсан мэт санаанд нь цалхийн буухуй зүрх сэтгэл нь уяран байв²¹” хэмээн илүү тодорхой үгүүлсэн байна. Тийм нандин СЭТГЭЛ өөрийн төлөө зовних бус өрөөл бусдын сэтгэлийн сайн сайханд санаа зовниж “...хамаг бодсон санасан нь бут нуран унаж байх вий гэж бодохоос зүрх нь пал пал түгшүүртэй цохилж эхэлжээ²²” гэснээр илэрч байна. Ариусал нигүүслийн үзэл санаа нэвт шингэсэн, амьдын хорвоогийн олон шалтгааныг нээсэн ”Бууж мордох хорвоо” үгүүллэг чухамдаа ”..ном олсон эс олсон, бясалгал буй үгүй, судас сайн муу, түйтгэр их бага, тэр нигүүдийн ялгамжаар зарим нь өнө удаан орших буй. Зарим нь нэгэн атга гурил идэхийн төдийд орших ч буй²³” гэсэнтэй адил ХҮН бүрийн сэтгэлийн дотор тодорхой цагийг эзлэн байна. Зарим нь утга санааны цаад шалтгааныг үл ухах, тийм хүмүүст энэхүү зохиол “атга гурил идэхийн төдий” зугаа. Гэтэл зарим хүмүүст нэгэн насны магадгүй хэдэн төрлийн БЯСАЛГАЛ байхыг таашгүй.

9. Бодох шалтгаан

Ийм л үнэт чанар герменевтик арга зүй нь үүднээс ”уран сайхны зохиол хэдий чинээ олон тайлбар үүсгэнэ. Төдий чинээ сайн бүтээл” байх магадлал өндөр. Тэгвэл “Бууж мордох хорвоо” үгүүллэг зарим судлаачдын дүгнэсээр зүгээр нэг ирэх буцахын тухай бус харин ч ирэх буцах учир шалтгааны тухай зохиогчийн БОДОЛ САНААНЫ ЦОГЦ ХЭЛЭМЖ юм.

Ингэхэд Төгөө өвгөн юу боддог вэ? Өнгөрсөн хийгээд улирагч он жилүүдийг дурсан бодно. Шалтгаан нь өнгөрсөнд оршигч дурсамж хүний амьдралын чухаг нандин зүйл юм. Монголчууд амьдын хорвоо гэдэг. Эсрэгцлээр үхэгсдийн хорвоо гэж бас байна. Ангаа өөр ХОРВООД оччихсон ч амьдын хорвоотой холбоотой хэвээр байна. Тэр холбоог дурсамж гэнэ. Дон Кихот тээрмийн зүг довтолдог шиг, үгүй бол Фаустын айдас шиг тийм өнгөрсөн цагаас Төгөө өвгөн, Ангаагийн амьд сэрүүн үеийн агшнуудыг сэргээн босгож байна. Ангаа өвгөний дүр одоо зөвхөн өнгөрсөн хэмээгч цаг хугацаанд үлджээ. Өнгөрөгч цаг хугацааг нэхэн санахад харуусал төрөх нь элбэг. Харуусал үгүй бол баяр бахдал бас үгүй. Өнгөрсөн үгүй одоогийн бодол эргэцүүлэл үгүй. “Төгөө ийнхүү өнгөрснийг дурсаж бодож “Би чинь тэгээд өнөө өөртөө амласандаа хүрч, Ангаагаа баярлуулж гялайлгасан

21 Мөн дээрх

22 Мөн дээрх

23 176 дугаар хуудас, “Дагина Мажиг лавдонмаагийн намтар” 2015 он

билүү?” гэж бодов²⁴” гэжээ. Өнгөрсөнийг эргэцүүлэн бодоод сайн сайхныг бүтээх САНААШРАЛД өвгөн автана. Шалтгаан нь **“...хүний амьдрал, нас намтарт үндэст өвс ногоо мэт урган дэлгэрч гандан гундаж, мөнх бусын салхин хүрдэнд автан нисдэг орчлонгийн жам ёсыг уяран бодсоор явлаа²⁵**хэмээн эгээрэхэд оршиж байгаа юм. Өвс ногоо мэт ургаад хатаж хагдрах хүний амьдралын тухай санаашрал нь Төгөө өвгөний БЯСАЛГАГЧ шинжийг бидэнд нээж байна. Пабло Пикассогоос нэгэн уран зураг сонирхогч “Таны зурсан бухын толгой улаан байгаа нь Европт фашизм цуст толгойгоо өндийлгөлөө гэсэн санааг дүрсэлсэн дээ, тийм, ээ” гэхэд тэрээр “Үгүй, ээ би зүгээр бухын улаан толгой зурсан юм” гэж хариулсан гэдэг. Түүн шиг “Бууж мордох хорвоо” үгүүллэг ямар нэгэн далд нууцлаг, хоёрдмол, давхар санаа агуулаагүй, амьдралын өдөр хоногуудад орших энгийн үнэн, жам ёс, учир шалтгаан, яруу сайхныг БЯСАЛГАГЧ хүний дүрийг, монгол ахуй амьдрал, гоо сайхны сэтгэлгээний өнгө дэвсгэр дээр зурагласан нь энэ үгүүллэгийн чухам монгол хэлт уран зохиолын чухал туурвил гэж үзэхэд аргагүй хүргэж байгаа юм. Энэ үгүүллэгийн талаарх олон дүгнэлтүүдээс онцолж зохиолч Г.Аюурзаны **“Үнэхээр сайхан өгүүллэг, жинхэнэ монгол философи шүү. Монголын утга зохиолд ийм бүтээл цөөхөн. Сайн өгүүллэг бичсэн гурав дөрөвхөн зохиолч монголд байдгийн нэг Дооров гуай гэж би боддог²⁶**” /Г.Аюурзана” Утга зохиолын тухай яриа” 2005, 14/ гэснийг сонгож авав. Шалтгаан нь “жинхэнэ монгол философи” гэсэн гуравхан үгэнд л байна.

10. Баярлах шалтгаан

Ирэх болоод буцагсдыг сайн угтаж, сайнаар үдэхийн шалтгааныг таниваас хайр уучлал хоёр зүрхэнд цэцэг шиг дэлгэрнэ. Тэр цагт хүний дотор ариусал үүсч **“...бодож олсон санаандаа сэтгэл ханан царай тавиран баясжээ”** гэдэг шиг БАЯР БАХДАЛ ертөнцийг дүүргэнэ. Зохиолын туйлын санаа энэ. Шалтгаан нь жамыг мэдвээс жаргал үргэлж сэтгэлд ирнэ. Энэ үнэхээр монгол философи мөн билээ. Алив бүгдэд эхлэл бий. Бас төгсгөл ч бий. Харин зохиолчийн тэмдэглэснээр” гол нь зөв эхлэл. Эхлэх л хэцүү гэнэ”.

“Би аль ч зохиолоо эхлэх гэж их зовдог. Нэн ялангуяа эхний нэг өгүүлбэр, цаашилвал эхний бүлэг, хэсгийг бичих гэж махаа иддэг. Миний бодоход үргэлжилсэн үгийн зохиолд эхний өгүүлбэр, бүлэг, яруу найрагт бол эхний мөр бадгаас л дараагийн зүйл, хэм хэмнэлээ буюу амь

24С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012 он

25С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012 он

26С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012 он

орон амьсгалж, амьдарч эхлэх шиг санагддаг юм²⁷ гэжээ. Харин “Бууж мордох хорвоо” үгүүллэгийг ажиглахад төгсгөл нь илүү хүнд байжээ. **“Төгөө хониныхоо барааг харж санаа амарсан мэт шүүрсэн алдаж дотор цайн баясжээ”**²⁸ гэсэн “ЦАЙРАХ” мэдрэмжээс баясал төрнө. Хэн нэгэн танил дотно хүнээ “явуулчихаад” ихэвчлэн сэтгэл санаа гунигладаг. Олон зохиолд холдон одсон хэн нэгнийхээ араас гансран санадаг. Тэгвэл “Бууж мордох хорвоо”-д дотор сэтгэл нь “цайн баясаад” байгаа юм. Бүх зүйл эсрэгээрээ. Зохиолчийн маш том ухаарал, түүний шалтгаан. Уншигч БИ-гийн зүгээс ирэх интроверт сэтгэцийн хэв шинжүүд дахин нэг хананд тулна. Тэр нь **“Өвгөний замд хонь мал байлгая гэж бодсон минь онох нь онож. Хэн намайг тийн хичээснийг мэдэв гэж. Мэдээд ч яах билээ. Бас мэдүүлээд ч яах билээ....”**²⁹ гэх Төгөө өвгөний бодол. Одооны бид нар энэ мэт сайн ҮЙЛ хийвэл цээжээ дэлдээд үүгээр түүгээр ярьж, их дуугаар орилоод давхина. Хүний чанар мөс ямар болсныг зохиолч Төгөө өвгөний уужуу бодлуудаар дамжуулан хэлэх гэсний шалтгаан. Эхлэлээс татаж төгсгөө. Учир шалтгаангүй зүйл ертөнцөд хаа ч үгүй. Төрөхийн шалтгаанаас үхэхийн шалтгаан эхэлнэ. Буухын шалтгаанаас мордохын шалтгаан эхэлнэ.

Хэдий “Бууж мордох хорвоо” үгүүллэгт дорны мэргэдийн тоолсноор найман түм, дөрвөн мянган ШАЛТГААН байхгүй ч хүн байхын 10 учир шалтгаан байна. Төгсгөлд нь нэгэн шүлэг сэтгэлд байсныг дэлгэе. Шүлэг ч бас шалтгаан.

Засах үгүй зүг шулуун бүтээснээр

Залхуу үгүй үл хаагдах тангараг болно.

Завсардах үйлсийг тэвчих увдисаар

Заяат ухаан номын агаар болон алдарлаа³⁰ хэмээснээр заяат ухаан бүхэн номын агаар болж огоот их сансар хийгээд хүний хорвоог бүрхэх болно.

27.93 дугаар хуудас, С.Дашдооров” Өндөр ээжийг хэрхэн бичив”, Бурхадын сархад” 2009

28С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012 он

29 Мөн дээрх

30336 дугаар хуудас, Мяларайвын саран мэт шавь Райчүн Дорждагвын намтар” 2015 он

СОРМУУНИРШИЙН ДАШДООРОВЫН “ХҮЛЭГ” НАЙРАГЛАЛЫН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ МИНЬ

МЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч Товуугийн Доржсүрэн

С.Дашдооров хэмээх агуу зохиолч, яруу найрагчийн уран бүтээлд задлан шинжилгээ хийх хэмжээний хүн би биш боловч түүний тухай хэдэн үг хэлэх учир шалтгаан надад бий. Тиймийн учир би энэ жижиг бичвэрийг чадан ядан тэрлэлээ.

1982 онд С.Дашдооров ах Сэлэнгэ аймагт очсон юм. Тэр их хүнтэй Сэлэнгэ нутгийнхаа тэнгэр дор танилцаж, “Сэлэнгэ” зочид буудалд түүний “Хүлэг” найраглалаас уншиж өгөхөд ихэд баярлан намайг үнсэж билээ. Бид Дооров ахыг хүндэтгэн Усан замаар аялуулж, Орхон-Сэлэнгэ мөрнийг усан онгоцоор өгсөж, уруудуулан, бас жижигхэн хэмжээний хүндэтгэл болгон Сэлэнгэ мөрний эрэг дээр задгай галд мах шарж, хоол хийж, уран бүтээлийн халуун яриа өрнүүлсэн юм.

Тэр үеийн бидний аялалын маршрутад усан онгоцоор аялуулах явдал заавал ордог байсан учир ингэж явсан хэрэг. Усан онгоцыг өөрийн юм шиг хэрэглэдгийн учир шалтгаан нь Сэлэнгэ аймаг дахь Усан замын тээврийн захиргааны ерөнхий нягтлан бодогчоор зохиолч Гомбын Цэрэндорж гуай ажилладаг байсантай холбоотой. Г.Цэрэндорж ах тэр үед “Урин цагийн эхээр” тууж, өгүүллэгийн номоо хэвлүүлсэн зохиолч байлаа. Дооров ахтай усан замаар аялж явахдаа би өөрийн бичсэн адууны тухай шүлгээсээ уншихад:

-Болж байна, болж байна хүү минь. Чамд ах нь туслана аа. Хэдэн шүлэг ахдаа өгөөд явуул хэмээн урмын үг өгч билээ. Би тэр үед Сэлэнгэ аймгийн Залуу зохиолчдын нэгдлийн гишүүн, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот дахь Мод боловсруулах комбинатын Доод склад цехийн бригадын дарга байлаа.

Дооров багш намайг тоож шүлгээ өгч явуул гэсэнд урамшиж, байгаа хэдэн шүлгээсээ шилэн шилэн байж “Уулын айл”, “Янгир” зэрэг хэдэн шүлэг Дооров ахад өгч явуулсныг “Утга зохиол урлаг” сонинд удалгүй хэвлүүлсэн нь миний урмыг үнэхээр тэтгэж шүлэг бичих дур хүслийг минь бадрааж өгсөн юм. Тэр үед залуу зохиолч хүн “Утга зохиол урлаг” сонинд шүлгээ гаргана гэдэг ном гаргасны дайтай баяр дагуулж ирдэг байсан цаг. Тийм өндөр шалгууртай байж дээ. Анх уулзахад Дооров ах:

-Би чинь ажлын гараагаа Сэлэнгэ аймгаас эхэлсэн хүн шүү дээ. Намайг Багшийн сургууль төгсөөд Сэлэнгэ аймгийн Зүүнхараа САА-д багшлахаар ирж байхад Зүүнхараад ёстой ажил ундарсан цаг байсан юм. Хүмүүс барилга бариад л, тариа, ногоо тариад л, социалист хөдөлмөрийн хөдөлгөөн ид өрнөөд л бужигнаж байлаа...хэмээн хуучилсан. Тэгэхээр Дооров ах Сэлэнгэ аймагтай амьдрал, уран бүтээлээрээ холбоотой хүмүүсийн нэг юм. Дооров ахын Сэлэнгэ аймагт ажилласан жилүүд 1955-1958 он юм билээ. Энэ онуудад Дооров ах Зүүнхараад багшилж байж. Арван есхөн настай ирсэн гэдэг. Надаас:

-Чи хэдэн настай байхдаа Сэлэнгэд ирсэн бэ гэж асуугаад 18 настай ирсэн гэхэд:

-Яг над шиг юм. Сэлэнгэ өгөөжтэй нутаг шүү. Миний уран бүтээлийн ундарга нь Сэлэнгэ нутгаас эхтэй гэж хэлж байв.

1985 онд Дархан хотод олон улсын зохиолчдын уулзалт болж түүнд Сэлэнгэ аймгаас Н.Сүхдорж бид хоёрыг МЗЭ-ийн албан ёсны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оруулж Дарханд ирэх даалгаврыг Д.Цэдэв дарга өгснөөр тэр том уулзалтад ирж билээ. Тэр үед би Сэлэнгэ аймгийн намын хороонд ажиллаж байлаа. Улаанбаатараас ирсэн зохиолчид дотор С.Дашдооров ах ирсэн байв. Дархан хотын “Дархан” зочид буудалд Ц.Дамдинсүрэн, С.Удвал, Д.Мягмар, Д.Пүрэвдорж тэргүүтэй томчуудаас эхлээд Ж.Лхагва, Х.Сампилдэндэв, Л.Чойжилсүрэн, Ш.Дулмаа, Д.Тарва тэргүүтэй нэр нөлөө нь улс даяар алдаршсан зохиолчид, түүнээс доош бид мэтийн цөөхөн залуучууд буудаллаж хэд хоносонсон. ЗХУ-ын төрийн шагналт яруу найрагч Егорь Исаев, Болгарын нэрт зохиолч Х.Чернев гээд нэртэй томчууд гадаадаас ирсэн байсан юм. Тэр уулзалтаас буцахдаа Дооров ах “Дархан” зочид буудалд надад нэгэн морины цомбон туурай бэлэглээд:

-За Доржсүрэн чи Дооров ах шигээ адуунд хайртай, адууны тухай бичдэг хүн. Олон сайхан бүтээл хийгээрэй гэсэн юм. Тэр их урмыг би зүгээр орхихгүй гэж “Үүлэн борлог” тууж, “Хүлгийн зоон дээр би Монгол” найраглал, “Нийлэх зам” өгүүллэг гээд олон бүтээлээ адууны тухай хийж 2009 онд “Үүлэн борлог” номоо дан адууны тухай бүтээлүүдээрээ гаргасан минь Дооров ахын надад хайрласан хишиг байсан юм. Энэ утгаараа Дооров ах намайг уран зохиолын ертөнцөд хөл тавихад том нөлөө үзүүлсэн багш минь байсан гэж би бодож явдаг юм.

Дооров ахын надад дурсгасан цомбон туурай яг 30 жил миний номын сан, бичгийн ширээн дээр хүндэтгэлтэйгээр байрлаж байна. Өглөө бүхэн энэ туурайгаа харах бүр би Дооров ахыгаа заавал дурсдаг юм.

Сормууниршийн Дашдооров “Говийн өндөр” роман, “Өндөр ээж” кино тууж, “Хүлэг” найраглал, “Хойтон жилийн наадам” шүлэг гээд дурдахад л уран зохиолын бүх төрлийг хамарсан, бүх төрлөөр ард түмний зүрх сэтгэлд хүрсэн бүтээлүүд туурвин үлдээснээрээ бусад зохиолчдоос ялгарах онцлогтой. С.Эрдэнэ, С.Дашдооров хоёрын зохиолоор Ж.Бунтар, Г.Жигжидсүрэн нарын найруулсан “Эх бүрдийн домог” кино 1975 онд Карловы-Варын олон улсын наадмаас тэргүүн байрын шагнал хүртсэн нь Монголын кино дэлхийн тавцангаас шагнал авсан анхных гэж бодоход тэр ямархан зохиолч байсныг нь харуулдаг.

“Өндөр ээж” шиг хүн бүхний зүрх сэтгэлд хүрсэн дүр бас үгүй. .

Миний хувьд адууны тухай өгүүлсэн учир “Хүлэг” найраглалынх нь талаар өөрийн бодсон бодлоо өгүүлэхийг зорилоо.

1. “Хүлэг” найраглал монгол моринд босгосон уран зохиолын агуу том хөшөө
2. “Хүлэг” найраглал монгол хүн, монгол морь хоёрын амьд шүтэлцээний дуулал
3. “Хүлэг” найраглал Монголын их говь, говийн хүн, хүлэг морь гурвын хоорондын салшгүй холбоосны дууль
4. “Хүлэг” найраглал анхны хайрын гэгээн дурсамж дагуулсан зөөлөн анир
5. “Хүлэг” найраглал монгол яруу найрагчаас өөр хэн ч ингэж бичиж чадахааргүй уран чадвар, дүр дүрслэлийг агуулсан бүтээл

1. *Моринд босгосон хөшөө болохын учир*

“Хүлэг” найраглалд сонгож авсан хүлэг нь маш омголон, ороо морийг сонгосон нь монгол морины эзнээ гэсэн сэтгэлийг тодотгох нэг том жишээ болсон. Маш номхон, унааширсан хүлэг морь байсан бол эзнээсээ хол явахгүйг нь хэн ч мэдэх юм. Энэ дүрээрээ монгол морь омголон догшин ч гэсэн эзгүй хээр эзнээ хаядаггүй хөл унаа юм шүү гэсэн санааг өгүүлсэн. Дээр нь монгол морь гэдэг хүн шигээ ухаантай адгуус болохыг энэ дүрээрээ нотолж үлдээсэн.

Хүлэг сайн морины тухай өгүүлсэн бүтээл монголын зохиолч, яруу найрагчдын уран бүтээлд хамгийн их байдаг ч “Хүлэг” найраглалд өгүүлсэн шиг үйл явдлаар нь зураглаж бүтээсэн томоохон бүтээл, тэр дундаа шүлгээр илэрхийлж үлдээсэн дүр дүрслэлийн өндөр мэдрэмж, үйл явдалтай найраглал

их ховор гэж хэлмээр санагдана.

Энэ бүтээл бол монгол моринд босгосон хөшөө юм гэж хэлэхэд хэн ч үгүйсгэхгүй байх. Зохиолч энэ найраглалдаа хүн чанарын тухай хүлэг морьтой зүйрлэж өгүүлсэн хэсэг бас бий. Ээрэм талд эзнээ хаяад явчихдаггүй ороо хүлэг байхад энэ амьдралд нөхрөө хаяад зулардаг тийм хүмүүс бишгүй байгааг бас ёгтолж хэлсэн мөртүүд байна.

Адууны бэлчээрт ижилдсэн
Анд зарим нөхдийнхөө аашийг бодоод
Хээрлэг морио нэг дурсах юм
Аймгийнхаа хязгаарт танилцсан
Аавын зарим үрсийн мөсийг бодоод
Хүлгийнхээ тухай бодолд автах юм
Хээр хөдөө унагасан ч
Хаяж орхиод явчихаагүй
Хээрлэг моринд минь ч
Тэд хайртай болгосоор байна
Хэл яриа мэдэхгүй ч
Хээр хаяад явчихаагүй
Хээрлэг мориндоо би

Улам хайртай болсоор байна даа... гэснээр харагддаг. Амьдралд хэл мэдэхгүй адгуусны араншингаас долоон дор найз нөхөд байна шүү гэж тэр харамсан өгүүлсэн байна.

Шил цагаан хээрлэг бол монгол морь бүхэнд зориулж босгосон мөнхийн хөшөө юм гэж хэлж болно. Уран зохиолын дүр болон мөнхөрсөн энэ хүлэг морь үеийн үед хүлэг морьтойгоо байсан монгол хүний зориг, хайр энэрэл, хүсэл тэмүүллийн илэрхийлэл болон үлдсэн гэж болно. Шил цагаан хээрлэг бол бодит дүр. Эрдэнэвангийн Буган халиун, Өвөрхангайн Аравгар хээр, Хэнтийн Гуулин хээр, Мянгадын Чонон саарал, өнөө цагийн Хэнтийн Сүрэнхорын хар, Хөвсгөлийн Нийгмийн хонгор, Амгалан төрийн Ажнай шарга морьд шиг бодит дүр. Монгол хүний зүрх сэтгэлд оршдог хүлэг бүхэн амьд хөшөө юм шүү гэдгийг Шил цагаан хээрлэгийн дүр харуулдаг. Ер нь Шил цагаан хээрлэгт зориулсан хөшөө их говьд босговол мөн ч их юм өгүүлнэ дээ гэж санагддаг. Бүүр зэрэглээ наадсан хээр босговол шүү.

2. *Монгол хүн, монгол морь хоёрын амьд толь болсны учир*

Эзгүй зэлүүд хээр, тэгээд ангамал говьд, зэрэглээнээс өөр юу ч үл харагдах тэр их талд эзнээ булгиж шидсэн ямарч адуу гөлмөө дэрвүүлэн үргээд арилна гэж хэнч бодно. Тэгээд унаашраагүй, ороо, омголон хүлэг шүү дээ. Гэтэл морь, хүн хоёр энэ их талд хоёулхнаа нэг нэгэндээ хань болж явааг, хэн хэндээ уусан ойртож байгааг, үргэж шидсэн хүлэг морь хоёрхон гүвээ даваад эзнээ хүлээн зогсож байгааг, хүлэг мориноосоо салсан хүн ямархан ааш араншинтай байхыг, юу юу бодохыг гээд олон үйл явдлуудыг зураглан бичиж үлдээсэн байдаг. Жишээ нь:

Гэнэт л морь маань

Бусгав бололтой

Гэснээ бас булгив бололтой

Гэнэгүй явсан би

Учир зүйгээ ч олсонгүй

Дөрөө алдан, унав бололтой

Дөрвөн туурай тачигнан

Тоос шороо нүүр булав

Дөрөөн таваг гялалзан

Найман ганзага сарвалзан холдов...гэсэн бол тэрхэн хооронд хүлэг морио хүртэл харааж элдэв бодол бодож байгааг дүрслэн зурахдаа:

Хэзээ нэгэн цагт

Гартаа оруулж авбал чамайг

Хэдрэг болтол нь уная гэж занав

Хонжоо ашиг горилсон

Хөгшин морины наймаачинд

Зарья ч гэж нэг бодов

Холын нутагт хэсэж

Олны гар дамжиж

Зовог, цаашаа...гэж бодов... гэснээр илрэхийлэгдэж байна. Харин хүлэг сайн морь эзнээ хаядаггүй болох тухайд:

Бохирч унатлаа гүйж яваа

Бараагий минь хараад өрөвдсөн юм байлгүй

Хүлэг минь, дороо байзнаан тогтосхийв

Боогдож тагларсан юм шиг дуугарч байгаа

Дуугий минь дуулаад хайрласан юм байлгүй

Хээрлэг маань, биеэ тавин зогсосхийв...гэж өгүүлээд унаа мориндоо хаягдсан хүн ямархан байхыг нүдэнд үзэгдтэл зурсан байдаг. Хүлэг морио барьж авсны дараах байдлаа:

Уулын хярын орой барьж

Уургын морь хэдийг ч сэлгэж

Ороолж цойлдог зангий нь бодоод,

Уужим талд суларснаа анзаарч

Унаган ижлээ тэмцэн тэмүүлж

Орхиод арилаагүй ачий нь бодоод,

Хээрлэг морио барьсандаа

Хэнхдэг цээжээ тэнийтэл

Амьсгаа авч газарт унав

Хээр талд унагасан ч

Хэзээ ч чамайгаа мартахагүй гэж

Хээрлэгээ харж баахан уйлав...гэснээр илэрхийлсэн байна. Энэ найраглалд хүлэг эзэн хоёр хоорондоо зүрх сэтгэлээрээ холбоотой болох, ер нь монгол морь, монгол хүн хоёрын мөнхийн шүтэлцээний тухай, бие биенийгээ ойлгож байгааг илэрхийлсэн энгийнээс ихэд шилжиж илэрхийлсэн мөртүүд байгааг олзуурхан анзаарч байна. Тухайлбал:

..Өршөөж хайрла намайгаа гэх шиг

Усгал нүдээ буруулан байж

Хавирга сүвээ рүү духаараа нудрахад нь

Өөрөө би буруугүй гэх шиг

Эрдэнэт тэргүүнээ гудайн байж

Өвдөг хормой үнэртэн налахад нь

Өөтэй газрын хэлтгийд автаж

Өөрөө би ойчсон байлгүй гэж

Шанаа юугий нь маажин хэлэв

Өдрийн халуунд нойрмоглож яваад

Өөрөө би унасан байлгүй гэж

Хүзүү юугий нь таалан илбэв...гэснээр харагдана. Ер нь “Хүлэг”

найраглалыг уншихад тууж уншиж байгаа юм шиг мэдрэмж төрдөг. Дүр дүрслэл, үйл явдал нь тэгэж мэдрэгддэг.

Мориноосоо уначихаад харааж зүхэж холын наймаачинд өгч сум хошуу дамжуулан зовоох юм шүү гэж явсан хүү хүлэг морио барьчихаад өөрийн бодож явсан буруу үйлдэлдээ гэмшин харамсаж:

Уужим жолоогоо хумьсхийж

Олом жирмээ чангалж байхдаа

Үсний нь сорыг хугалчих вий гэж бодов

Уран толгойгий нь хантайрч

Дөрөө шүүрэн мордохдоо

Цогцос биеийг нь өвтгөчих вий гэж бодов

Хаа хүрэх вэ хүргээд өгье гэх шиг

Хазаар даран тэмүүлэхэд нь

Амгай жавьжаа халаачих вий гэж хайрлав

Хайрга чулуу үсчүүлэн

Харгуйн тоосыг босгоход нь

Хархан туураа халсалчих вий гэж хайрлав...гэж өгүүлснээр илэрхийлэгдэж байна.

“Хүлэг” найраглал бол амьдралын алсад хөл тавьж байгаа залуучуудад хандсан ухаарлын сургамжаар дүүрэн зохиол юм. Залуу халуун насан дээрээ хол явж газар үзэж, ухаан сууж алсыг зорьж байхыг хэлсэн ухаарлын мөртүүдээр баян. Ер нь бүхнийг хайрлаж энэрч явах ухаантай байхыг хүлэг эзэн хоёрын үйл явдлаар харуулсан ч амьдралд хандах хандлагыг сургамжилснаар нь харж болно. Тухайлбал:

...Таанын толгой шиг ангаж явахад чинь

Ташуу санаж цангаагагүй байгаа гэж

Эргэж нэг санав

Талын зээр шиг хурдалж явахад чинь

Ташуур чамдаа далайгаагүй байгаа гэж

Эрэгцүүлж нэг санав...

Уулын толгой ширтэн явбал

Ухаан санаа саруул байдаг юм гэж

Айлын өвгөнөөс дуулснаа санаад

Уужим талдаа дуулж явбал

Унасан морь чинь сэргэж байдаг юм гэж

Аавын амнаас сонссоноо санаад...уртын дуугаа цээл сайхан хоолойгоор дуулахад нь Шил цагаан хээрлэг нь сэргэж тэмүүлж байгаагаар харагдана. Шил цагаан хээрлэг бол хэдэн өдөржин уургач морь сэлгээд баригддаггүй омголон, ороо хүлэг. Тийм атал их талд эзнээ хаялгүй баригдаад ийнхүү дэргэж байгаа дүр нь нүдэнд үзэгдэж, аргагүй л монгол морь мөн дөө гэх бахархал, омогшлыг зүрх сэтгэл рүү асган нүдний нулимс цийлэлзүүлдэг тийм дүр юм.

3. *Говь, хүн, хүлэг гурвын холбоос болохын учир*

С.Дашдооров “Хүлэг” найраглалаа 1967 оны 12-р сараас 1968 оны 01-р сарын хооронд бичсэн байна. Энэ үед С.Дашдооров Москва хотноо М.Горькийн нэрэмжит Утга зохиолын дээд сургуульд элсэн суралцаж байсан үе. Харийн нутагт эх нутаг, их тал, хүлэг сайн морио үгүйлж суугаа монгол эрийн дүрийг:

Нарны нь илчийг биедээ шингээсэн

Намуун талын тэртээ рүү

Санаа бодлоо алднам

Найрын нь дууг цээжиндээ нандигнасан

Намаржаа дэнжийн гэрүүд рүү

Салхин хүлгээр айлчилнам...гэж хаа холын нутгаас эх нутгаа үгүйлсэн сэтгэлээ илэрхийлжээ. Харин хүлэг сайн морио их хотын долоон давхар байшинд үгүйлэн санаж суугаагаа:

Ургах нарны түрүүчийн гэгээг

Таанын шүүстэй амтлан цавчилсан

Унаган хээрлэг морио дурсав

Унах нарны сүүлчийн туяаг

Талын тоостой сүлэн цацалсан

Шил-цагаан хээрлэгээ санав...гэж өгүүлжээ. Ингэснээр харийн нутгаас хүлэг сайн морио зүрх сэтгэлдээ нандигнан яваагаа илэрхийлсэн төдийгүй Шил цагаан хээрлэгийн гадаад дүр төрхийг, говийн өглөө, оройн өнгийг давхар илэрхийлсэн байна. Мөн говийг үгээр зурсан гэгээн мөртүүд их бий. Жишээ нь:

Жин үд талд налайж,

Хамаг байгаль халуурхан дүнсийж,
Хавийн юм бүрэлзэн тунарна
Жишим хэлэхийн аргагүй
Зуны нар зулай голлож
Зоо мөр цоргиж шарна... гэж говийн өдрийн халууныг зурагласан бол
Өргөн тал...
Өвс ногоо, өнөө л зэрэглээ...
Өндөр нам болон наадна
Өлөн бүргэд
Тээр дээр эргэлдэнэ
Хажууд голио царцаа гаслана...хэмээн энэ ээрэм говьд амьдрал үргэлжилж
байгааг зурсан байдаг.

Говь нутагт ус, бэлчээр хомсдож амьдралын тэмцэл болж байсан холын он цагийг:

Ургах унах нарны хооронд
Хүүхэд ихэсгүй усан дээр
Ховоо татан өнждөг болов
Ус ундаа эрдэнэ болж
Хүн мал, худаг дээр
Тоос босгон багширдаг болов
Хавийн бэлчээр тарчиг
Адуу мал ч тогтохгүй

Долоон гүвээ даван одно...гэж нүдэнд харагдтал өгүүлжээ. Энэ мөрүүдээс их говийн тарчигхан хаврын хөхөлзсөн салхи, өнгө гандсан халцгай улаан тал, малын хөлөөр багширсан тоос шороо, худаг усан дээр зогссоор хөх хар болж аяншиж ядарсан хөх эрчүүд, бүсгүйчүүдийн дүр зураг сэтгэлд ургана. Ийм нэг хахирган хавар цагаар төрсөн унага түүний насан туршийн агуу хүлэг морь болоод баяр баярын дээдийг авчирсаныг:

Аймаг сумын баяр наадамд очихдоо мөнгөн эмээл, суман ташуураар
Гоодьё гэж боддоггүй явлаа
Ахан дүүсийн амрыг эрэн айлчлахдаа
Торгон дээл, дурдан бүсээр
Гоёоё гэж санадаггүй байлаа

Зээрийн сүрэг шиг зүс нь жигдхэн
Аавын буян сүргээ хурааж
Шил цагаан хээрлэгээ л барьдаг байлаа
Хээрийн тахь шиг жавхаа бадарсан
Агт хүлгийн сүрий нь дарж

Шил цагаан хээрлэгээрээ гоёдог байлаа...гэснээр харагдана. Шил цагаан хээрлэг бол хээрийн тахь шиг жавхаа бадарсан агт олон сүргийн сүрийг дарах тийм сайхан хүлэг гэдгийг дээр уран яруу өгүүлжээ.

“Хүлэг” найраглалд монгол ахуйн дүр төрх их содон туссан байдаг. Шил цагаан хээрээ барихаар уургач бор морьтойгоо хэрхэн явж байгаагаа:

Дайрав
Адуу тал тал тийшээ
Асгасан шагай шиг бутран бужигнав
Давирав
Угийн сурамгай уургын борлог ч

Уурсан бар шиг уулгалан довтлов...гэсэн бий. Энэ хэдэн мөртөөс монгол хүн морь уургалахаар адуу руу зүсэн орж байгааг тодоос тод харж болно. Энэ уургач, уургын морь, уургалуулах гээд ухасхийж байгаа морь гурвын тухай:

Түймрийн гал гэмээр тоосон дунд
Шил цагаан сүүл хатган урагшилж
Түвшин талын гүн рүү цойлон зугтав
Түлсэн галын элч гэмээр амьсгаа юугаа цацаж
Усан борлог улам улайран эрчилж

Уургын толгой хондлойд нь дөхүүлэн аваачив... гэснээр харагдана. Энэ хэсгээс одоохон уурганы хуйв морины толгойд орох нь дээ гэсэн бодол өөрийн эрхгүй төрүүлдэг. Уургын борлог Шил цагаан хээрлэгийг даган эргэж байгаа, уургач хүү уургаа хэрхэн шидэж байгаа дүр дүрслэл сэтгэл тод харагддаг. Ийм дүрслэлүүд нь жинхэнэ монгол зураглал гэж хэлмээр байна.

Ийм л сайхан хүлэг морьтойдоо бахархаж их талтайгаа амь нэгдэн гурвуул нэгэн цул болж амьдрал үргэлжилж байгааг Дооров энэ найраглалдаа тод томруун тусгасан байна. Тиймийн учир “Хүлэг” найраглал говь, хүн, хүлэг гурвын мөнхийн холбоос болж монгол ахуйг зурж үлдээсэн байна. Үүний тайлал нь эрэлд олон хоног яваад өөрийн тэмээгээ олж ирж чадаагүй ч, өөр айлын алдсан тэмээг олоод, дээр нь нутаг усаа гэх элгэмсүү сайхан сэтгэл

тээж ирснээ:

Саруул талын үзэсгэлэнг
Салхины нь үнэртэй хамт
Өвөртөлж би ирсэн юм
Саахалтын хэдэн тэмээг
Сарангийнхаа тухай бодолтой
Туусар би ирсэн юм гэснээр илэрхийлэгдэнэ.

4. *Анхны хайрын дуулал болохын учир*

“Хүлэг” найраглалд Саран хэмээх бүсгүйн дүр гардаг. Энэ дүр бол найраглалыг чимж өгсөн, амь оруулсан, хүний сэтгэл зүрхэнд ойр болгосон хэсэг нь. Говийн хүү говьдоо уусаж, говьдоо хайр дурлалтай учирч, алс хэтийнхээ тухай говиосоо эхэлж алс уужмыг төсөөлдөгийг энэ хэсгээс харж болно. Мөн говь нутаг гоо үзэсгэлэн төгс сайхан бүсгүйчүүд, охид бий гэдгийг Сарангийн дүр харуулдаг. Хээр хөдөө ганцаар явахад зүрх сэтгэлд нь хань болж мөрөөдөл, бодлын үзүүрт ирж байгаа Сарангийн дүр бол их говьд ургаж байгаа залуу насны гэрэл гэгээ, говь амилж амьдрал үргэлжлэхийн утгыг илэрхийлсэн дүр болсон юм.

Ургахын нарнаар Сарантайгаа
Зэлнийхээ адууг уралдан хурааж
Хэн хоцорсныгоо шоолно гэж бодном
Унахын нарнаар түүнтэйгээ бас
Саахныхаа хургыг гүүргийлэн ялгаж
Хэн хэндээ хамжилцана гэж бодно...
Найраар баян намар
Гүүн зэлээ хурааж
Гүвээн цаана нуугдахуй
Манайх, тэднийх талаас нүүж
Адуу малаа тууварлан
Ачаа хөсөг холдохуй
Хоёр биесээ эргэн эргэн харалцаж
Хонгорхон зүрхэндээ дүүрэн гунигтай
Холдож ядан сална гэж бодном

Хойтон зун бас уулзаж

Хос зүрхэндээ дүүрэн баяртай

Хоногийн олонд цэнгэнэ гэж бодном...гэсэн нь малчин хүүгийн хайр сэтгэлийн илэрхийлэл бөгөөд говийн хүн, говийн айлын амьдралын зураг нүдэнд харагддаг.

5. Монгол яруу найрагчийн уран чадварын дүр дүрслэл болохын учир

Нарны нь илчийг биедээ шингээсэн

Намуун талын тэртээ рүү...

Найрын нь дууг цээжиндээ нандигнасан

Намаржаа дэнжийн гэрүүд рүү...санаа алдан нутгаа санаж байгаа,

Ургах нарны түрүүчийн гэгээг

Таанын шүүстэй амтлан цавчилсан...

Унах нарны сүүлчийн туяаг

Талын тоостой сүлэн цацалсан...ийм сайхан хүлэг морьтойгоо,

Зээрийн сүрэг шиг зүс нь жигдхэн...

Хээрийн тахь шиг жавхаа бадарсан...адуун сүрэгтэйгээ,

Хуурын хөвч сулдаа уянгалам

Хулсан лимбэ аяндаа эгшиглэм...салхи татан хатирдаг

Хуурай мөчир хугалж хаямгүй

Хултай айраг цалгиаж асгамгүй...сайхан алхалдаг хөл унаатайгаа С.Дашдооров дүрслэн өгүүлсэн байна. Энэ бүхэн бол монгол яруу найргийн дүр дүрслэлийн уран чадварын илэрхийлэл, монгол ахуйтай холбон дүрээ босгож илэрхийлсэн зохиолчийн монгол ухааны цар хэмжээг харуулсан гэж ойлгож болмоор байна.

С.Дашдооров “Хүлэг” найраглалаа монгол морь, монгол хүн, монгол ахуй, монгол говийн дуулал болгон үлдээжээ. Он цаг улиран одовч ийм агуу бүтээл улам өнгө орж, өнөө цагийн ороо бусгаа үеийн аясыг гэрэл гэгээгээр чимж, хожмын үр хүүхдүүд удмын монгол ахуйдаа уусаж амьдрах сэтгэлийн орон зай нь цэлмэн гийхэд нь туслах гэрэл болох бүтээл яах аргагүй мөн гэж хэлж болно.

Уншихад ойлгомжтой, энгийнээ энгийн, уран яруудаа яруу тансаг болсноороо энэ найраглалд орших үг бүхний үнэ цэнэ их юм. Өгүүлж байгаа амьдралыг өөрөө туулж, биеэр амсаж мэдэрсэн хүний үг гэдгийг уншсан хэн ч амархан олж мэдэх тийм мэдрэмжийг энэ бүтээл төрүүлж чадна.

С.Дашдооров хэмээх их хүн, уран зохиолын давтагдашгүй ертөнц бурхан болоод хорь шахам жил болж байгаа ч түүний бүтээлүүдэд байгаа дүр бүхэн мөнх залуу хэвээрээ ажээ. Үүнийг тавиад жилийн тэртээ бичсэн “Хүлэг” найраглал батлана.

Тэмээний эрэлд явж байгаа залуу хүүгийн дүрээр говь нутгаа, хүлэг морио, монгол ахуйгаа, хайр сэтгэлээ, хүн чанараа гэсэн их олон зүйлийг багтааж зурсан энэ найраглалын эцсийн санаа нь “Хүлэг морь эзнээ хаядаггүй” гэсэн өвгөдийн үгийг баталж дүрээ гаргаснаас гадна хүн чанараа хадгалж бусаддаа үнэнч явдаг нь хүний амьдралд хэдсэн билээ гэсэн том санааг хэлснээрээ онцлогтой. Хүлэг мориноосоо дутуу ухаантай хүн ч бас байгаа шүү гэсэн санааг хэлсэн нь ухааралыг хэнд ч төрүүлнэ. Бас говь нутаг ийм шүү, говийн малчин хүний ахуй амьдрал энэ шүү гэдгийг зурж үлдээсэн ховорхон зохиол. Бас 1960-аад оны сүүлчийн нийгмийн амьдралын тухай өгүүлсэн нь тод харагддаг. Ингэж л бодож байна даа.

Агуу С.Дашдооровын “Хүлэг” найраглал миний ч амьдрал, уран бүтээлд том нөлөө үзүүлж чадсаныг эцэст өгүүлэхийг хүсэж байна. Одоо ч би “Хүлэг” найраглалыг дахин дахин уншиж суух дуртай. Ингэж суухад говийн таанын үнэр ханхийж, говийн наран зоо нурууруу шарах шиг болдог. Тэртээд зэрэглээн дунд атан тэмээдийн торолзох нь, босон суун дэрвэлзэх толгодын элдэвлэх нь, айсуу холоос наашлах хүлэг морьтны бараа бүдгэрэн тодрон байх нь, сэрвэлзэх талын дундах цагаан гэрийн гадаа саравчлан зогсох Саран бүсгүйн бор царай үзэгдэх нь, малын хөлийн тоос угалзран худаг руу цувж яваа мал сүрэг гэлдрэх нь, нар салхинд онгож аяншсан хүдэр бор эрчүүд, эршүүд бүсгүйчүүдийн царайд хөлс дааварлах нь харагдаж, унших бүр цоо шинэ зохиол уншиж байгаа юм шиг санагдуулдаг. Гоёчлон өнгөөр будаагүй ийм л энгийн атлаа үнэн, ухаарал тээсэн бүтээл одоо ч үгүйлэгдэж байна уу гэж өөрийн эрхгүй санагддаг даа.

“СЭРГЭЛЭН БАГАЧУУД” СЭТГЭЛД ХОНОГШИХЫН УЧИР

Д.Нацагдоржийн шагналт хүүхдийн зохиолч О.Сундуй

Төрийн шагналт, Ардын уран зохиолч С.Дашдооров бол яруу найраг, хүүрнэл зохиолоороо Монголын шинэ үеийн уран зохиолын хоймор заларсан уран үгсийн суу билигтнүүдийн нэгэн. Үүнийг ард түмнийхээ сэтгэл зүрхэнд хоногшсон “Говийн өндөр” роман, “Монгол” найраглал тэргүүт олон арван бүтээлүүд, шүүмж судлаачдын үнэлэлт дүгнэлт гэрчлэх билээ.

Харин энэ авьяас билигт хүмүүнийг их утга зохиолын замд хөтөлж уншигчдынх нь өмнө нүүр хагалсан анхны бүтээлүүд болох хүүхдэд зориулсан номуудынх нь талаар нь дурдан өгүүлсэн нь ховор ажээ. Тэрбээр 1956 онд хүүхдэд зориулсан өгүүллэг “Сэргэлэн багачууд” номоороо уран бүтээлийн анхны шангаа татаж зохиолч байхын баяр хөөрийг амталсан байдаг. Түүнлүгээ адил Л.Түдэв “Сайн байцгаана уу? Хүүхдүүдээ”, Д.Пүрэвдорж “Бяцхан аялал”, Ч.Лхамсүрэн “Эрийн сайн эрэлхэг Болдбаатар”, Д.Намдаг “Алим”, Д.Мягмар “Тугтай чарга”, Ц.Уламбаяр “Багачууд”, Ж.Лхагва “Саарал даага”, Д.Цэнджав “Дэгдээхий”.... гээд үе үеийн аваргууд уран зохиолд хүүхдэд зориулсан анхны номоороо орж ирснийг дурдвал бас ч сонирхолтой судлууштай зүйл мөн шүү. Үүний шалтгаан нь хувь уран бүтээлчийн онцлог гэхээсээ илүүтэй анхлан бичигч залуу хүний хувьд хүүхэд насны дурсамжаасаа хараахан холдож амжаагүй үе байдагтай холбоотой болов уу хэмээн таамаглаж байна.

Гэтэл С.Дашдооров зохиолчийн хувьд “Шинэ сурагч” (шүлгүүд) 1957 он, ”Алтан хараацай” (үлгэр найраглал) 1960 он, “Боролзой хөвүүн” (үлгэр найраглал) 1963 он, ”Өнчин цагаан ботго” (үлгэр найраглал) 1963 он, ”Уулсын өнгө” (тууж) 1968 он, ”Дайны жилийн алим буюу сургуулийн зээрд” (найраглал) 1976 он... зэрэг шил даран гарсан олон номоо бяцхан уншигчид, өсвөр насныханд зориулсан нь яавч тохиолдлын зүйл биш юм. Эдгээр бүтээлүүдээс 1971,1981 оны “Хүүхдийн уран зохиолын дээжис”-т ч мөн хэвлэгдсэн байна. Дээрх бүтээлүүд нь С.Дашдооров бол хүүхдийн уран зохиолын хөгжилд амсуурга төдий бус арвин бүтээл туурвилаа зориулсан уран бүтээлч мөнийг илэрхийлж байгаа юм.

Тийм ч учраас бүтээл нь хүүхдийн уран зохиол судлаачдын анхаарлын гадна байсангүй. Хүүхдийн уран зохиол судлаач, шинжлэх ухааны доктор

Д.Оюунбадрах “Хүүхдийн уран зохиол” бүтээлдээ “Хүүхдийн уран зохиолд... далаад оны эхэн үед яригдаж байсан хэтэрхий сүржин аяс бүрэн арилж үйл явдал, сэтгэл санааг урнаар өгүүлэх болсон байна” гээд С.Дашдооровын “Дайны жилийн алим буюу сургуулийн зээрд” найраглалыг жишээлэн дурджээ.

Мөн утга зохиол судлаач Д.Өлзийбаяр “Хүүхдийн зохиолын тухай бодол” номдоо дунд ахлах ангийханд зориулсан бүтээл ховор байгааг дурдаад “...С.Дашдооров “Уулсын өнгө” туужийнхаа Тавхай, Чимгээ нарын дүрээр өсвөр насныхны үерхэл нөхөрлөл хайр сэтгэлийн нарийн нандиныг нээн үзүүлсэн” хэмээн олзуурхан өгүүлжээ.

С.Дашдооров зохиолчийн хүүхдэд зориулсан эдгээр бүтээлүүд нь төрөл зүйлийн хувьд шүлэг, найраглалын хэлбэр зонхилсон байгаа юм. Энэ нь жар далаад оны хүүхдийн уран зохиолд тууж, найраглалын төрөл давамгайлан хөгжиж байсан онцлогийн илрэл төдийгүй найраглалын төрлийнх нь гол төлөөлөгч болохыг харуулж байгаа юм. Хэвлэгдсэн номын тоогоор бус хэлсэн санаа, бүтээсэн дүр, дүрслэлийн цар хүрээгээр уран зохиолд эзлэх байр суурь нь хэмжигддэг учраас түүний хүүхдэд зориулсан зохиолын төрөл зүйлийн тухай яриагаа түр цэглэж уншаад төрсөн сэтгэгдэлээ хуваалцъя.

Утга зохиол судлаач, шинжлэх ухааны доктор Д.Оюунбадрах “Хүүхдийн уран зохиолын дүрийн онцлог” бүтээлдээ “...Уншигчид нь хүүхдүүд юм болохоор тэд зохиолынхоо дүрийн дийлэнх хувийг эзэлж болох ч томчууд, амьтан, ургамал, эд юмс зэргээс эхлээд зохиомол, хиймэл маягийн дүр ч хүүхдийн уран зохиолын баатар болж болдог”... гэжээ. **Тэгвэл С.Дашдооров зохиолчийн эдгээр бүтээлүүдийн хамгийн гол дүрүүд нь хүүхэд өөрөө юм.** Түүний анхны ном “Сэргэлэн багачууд” өгүүллэгийн гол баатар Балбар, Наран хоёр арваад насны тэрсхэн жаалууд. Наран өндөр, туранхай, булчин, шөрмөслөг байхад насаар нэг дүү Балбар нь намхан булцгар шар хүү. Ардын үлгэрт дүрслэгддэг Шовгор, Хавтгар хоёр шиг хөгжилтэй дүр төрх. Тэд эрхэлж наадаж яваад богцтой юм олно. Богцноос чихэр, боов гарч ирнэ гэж бодсон хүүхдүүд их хэмжээний мөнгө байхад цочирдон айж байна. Энэ бол яах аргагүй хүүхдийн нийтлэг дүр төрх. Гэвч энэ жаалууд нэг хэвэнд цугтасан мэт хэв шинжит дүрүүд огт биш. Балдан “Би энэ мөнгийг түрүүлж олсон. Аавдаа өгнө” гэж байхад Наран “Хариуцлагатай хүнд өгсөн дээр” гэсэн санаа гаргаж байна. Зохиогч хэнийх нь зөв болохыг уншигч хүүхдүүдийнхээ бодол санаанд орхиод цааш үйл явдлаа өрнүүлээ.

Тэд явсаар тавь орчим насны хууз хар сахалтай ширүүн төрхтэй завьчинд очиж “Биднийг гол гаргаж өгөөч” гэж гуйна. Цааргалахад нь мөнгө олсон

тухайгаа үнэнээр нь хэлнэ. Мөнгөний бараанаар завьчны араншин хувирч тэднийг саатуулах арга хайна. Чухам эндээс л манай уншигчдын цааш нь унших хорхой гозолзож байгаа юм даа. Хүүхдийн зохиолын нэг онцлог нь одоо яадаг бол гэсэн хурц үйл явдлаар уншигчаа дагуулан хөтлөх явдал байдаг. Завьчны “Маргааш эрт гол гаргаж өгнө” гэсэн зальхай үгэнд итгэсэн хүүхдүүд хоолноос нь идчихээд олсон мөнгөө эзэнд өгч баатарлаг гавьяа байгуулахаар шийдэн унтахаар хэвтэж байна. Хүүхдийн ариун сайхан сэтгэл гэдэг энэ. Зохиогчийн дүрсэлсэнээр хот руу гэтэх чоно мэт богцтой мөнгө рүү санаархагч завьчны сарны гэрэлд тодрох зэвүүн төрх, сэргэг байж аюулаас мултарсан Нарангийн овсгоо самбаа уншигчдыг догдуулж байгаа нь гарцаагүй. Шөнө дөлөөр завьчны гараас мултарч голыг сэлэн гаталж байгаа хүүхдүүд. Хөвөөнд нь хүрч чадалгүй живсэн Балбарыгаа авраад уйлж суугаа Наран. Мөнгийг өөрийн болгоно гэж бодож явсан Балбарын ичингүйрэл. Энэ бүхэн одоо ч гэсэн манай хүүхэд багачуудад нэн сургамжтэй билээ. Адал явдлаар дамжуулан хүртээж байгаа агуулгын ач холбогдол нь хүүхдийн уран зохиолд аль цаг үед шинэ байдаг юм. Учир нь хүүхдийн уран зохиол уншигчаа хүмүүжил үүргээ гээх ёсгүй.

С.Дашдооров зохиолчийн удаах ном нь 1957 онд хэвлэгдсэн “Шинэ сурагч” шүлгийн ном юм. Зохиогч маань 1955 онд Багшийн сургуулиа төгсөөд Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн бага сургуульд багшилсан байдаг. Оюутан ахуйдаа улс төрийн хичээл дээр шүлэг бичсэн хэргээр хөөгдөх шахан донгодуулж байсан залуу багшийн энэ ном нь анхны шавь нарынх нь гэгээн бодол, хүсэл мөрөөдлөөс төрсөн нь илэрхий. Багшилж байхдаа галт тэрэгнээс буудал дутуу бууж улсын даалгавараар авч яваа шуудай мөнгөө үүрээд жин өвлөөр 24 км алхаж сумандаа хүрсэн тухайгаа дурссан байдаг. “Сэргэлэн багачууд” зохиолоо бичих үүдэл санаа ч мөн энд төрсөн байх магадгүй ээ.

“Шинэ сурагч” номынх гол баатар мөн л сургуулийн босго алхаад удаагүй байгаа хүүхдүүд, тэдний хүсэл тэмүүлэл нь билээ. “Ангийн ширээ” шүлэгт:

Гэрэл гэгээтэй анги минь

Тэнгис шиг санагдах юм.

Гэтэл суудаг ширээ минь

Онгоц шиг л санагдах юм... гээд эрдмийн далайд аялагч хөлгийн дарвуул нь сурагчийн давтлага, хичээл зүтгэл хэмээн дүрсэлжээ. Хүүхэд үүхэд ялгаагүй хөдөлмөр зүтгэл л бидний дарцаглан намирах дарвуул минь шүү дээ. “Хичээлийн дэвтэр”-т гэхэд л

Хичээлийн дэвтрийн шулуун шугам нь

Хэтдээ туулах амьдралын шугам

Энэ шугаман дээр яаж бичнэ.

Ирээдүй бас түүнээс хамаарна гэсэн санааг илэрхийлсэн бол “Иш, үзэг” шүлэгтээ хэн хэндээ түшигтэй явахад л нөхөрлөлийн үнэ цэнэ байдаг хэмээх санааг дам өгүүлжээ. Энэчлэн тухайн цаг үеийнхээ уриа лоозон, хоосон тоочилтоос ангид уран санаачлга, ур хийцтэй шүлгүүдээр уг ном бүтсэн байна.

“Шинэ сурагч”-ийн дараа 1960-1963 оны хооронд хэвлэгдсэн “Алтан хараацай”, “Өнчин цагаан ботго”, Боролзой хүү” зэрэг ардын аман зохиолоос сэдэвлэн бичсэн шүлэг найраглалууд нь үлгэр домгийг өнөөчилж, үйл явдлаар баяжуулсан нь уншигч багачуудад ойлгомжтой, уран яруу дүр дүрслэлтэй бүтээлүүд болсон санагдана. Жишээлэхэд “Өнчин цагаан ботго” үлгэр найраглалд ингэ, ботго хоёр зугтаж байгааг:

Гулс гулс алхлан

Гурван гүвээ давав.

Дөмөн дөмөн тэшиж

Дөрвөн гүвээ давав.

Тавран тавран зугатаж

Таван гүвээ давав гэж ахиулалын аргаар үйл явдлыг нүднээ харагдтал дүрсэлсэн төдийгүй хүүхэд багачуудад алхлах, тэших, таврах гээд тэмээний явдлыг танин мэдүүлэх ач холбогдолтой байна. Эхийгээ санан тэмүүлж яваа ботгыг:

Буйлан буйлан дуулсхийгээд

Бутан толгой шүүрсхийгээд

Дэмэн дэмэн жонжисхийгээд

Дэрсэн толгой хазасхийгээд

Хонхон хоёр чихээрээ

Холын чимээ чагнан

Алаг хоёр нүдээрээ

Алсын бараа ажин... хэмээн дүрсэлсэнээрээ амрах, идэхээ умартан арга барагдан явааг уран дүрсэлжээ. Дээрх үлгэр найраглалуудаас яруу сайхан дүрслэлийн олон арван жишээг ийн дурдаж болох юм.

Харин одоо С.Дашдооров зохиолчийн хүүхдэд зориулсан томоохон

бүтээл болох ”Дайны жилийн алим буюу сургуулийн зээрд” найраглалын талаар өгүүлэе. Энэ зохиолыг би анх 1977 онд Багшийн сургуулийн сурагч байхдаа уншиж билээ. Одоо хоёр дахиа уншиж байна. 17 насандаа уншаад Ишгэн багш шиг авьяастай, юм бүхнийг зааж үлгэрлэж чаддаг, шавь нарынхаа хайрыг татсан багш болохын хүсэл мөрөөдөлд автаж байж билээ. Одоо бодоход үлгэрт итгэдэг наснаас хэтрээд уран зохиолоос үлгэрлэн дуурайх баатраа хайдаг насандаа энэ зохиолыг уншиж л дээ. Санаанд минь үлдсэн сайхан зохиолуудын нэг. Энэ найраглалын гол баатрууд нь дайны жилийн хүүхдүүд төдийгүй тэдний хайртай хүлэг сургуулийн зээрд морь юм. Уянгын “би” баатрын дурсамжийн хэлбэрээр бичсэн ч “Сэргэлэн жаалууд”-ын нэгэн адил хүүхэд баатартай зохиол юм. “Би” баатрын :

Өлзийн барааг харахгүй бол

Өр зүрх минь зөндөө уйдагдагсан

Намайг байхгүй бол бас

Найз минь зөндөө санадагсан хэмээн өгүүлсэн үй зайгүй дотнын найз нь Өлзий. Өлзий өөрийн үзэл бодол, хүсэл мөрөөдөлдөө үнэнч өвөрмөц нэгэн дүр. Хичээл номдоо гавихгүй ч хэтийн бодолдоо туйлбартай. Адуунд дэндүү гэмээр хорхойтой. Зургаахан наснаасаа даага сургаж гайхагдсан. Дайн хэрвээ болбол Дандар баатар шиг хүлэг сайн морио унаад хүчит сэлмээ эргүүлж баатар болно гэж боддог. Бодол бүхэн нь морьтой холбоотой. Дайны жилийн өвөл Ишгэн багштайгаа малчдад туслаж явахдаа хөр цасанд өөдөж унасан сарвааг хараад хамгийн түрүүнд тэвэрч өргөөд, тэнхрүүлэн авах санал гаргаж байдаг. Аливаад удаан хойрго юм шиг энэ жаал адуу гэхээр л хүний түрүүнд явж байдаг нь дээрх үйлээр илэрдэг. Зохиолч энэ тухай

Адуунд хайртай болохоороо

Өлзий уяран тэвэрсэн юм.

Ам хамрыг нь арчаад

Өвөр дэх ааруулаа өгсөн юм гэж дүрсэлжээ. Балчирхан наснаасаа хүсэл бодолдоо тууштай явсан Өлзий хожим дунд сургуулиа төгсөөд гарамгай сайн адуучин болж түүний сойсон сургуулийн зээрд даага нь хурдан хүлэг болж наадамд түрүүлж байдаг. Ийнхүү хөдөөдөө шилбүүр унаж, адуучин болно гэж өссөн хүү хүсэл мөрөөдөлдөө хүрч аз жаргалтай амьдарч байна. “Би” баатар маань найзынхаа ажил үйлсээр бахархан “Аз жаргалыг холоос хайдаггүй. Дуртай ажлаа хийж яваа хүн бүхэн жаргалтай” гэдэг санааг давхар хэлсэн юм.

Уянгын “би” баатар маань анх уншихад ч одоо ч их сонирхолтой хүсэл

мөрөөдөл дэврүүн сэтгэлээр дүүрэн хүүхэд байлаа. Багаасаа л тэр зураг зурах дуртай. Зураач болох хүсэлтэй. Эхлээд тэр уул ус, өвөлжөө, хаваржаа, аав ээж эмээ өвөөгөө зурдаг байсан бол сургуульд ороод найзуудаа, дараа нь сургууль, дайны талбарт хүргэх бэлгийн цуваа, ялалтын сүр жавхлан улаан танк зурна. Зургийн сэдэв зүгээр л нэг өөрчлөгдсөн юм бишээ. Энэ нь гол дүрийн сэтгэлгээний өсөлт хөгжилтийг харуулсан сонирхолтой арга санагдана. Зургийн санаа улам гүнзгийрч байгаа нь уран бүтээлчийн цаг үеэ мэдрэх дүрслэх агуулгын хүрээний тэлэлтийг давхар үзүүлсэн мэтээ. Хүүхэд бүхэн хүсэж мөрөөдөх тэмүүлэх дуртай. Тиймээс ч би баатар, Өлзий нарын дайсныг дарж дархан цолоо мандуулах гавьяат үйлсийн зөгнөл мөрөөдөл бяцхан уншигчдынхаа сонирхлыг аргагүй татна. Арваадхан настай “би” баатар маань дайны сүүдэр туссан тэр жилүүдийн гачигдал бэрхшээлд огтхонч авталгүй болж буй үйл явдлын гэрэл гэгээг дандаа олж харж тэмүүллээс тэмүүлэлд хөтлөгдөнө. Багачууд маань тийм л гэгээн хүсэлд автаж унших дуртай л даа. “Би” баатар маань:

Аав маань байн байн

Даавуу даалимба ховордлоо гэнэ.

Аюулт хар дайны

Гай гамшиг гэлцэнэ.

Айл саахалтынхан бас

Гурил будаа дууслаа гэнэ.

Аймшигт хар дайны

Гай гамшиг гэлцэнэ.

Багш захирал үргэлж

Дэвтэр харандаа үгүй боллоо гэнэ.

Балагт хар дайны

Гай гамшиг гэлцэнэ ... гэж эргэцүүлэн бодоод Өлзий найзтайгаа хамт дайнд явж ялалт байгуулахаар шийдэж байна. Сургуулийн бараа бүдгэрч, сумын төв алсарч үнэхээр тэд ааруул боорцгоо аваад дайнд явсан боловч ангийн охинтойгоо тааралдаж хамаг төлөвлөгөө нь нурж байна. Үе тэнгийн уншигчид нь бол үнэхээр тэдний зөв болохыг баталж баригдалгүй явсаар байгаад дайны талбарт очоосой гэж бодно. Ялимгүй жаахан томчууд нь яршиг даа гэж шоолно. Аль нь ч байсан тэдэнд хөгжилтэй хөөртэй санагдана. Хүүхдийн зохиол бол хүүхдэд тохиолдсон явдал байж байж уншигчдаа дагуулдагийн жишээ энэ. Дайнд явах мөрөөдөл нь биелээгүй жаалхүү маань

фронтод бэлэг хүргэх цуваа тэргүүлэгч галч Доог санаашрангүй харж

...Улсын чухал албанд

Ингээд нэг явахсан.

Улаан туг лоозонтой

Үдүүлж байхсан гэж ... бодно. Хүүхдийн бодлыг хачиргүй үнэн илэрхийлжээ. Үдэж зогсоо олон хүүхэд ингэж бодож байгаа.

Удалгүй сургуульд нь Ишгэн хэмээх залуу багш ирнэ. Ишгэн багш дуулна, бүжиглэнэ, хөгжимдөнө, спорт бүхэнд гарамгай. Ангийнх нь хүүхдүүдийн авьяас билиг нээгдэж хар дайны сүүдэр хаа хол одсон мэт тэдний сэтгэлд дандаа нар мандаж байлаа. “Би” баатар маань зураач болох хүслээ орхиж Ишгэн багш шигээ юм юманд авьяастай, хүүхдүүдийн хайрыг татсан багш болохоор шийдлээ. Тэгээд дуулж сурах нь зөв гээд гоцлон дуулаад эхэлтэл хүүхдүүд инээлдээд нэг л бишээ. Харин багшийнхаа цанаар гулгахыг харж бишрээд Өлзий найзтайгаа хамт модон торхны хавтас модоор цана хийлээ. Айлын торх эвдсэн гэмтэй ч хийсэн цана нь дажгүй шүү. Ийм л сониуч дэврүүн хүүхэд дээ. Уншигч маань ийм найздаа их хайртай байдаг юм шүү. Учир нь тэд хоорондоо хүсэл тэмүүлээр ихэр байдаг юм. Өдөр, сараар хүсэл мөрөөдөл нь өөрчлөгдөж байдаг энэ жаалхүүд огт хувирдаггүй хэдэн чанар бий. Юуны өмнө тэр найзыгаа хэзээ ч өөчилж голж, гомдож тунирхаж байгаагүй. Зохиолч энэ тухай нь:

Өөгүй сайн хүү гэж

Өлзий найзаа нэрлэж чадахгүй

Адайр зан нь хөдөлбөл

Амархан тайтгарна гэж үгүй

Өөрийнхөө дургүй юманд

Намайг зарах гэдэгсэн

Өвчин хууч хөдөллөө гээд

Шалтаг тоочоод суучихдагсан

Тэглээ гээд найздаа

Муу юм санаагүй

Тэр зангий нь мэддэг болохоор

Гомдож их гонсойгоогүй... гэж өгүүлсэн юм. Бас би баатар маань хичээл номоо сайн давтаж онц сайн сурдаг. Гэхдээ түүний онцлон хэлэх хамгийн нандин чанар нь үргэлж сайн сайханд тэмүүлж найз нөхдөө дандаа баярлуулж

баясгах гэсэн агуу сэтгэл юм. Энэ бол үнэхээр хүүхдэд л байдаг өгөөмөр сэтгэл гэж хэлэхэд ч хилс болохгүй. Зохиолч жаалхүүгийн энэ чанарыг нь юм бүхэн ховор дайны жилд шагналд ирсэн алимаа маш олон хэсэг хуваан хүн бүхэнд хүртээж байгаагаар харуулсан юм. Өнөө ч гэсэн би С.Дашдооров зохиолчийн дэврүүн их хүсэл тэмүүлэлтэй, өгөөмөр ариун сэтгэлтэй жаалхүүд хайртай байдаг юм. Энэ дүр уншигчийн сэтгэлд хоногшин үлдсэний шалтгаан нь зохиолчийн дүр дүрслэл уншигчдынхаа сэтгэл зүйд нийцүүлэн урласанд байдаг бизээ.

”Дайны жилийн алим буюу сургуулийн зээрд” хэмээх энэ зохиол нь бүхэлдээ нэг л сайхан хайр энэрэл, халуун дулаан сэтгэл шингэсэн бүтээл санагддаг. Энэ зохиолд холын дайны сүүдрээс өөр эсрэг гэмээр зүйл огтхон ч үгүй. Энх тунх сайхан амьдралаа өмгөөлж хамгаалахын тулд фронтод бэлэг явуулж байна. Энэ нутгийн хүмүүс бүгдээрээ үр хүүхэд хойч үеийнхээ төлөө галч Доо шиг амьдралаа зориулж байна. Холоос ирсэн залуу багш Ишгэн шавь нарынхаа төлөө бүхий л авьяас билиг, мэдлэг боловсролоо дэлгэрүүлж байна. Хүүхдүүд сургуулийн зээрдийг хайрлаж өсөхдөө энэрч хайрлахын ухаанд суралцаж сайхан хүн болон өсөн торнигчоож байна. Адуунаас хоцорсон даагаа арчилж тордож байгаа хүүхдүүдэд нь бэлэглэж байгаа жудагтай эр хүн...Ийм л нэг сайхан хүмүүс. Томчууд ямар байна үр хүүхэд ирээдүй хойч нь тийм л байна.

Төгсгөлд нь өгүүлэхэд:

-Ардын уран зохиолч С.Дашдооров нь шинэ үеийн хүүхдэд зориулсан уран зохиолд уншигчдынхаа нас сэтгэхүйн онцлогт нийцсэн “Сэргэлэн багачууд”, ”Дайны жилийн алим буюу сургуулийн зээрд” бүтээлүүдээрээ тод мөрөө үлдээсэн уран бүтээлч юм.

-“Сэргэлэн багачууд” -ын Наран, Балбар, ”Дайны жилийн алим буюу сургуулийн зээрд”-ийн Өлзий түүний найз Жаалхүү тэргүүт хүүхэд **-баатрууд** нь түүний дүр дүрслэлийн гол онцлог бөгөөд уншигчдынхаа сэтгэлд санаанд хоногших давуу тал нь мөн юм.

- Ардын уран зохиолч С.Дашдооровын хүүхдэд зориулсан зохиолууд нь шинэ цагийн уншигчдын ёс суртхууны төлөвшилд сайнаар нөлөөлөх агуулга дүр дүрслэлтэй тул тэдэнд зориулан хэвлэх нь зүйтэй.

*Талын тухай шүлгээс нь таанын үнэр анхилдаг Дашдооров
найрагчийн
Хүүхдэд зориулсан бүтээлээс нь хүүхдийн сэтгэл гэрэлтсээр л
байна.*

Ашигласан ном бүтээлийн жагсаалт:

1. С.Дашдооров “Сэргэлэн багачууд”
2. С.Дашдооров “Шинэ сурагч”
3. С.Дашдооров “Өнчин цагаан ботго”
4. С.Дашдооров “Боролзой хөвүүн”
5. С.Дашдооров “Алтан хараацай”
6. С.Дашдооров “Дайны жилийн алим буюу сургуулийн зээрд”
7. С.Дашдооров “Уулсын өнгө”
8. С.Дашдооров “МУЗД-34
9. Хүүхдийн уранзохиолын дээжис 1971 он,1981 он
10. Д.Оюунбадрах “Монголын хүүхдийн уран зохиол”1-2 дугаар дэвтэр
Д.Оюунбадрах ”Хүүхдийн уран зохиолын дүр,дүрслэл”
11. Орчин үеийн утга зохиолын товч түүх 1966 он
12. Л.Түдэв. “Бяцхан уншигчийн их утга зохиол”
13. Д.Өлзийбаяр “Хүүхдийн зохиолын тухай бодол”

2015-11-8

“ГОВИЙН ӨНДӨР” УУЛТАЙ ТАНИЛЦСАН МИНЬ

18-р сургуулийн газар зүйн багш С.Ариуннандин

1999 онд санамсаргүй тохиолдлоор нэгэн ном уншсан нь “Говийн өндөр” роман байлаа. Хамгийн түрүүнд миний анхаарлыг Дэлгэрхангай уул татлаа. Зохиолын эхний хуудсанд нэгэн жолооч тус суманд ирж байгаа бөгөөд “Холоос бараатай сайхан уул байна шүү Говийнхон л болсон хойно хайрхан буюу богд гээд яаж сүйд болдог бол доо” гэсэн өгүүлбэр нь газарзүйн ангийн оюутанд онц сонирхолтой байлаа. Би уг номын эхний бүлгийг уншиж дуусахдаа Дэлгэрхангай суманд очиж үзэх юм байна гэсэн бодолтой үлдлээ. Сургуулиа төгсөөд хэдэн жилийн дараа өнөөх сэтгэл зүрхэндээ мөнхөрсөн тэр уулыг уулга алдан бишрэн харж байлаа. Надад нутгийн ардын мэндчилгээ уул хоёр хоорондоо холбоотой юм шиг санагдаж билээ. Тал нутгийн сүрлэг тэр уулын сүрэнд дарагдах мэт аятай юу хэмээн намуухан мэндчилэх нь өнөө уулаас л сүрдэх мэт. Уулаас үүдэлтэй сонирхол минь өөрийн эрхгүй дүрийн онцлог, романы гол утга санаа руу идэвхитэй орлоо. Уг романы гол дүр Дамдин ба өнөөгийн нийгмийн гэнэн цайлган, эцэг эхийн үгээр дуурайллын учрыг олоогүй ч дагаж мөрддөг тусархаг, ажлыг чин сэтгэлээсээ хийдэг боловч хэтэрхий гэнэн байсан нь хэд хэдэн зүйлээр илэрдэг. Жишээ нь: Самбуу даргын манайд очоорой гэсэн үгэнд итгэж тууварчдаас салж хэд хоног хотоор яван олж байна. Мөн хөдөө буцаад явах уу яах вэ гэдэг асуудал тулгармагц Дандар баатрын хөөрхийг нэг юм бодооч гэсэн үгэнд уяран Самбуу ах цэргийн дарга болгочихгүй байгаа даа гэж бодож байгаа инээдтэй ч юм шиг Дамдингийн аав улсаас хичээллийн хэрэглэл үнэгүй авах өдөр сургуулийн гуанзанд хоол идэж байгааг илэрхийлж “Миний хүү засгийн хоол үнэгүй идэж байж засагтаа муу санав” гэж хэлснийг санаж байгаа мөртөө бас л учрыг сайн ойлгосонгүй.

Тусархуу шинж

Самбуу даргынхыг хайж олоогүй байхдаа гуанзанд орж хуушуур идээд дараа аяга тавгыг зөөн тусалж байгаагаар илэрхийлэгдэж байна. Мөн Жамбал арван өдрийн ажлаа сайн хийгээд Дамдинг сурвалжлагчтай уулзуулаад яг үнэнээ буюу бушуухан ажлаа дуусахад хоёр найзтайгаа тун сайхан хоол хийж идье гэж бодож байснаа хэлэх гэтэл болиулж байгаа дүрийн инээдэмтэй гэнэнг харуулсан. Гэвч Дамдин богино хугацаанд өөрчлөгдсөн. Үүнд нийгмийн байдал, хайр дурлал, бусдын нөлөө, өөрийн хичээн зүтгэл,

байдлын өөрчлөлт хотод ирээд өмссөн хувцсаа суудрээ харж засах ба хэн нэгэн өөр ч харж байгаа мэтээр биеэ авч явна.

Хайр дурлал

Хөдөө байхдаа Өлзиймаатай хамт малд явах ажил хийх дуртай байсан бол хотод ирээд Гэрэл олон зүйлээр түүнд таалагдаж эхэлсэн бөгөөд театр болон хоолны газар тааралдахдаа Гэрэлд таалагдах гэж хичээж байна. Гэрэлтэй хамт тамхи татаж байхдаа Чи надаас сэжиглээгүй биз асуусан нь “Чи надад хайртай юу” гэж асуусан үг байв. Гэрэл хаанаас даа хэмээн хариулахад “За тэгвэл чи намайг тоож байгаа бол гүйцээ Би чамд хайртай яваа шүү, өөр мянган хүүхэн хэрэггүй” гэсэн энгийн үг яриа ашигласан боловч өөрөө үүндээ маш их санаа зовж байлаа.

Бусдын нөлөө

Хороо хорины эргүүлийн хэлсэнээр хотын захиргаан дээр очихдоо баруун аймгийн Чогдов хэмээх залуутай танилцсан түүнд хамгийн сайхан зүйл байна. Дамдин хэдий бүрэг боловч өөрөө анх “Нэр хэн билээ. Нутаг хаана вэ?” гээд асуусан. Өмнө ингээд хүний алдар нэрийг лавлан асууж байсныг зохиогч өдрийн одтой зүйрлэсэн тул зоригтой үйлдэл болжээ. Түүний асуултанд Чогдов нутаг усаа хэлэн хариу Дамдингаас асуувал “Нутаг уулын ард Арын төвд” гэж хариулав. Энэ Говь-Алтай аймгийн тухай мэдэхгүй учир өөрийн нутгийн онцлогоор хариулсан хэрэг. Уулаа нэрээр хэлэх албагүй Уулын ард гэвэл нутгийнхан асуултгүй Дэлгэрхангай уул гэж мэддэг тул бардам хариулт өгсөн энэ бололтой. Чогдов Бурхан буудай уулын өвөр орчим Бигэр нуурын хөндийд төрж өссөн бүх талаараа Дамдингаас өөр гэдэг нь дараах зүйлүүдээр баталж байна. Чогдов бага сургууль төгсөөд бага сургуулын багшаар томилогдсон, уран сайханд авьяастай хэмээгдэж аймгийн клубт жүжигчнээр ажилласан. Дамдинд нутгынхаа түүх домог үзэсгэлэнт газар аргал янгирийн тухай ярьж өгнө. Өглөө бүр орос хуанли ашиглан “Өнөөдөр ийм түүхэн өдөр тэр төрсөн” гэж уншаад мэдэхгүй орос үг гарвал толь бичгээс харж мэднэ. Шинэ сониноос шүлэг хайж цээжилнэ. Мөн зохиолч яруу найрагчдын тухай судалж хэн нэгэн зохиолчдтой таарвал бөөн баяр болно. Чогдовын ил байдал Дамдинд амьд лавлах гэлтэй. Түүний уран тод уншлага цэцэн цэлмэг яриа ажилсаг шинж нутгынхандаа мангар хэмээх Дамдинг бүх талаар өөрчилж байна.

Өөрийн хичээл зүтгэл:

Дамдингийн хичээл зүтгэл нь эцэг эхийн хүмүүжлээс эхтэй. Суманд хүний оролцоо ихтэй ямар ажил байна түүнд оролцоно. Тухайлбал ачаа ачиж, машины ачаа буулгах сумын уран сайханчдын тоглолтын ажилд сайн дураараа тусалж л байна. Нутгын ард Цогзолын адуу малд нь явж тусалцана. Сумын хүн эмнэлэг дээгүүр очиж тэнд өдрийг өнгөрөөж сувилагч Цэвэлмаа бүсгүйд ус авчрах, заг хагалах, хог арилгалцах элдэв ажилд туслан байгаадаа өөрөө баяртай байгаагаа Цэвэлмааг өөртөө хайртай, дуртайн тэмдэг гэж ойлгох ч угтаа бол тийм биш. Дамдин аймагт болсон урлагийн тоглолтонд ажиллахдаа ч урилга үзүүлсэн хүнийг “Энэ чинь манай билет биш” хэмээн уурсан боловч улаан булангийн эрхлэгч сөөнгө эрд загнуулан тушаал буусан боловч тоглолтын үед хөшиг хаах, гэр цэвэрлэх ажилд томилогдсон ч мөн л чин сэтгэлээсээ хийсээр байв. Барилгын тоосго зөөх анхны өдрөө ажил дууссаны дараа бие халаад ид ажилламаар болох үед дууслаа хэмээн харамсаж байгаа ажилсаг зан чанарын илрэл. Хотод Самбуу даргынхыг хайж явахдаа түлээчинтэй тааралдан айлын түлээ хөрөөдөж байгаа нь түүний ямар ч үед ямар ч ажил хийхэд бэлэн байгааг харуулж байна. Говийн хүн тул мод, түлээний ажилд дөргүй ч ямар ч үед ажлын эвийн аргыг олж байна. Мал туун хотод орж ирэхдээ замдаа туусан малдаа өөриймсөг хандахаас гадна малаа зарсаны дараа өөрийн мал шиг харамсаж байдаг нь тухайн хүний аливаад чин сэтгэлээсээ хандаж чаддагийг харуулсан.

Самбуу даргын амьдарч байхдаа түлээ ус, хоол ундын ажилд тусалж тэдний анхаарлыг өөрийн эрхгүй татаж чаддаг нь тухайн нийгмийн бүтээн байгуулалт, улс эх орныхоо хөнжилд өөрийн хувь нэмрээ оруулан нэр төртэй ажилласны үр дүнд Намын эх хуралд баяр хүргэх нийслэлийн ажилчин залуучуудтай Улсын төв театрт очиж байгаад Данжуур даргатай таарсан боловч өөрөө анзаарсангүй. Данжуур дарга Дамдинг Тэргүүний залуустай намын эх хуралд баяр хүргээд гялалзаж явдаг нь овоо л байгаагийн тэмдэг яамай даа гэж сүрхий тоосон боловч дуудах гэтэл “Должингийн мангар” гэдэг нэр орж ирээд болсонгүй бөгөөд тэр нэрээр өнөөдөр Дамдинг дуудах зохисгүй болжээ гэдгийг ойлгосон байх аа. Жамбал аравны барилгачдынхны ажил үйлсийн тухай тухайн үеийн мэдээллийг хамгийн том хэрэгсэл радиогоор ярьсан боловч өөрөө сонсоогүй жолооч Тогоогоор яриулах гэсэн боловч цаадах нь санаанд хүртэл яриагүйд урам нь жаахан хугарав. Гэвч тэдний тухай ярихад Дэлгэрхангай сумын Улаанбулангийн арын тасалгаа, сумын контор, намын даргын гэрт байдаг хүлээн авагч ажиллаж байсан болов уу? Миний нэрийг гаргахад уугуул ус, суугуул нутгийн Дамдингаа

гэж таних болов уу? гэж бодож байсан нь аливаа хүний сэтгэлийн уг чандад уугуул сайхан нутаг ус, төрж өссөн орон гэр нь ямагт байдгийг, хүн өдөр тутмын амьдралдаа нутаг усаа ярихгүй санахгүй мэт байгаа боловч тэсэлгүй их уйтгар гунигтай үедээ хэнээс ч юунаас ч эмээлгүй нутаг усаа, эцэг эхээ санан дурсах нь хүмүүний нэгэн сэтгэл билээ. Энэ Дамдин нь олон зүйлээр өөрчлөгдсөн нь тухайн нийгмийн миний мэдэхгүй үеийн нийгмийн том хувьсгал болжээ.

Бидний мэдэхгүй тэр нийгмийн амьдралыг уг романы үйл явц бидэнд танилцуулах бөгөөд нэгдэл байгуулж буй үеийн хүмүүсийг сэтгэл, сэтгэлгээ, ажил амьдралын орчин зэргийг би сонсох, харах, мэдрэх боломжгүй тул уг романаас өөрийн хүлээн авч чадах хэмжээгээр авсан учир зохиогч хойч үедээ өгвөл зохих зүйлсээ зохиолоороо дамжуулан өгсөн болой.

Уулаас эхлэлтэй унших хүсэл минь

Уужуу тайван сэтгэлтэй, урт холын амьдралын замтай Дамдин хэмээх дүртэй танилцуулж инээх баярлах, хайрлах дурлах, уйтгарлах гуниглахыг нь бүхэл бүтэн романы туршид цаашид яах бол гэсэн сонирхлыг улам төрүүлж байсан бөгөөд өнөөгийн нийгэмд Дамдин шиг хүн Улаанбаатарт гарвал яах байсан бол оо...

2015.11.09 УБ хот

С.ДАШДООРОВЫН “НУУР НУУРЫН ШУВУУД” НОМ ДАХЬ АВИА, ДҮРС ДУУРАЙХ ҮГСИЙН ТУХАЙ.

Дархан-Уул аймаг ХААИС-ийн монгол хэл бичиг,найруулга зүйн багш Ц.Буянхишиг

Ардын уран зохиолч, төрийн шагналт С.Дашдооров “Нуур, нуурын шувууд” шилмэл өгүүллэгийн түүврээ 1991 онд “Монгол уран зохиол” хэвлэлийн газар хэвлүүлжээ. 12,7 хэвлэлийн хуудас бүхий энэ номонд 1955-1990 он хүртэлх 38 өгүүлэл он цагийн дарааллаар бичигджээ. Нэг гол баатартай, цөөн тооны туслах дүртэй бөгөөд баатруудынхаа амьдрал үйл хэргийн нэг жижиг хэсэг, учрал тохиоллыг амьдралын нэгэн агшинд харуулж түүгээрээ хүн, байгаль, нийгмийн утга чанартай анхаарал татсан эгзэгтэй гол асуудлыг хөндсөн байна. Эдгээр өгүүллийн баатрууд нь ихэвчлэн амьдралд хөлөө олсон, зан чанар, үйл хэрэг нь төлөвшиж тогтсон бие даасан хүмүүс байна. Зохиолчийн төрийн шагнал, ардын уран зохиолч болоход нэр нь дурдагдаагүй зохиолуудыг сонгож задлан дэлгэж, дүн шинжилгээ хийхийг зорьсон болно. Мөн тэрээр авиа дуурайх, дүрс дуурайх үгсийг хэрхэн мэдэрч, оновчтой сонгосон хийгээд тэр нь хүний сэтгэлд хэрхэн нөлөөлж байгааг хөндөж бичлээ.

Хүн амьтны сонсох эрхтэнд өртсөн долгион, чихэнд сонсогдох чимээ анир буюу хэлний хамгийн бага үндсэн нэгжийг авиа гэдэг. Авиа нь уран зохиолтой сонсол зүй, авианы утга, авиаг мэдрэх, хүлээн авах, хөг, аялгууны уран сайханд гүйцэтгэх үүргээрээ холбогддог¹.

Уран зохиол бол үгийн урлаг. Үг нь хэд хэдэн авианы нэгдлээс бүрдэж, авиа бүр өөр өөрийн хөг аялгуу, сонсголон, ая эгшигтэй тул дүр бүтээж, дүрс илэрхийлэх үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь баатруудын хэл ярианы үед тод илэрч, авианы аялгын тусламжтай дүрийн зан төрхийг бүтээх, онцлогийг гаргахаас гадна авианы бүлэглэл нь цаг үе байгаль, цаг улирлын аяс, хүний сэтгэлийн дотоод, гадаад байдлын холбоо уялдаа, амьдралын орчин, үүссэн нөхцөл байдлыг илэрхийлэхэд тусалдаг.

Хэлний хамгийн бага нэгж авиа нь уран зохиолын найруулгад уран сайхны олон талын үүрэг гүйцэтгэнэ. Ялангуяа яруу найраг, туульсын зохиолд өнгө аяс, хөгжим аялгуу бүрдүүлэх, мэдрэмж, аяс байдал, хандлага, дүрслэлийг бодот байдалд ойртуулах, дүрс үүсгэх, баатрын сэтгэл санааны далд чинадыг нээх, анирдах боломж олгоход чухал үүрэгтэй. Проф. Ц.Сүхбаатар авиаг зөв

1Д.Галбаатар Уран зохиол, нэвтэрхий толь, УБ, 2012 он

сайн найруулах нь “тухайн зохиолын хэл ярианы уран найруулгыг ихэсгэж чадах агуулгат зохицсон дуудлагатай үгийг сонгон аваад тухайн тохиолдолд оновчтой хэрэглэхийг авианы найруулга гэнэ. Авиаг найруулах хэд хэдэн ур маяг байдаг. Үүнд: аялга, авиа зохицуулах, авиа дуурайх, авиа давтах²” гэжээ. Авианы найруулга найруулга нь уран зохиолд утгын төдийгүй найруулгыг тансаг сайхан болгоход чухал зүйл үүрэгтэй. С.Дашдооров “Чимээгээр хийсэн шүлэг” –т

Ган хадуур, ган хадуур

Ганц нэгхэн, ганц нэгхэн

Газар өвсний хоорондуур

Ган хийнэ, дан хийнэ ...гэсэн нь авиа ба үг хэллэгийг давтан ажлын үеийн чимээ шуугиан, аяс эрчим, бахадлын аяс хандлагыг авиа зохицуулан өвөрмөц ая дан үүсгэсэн төдийгүй “ган хийнэ, дан хийнэ” мөрөөр зөвхөн дуу чимээ бус, өвс хадах үйлийн эрчим, хөдөлгөөн, хадланчдын урам зориг, дүр зураг бүхнийг шингээжээ. Мөн “ган хадуур”, “ганц нэгхэн” гэх үгсийн “н” авианууд дууны цуурайллыг үүсгэж, “хадуур” –тай хамсан давтсанаар сүрлэг, мэрийлттэй байдлын дүр зургийг бүтээхэд гол үүрэгтэй байна³.

С.Дашдооровын “Нуур нуурын шувууд” түүврийн өгүүллэг бүрээс хэлний авиа нь уран дүрслэлд утга, хөг чимэглэн, дүрийн сэтгэл хөдлөл, байдал янз, түүгээр дамжин илрэх өнгө аяс, хандлагыг илтгэх уран хэрэглүүр болж байна.

Уртын хөндийд (1955) өгүүллэгт авиа дуурайсан дүрс дуурайсан үгийг оновчтой сонгосноор тухайн дүр ямар их амь орж байгааг харж болно. Жишээ нь: “Нацаг **галвалзан** алхаллаа” гэсэн өгүүлбэрт “галвалзан” гэдэг үгийг авснаар залуу хүн өөрийн эрхгүй урам орон алхаж явааг, “сайхан бодол **пур пурхийн** төрөх нь” гэхэд “пур пурхийн” гэдэг үгийг залуу хүн өөрийнхөө хувьд нэгэн их ажил амжуулж аваад цаашид ихэд урам орж илүү олонг бодож байгааг тодотгон өгүүлсэн бол “есөн зоосоо **шарр, шарр** зайлан” гэж “шарр, шарр” гэсэн үгээр сүжиглэнгүй, нямбай байдал үзүүлэх дуу чимээг гаргажээ. Бид “тэнтэр, тунтар гишиглэн” гэх өгүүлбэрийг бага жаахан хүүхдийн алхах гишгих байдал хэмээн хэдийн мэддэг бол “**тунтар, тэнтэр** гишигчин” гэж солин найруулсан нь залуу хүн ичиж бантсандаа үзүүлж байгаа алхаа гишгээний дүр байдлыг гаргаад “**гуд шуд** татлан” хэмээн адтай бахтай, нэн гүжирмэг бөгөөд арьсан дор аагиж байгаа нэгэн бяртэнхээний идшидийн болц явцыг үзүүлжээ. Мөн “...**дэжигнэн хуухиран** өнгөрч байгаа зээр” гэж сүрэг

2 Ц.Сүхбаатар “Монгол хэлний найруулга зүй, УБ, 2004 он

3 Д.Галбаатар “Утга зохиол, онол, түүх, шүүмжлэл, УБ, 2012 он

зээрийн бор шуурга хөр цас түжигнүүлэн, шороо цас бужигнуулан давхиж байгааг, “**таахаг таахаг** алхлан” гэж тухайн хором агшинд ажлаа овсгоо самбаатайгаар амжуулсан хүний сэтгэл дүүрэн байдлыг “...тэмээ хамраа **шүүхрүүлэн гулс гулс** том тавхайгаа **палис, палис** гишиглэн” хэмээн гэрийн бараа ойртон байгааг мэдэрсэн амьтан өөрийн зөнгөөр явж байгаа байдлын дуу чимээтэй дүрслэл болж чаджээ. Энэчилэн “шүд шүдэндээ **тожигнуулан**, ам амандаа **бултгануулан**” хэмээн сумынхаа хоршооноос авчирсан хатаж чинэсэн цагриган боовыг залуу хөгшингүй идэж байгаа байдлыг гаргасан бол “буун дуу **пан пүнхийн**” хэмээн сүргийн манлай болж гоохолзож явсан амьтдыг хол ойроос онож, алдаж буудаж байгаа буун дууны авиаг дуурайн бичсэн байна. “Хэ цыс” тоомжиргүй хамар дороо дуу алдах, “хүд хүд” дотроо хаяагаа манан инээх, “хөө, хөө” үе тэнгийн найзтайгаа нөхөрсөгөөр, цайлган зангаар цаанаа л нэг хөгжөөнтэй хөхрөх, “хэгхийх” чээжиндээ хээв нэг дуу алдах чимээ, “хым” их л дургүйцсэн янзтай намжирдан дуу алдах, “ээн” гэж хамраараа хариу үг дуулах гэсэн бололтой дуугарах, “сүүлээ мушгиулсан бяруу шиг оо-оо хэмээн орилж”, “муу турсгыг хуухай..”, “ваа, муугаас зайлуул”, “хэш-ш”, “мөөн-өн”, “юу? уухайс энэ чинь”, “Хн”, “хайя”, “өө-ө-өө”, “яамай, яамай” гэх мэт хүний амнаас гарч байгаа мэдрэх, зөвших, илэрхийлэх, харилцах утга бүхий өгүүлбэрүүд олонтоо байна.

“Хөхөө” (1957) өгүүллэгт байгаа авиа, дүрс дуураисан үгсээр оюутан сурагчдын бүтээлч сэтгэхүй хийгээд бүтээлчээр зохион найруулж бичих чадварын суурийг тавих ажил хийж болмоор санагдлаа. Жишээ нь: “Дулмаа тэргэн дээрээ бидоноо **дан дин** дуугарган тавьж”, “**пөг пөг** шогшив”, “тэрэгний дугуй **энхэл донхол** замаар **дэнхэн донхон** өнхөрч”, “**там тум** гадарлаж” “**пад, пад** хийсэн тэрэгтэй хүн”, “бут бүрийг **бумбайлган** засч”, “**шивэр авир** ярилцаж”, “модон тэрэг **тор, тор** дуугаран” “амандаа хараал тавин **дэrr** гэж хашгирав”, “шавхайтай муу гутлаа **майр, сайр** чирэн”, “буурал орсон гээгээ **гунайтал** сүлжин”, “**тог тог** алхалсаар”, “хоёр авгай **маг маг** хөхрөн”, “**гүүг, гүүг-гү** хэмээн хөхөө үргэлжлүүлэн донгодов”, “**сэв сэв** алхлан” гэх мэтээр авиа, дүрс дуураисан үгсийг тулгуур болгон оюутан сурагчид нэг сэдэвтэй эх зохион найруулж болох юм. Ингэвэл тухайн суралцагчийн бүтээлч сэтгэхүй төлөвшихөд тустай. Оюутан сурагчид “Дулмаа тэргэн дээрээ бидоноо **дан дин** дуугарган тавьж” (хоосон хоёр бидоноо өндөр дугуйтай тэргэн дээр бүсгүй хүн тавихад хоорондоо дуугарах чимээ), “**пөг пөг** шогшив” (гэрийн зүг явлаа гэдгээ мэдсэн юм шиг), “тэрэгний дугуй **энхэл донхол** замаар **дэнхэн донхон** өнхөрч” (гүдгэр, хотгор, овор товон бөгөөд явахад бага зэргийн бартаатай тэгш биш хөдөөний замын дүр

байдалд тохируулан модон тэрэгний явах байдал), “**там тум** гадарлаж” (охин хүүхдийнхээ ааш аягыг хараад юунд ингэж сэтгэл догдолж байгааг эх хүн мэдэх), “**пад, пад** хийсэн тэрэгтэй хүн”, (мотоциклийн гэрийн ойролцоо ирэх үеийн дуу), “бут бүрийг **бумбайлган** засч” (ажилдаа дуртай, сэтгэлээ өгсөн байдлын илрэл), “**шивэр авир** ярилцаж” (хүмүүс сайн муу явдлыг сэм шивэглэн бие биедээ уламжлан дамжуулан ярих), “модон тэрэг **тор, тор** дуугаран” (хатуу зүйлийн хөдлөхөд гарах дуу чимээ), “амандаа хараал тавин **дэpp** гэж хашгирав” (настай хүн тэнхээгээрээ жолоогоо татан сандран морио зогсоох үед гаргасан дуу), “шавхайтай муу гутлаа **майр, сайр** чирэн” (муу муруй, саруй гутлаараа зохимжгүй байдал үзүүлэн явах), “буурал орсон гэзгээ **гунайтал** сүлжин” (ихэд чамбай хичээнгүйлэн сүлжсэн байдал), “**тог тог** алхалсаар” (хатуу зүйлийг цохих, цохилоход гарах чимээ) “хоёр авгай **маг маг** хөхрөн” (хоёр настай эмэгтэй хүний яриандаа ихэд халсан үеийн дуу авиа), “**гүүг, гүүг-гү** хэмээн хөхөө үргэлжлүүлэн донгодов” (хөхөө болон бусад амьтны дуугарах дууг хүн дуурайж байгаа байдал), “**сэв сэв** алхлан” (хөнгөн зөөлөн хөдөлгөөн бүхий алхаа) зэрэг хаалтанд байгаа үгийн утгын тайлбаруудыг сэтгэл оюундаа бодож олон зохион найруулж бичвэл ёстой өнөө бодит чадвартай бүтээлч сэтгэхүйтэй иргэн хүн бий болох буй за.

“Эхийн сайхан сэтгэл” (1959), “Тоорой банди” (1962) зэрэг өгүүллэгт байгаа авиа дуурайсан дүрс дуурайсан үгс нь өгүүлбэр зүйн үүднээс нэр ба үйлийн тодотгол гишүүн болж болж үйлийн дүр байдлыг илтгэж байгааг харж болно. “...Намрын хонгор салхины сэвс сэвс үлээлтэнд шивээн толгой нахис нахис бөхөлзөх ажээ” хэмээсэн нь байгалийн бүх зүйл уран зохицолтой бөгөөд үүгээрээ байгалийн сүр жавхлан гоо сайхныг үзүүлдэг гэдгийг “сэвс сэвс”, нахис нахис” гэсэн дуу авиа, дүр дүрслэл дуурайсан үгээр тодотгон гаргажээ. Мөн “Гэрийн дээвэр салхинд дэрвэс дэрвэс хөдөлж “гэдгийн “дэрвэс дэрвэс “нь “хөдөлж” гэдэг үйл үгийг тодотгон үйлийн дүр байдлын байц гишүүн болж байгааг “...хүүгийн царай зэрвэс, зурвас үзэгдэж”, “морьдын төвөргөөн түжир түжир сонстлоо”, “гэрийн дээвэр пад пад балбачин”, төмөр хувин тор тор дуугарч”, “өнчин хамхуул дэгэн догон хийсэх нь”, “бор гэр бортойн байсан”, “торгон савхин гутал жиг жуг дуугарна”, “хүү будаа өрөм бувар бувар идэж”, “ар хонгоо пад хийтэл алгадан”, “модон эрихээ шажигнуулан манай руу майжиг, майжиг алхан ирж” гэх мэт өгүүлбэрүүдийг задлахад давхар батлагдаж байна. Харин “намрын хонгор салхины сэвс сэвс үлээлтэнд” гэсэн өгүүлбэрийн “сэвс, сэвс” гэсэн авиа дуурайсан үг нь нэрийн тодотгол болж байна. Үүнийг лавшруулан “миний болхи, толхихон үг”, “өмбөө цөмбөө аргал” гэх мэтийг харахад болно.

Монгол ахуй, зан заншил, хэл соёлын шүтэлцээ, аж төрөх байдал зэргийг харуулсан авиа, дүрс дуурайсан үгс их байна. Жишээ нь: “Хөдөөгийн мөнгөн сар” (1966 /1985) өгүүллэгийн “холбоотой хонь ямаа хамрынхаа хямсааг сэртэс сэртэс амьсгалах аж” гэсэн өгүүлбэрийн “сэртэс, сэртэс” гэдгийг бодож үзэхэд үдийн саалийн цагт хонь ямаагаа холбодог бөгөөд жин үдийн халуунд хонь ямаа ингэж амьсгалдаг гэсэн нүүдэлчин малчин ахуйн дүр зураг хэл соёлтойгоо хамт бууж байгаа юм. Энэ мэтчилэн “дүү маань салхи хөгжөөн жингэнэтэл исгэрэнгүүт”, “саальчдын хонь ямааны дэлэн шар сүр, шар сүр шувтрах дуу”, “аавын морь нүдэн дээгүүрээ шавсан үүрэглээ ялаанд уцаарласан янзтай толгой дохин хазаарынхаа амгай тэнхлэгийг хангир жингэр дуугаргахаас өөр юм олж үзсэнгүй”, “тэр хүний шонгийн мод мэт нарийхан дүрс цаанаа мандах сарыг зүсэн сүүхийж наашлах тусам..”, “морин төвөргөөн тор тор хийж”, “ган дөрөө ханхийн” зэргийг уран сайхнаар уран дүрслэлтэй бичсэн нь жинхэн малчин ардын амьдрал дундаас төрсөн билиг танхай зохиолч л ийм яруу тансаг бичдэг байх даа гэсэн сэтгэл төрлөө.

Авиа дуурайсан, дүрс дуурайсан үгс нь уран зохиолд уран дүрслэлээр дамжин илрэх боломжгүй, зөвхөн мэдрэхүйд өртөгдөх нарийн мэдрэмж, өнгө аясыг ялгаруулан тодруулахад тусална. Өөрөөр хэлбэл зохиолын агуулга түүний илэрхийлэл болсон хэлбэрт тохирсон хөг эгшиг аялгуу хөгжимтэй байдаг. Талын хот (1966) өгүүллэгийн “Оргой авгайн гэр дотроосоо түнхэлзэн хөдлөх шахуу” гэсэн өгүүлбэрийн “түнхэлзэн” гэсэн дүрс дуурайсан үг нь төмбөгөр, цэндгэр, төмбөгөр түнхгэр юмны түнхэс түнхэс хийн гадагшаа бага зэрэг зохисгүй үргэлжлэн хөдлөх байдал гэсэн нарийн мэдрэмж, өнгө аясыг ялгаруулан монгол хүн л мэдэрч болох хөг эгшиг аялгуу хөгжим бий болгож байна. Малаа мэддэг жинхэнэ малч удмын хүн л “сугсалзсан хар ат уначихсан” гэсэн өгүүлбэрийн “сугсалзсан” гэдгийг “өтгөн сахлаг өвс, үс зэрэг юм салхины аясаар байн байн ганхан хөдлөн сугсар байдалтай харагдах “хэмээн ойлгоно. Үүнийг ”тэмээнийхээ дөрвөн тавхайг гялалзуулан савсага, савсага тэшүүлж одов”, “элэг тэнийсэн янзтай ов тов цоохор царайдаа баярын совин гэрэлтүүлж”, “яв цав ярихын дээр”, “зузаан ултай гутлаа майр сайр чирэн гэлдэрч”, “тасгийн эрхлэгч тас тас хөхрөн”, “шуудан тасгийн эрхлэгч хултай айраг далвилзуулан”, “бие биедээ түшиг, дүнгэр, гангар гээд догь байх бий шүү”, “тэд тоос шороо босгон пар сүр гүйлдэн”, “хөлөрч чинэрсэн авгай ёо, ёх болон дуу алдсаар хөлөө нэгэн хоёр зөөснөө газарт лагхийн сууж” гэх мэт өгүүлбэрт байгаа авиа, дүрс дуурайсан үгсээс харж мэдэрч болно.

Монгол үг нь залгамал бүтэцтэй бөгөөд язгуур, дагавар, нөхцөл гэсэн ерөнхий байртай юм. Манай хэлний язгуур, дагавар, нөхцөл нь өөр өөрийн

гэсэн утгатай. Тэгвэл бидний авч үзэж байгаа авиа дуурайсан, дүрс дуурайсан үгсийн бүтцийг “Тэнгэрийн дуун” (1966), “Энх улирал ханхлахад” (1970), “Нууранд буусан хун” (1972) өгүүллэгт хэрхэн гаргасанг авч үзье. Жишээ нь: “Өндөр бор морь маань жолоо эргүүлмэгц алхаагаа хөнгөлөн нэгдлийн төв уруу дэвэлзтэл алхав” гэсэн өгүүлбэрийн “дэвэлзтэл” гэсэн үгийн “дэв” гэсэн язгуур нь эрдэмтэн Д.Бадамдоржийн хэлснээр “дэн, дэнж, дэндий, дэв, дээвэр, дээл, дэвхэр, дэвж, дэвсэг, дэвш, дээвэр, дээж, дээр, дэл, дүүл/дэгүли/, дэг, дэгж, дэгд, дэн, дэмнэ, дэмж, дэрвэ, дэрдий, дэвс, дэл, дэлгэ, дэлбээ, дэлгүү гэх мэт үүр үгэнд давтагдаж дээр гэх ерөнхий утга гаргаж байна. Дээр гэсэн ерөнхий утгатай “дэв” гэсэн язгуур дээр “лз “гэсэн үйл байдлын олон удаа боловч давталтын явц удаавтар бараг тоолж болохуйц байдалтай эс тусах үйл үг бүтээх дагавар залгажээ. “Дэвэлз” гэсэн үйл үгэнд “тэл” хэмээх угтаж нөхцөлдүүлэн холбох утгатай нөхцөлийг залгаж байн байн үсэрхийлэн хөнгөн хуйсгануур байдалтай явах морины явдал эзэндээ “дэвэлзтэл” мэдрэгдэж байгаа учраас энэ үг үүссэн байна. Энэ тухай “Хэлний утга судлал бол хүний хэлний авиабарын утга ялгаруулах шинж, бүтээвэр, үглэвэр, нийлэмж үг, нийлмэл үг, хэлц үг, өгүүлбэр, цогцолбор, эхийн утга санаа хийгээд аялгаар илрэх утга бас цэг цэглэл, дохио зангаагаар илтгэх санаа зэргийг судлах хэл шинжлэлийн түвшин юм.” хэмээн эрдэмтэн Д.Бадамдорж “Монгол хэлний утга судлал” (2001) номондоо бичсэн байдаг.

Ер үндэстэн угсаатан хэлтэй болно гэдэг тухайн үндэстний оюун сэтгэхүй, өвөрмөц шинж, юмыг ухааран бодох ойлголттой холбоотой байдаг учраас аливаа нэг ижил юм үзэгдэлд үндэстэн бүхэн өөр өөрөөр хандаж, өөр өөр үгээр нэрлэсэн байдаг. Үгийн гол мөн чанар юмыг заан нэрлэхэд оршино. Тэрхүү юм нь үгээр илэрч, хүний ухамсарт туссанаар сая ухагдахуун илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл үг нь нэг талаар юманд хандаж, нөгөө талаар ухагдахуунд хандсан байна. Тэгвэл үг буй болно гэдэг нь байгаль дээрх үй түмэн үзэгдэл юмст нэр оноон өгч, утгыг илэрхийлнэ гэсэн үг. Чухам монгол угсаатан хэдий үеэс хэлтэй болж монгол яриа үүссэн бэ гэдэг нь балар эртний үед холбогдох асуудал бөгөөд яг тэр үед хэлтэй болсон гэж хэлэхэд бэрхтэй. Ямартаа ч бидний сонгон тайлбарлаж байгаа “дэвэлзтэл” гэх үг нь монгол хүний харааны хүртэхүйд хүртэж байгаа юманд өгсөн нэр болох нь тодорхой байна.

Хүний сэтгэлийн олон нарийн өнгө аяс янз байдал, хандлага, бодол санаа урваж хөрвөх илрэл, хөдөлгөөн, сэрэл, мэдрэмжийг уран зохиолд авиа дуурайх, дүрс дуурайх үгсийн тусламжтай нээн дүрслэх шаардлага гардаг. Үүнийг дээрх өгүүллэгт тод томруун дүрсэлжээ. Жишээ нь: “Миний барааг алсаас харахул лавтайяа нөмрөгөө хийсгэн яваа эртний баатар мэт сүр жавхлан

төгс байгаа болов уу хэмээн сэтгэж эл бодолдоо урамшин хөөрч цувныхаа хормойг улам “дэрвүүлэн” “тэнтэр, тунтар гишигчин”, “хам хумхан цай ундаа уусан болоод”, “алсад гэнэт тэнгэр дүнхийн дуугарах сонстов”, “гадсан гялбаа гялс гялсхийн тэнгэр нүжигнэн дуугарах”, “түрүүчийн дусаал дээл хувцас, дээвэр туурга, дэлхий газар дээр пад падхийн буув”, “борооны садран цутгах чимээ”, “байн байн хашгирч, энд тэнд сүр сар хийвэл дав дув цочин суулаа”, “налчинхай хүрэн ингэ зэлний баруун үзүүрт чихээ дэлдэгнүүлэн зогсож байна”, “хяламхийн харснаа”, “нэхий хүр хүр хэдрэгдэж суусан”, цай пор пор буцлан” “гэрийн хаяагаар сэм сэмхэн үлээх талын агь таана”, “хотондоо налайх хонины шир шир хивэх, ганц нэг ямаа малын босож хохих хөлийн шавир авир чимээ”, “турван тэмээ торх тоодон тэгнээстэй гулалзуулан алхаж ирэх”, “шүлсээ гуд гуд залгин”, “газарт хаяснаа гуд татан босгож”, “хаа нэгтэйгээс тожир, тожир морин төвөргөөн ойртож ирэх”, ” агт маань пар пар тургилан”, “үүр шөнийн болжмор жир жир жиргэж”, “хазаарынхаа амгайг тор тор хэмлэн” “тэр хүн миний хажуугаар бөхөг бөхөг алхлан”, “би год үсрэн гэрээс гарвал”, “Тэгтэл аймгийн замаар улаан туг дээрээ хийсгэсэн ачааны машин автобус хоёр газрын энхэл донхолд тонголзон айсуу”, ”зарим нь бүр год шодхийсэн зүйлсээр олны сэтгэлийг чилээн” “бяцхан танхимын хана гадагшаа түнхэлзэн хөдлөхөөр чихэлдэн цугларчээ”, “манай нэгдэл нэг дүнхийсэн сайхан ордон барих цаг болжээ”, “ангаж цангасан бол манайд очиж юм уу л даа гэж эг магхийн урилаа” зэрэг нь цөм хүний сэтгэлийн өнгө аяст тухайн юмст хүртэгдсэнээс С.Дашдооровын хэлснээр “сэтгэлийн утас тонхийтэл” цохисноос үүссэн үгс юм.

“Дулмаад тохиолдсон явдал” (1972),” Тэр жилийн наадам” (1974), “Хас өвгөний гэмт хэрэг” (1974) зэрэг өгүүллэгт хэмнэл, хэмжээ тааруулах, хөгжим аялгуу шингээх зорилгоор нэг ижил юм уу зохицолт авиануудыг давтсан байна. “Сумын дарга, зарлагаа майр сайр, майр сайр гутлаа чирэн орж ирмэгц”, “мандолин хөгжмөө аван тайны гэрийн гадна суун дон дон цохиж”, “тулганы сүүмэн сүүмэн галд”, “яриа хөөрөөгөө хөндлөнгийн хүн хар дуулчих вий хэмээн заримдаа шивнэлдэн, наг наг хөхрөлдөн ирж унтсан юм”, “түрийгээ пад пад балбан, хоёр гараа хооронд нь таших мэт тас тас алгдан”, “буурал мориныхоо пөг пөг шогшоонд эмээлийнхээ дэвсийг хоёр өвдгөөрөө нал нал балбан”, “хувийн өмчийн үзэлдээ үхширтэл баригдсан хүн мэр сэр байна”, “бас мар мар инээцгээж байсан”, “буурал морь нь ч эл үгийг ухаарч ойлгох мэт тэргүүнээ түгдэг түгдэг хаялан алхлах аж” гэх зэргээр авиаг зохистой давтан тухайн зохиолын хөг хэмнэл, дүрслэгдэхүүний шинж байдлыг яруу сонсголонтой хөгжимлөг болгожээ. Өөрөөр хэлбэл ингэж дахин

давтаж байгаа нь тухайн үйл хөдөлгөөн дүр, авиа чухал болохыг сануулсан хэрэг бас мөн.

“Оддын дундах шинэ жил” (1973) зэрэг өгүүллэгт дүрийн гадаад, дотоод хэлбэр байдал нь тухайн зүйлд хандсан өгүүлэгчийн сэтгэлийн өнгө хэлбэрээс шалтгаалдгийг үзүүлэхдээ “Эсгий үүд хүлхгэсхийн”, “галгиулан ирж буунгуут”, “Ах маань ч бид хоёрыг хөл газар хүрэхгүй дэндэлзэн байгааг гадарласан бололтой” “цоргоор гэнэт годхийн асгарах усыг хүүхэд мэт гагцаар харж”, “улаан бүйлээ гарган дадганатал хөхөрч”, “хөлөө ялаархсан адуу шиг доёгонуулан хөдөлгөж”, “хэдэн сум харжигнуулан гаргаж” “хаалга чахруулан нээснээ”, “уулын модод цасан цацаг чимэгт дарагдан сүглийж”, “модчидын түлсэн галын утаан сүүдэр сүүтэгнэн”, “ахиулан харвал зүүдийсэн саарал юм зогсож байгаа харагджээ.”, арван салаа эвэр данхалзан ил гарч, арваад буга согоон сүрэг дэгдэн гарч ирэв”, “царай зүсээ гялалзуулан”, “Жамаа дороо дэвхцэн адгаж” “хэрчим түлээг шүүрэн авч гялс гялс нүүлгэн”, “цонхны шил хангир жингэр хагаран бутарч”, “гэртээ уухилж аахилсан юм үсрэн оруутаа”, “хөлийн дор чийхрах цаснаас өөр чимээгүй”, “бүжиг гэхэд гадарлахын аргагүй цас хяхатнуулан дэвхцэж” гэх мэт. Эндээс “Эсгий үүд хүлхгэсхийн “гэдэг өгүүлбэрийн “хүлхгэсхийн” гэдэг нь тухайн харж байгаа хүний сэтгэл оюуны тэр зүйлд хандах хандлагаас гарч байгаа үг юм. Өөрөөр хэлбэл эсгий үүд хөдлөн онгойх байдлыг хэн ч ямар байдлаар харж түүндээ тохирсон уран дүрслэлтэй үг хэлж болно гэсэн үг.

Тухайн бодит зүйлд өөрт нь байгаа дүр төрх, дуу авиаг хэлний авиа дуурайх, дүрс дуурайх үгсээр оновчтой зөв олж сонгосон нь утга гүн, сэтгэлд зохист, тэгш хэмт, хослол төгөлдөр болжээ. Жишээ нь: “Нарсны нүүдэл” (1978) зэрэг өгүүллэгт “Өмбөө цөмбөө хонин чулуудын дундуур чив чимээгүй урсах горхины дээд бие” гэсэн өгүүлбэрийн “өмбөө цөмбөө” гэсэн уран тодотгол бас чимэг үг гэж болмоор дүрс дуурайсан үг нь нэгдэж хамссан буюу тэрүүхэндээ цугларсан гэх утгыг илтгэж байна. Үүнийг “эмээл дээрээ цомцойн суусан, лаглайж суусан, өцийж өндийсөн, сүүжилдэн хэлтийсэн элдэв төрх байдлаар нь хэн яваагий нь алзахгүй танина”, “гадгаад архинд согтож байгаагаа үглэн майтарч байснаа”, “өвгөн амаа жилэмдэн”, “нарийн мөчир тас няс хугалан”, “хараацай агаар сүлжин час час дуугаран”, “хэдэн шүдээрээ оноож ядан өм цөм хазаж”, “энэ хойно дүнхийж байгаа нүцгэн өндрийг”, “дэлдийсэн бор хүү”, “хүрэн цүнхээ түнтэгнүүлэн”, “уруул амаа умалзуулан”, “нүд дүүрэн мэлтрүүлэн”, “аав цээжээ түнхэлзүүлэн”, “енгэнэтэл уйлж байгаа”, “хүү нь давхийтэл”, “сурлагаараа сунайтал түрүү авахгүй ч”, “годрон туссан ямаа шиг арагшаа татвалзан”, “духан дээр шуугитал үнэрлэн үнсээд”, “охин маань

элий балай аштай болжээ”, “чих нь дүнгэнэтэл шуугьж”, “там тум томчуудын ярианаас ...бүдэг бадаг сураг дуулжээ”, “бороо зөгнөн гуаглалдах мэлхийн дуу”, “аав хүү хоёр бие биенээ ширвэн харснаа”, “өглөөний мандан бүхий нарны гэрэлд цэвцийн цайж харагдана” гэх мэт өгүүлбэрт байгаа авиа, дүрс дуурайх үгсээс харж болно.

“Бид хэлнийхээ генотип буюу гени рүүгээ халдаж болохгүй. Авиазүй бол хэлний генотип нь билээ. Гадаад хэлний авиа яг тэр чигээрээ монгол хэлэнд орж ирээд, байр сууриа эзлэх аваас хэлнийхээ генийг бид алдаж эхэлнэ. Өөрөөр хэлбэл эрт үеэс монголчууд хэлний дархлаатай, хэл нь өөрийгөө хамгаалдаг байж л дээ. Харь хэлнээс үг авахдаа өөрийнхөө зүй тогтолд тохируулж, монголжуулж авдаг байж. Самгард хэлний “шлока” гэдэг үг монголд орж ирэх болов, түүнийг авахгүй биш авна, хэрэгтэй үг, гэвч монгол хэлэнд “к” гэдэг авиа байхгүй, давхар гийгүүлэгчээр үг эхэлдэггүй, тиймээс “шүлэг” болгоод авна. Монгол хэлний авиазүйд эгшиг зохицох ёс гэж сайхан дүрэм бий. Гадаад үг монгол хэлэнд орж ирэхдээ эгшгээ зохицуулж, эр эмээрээ ялгарч байх ёстой юм” гэж эрдэмтэн М.Саруул-Эрдэнэ бичсэн байна. С.Дашдооровын уран бүтээлд энэхүү авиа дуурайх байдлаар бичсэн үг хэллэг бий. Жишээ нь: Дээрх өгүүллэгийн үхэрчин Дондов гаднаас ирсэн хүний өгсөн “Виски” архийг “Ходоод халгуун оргиод толгойд ч мөн хурдан гарч байх чинь вэ? “Хийсгэе” гэдэг нэрэндээ ч таарсан рашаан байна даа” хэмээн тухайн үеийн хүмүүс хэлнийхээ генийг хэрхэн хамгаалж, ярьж байсан үгийг бидэнд авчирчээ.

С.Дашдооров говийн малчин айлын малч удмын хүн болохоор тэмээгээ их сайн мэдэж, тэмээнийхээ дүр дүрслэл, ааш аягийг тод томруун бичжээ. Жишээ нь: “Ботгон бор толгод” (1979) өгүүллэгт “зузаан гуятай бор ат алцага алцага тэшин тарган тавхайгаараа газар алгадан ширэн тавхайгаа гялалзуулан холдов”, “Цэндсүрэн унасан тэмээнийхээ хамрыг шүүхрүүлэн миний ард ирж зогсов”, “Цэндсүрэнгийн унасан бор ат таахайтал хойд хоёр хөл дээрээ оцойж шээсээ утас мэт савируулан зогсоно”, “түүний унасан буурал магнайтай бор ат нь урт сормуустай тунгалаг нүдээ түргэн түргэн цавчлан дөхөн очвол эзнээ өмөөрөн гуд гуд гулгин хэвэх сэвсээрээ нүүр нүдгүй булах янзтай”, “бурантгий нь сурмагаар сугсран тэмээгээ эргүүлэн” гэх мэт өгүүлбэрүүдийг уншихад таны сэтгэл оюунд тарган, бор, атан тэмээ урган гарч ирж байгаагийн гол утас нь “алцага алцага, шүүхрүүлэн, таахайтал, гуд гуд гулгин, сугсах “гэх мэт авиа, дүр дуурайсан үгэнд байгаа юм.

Хүүхдийн гадаад дүр төрх, дотоод ааш аяг, хэл яриаг тухайн хүүхэдтэй яг зэрэгцээд тоглож байгаа юм шиг авиа, дүрс дуурайх үгсийг ашиглан гаргасан

байна. “Багачууд, томчуудын зовлон” (1980) өгүүллэгт “Зул охин нааш цааш тожир тожир гүйн баахан юм зөөж өрж” гэсэн өгүүлбэрийн “тожир тожир” гэсэн бага жижиг хүүхдийн хөнгөн түргэн хөдлөх байдал чимээ хоёрын хавсарсан үгийг хасч “Зул охин нааш цааш гүйн баахан юм зөөж өрж” хэмээн найруулбал энэ өгүүлбэр нь хамгийн наад захдаа 3-6 насны хүүхэд тоглож байгаа гэсэн мэдээллийг хүнд өгч чадахгүй бөгөөд өгүүлбэрийн гол амин сүнсийг авч хаяж байна гэсэн үг. Харин хэдэн настай нь мэдэгдэхгүй хүүхэд тоглож байна гэж ойлгогдоно. Тэгэхээр авиа дуурайсан, дүрс дуурайсан үгсийг зөв оновчтой олох нь тухайн зохиолчийн нөр их хөдөлмөр бөгөөд тухайн зохиолын гол утга санаа түүгээр амилдаг гэж болно. Энэ мэтчилэн “худалдагч болохоо больж годхийн худалдан авагчийнхаа дүрд хувиран”, “орцныхоо хана туурганд ааваараа заалгасан “а” үсгээ бичиж сууцны даргад зэмлүүлэн алаг нүдэндээ бөөн бөөн нулимстай зогсож”, “хажууд минь дэрвийсэн хөх эрээн хувцастай хүүхэлдэйгээ авчирч тавилаа”, “нөгөө талд луглайсан хүрэн баавгай авчирч тавилаа”, “Зул охин хаалгаа нээн дэгдэн алга болов” гэх мэт өгүүлбэрүүдээс дэлгэрүүлэн ойлгож болно.

Яруу найраг, шүлэг нь хэлний авианы яруу хэрэглүүрт түшиглэсэн найруулгын онцгой хэлбэр байдаг бол С.Дашдооров үргэлжилсэн үгийн зохиолд авианы яруу хэрэглүүрийг онцгой сайн гаргасан байна. Иймээс энэ сайхан бэлэн материалыг ашиглан ЕБС-ийн монгол хэлний хичээлд авиа, дүрс дуурайсан үг хэмээх шинэ нэгж хичээл оруулбал сурагчдын мэдрэмж хөгжин бүтээлч сэтгэхүйтэй болох үүд хаалга нээгдэнэ. Шинэ үеийн найруулагч нар жүжиг, киноны зохиол олдохгүй байна хэмээн олонтоо ярьж байгаа бөгөөд тэд энэ мэт хуучны сайхан зохиолоо уншиж үүцээ уудлахгүй байгаагийн шинж буюу. Тэр үүцийг задалвал бараг 50-60 жилийн өмнө бичсэн мөртлөө одоо уншихад энэ цаг үеийн хэрэгцээг хангаж байгаа “сонгодог” зохиолууд С.Дашдооровт байгааг олж болно. Монгол хэлний тайлбар тольд дээрх үгсийн утгыг найрийвчилан тайлбарлаагүй байна. Ялангуяа мэдрэх, зөвших, илэрхийлэх, харилцах утга бүхий үгнүүдийг /өгүүлбэр/ бараг огт тайлбарласангүй. Иймд эдгээр сайхан зохиолуудыг тулгуур болгон монгол хэлний авиа дуурайсан, дүрс дуурайсан үгсийн толь бичиг гаргаж болно. Гэхдээ зарим авиа дуурайсан, дүрс дуурайсан үгсийг зохиол болгондоо давтсан байсан нь өөнтөгч нүдний гадуур өнгөрсөнгүй.

Ардын уран зохиолч, төрийн шагналт С.Дашдооров зохиол бүтээлээ зөвхөн шүлэг, өгүүллэгээр хязгаарлалгүй тууж, роман, найраглал, жүжиг, кино, дуурь зэрэг бүх төрлөөр бүтээл гаргаж байснаараа ховор онцгой авъяас билигтэн байлаа.

*Хэн намайг тийн хичээснийг мэдээ аж, мэдээд ч яах билээ,
мэдүүлээд ч яах билээ.*

С.Дашдооров

С.ДАШДООРОВ АБУГАЙ... ТИЙМ ӨНДӨР ХҮН ҮҮ...? ТИЙМ НАМХАН ХҮН ҮҮ...?

СУИС-ТУС-ийн багш: Э.Дашзэвэг

С.Дашдооров абугай...! Тийм өндөр хүн үү...? Тийм намхан хүн үү...? гэж асуух нь хэнд хамаатай юм бэ? Хамаатай ч байж болох юм. Яагаад гэхээр саяхныг хүртэл жижүүрийн үг, хэллэгээр нэгнийгээ үнэлэн, дүгнэдэг “асан” цаг байлаа. Харин одоо бол туурвиж буй..! туурвин үлдээсэн, тухайн уран бүтээлчийн сэтгэлгээний цар хүрээ, сэтгэхүйн онцлогоор нь “үнэлэмж” тогтоодог болжээ.

Тэр ч нь зөв юм. Тиймээс ч С.Дашдооров абугай...дээрх тодтотголын хариулт болох тийм л өндөр “сэтгэгч” байсан юм. Монголын нийгмийн ороо бусгаа шилжилтийн цаг үед, харанхуй, бүрэнхий, үзэл суртал, нам засгийн шахалт, хайлчилбарын жилүүдэд нийгмийн золиос байсангүй. Харин ч “мөлчгөрөө” гэдэг шиг яруу найраг, үргэлжилсэн үг, кино зохиолын хуучин үзэгдэл биш шинэ хоёрдогч үзэгдэл болон гарч иржээ.

Чухамхүү хуучинсаг биш, сэтгэлгээт орчин үеийн сэдэв рүү чиглэсэн байдаг нь зохиолын ур ухаан өндөр мэдрэмжүүд, зохиолын дүрслэл, байгууламж хийцээс нь харагддаг. Дүрийн мөн чанарын дотоод сэтгэхүйг гярхай ажиглан амьдралын болзолт, бололцоот дүрүүдийг хооронд нь зөрчилдүүлж дүрээ хаана ч амьдруулж чаддаг нь уран бүтээлчийн туурвил зүйн онцлог. Үүнийг С.Дашдооровын монголын кино урлагийн түүхнээ үлдээсэн жим буюу Гурван найз (1958), Өндөр ээж (1968), Нар хиртсэн жил (1973), Чимгээгийн төрсөн өдөр (1973), Эх бүрдийн домог (1975), Тэнгэрийн муухай арилдаг (1978), Их замын эхэнд (1978) зэрэг бүтээлүүдээс харж болно.

Үүнийгээ цааш бичихийн өмнөхөн нэгэн зүйлийг ишлэл зүүлт болгоном.
Үнэлэмжгүй болж буй...

Үлэмжхээн өндөр босго давж орж ирсэн, орчин цагийн “олиггүй” кино бүтээгчидэд зориулан, жинхэнэ өндөр кино зохиолч, өндөр кино найруулагч, баг хамт олны тухай бичиж буйгаа мэдэгдмээр байна.

ӨНДӨР ЭЭЖ ГЭЖ ХЭН БЭ? Тийм өндөр хүн үү...? Тийм намхан хүн үү...? хэн нэгэн хүнд хамаатуулан ойлгох хэрэггүй бизээ. Энэ бүгдэд нь хамаатай. Учир нь зохиолч хүн эмзэглэлийнхээ торгон мэдрэмжин дээр шинэ зохиол бүтээлээ туурвидаг болов уу.

С.Дашдооров абугайн... “Өндөр ээж” тууж бичигдсэн түүх их сонин л доо.

Дундговь аймгийн захад шахуу байх “Цахирт” хэмээх сууринд “өндөр мээм” гэдэг маш сайхан зантай, орсон гарсаныг дайлж цайлсан хөгшин байсныг санаж үүгээр гол дүрээ болгож түүнийгээ хоёр жил шахам тархи оюундаа боловсруулж бодоод байжээ. Дотроо намхан биетэй, сайхан сэтгэлтэй хөгшин харагдаад байсан байгаа юм. Нэг удаа зохиолч Д.Гомбожав агсны ээжийнд очтол ээж нь “Хүү минь чамтай ингээд ороод ирэх шиг санагдаад байх юм” гэж өр өвдөм ярьжээ. Үүнээс сэдэвлэн өндөр ээж нэг хүүтэй байх ёстой юм байна. Тэр нь дайнд үрэгдсэн байх ёстой хэмээсэн санааг олж цэргийн хүүг нэмж бичжээ.

Ингэж л өндөр ээжийн сэтгэлээр С.Дашдооров абугайн зохиол бүтээлийн өндөр “сэтгэлгээг” харж болно.,,

“Өндөр ээж” туужийн Догоо авгайн гэрийн гадаах дүрслэлд зохиолын амин сүнс нуугдаж байх шиг...

Эндээс л зохиолыг задлан шинжлэхүй.

... өвс ногоо халцран, машины мөр чийрэлжээ. Гэрийн хойно машины резенин дугуй, хагас гол, дугуйны бул, нум, төмөр их бага араа шүд бүхий элдэвийн зүйл нэгэн доор хуураасны дээр галын хорын сав, машины тос хийх гозгор лааз хэд хэдийг талбийжээ. Ойр хавийн нь халцгай газарт асгарч дууссан бензин тосны толбо хүрэнгэн шингэсэн нь тодхон харагдана...

Үүнийг уншсан хэний ч нүдэнд эмх замбааргүй байдлын дүр зураг буух нь дамжиггүй. Энэ бүх гэрийн гадаа байгаа хатуу төмөр эдлэлүүд ганцхан Догоо авгайх биш. Төмөр эдлэл болгон өөрийн эзэдтэй. Эндээс л солгой Ойдовоос эхлээд сагсуу Гочоо, гүзээ Жид, тасга Доо, хожиг Санжаа, зовлонт Хорлоо, шар Тэшигээр ч дуусахгүй өч төчнөөн хүний дотоод мөн чанарын тохиолтой машин, машины сэг, сэлбэгний хаягдал бий.

Яагаад үүнийг Догоо авгай гэрийхээ гадаа овоолж, аргал хомоол шиг түүж цуглуулдаг нь учиртай. Энэ нь харгислалын төмөр зэвсэгний үлдэгдэл юм. 1945 оны дайны хор хөнөөл, уршигт явдал манай ээжүүдийн сэтгэлийг зүсэм талх шиг зүсээд, зүсээд хаячихсан.

Зохиолын санаа бол энэ бүх зовлонгийн шалтгааныг монгол эх хүн өрөм шиг сэтгэлээр зүрхээ царцайлгүй байж дайнд мордсон хүүгээ хүлээж чадсанд л байгаа юм.

Эндээс л зохиолын эхлэх болсон шалтгааныг хайхуй...

..Өвсногоо халцран, машины мөр чийрэлжээ: Амьд байгалийн өвсногоо юмс үхэж буй нь. /Догоо авгайн сэтгэл хоосрон үгүйрэх/ орон зай холбоосоор сэтгэгдэнэ. Машины мөр чийрэлжээ гэнэ нь харийн түрэмгийлэгчдийн гар хөл, монголын хөрс шороо руу далд санаагаа хэрэгжүүлэх гэсэн бодлого юм.

Газар шорооныхоо төлөө олон ч ээж аавын хүүхдүүд амь биеэ өгсөн. /Гомбожав хүүгийн амь / үрэгдсэнийг дуулгах, үрэгдсэнийг хүлээх хоёрын хооронд хоосонг дүүргэх гэсэн /Догоо авгайн/ сэтгэлийн цагаан сүү хэзээ ч хар болсонгүй. Үүнд л зохиолын эргэлт, гол улаан шугам зангилагдана.

... Гэрийн хойно машины резенин дугуй, хагас гол, дугуйны бул, нум, төмөр их бага араа шүд бүхий элдэвийн зүйл нэгэн доор хуураасны дээр галын хорын сав, машины тос хийх гозгор лааз хэд хэдийг талбийжээ.

Энэ чинь нөгөө Өндөр ээжээ... гэж авгайлан дууддаг олон хүүхдийнх нь ачаа тээш. Хүүгээсээ хойш их л зовлонг нуруун дээрээ үүрч яваа.

...шөнө ирсний нь шөнө ирлээч гэхгүй, өвөл гал түлж дулаацуулна. Зун бол амны нь цангааг дарж аль л байгаагаа өгнө.

Догоо /авгай/ энэ үйлдэл ухамсартайгаар бүх сэтгэлийн үйлчлэлд хамаарагдана.

... Ойр хавийн нь халцгай газарт асгарч дууссан бензин тосны толбо хүрэнтэн шингэсэн нь тодхон харагдана.

Бүгдийн өмнө өөрөө бурууг хүлээнэ. Зохиолын төгсгөлд салхи шуургатай өвлийн тэсгим хүйтэнд явуулын машин замд саатсаныг мэднэ. Хүний үрд амь залгуулах гэж яваад очих газартай хүрхэд таван алхамын зайд очин “осгож” мөнх бусыг үзүүлэн, тэнгэрийн орон руу залрана.

Өндөр ээжийн сэтгэл тийм л өндөр байсан юм.

Өндөр ээж туужаас Өндөр ээж кино руу шилжсэн нь цаг үеийн асуудал байсан нь илт анзаарагдана.

...Р.Доржпалам найруулагч орчин үеийн сэдэв рүү хандахдаа хүний сайхан сэтгэл, дайны хор ууршиг аль алинийг нь зэрэгцүүлэн тавьжээ. Тиймээс дайны сэдэвтэй “Өндөр ээж” кино 1968 онд бүтээгдсэн юм. Уг кино хоёр хэсгээс бүрдэж байна. Эхний хэсэгт эх, хүү эцэг гурвын халуун дотно харьцаа, хүүгийн эх орны ард түмнийхээ төлөө байгуулсан эрэлхэг гавьяаны тухай өгүүлнэ. Энэ хэсэг нь бие даасан туурь шинжтэй юм. Хоёр дахь хэсэгт эхийн хүнлэг сэтгэл, өнөөгийн хүний зан чанарыг дүрслэн харуулжээ. Уг хэсэг өгүүлэмжийн хувьд тэнцүү шахам боловч хоёр дахь уг кино гол санаа агуулагдсан байна.

Ийнхүү өнөөгийн хүний нийгэм, олноо гэсэн сэтгэл нь нийтийн төлөө, ниит нь нэгийн төлөө гэсэн социалист зарчмыг киноны хэлээр тодорхой үзүүлэхийг уран бүтээлчид эрмэлзжээ¹ гэж дүгнэсэн байдаг. Тухайн үеийн нийгмийн шинж, өнгө төрхийг үзүүлсэн нь магад ч өнөөгийн энэ нийгмээс “Өндөр ээж” киног үзээд туужтай нь харьцуулан харахад нийтийн төлөө, ниит нь нэгийн төлөө байлгах гэсэн зориудын социалист аж байдлын зохиол биш, кино ч биш юм.

Догоо авгай шиг ийм ӨНДӨР ЭЭЖҮҮД тэр үед их амьдарч байсан шүү дээ. Үүнийг уран зохиолын хэлээр, кино дүрсний хэлээр үзүүлэх шаардлага л гарчээ.

Манай хуучны кинонуудад сэтгэл зүйн маш хүчтэй хэв шинжүүд, санаанууд илрэх болов чиг нийгмийн үзэл санаа түрэмгийлсэн зохиомол тайлбарууд давамгайлсан байжээ.

“Өндөр ээж” кинонд өөр өнцөг, тусгал, зураг, өндөр хурд, кадр, дүрс, эвлүүлэг, /найруулагчийн бодролууд/хөвөрнө.

Кино хальсан дахь гурван том шалтгаан

1. **ДҮР.** “Өндөр ээж” кинонд /Цэрмаа/ дүрийг шинээр оруулсан юм. Гомбожавын дайнд үрэгдсэн цахилгаан мэдээ /Цэрмаа үүнийг уншдаг. Энэ бол найруулагчийн кинонд хийсэн уянгын аяс, хүлээлт, хүлээн авалтын шийдлийн хурц хэлбэр Энэ нь найруулагч, зохиолч ч киноны санаагаа /Цэрмаа/-гаар дамжуулан гаргах гэсэн нэг талын “хөшүүрэгт” дүр болж өгчээ. Гомбожавыг нас барсныг мэдчихээд гэрээс гараад тэмээтэй тэшүүлэн явж буй /Цэрмаа/ бүсгүйн дотоод сэтгэлийн шаталт, тэнцвэргүй байдлыг хальсан дээр буулгахдаа

¹Ц.Зандраа “Кино урлагийн үндэс” УБ, 1999,34 тал

тэмээний хурд, тэмээгээ ташуурдах байдлаас бүсгүйн сэтгэл зүйн хувирал, хандлагыг холбон үзүүлсэн санагдана. Үүгээр энэ дүрийн үйл төгсөж, өөрийн гэсэн үүргээ биелүүлээд кино кадрт үзэгдсэнгүй. Дүрийн хувь заяа нь цаашид мэдээж ихээхэн эмгэнэлтэй үргэлжлэх тодорхой.

2. **ДҮРСЛЭЛИЙН ХЭЛ.** Кино үзэгдэл, дүрслэл бүхэндээ маш том шалтгааныг тээж байдаг. Зөвхөн дүрсээр киноны хэлэх гэсэн санааг ч гаргаж болно. Энд нэг дүрсийг зориуд онцлох гэсэн юм.

...бараан цэвхийсэн тэнгэр /кино кадрт бууна./ Энэ юуг илтгэнэ вэ? ..Гомбожав хүү тэнгэрт хальсныг илтгэх боловч бид өөрөө өөрсдийгөө тэр бараан цэвийсэн тэнгэр лүү авч явж байна гэсэн киноны давхар санааг нууцлана.

3. **ХАРИЛЦАН ЯРИА.** Кино эхлэхдээ /машины дүрс, хоолой/ “**одоогоос олон жилийн өмнө говийн нэгэн аймагт ийм нэгэн явдал болсон юм**” гэнэ.

Доорх харилцан яриаг текстийн түвшинд тайлал хийхүй.

...Должин авгай өвгөн Дамирандаа хандан: Энэнээс л болж байгаа юм. Дайнд хөөгдсөн юм шиг газрын мухарт нүүх юм. Амьтны мал болоод л байхад манай хэд бололгүй яах вэ? /Дүрийн гадаад, дотоод байдлыг харилцагч дүрүүдийн текст, үгнээс хайж болно. Дамиран өвгөн ямар хүн болох нь дээрх текстээс харагдаж байна. Бэлчээрийн сайныг хөөсөн. Юманд ул суурьтай ханддаг нь харагдана. Мөн ээжийн зөн совин ухамсаргүйгээр “дайнд хөөгдсөн юм шиг” гэж хэлж байгаа ч дайн энэ үгийг хэлсний дараахан эхлэнэ. Үгний цаадах далд суурийг жүжигчид тоглох нь том шалтгааны нэг юм./

... Цэрмаа: Дамиран гуай та нэгэнт өнгөрсөн юмны хойноос гэмшээд яах вэ. Одоо удахгүй хоёр гурав хоногоос буцах юм гэнэ лээ. Тэгтэл нь та хоёр замыг нь тосоод хүлээчих. /Кино эхлэх болсон шалтгаан үгийн сүнс энд амилна. Өнгөрсөн юмны хойноос гэмшилгүй амьдрал гэж хаана ч байх билээ./

Өндөр давтамжтайгаар “өндөр” гэдэг үгийг хэдэн ч удаа бичив. Тууж, кино хоёр нэгэн санаагаар дамжигдан уншигдаж байна. Зохиолын төгсгөлд гардаг шиг Зам нэгдлийн Цахиурт бригадын гуанзанд ширээ тойрон суух хүмүүс ярилцна.

“..Үгүй бас хачин юм даа! Гурил гэвэл гурил байна. Мах гэвэл мах нь байна. Ногоо ч нь байна. Тэгтэл яагаад энэ гуанзийнхан нэг олигтой

хоол хийчхэж болохгүй байна даа! Гэртээ бол ийм юм хийхгүй дээ”

Догоо авгай ч намхан биетэй ч, өндөр л сэтгэлтэй хүн байж дээ.

“ӨНДӨР СЭТГЭЛ Л” дутаж байна даа гэж кинон дээр нь хэлдэг. Би ч бас энэ бүгдийг бичиж суухдаа манай утга зохиол, кино урлагт ийм сайхан бүтээлүүд төрөх байх аа. Авьястанаа ч бас төрүүлэх биз ээ. Гагцхүү цаг хугацааны асуудал боловч үүнд арай “ӨНДӨР СЭТГЭЛ Л дутаад байна уу даа?.

**Эцэст нь нэмэн дэлгэрүүлэхэд С.ДАШДООРОВ АБУГАЙ...
ТИЙМ ӨНДӨР ХҮН ҮҮ...? ТИЙМ НАМХАН ХҮН ҮҮ...?**

БУУЖ МОРДОХ ХОРВОО

Улаанбаатар -Эмпати дунд сургуулийн багш Нямын Заяа.

“Бууж мордох хорвоо” бол ... жинхэнэ монгол сэтгэлгээг илэрхийлсэн магадгүй энэ анатологт (Монголын шилдэг өгүүллэгүүд ном) буй хамгийн сонгодог өгүүллэг ч байж мэдэх юм. Г.Аюурзана.

“20-р зуунд бүтээгдсэн Монголын урансайхны уранзохиолд цөөн биш сонгодог (классик) зохиолч зохиол өөрийн хууль зүйгээр нэгэнт гарч иржээ. Энэ бол өөр судалгаа, өөр дүгнэлт харьцуулал шаардах шинэ хэв төлөвийн сонгодог урансайханы зохиол юм” гэж багш маань “Ухаарахуй” номоо дуусгажээ. Мөн “гарсан цаг үеэс хойших бүх хугацаанд үнэ цэнээ алдаагүй дараа дараагийн үед шилдэг бүтээлийн жагсаалтад орж байдаг бүтээл туурвилыг сонгодог хэмээн тооцдог” гэжээ. Тэгэхээр С.Дашдооровын “Бууж мордох хорвоо” бол 20-р зуунд төрсөн сонгодог бүтээлүүдийн нэг мөн . Сонгодог бүтээлийг олон талаас нь судалж болно . Ялангуяа “Бууж мордох хорвоо” шиг гайхалтай бүтээлийг бүр ч олон талаас харж, судалж, сурч болно.

Нэг. Уран бүтээлийн аргын тухайд

А. Социалист реализмын арга

Эрдэмтэн судлаач Д.Галбаатар бүтээлдээ ... “Уран бүтээлийн арга гэдэг ойлголт нарийн нийлмэл төдийгүй хийсвэр ухагдахуун юм. Өөрөөр хэлбэл гүн ухааны тодорхой үзэл онолыг хүлээн зөвшөөрсөн зохиолчийн ертөнцийг үзэх хувийн үзэл, уран сайхнаар сэтгэн туурвих таалалт хэв маяг, санаа ба юмс үзэгдлийг дүрслэн илэрхийлэх өвөрмөц барил, бүтээх авьяас чадварын нийлбэр тогтолцоо гэж үзэх нь зохистой юм. Эдгээр зүйлс тодорхой зарчмуудаар дамжин зохиолчийн зохиол бүтээлийн эд эсэд нэвчин шингэж оршдог зүй тогтолтой”... Монголын уранзохиолд реалист, реалист бус хоёр үндсэн арга чиглэл эртнээс бүрэлдэн бий болж ...нийлэг байдлаар хөгжиж байгаад 1940 оод оны сүүл үеэс дан ганц “социалист реализм” ноёрхогч байртай болсон дүр төрх харагдаж байна”...үүнээс өөрөөр хөгжих арга зам ч үгүй байсан” гэжээ. Чухам энэ үед С.Дашдооров уран бүтээлээ эхэлсэн ид үе билээ. Тиймээс тэр уран бүтээлээ социалист реализмын аргаар бүтээхээс аргагүй. Социалист реализмын арга гэдэг бол тийм муу зүйл биш. Энэ бол дэлхийн уран зохиолын нэг гол чиглэл бөгөөд юмс үзэгдлийг учир зүйн холбоо, хөгжил хөдөлгөөнд нь бодотой дүрслэх, үйл явдлын мөн чанарыг нээхдээ

оюун санаа хийгээд амьдралын нөхцөл байдлын онцлогтой уялдуулсан үнэн байдлын дүр зураг, амьдралын урансайханжсан үнэн, үзэгдэл явдлын учир зүйг сайхны зарчимд нийцүүлэн дүрслэх арга юм. Уулаас хүн төрөлхтөн сайхан зүйлд л дуртай билээ. “Бууж мордох хорвоо” өгүүллэг нь бүхэлдээ монгол нутгийн хөдөөгийн амьдралын нэг хэсгийг шууд дуурайлган дагуулж бичээд түүнээсээ хүсч байгаа зүйлээ нээн гаргасан реалист зохиол мөн. С.Дашдооров зохиолчийн тэр хүсч байгаа зүйл нь монгол эр хүний жудаг, хүн чанар, хүний мөс, өв уламжлал, бүр гүн утга нь буугаад л морддог хорвоогийн үнэн.

Реализмын үнэн гэдэг бидний харж байгаа амьдралын үнэн биш, үйл явдал, үзэгдлийн цаана байгаа үл үзэгдэх үнэн байдаг. Тэр үнэн зохиолчийн хүссэнээр ч биш сайн бүтээсэн дүрийн хөгжлөөр гарч ирдэг үнэн юм. Тиймээс реалист зохиол бол бидэнд, бидний хүсдэг үнэнийг бүтээж өгдөг бололтой. Олон хүн сайнтай муутай, уулын мод урттай богинотой гэхдээ бидний туулсан ялангуяа социализмын сүүлийн он жилүүдэд:

... малд нүдтэй ...төрийн нуруу түвшин, малын бэлчээрт уулзсан хүнтэй мориноосоо бууж хүндлэн, хөөрөг зөрүүлэн угтаж, үдэх, насан өөд болсон хүний гэгээн цагаан мөр, ач тусыг дурсан ярьж, мөнх галын бяцхан тасархай зул өргөн зориулдаг сайхан заншилтай, халуун хошуут малыг сайн сайхны бэлгэдэл болгон тайтгардаг...мал сүргийн бэлчээрт ... хүний амьдрал, нас намтар үндэст өвс ногоо мэт урган дэлгэрч, гандан гундаж, мөнх бусын салхин хүрдэнд автан нисдэг орчлонгийн жам ёсыг уяран ухаарч, эрт эдүгээг эргэцүүлэн тунгаадаг, нутаг ус, айл саахалтынхаа нэр төрийг өргөн явах... хүний арчаа овсгоог, буурлуудаасаа сурсан... өвгөдийн сургаалыг санаж... хүмүүс бид бие биедээ хэчнээн ч их өртэй байх юм бэ дээ (4) гэж ухаардаг **монгол хүнийг,**

...морио амгайвчлан чөдөрлөж, налайх хонио хараад ...хөх тэнгэр өөд саравчлан...хурга мал тонших шувуу үгүйг анзааран ажиглаад...эхээ даган нялх ногоо гоочлох шинэ төлийг харж баясдаг...малынхаа өнгө зүс сэргэг чийрэг, цовоо цолгиныг харахдаа сэтгэл нь хөөрдөг, малын мөр, тэнгэр нар салхины аясыг тайлах эрдэмтэй, малд хайртай, эрэл сурлын хүнд тус хүргэхийг нэр төрийн хэрэг хэмээн мөрддөг, ядарч зүдэрсэн хүнд тус дэм болохыг ариун үйл гэж баримталдаг малчин монгол хүнийг,

...Шар ногоон дурдан бажгар өргөн гэгчийн ороож, хошмогтой цагаан эсгий тоорцог чихийг нь сөхөн өмсч, товхийсэн мөнгөн тоногтой эмээл хазаар тохож, зун бол бэлгүй хэт зүүн, өвөл бол хутга савх сэлтийг бүрэн зүүдэг, адуу дайралдвал унага дааганаас аваад азарга морьдыг хүртэл шинжиж, сайн

морь унаж, эдэлж унасан морь нь хэзээд өнгөлөг, эцэж цуцсан, унаширч гундсан явах нь үгүй, айлын босго алхан орж ирвэл эзэгтэй нар хүндэтгэн идээ будааныхаа дээжийг барьж, гэрийн эзэд хууч яриа дэлгэж, хурдан морио шинжүүлэх гээд, зам нийлэх ч юмуу, ажил төрөлд хамт явснаа аз тавилан хэмээлцэх, ойр дөт үерхэж, айлсаж саахалтлахыг захаас аван хүсэхээр, бэлчээр ус таньдаг, бичиг ном мэддэг, хүний тусыг эрж хүүе хаая гэж хошуу цорвойдоггүй, хос морьтой дэвэлзэн газраас ургасан мэт гарч ирэн дөрөө мултлах монгол эр хүнийг, үгүйлэх болж, үндэсний өв уламжлал, зан заншил, сааралтах болсон бизээ. Орчлон эргэдгээрээ эргэж, хүн ‘төрдгөөрөө төрж, амьдрал үргэжилдгээрээ үргэлжлэвч яах аргагүй “хөгжлийн” шалтгаанаар ийм монгол хүн цөөрөхийг Дооров зохиолч анзаарчээ. Үнэхээр энэ бол зохиолчийн монгол эр хүн ийм байх ёстой, ийм эрчүүд байхад монгол монголоороо байх тухай туйлын хүслийг илэрхийлсэн реалист дүр дүрслэл мөн. Реалист арга амьдралыг хэдийгээр гоёчлон харуулдаг гэдэгч энд байсан гоёыг байхгүй болчих вий гэж урнаар дүрслэн үзүүлж үлдээжээ.

Б. Натуралист арга

Одоогоос хэдхэн жилийн өмнө С.Дашдооровын уран бүтээлийн натурализм гэж яривал юу болох байсан бол. Харин өдгөө үгийн урлагийг зөвхөн нэг арга барилд тохируулан тайлбарлах биш өөр олон талаас нь судлах өргөн бололцоо нээгджээ.

Зохиолч С.Дашдооров энэ өгүүллэгээ бичихдээ дан ганц реализм биш Монголын уранзохиолд уулаасаа байсаар ирсэн натурализмын аргыг ч ашигласан байна. Натурализм буюу хуулбарлах арга манай шинэ уранзохиолд 30,40-өөд онд байсныг үзэл сурталгүй, урансайхангүй хэмээн “нам дарсан” мэтээр уранзохиолын судлал түүхэнд бичдэг. Гэтэл уран бүтээлийн аргууд нэг улсын бүхэл уранзохиолын түүхэнд биш бүр нэг зохиолчийн нэг зохиолд нь нийлэгшин оролцдог байна. Энэ тухай судлаачид ч тэмдэглэсэн байдаг.

... “Төгөө ганц чүдэнзээр асаасан тамхиныхаа галыг ган төмөр толгойг нь гарынхаа эрхий хурууны өндгөөр байн байн дарж, цогийг нь бөхөхөөс урьган хавтаганыхаа мөнгөн тээгэнд сурмагхан цохиж шинэ утгасан тамхиа асаан угсран татаад ... түгдийн завилж суусан биеэ цэгцлэн... гансны толгой дахь цогтой үнсийг гарзшаасан янзгүй хий үлээн хүүдийтэй тамхиа аанай л дадсан зангаараа бүсээ тэмтчин баруун нуруундаа тээгээр нь бөх гэгч хавчуулж, ...шороо чулуу шүжигнүүлэн алхаж ирэх чимээнээр хажуулдаж хэвтсэн морь нь эзэн рүүгээ нэгэнтээ соохогсхийн харснаа залхуутай гэгч нь чөдөртэй хөлөө тэлчлэн босов. Тэгснээ эмээлийнхээ гөлөм дөрөөг шигшин

шилгээхэд нь Төгөө амандаа “шийг шийг” шившиж, мориныхоо толгойд эвхсэн жолоо цулбуураа тайлан хазаарлаж чөдрийг нь аван ганзагалаж, биеийн чилээг гарган хэдэн алхам хөтлөн явснаа мордон хоёр тийшээ холдон явсан хониныхоо хойноос...өөрийгөө саатуулан харж байснаа нугалж суусан өвдөгнийхөө ойр гарт өртсөн жижиг жижиг чулууг хэд гурваар нь нь түүн, тэгснээ солгой гарынхаа алгыг дээш харуулан эвэршиж бяцарсан таван хуруугаа эрхийнээс нь эхлэн хэдэнтээ дарж тэнийлгэн өдөр гарагийн тооцоо хийв. Тэр, Хангай өвгөнийг хэзээ нутаглуулах нь вэ гэж тунгаан үзжээ. Тэгээд маргааш юм байна гэж өөртөө өгүүлэн хонь малаа харж ахин чулуу түүн алгандаа өнхрүүлэн саатав” гэх мэтээр тоочиж дүрслэн бичсэнийг хээрийн хоймор, малын бэлчээрт суугаа Төгөө өвгөний дүр байдлыг хуулбарлах аргаар бичсэн байна гэж үзлээ.

Өгүүллэгийн дотор ийм дүрслэл их бий.

Энэ тухай эрдэмтэн Д.Галбаатар “Ийнхүү баатрынхаа үйлдэл, үйл хэрэг,орчин амьдралын хэв төрхийг хэсэгчлэн бичиж тэдгээрийг тусгай холбоосуудаар хэлхэх явцдаа илүүц байж болох юухан хээхнийг ч болов орхигдуулахгүйг хичээсэн иймэрхүү барил бол натурализмын фотографийн бичлэгийн үндсэн гол хэлбэр юм”(3-255) гэсэн байна. Натуралист чиглэлийн гоо сайхны үзэл баримтлалыг “фотографизм” “биологизм гэж хоёр хуваадаг ажээ.

Дээр өгүүлснээр сайн дүрийн хөгжил нь цаашид яаж үргэлжлэхийг шийддэг үүднээс хонио хариулаад ертөнцийг бясалгаж яваа монгол өвгөнийг ингэж л дүрслэхээс өөрөөр нэмж чимэх хэрэггүй бөгөөд урансайханжсан үнэн болговол худлаа болно.Тэгэхээр энэ өгүүллэг бол уранбүтээлийн аргын хувьд дан ганц реалист аргаар бичсэн зохиол биш юм.

Хоёр. Өгүүллэгийн дүрийн тухайд

Өгүүллэгт ердөө дөрвөн өвгөний дүр гарна. Уранзохиолын дүр бол бодит байдлыг дүрслэн гаргах арга гэдэг. Дүр бол тухайн зохиолдоо бодит байдал аж амьдралыг тусгаад зогсохгүй, зохиолчийн ертөнцийг үзэх үзэл, сэтгэл зүйн хувиралыг илэрхийлж байдаг. Давтагдашгүй дүрийн гол онцлог бол зан төрх гэдгийг эрдэмтэн Ч.Билигсайхан чухалчлан дурджээ. Үнэхээр хүмүүсийн дунд адилхан андуурмаар хүн зөндөө харин тэдний сэтгэл яагаад ч давтагдахгүй.

Хангай өвгөн нутаг нугынхандаа “Ангаа” хэмээн авгайлуулж дуудуулж явсан...хамгийн хүндтэй хүнийг нэрлэн дууддаггүй монгол ёс бий билээ.

Хангай нутаг усандаа ямар байр суурь эзэлдэг хүн болохыг авгайлан хүндэтгэхээс эхлээд олон дүрслэлээр илэрхийлжээ.

-За хүү минь тогоо шанагаа манаад л тоононыхоо утааг дурандаад сууна уу? Битгий тэгж бай зүдэг гэдэг юм...чамайг эхнэрээ хардаад энд тэндээс харуулдаж суудаг гэж тоглоом болно. Гэрийн эзэн гэдэг чинь гурван даваан чанадыг байг гэхэд, гурван гүвээн чанад санаа бодлоо бэлчээж явдаг юм. гэж хэлснээс хойш идэр залуу Төгөө уяа шонгоо эргэлдэн харуулдахаа больж, уул уулын бараа толгой ширтэж, ухаан бодлоо холын холд бэлчээхийг хэчээн орон гэрт хоргодоомтгой муу зангаа орхижээ.

Хангай өвгөн... сургуулийн хүүхдийн барилдаан үзээд ... хүүхэд хүүхдийг л “сайн барилд”, наад нүдээ хар гэм”, “цаад хөлөө гэм” хэмээх нь ирээдүйд зөвхөн миний хүүхэд сайн болоосой гэсэн ойрхоны бодолгүй, нутаг усандаа сайн бөх, сайн сайхан эр хүн төрөөсэй гэсэн холын холч ухаантай монгол эр хүний дүр.

Самбаа -Муу өвгөн чинь ийм хэл дуулаад яаж гэрт гэдийж суух вэ гэж бодоод ... Ангаагаа нутаглуулахад нь ёс төр гүйцэтгэлцэн бараа больё гэж шийдээд шогшиж явна... манайхан чинь Ангаагийн л амыг харж байсандаа... түмэнд нүүрийн буянтай хүн байждээ... гэж өгүүлэх Самбаа өвгөн жаран нэгнийхээ жилийг ардаа хийсэн,залуус харчуудад өвгөд настан гэж хүндлүүлэх насандаа ирсэн, хэл зар нрээгүй байхад хүндэтгэн очих ёстойгоо мэдэх монгол эр хүний дүр.

Төгөөг орь залуу явахад... нэр төрийг өргөж өгөөд зогсохгүй амьдралынхаа туршид дагаж мөрдөх сургаал юугаа хайрласан, Хангай өвгөнийг өдий өвгөн настай болтол ачийг санаж явдаг энэ өвгөн, буугаад мордох мэт хурдан өнгөрдөг амьдралыг ухаарсан, зөвхөн монгол хүнд л байх сэтгэлээр халуун хошуут малаараа өвгөнийг сүүлчийн замд үдэж, үлдэж хоцорсон үр хүүхдийг нь баярлуулаад энэ үйлсээ би л хийсэн гэх биш, би хийх ёстой хэмээн сэтгэл өөг үлдэх, хүний ач тусыг үл мартах монгол эр хүний дүр.

Сад- Баян садын адуу чийрэг, догшин түүгээрээ ч гэрийн эзэн бахархана. Бараан голцуу таван азарга адуугаа хурааж, адуугаараа аагархан... ирсэн улсыг голж шилэх мэт алхаа гишгээ, харц нүд нь нэг л ондоо... багц багцаар багласан ногт чагт гарынхаа бугуй тохойд сэгсийтэл углан ирж ... арц унгатган ариулж ёслоод... “За муусайн нусгайнууд ... толгойг нь олохгүй ороолгож хөөгөөд ороо болгочихож мэднэ” гэж хэлж чадах, хүн голомтгой зантай энэ хүн бол ажилсаг, малч, арга ухаантайгаа хөрөнгөөрөө батлах монгол эр хүний дүр.

Өвгөдийн дүр бол уран дүр. Хэдийгээр реалист зохиолын дүрүүд хэв шинжит байх нь их боловч эдгээр өвгөд өөр өөрийн бусдаас ялгарах зан төрхтэй ялангуяа гол дүр болох Хангай өвгөний дүр бол сайхны тааллаар зурсан бодит байдал уран сэтгэмж хосолсон урансайхны дүр. Уран дүрүүд хүнд сайхны мэдрэмж төрүүлнэ. Хэв шинжит дүрүүд цаг хугацаа болоод нийгмийн хөгжлөөс хамааран тодорхой хэсэг бүлгийн төлөөлөл болж ихэвчлэн үлгэр жишээ баатрууд болон гарч ирдэг. Харин энэ өгүүллэгийн хувьд Монгол Улс байгаа цагт ийм монгол хүн байна гэсэн санаа гэж ойлголоо. Харин Хангай өвгөн талийж одсон нь өмнө өгүүлсэнчлэн ийм хүн, алга болж байгааг хэлсэн мэт санагдана. Гэхдээ түүнээс сурснаа залгамжлуулах Төгөө өвгөн үлджээ. Төгөө үргэлжлүүлнэ. Ингэж өв уламжлал үргэлжилнэ. С.Дашдооровын эл өгүүллэг ийнхүү хүн байхын утга учир, монгол хүний мөс чанар, жудаг, хэмээх онцлох чанарыг заах, сургахдунхаглах биш дүрслэн үзүүлэх аргаар гаргаж өгсөн дэвшилтэт зохиол. Энэ бол уранзохиолын гол үүрэг мөн. Зохиолч дүрийн зан төрхөө гаргахын тулд Төгөө өвгөний бодлоор бусад өвгөдийн зан төрхийг тодорхойлсон ба дүрийн орчин буюу малын бэлчээр, дэвшүүлж байгаа малчин монголын уламжлалт ухаан зэрэг нь үнэхээр зохистой болсон. Энэ зохиол “Амьддаа бие биеэ хайрлая хүмүүсээ” гэсэн агуу санааг хэлж байна. Буугаад л морддог хорвоо шүүдээ.

Гурав. Өгүүллэгийн уран дүрслэлийн тухайд

А. Далд утгат найруулга ба бэлгэдэх ёсыг ашигласан нь

Монголын эртний уранзохиолын түүхэнд далд утгаар бичих, утга далдлах тухай онол түүхийн номд дурдаж, эртний туурвигчид далд утгыг ихэд тоож, ихэс дээдсийн дунд хэлэлцэж мэтгэлцэж байсан ба С.Буяннэмэхээс хойш энэ томьёоллыг хүлээн зөвшөөрөөгүй гэдгийг эрдэмтэн Д.Галбаатар багш дурджээ. Анзаарвал далд утгат дүрслэлийн тухай яруу найрагт түшиглэн тайлбарласан нь их байдаг. Энэ нь дорно дахины яруу найргийн уламжлалтай холбоотой бизээ. Далд утгаар илэрхийлэх нь манай үндэстний хэл сэтгэхүйн онцлогтой холбоотой эртний мэргэдийн хэлснээр монгол хүн бэлгээр, хятад хүн бэнчингээр гэдэг. Үүний дээр монгол хэл бол утга далдлан бичихэд зохилдох баялаг өргөн баймж утгатай юм.

Бууж мордох хорвоо гэхэд энэхэн замбуутивийн амьдрал даяхнаараа, ирж буцдаг жам ёстойгоо, энэ ба хойд настайгаа, ихэс дээдэс үр хойчтойгоо, эгээтэй л уяран дуулмаар сонсголонтойёо багтаж байгаа их өргөн утга агуулга,далд ухааныг монгол хүн л ухаарах буйзаа.

... нэрсэн тамхиныхааутааг, төө урт цагаан хаш чулуун соруултай гаансаар хорыг нь саармагжуулан сорж тамшаалах нь тамхи татах биш монгол эр хүний гангараа, хаш чулуу эдэлсэн эр хүний яс хугарахгүй байхын бэлгэдэл байдгийг монголоос өөр хаана мэдэх билээ.

Хоёр өвгөн хэн хэнийхээ амар мэндийг асуулцан, харуусал уярлаа цайруулан хөөрөг тамхиа зөрүүлэн хэд гурван үг сольж, салж явахын тэмдэг болгон дахин тамхилахыг, энэ биед эрдэнийн чулууг тохирсон хэмжээгээр эдэлж хэрэглэхийн жишээ болгож бүтээсэн, эцэг өвгөдийн эрч хүч шингэсэн, үнэт чулуун хөөргийн учрыг монголоос өөр хаана мэдэх билээ. Японы сэтгүүлч зохиолч Ротару “Тал нутгийн тэмдэглэл” номдоо монгол хүнийг шуналгүй бөгөөд үнэт эдлэлийг хэрхэн хэрэглэж ирсэн тухай, хүнд алт хэрэгтэй юу хэрэгтэй тийм учраас нэг бөгж, мөнгө хэрэгтэй юу хэрэгтэй тийм учраас нэг мөнгөн аяга, эрдэнийн чулуу хэрэгтэй хэрэгтэй тийм учраас нэг хөөрөг хангалттай гэж монгол хүн үздэг тухай бахархан дурдсан байдаг.

Дайралдах олон адуу болон далай цагаан хонин сүрэг, халуун хошуут мал юуг арвижин дэлгэрэхийн үүд хаалга, ажил үйлс бүтэхийн аз дохио, амны хишиг буян хэмээн ард түмэн минь бэлгэдэж ирснийг монголоос өөр хаана мэдэх вэ?

Адуу чинь өснөө! Сүргийн чинь эзэн ирж хэмээн хадамд нь хэлсэн үгээр хүргэнийх нь нэр төрийг өргөж чаддаг, хүний, өөрийн гэж ялгалгүй хүмүүжүүлж, хойч үедээ итгэдэг холч монгол далд ухаан бидний өвгөдөд л бий.

Бид чинь энэ хойд үедээ Ангаагийн чинээ байр суурь эзэгнэн байна уу гэж өөр өөрийн үүрэг хариуцлагыг өөрөө ухаардаг, ийм нэг олондоо буянтай явах нас намба ирэх болов уу хэмээн хэрсүүждэг монгол хүний тухай үе үеийн уншигчид энэ зохиолоос ойлгож ухаарсаар иржээ.

Энэ мэтээр эл богинохон өгүүллэгийн дотроос задалж тайлан ухаарвал түмэн утгас дэлгэрэх ажээ.

Б. Зохиолын хэл найруулгад хоршоо үгийг хэрэглэсэн тухай

Хоршоо үг бол монгол хэлний нэг баялаг тал мөн бөгөөд анх Б. Ринчен гуай тусгайлан судалж эрдэмтэд өртөөлөн баяжуулсаар одоо 8000 гаруй хоршоо үгийн сан байгааг бүртгэжээ. Эрдэмтэн Д.Бадамдорж судалгаандаа монгол хэлний хоршоо үг нь шинэ ухагдахууныг тэмдэглэдэг, дан үгээс хавьгүй илүү багтаамжтай дэлгэр утга санааг нэвтрүүлдэг гэж тэмдэглэсэн байна. Үнэхээр хоршоо үг нь тухайн санаа, үйл явдлын эрчийг нэмэх лавшруулах, эсвэл бууруулж доройтуулах маш хүчтэй нөлөөтэй болохыг олон жишээгээр

баталж болно. Өнөө (хэн хэн) нь жаран нэгнийхээ жилийг ардаа хийчихээд явж байгаа (залуус харчуудад) (өвгөд настан) гэж хүндлүүлэн налайж суудаг насандаа ирсэн харин Хангай өвгөн тэднийг (багачууд хүүхэд) гэх юм уу залуус гэж гэж дуудах дуртай байлаа. Тэр (нас намбаар) нь ингэж хэлдэг байсан юм уу нэг бол (ажил үйлсээр) нь ч тэгж цэгнэдэг байсан юм уу... эсвэл ухаан зүг (самбаа сэхээгээр) нь ч хэлдэг байсан юм уу хоёр өвгөн хэн хэнийхээ (харуусал уярлаа) цайруулан (хөөрөг тамхиа) зөрүүлэн (хэд гурван) үг солив” (4) ...Хүн болгон л энэ (нэр төр) (итгэл найдварыг) хэрхэн өргөх нь вэ гэх шиг, зарим нь (шоолж сонжсон) янзтай жуумалзан харж (хөдлөх барихыг) (ажин анаж,) ... адуу (хуруулцан хашилцаж) (шинэ тулгар) уургачдыг (урамшуулан дэмжиж,) (ойлж цойлсон) (хэд гурван) адууг хэрхэн эргүүлэхийг хүүхдүүдэд зааж ...гэх мэтээр элбэг хэрэглэжээ. С.Дашдооровын

“Бууж мордох хорвоо” өгүүллэг 5000 хүрэхгүй (4605) үгийн сантай богино өгүүллэг боловч давтагдсан тоогоор 200 гаруй хоршоо үгийг зохиолоо найруулан бичихдээ оруулж санаа оноогоо хэрхэн хүчирхэг бөгөөд яруу илтгэснийг мэдэж болно. Энэ тухайд тусгайлан судлах боломжтой юм.

Төгсгөлд нь “Бууж мордох хорвоо” өгүүллэг бол социализмын үеийн ангич намч үзэл, үзэл суртал, өнөөгийн улс төр, ашиг сонирхлоос ангид, ямарч нийгэм, нийгмийн ямарч өөрчлөлтөөс хамааралгүй монгол хүн байхын утга учрыг өгүүлсэн сонгодог бүтээл мөн.

“Уранзохиол гэдэг ерөөс хүний амьдралын тухай бодрол, янз бүрийн зан төрхтэй хүмүүсийн хүрээлэн буй ахуй, байгаль хүнтөрөлхтөн, нийгэмтэй харилцах харилцааны давтагдашгүй өвөрмөц замналын түүх, энэ бүхнийг ухаарсан ухаарлын сургамж туршлага юм” гэж эрдэмтэн Ч.Билигсайхан бүтээлдээ дурджээ.

АЛИМНААС НЬ АМСАЖ, ДААГАНД НЬ СУНДАЛДАХУЙ...

/шүүмж/

Хүүхдэд зориулсан зохиол бол өсвөр үеийнхний хүмүүжилд нөлөөлж, тэдний танин мэдэх ухааны царааг тэлэхэд чиглэсэн байх учиртай. Тиймээс хүүхдийн утга зохиол нь хүүхдэд багш, эцэг эхчүүдэд зөвлөгч болдог юм. Ер нь хүүхдийн сайн зохиолд уншигчийн насны тодорхой зааг тогтооход түвэгтэй байдаг. Ойрмогхон би ахмад зохиолч С.Дашдооровын хүүхэд багачууд зориулсан нэг номыг уншлаа.

Төрийн шагналт зохиолч С.Дашдооров анхны ном зохиолоосоо эхэлж уран бүтээлийнхээ ихээхэн хэсгийг хүүхэд, залуучуудад зориулан бичдэг бүтээлчдийн нэг нь юм. Тэр 40-өөд оны хөдөө нутгийн сургууль, сурагчдын амьдралыг харуулсан “Дайны жилийн алим буюу сургуулийн зээрдээ” хүүхдийн номын “Их сүрэгт” нийлүүлжээ.

Зохиомжийн аятайхан хэлбэрийг олж, дурсамж маягаар бичсэн эл найруулал нь уншигчийг дайны жилийн алимнаас нь амталж, сургуулийн зээрдийг нь унаж үзэх хүслээр хөтөлж чадахуйц болжээ. Уул найраглалд дүрслэгдэж байгаа “би” болон түүний найз Өлзий нар шиг оргилуун их хүсэл эрмэлзэлтэй хүүхэд багачууд өнөөгийн сургуульд олон зуугаараа бий. Тэд их эрдэм ном сурч, ямар нэгэн гавьяат үйлс бүтээх хүсэл мөрөөдөлтэй явааг зохиолч олж мэдээд, түүнийг зохиолдоо тусгасан нь маргаангүй.

Эл найраглалын гол баатрууд нь хий дэмий санаагаа зовоож, хоосон бясалгах биш, амьдралд идэвх санаачилгатай хандаж байна. Үүнийг “би” болон түүний найз Өлзий хоёр дайнд явах гэж зэр зэвсэг дархалж, цанаар гулгаж сурах гэж торхны модоор цана хийж байгаа зэргээс харж болно. Нөгөө талаар өвлийн амралтаар олуулаа явж малчдад туслаж явахдаа сүргээсээ тасарч хунгарт шигдэж хоцорсон зээрд даага олоод, түүнийг тэжээж тэнхрүүлсэн зэрэг нь малчны үр хүүхдийн ажил үйлсийн тусгал болсон ач холбогдолтой. Бас дэлхийн II дайны үед монголын ард түмнээс зөвлөлтийн ард түмэнд үзүүлсэн сэтгэл харамгүй тусламжийн нэгээхэн хэсгийг

“Индрийн талбайд цугларсан

Хүмүүс нэг л хөгжөөнтэй.

Ижил ижил ачаатай

Тэмээд нэг л жавхаатай.

Аяны даамлын гарт

Улаан туг намирна.

Ачаа бүхний бөөрөн дээр

“Фронтод” гэсэн бичиг дурайна“ гэж өөриймсөг чин сэтгэл, цоглог өөдрөг өнгө аясыг тод томруун дүрсэлсэн байна. Үүнээс гадна олон талын авьяас чадвартай Ишгэн багшийн дүр бол тэр үеийн багш нарын нэгэн өвөрмөц нийтлэг дүр болж чаджээ гэж хэлэх үндэстэй юм. Шавийн эрдэм багшаасаа гэдэг нь багш хүн, сурагчдад хэр зэрэг үлгэртэйгээр нөлөөлснөөс шалтгаалах зүйл. Энэ нь

“Аливаа юмыг багш шигээ

Сурч мэдэхсэн гэж

Арга эвийн нь олоод багш шигээ

Гоёхон бичдэг болохсон гэж” сурагчид хичээн дууриаж байхад,

“Авьяас эрдэм хосолсон

Аргагүй сайн багш гэж

Энэ багш шигээ хүүхдүүд минь

Эрдэм номд шамд гэж” ард олон үр хүүхддээ сургамжилж захиж байгаагаас тодорхой байна.

Зохиолч, хүүхэд сурагчдын хоёр дахь гэр нь болсон сургуулийн тухай чамлалтгүй дүрслээд,

“Тэр сайхан ордон руу

Сүрдэн сүрдэн дөхөж

Тэнгэрт ойрхон дээврий нь

Өлийн өлийн дөтөлж

Худгийн асгар арилаагүй

Гутал юугаа цэмцгэрхэн гишгэж,

Хурганы бэлчээрээс холооогүй

Сэтгэл юугаа цээжиндээ тээсээр” ирж анх сургуульд орж байгаа хүүхдийн сэтгэлийн хөдлөлийг эвтэйхэн илэрхийлсэн байтлаа,

Дэлгэж урдаа тавьсан

Дэвтрээсээ хүртэл сүрдэж

Хуруу гартаа барьсан

Харандаа юундаа түүртэж” байгаа нь тэр үеийн сурагчид юм юмнаас айдаг, үхээнц дорой байжээ гэхээр барахгүй нөгөө сэргэлэн цовоо, урагш тэмүүлсэн хүсэл эрмэлзэлтэй баатруудынхаа зан чанартай урвуу харьцаатай болж байгаа юм биш үү?!

Уул нь зохиолч маань сурагчдын даруу төлөв, сахилга бат сайтай дүр төрхийг гаргах гэж бодсноо арай гаргаж чадаагүй бололтой.

Өөр нэг ажиглагдсан юм бол 40-өөд оны үед өлийн өлийн харахаар тэнгэрт ойрхон дээвэртэй олон давхар битгий хэл хоёр давхар байшин суманд байтугай аймгийн төвд ч байгаагүй шүү дээ.

Зохиолын “би” гэдэг баатрын өгүүлж байгаагаар түүний найз Өлзий баахан эрх танхи бөгөөд,

“Холдсон ботго эргүүлэхдээ

Хойрго гэдэг яриангүй

Хонь малд явахдаа

Хоргодоо гэж аргагүй” зантайг зөвтгөдөггүй мөртлөө, аав ээжийнхээ нүднээс далдуур,

“Амттай сайхан чихэр

Авдар савнаас авах” зэргээр болохгүй, бүтэхгүй хэрэг түвэг гаргахдаа,

“Хоёр биенийхээ нууцыг

Гойд сайн хадгалдаг

Хоёр зүрхний зовлонг

Хосгүй сайн мэддэг“ нь жирийн сайхан үерхэл болон шударга үнэнч байхын үнэ цэнийг бууруулж, зөвхөн болчимгүй буруу явдлаа нуун хаацайлахад хэрэгтэй мэт ойлголт өгч байна. Өнгөрсөн явдлыг бичихдээ түүнд өнөөгийн байр сууринаас хандах ёстой юм. Энэ нь одоогийн хүүхэд сурагчид амьдралын үзэгдэл юмст илүү их шүүмжлэлтэй хандаж, шүүн тунгаадаг болсон онцлогийг харгалзах хэрэгтэй гэсэн үг юм. Гэхдээ амьдралын зөрчлийг бүрхэгдүүлэх биш, буруу юмыг жигшүүлэх эвтэй арга хэлбэрийг олох нь хамгийн чухал юм. Түүнчлэн хүүхдийн гэнэн хөгтэй явдлыг гаргасан уг найраглалын наймдугаар бүлэг нь хэтрүүлэл ихтэй учир үнэмшил багатай болсон шиг санагдана.

Нөгөөтэйгүүр уул найраглалаа бүтээж урлахад яарсан тал харагдана. Үүнд:

“Заагдсан хичээлдээ овоо

Заримдаа дунд, голцуу сайн авна.

Захирлын тушаалаар

Шагнал урамшил ч хүртэнэ” гэсэн шиг ур муутайхан бадгууд тааралдахын хамт “Охорхон зуур гэмшив”, “Аагтай хөлс ханхлуулна”, “Монхор цагаан магнай”, “Эсгий нэмнээ ч өмсгөв” гэх зэргээр онож хэрэглээгүй буюу учир шалтгааны хувьд эргэлзмээр үг хэллэг ч цөөнгүй байх юм. Эдгээрийг утга шилжүүлэн хэрэглэсэн гэж булзааруулан цагаатгая гэвч буруу нь бултайгаад байх тул хойшдын бүтээлдээ аар саар ч болов анхааран үзэж байгууштай.

Ийнхүү С.Дашдооровын авчирсан алимнаас амсаж, унаж ирсэн дааганд нь сундалдахуй ийм бодол төрөв.

*Яруу найрагч Б.Монголхүү
1978 он*

”ДУРСАМЖИЙГ ДУРААРАА НЭЭХҮЙ”

Г. Наранцэцэг /ХУД-ийн ГХГС-тай 18-р сургуулийн багш/

...Төрийн шагналт ардын уран зохиолч С.Дашдооров бол монголын зохиолчдын дунд үеийн “утга зохиолын буянт өргөөнд төрөгчид”¹-ийн нэгэн билээ. Нэн ялангуяа жар.далаад оныхон андахгүй гэхэд хилсдэхгүй биз ээ. Учир юун хэмээвээс дунд сургуулийн сурах бичгээс эхлээд урлаг утга зохиолын «алтан фонд» -ын мөнхийн өв болсон “Өндөр ээж” /кино/ туужийг дурдахад болох буй за.

Тэрээр өөрийнхөөр нь “хөдсөн дээлтэй”балчир нас, бага сургуулийн сурагч ахуй үедээ “ӨӨРИЙН УЧИР” -ыг олсноо гуч гаруй жилийн дараа дурсамж тэмдэглэлдээ өгүүлжээ.. Эл дурсамжаас үүдэн авах ухаанаар зарим сэнээг дэлгэн өчүүхэн миний зүгээс тайлахыг чадан ядан зорьсон билээ. Түүний бичсэн “ӨӨРИЙН УЧИР”- д ирээдүйд зохиолч болох хүсэл эрмэлзлээ олж бэдрэн явах зэмд ямархан хөгтэй учрал тохиолдсоныг.хүүхэд насны гэнэхэн бодолд хөглөгдөн “...Би дөрөвдүгээр анги төгсөөд цаашаа сургуульд явахгүй бол том болоод, шилийн сайн эр болохыг бодно...” гэх сацуу үргэлжлүүлээд сургуульд явбал жолооч юм уу, зохиолч болохоо ярьж, найздаа нэг их худлаа яримаар санагдаад ирэв... хэмээгээд сумын улаан булангийн эрхлэгч Содномдоржийн зохиолыг өөрийн мэтээр “аан уун”-гүй хөөрч орхиход Хоролсүрэн найз нь ихэд сонирхсонд улам “давс нэмж” ярьсан нь хожим зохиолч болсон хойноо үнэн учраа хэлсэнд хэн ч итгэсэнгүй харин зохиолчийн авьяас багад тодорсон гэсэн ойлголт төрүүлээд зогссонгүй /өнгөрсөн борооны хойноос цув нөмрөх гэгчээр/ хийсэн хэргээ запруулах боломжгүй санагдавч нөгөө талаас нь харвал санамсаргүй дэггүйтэн худлаа ярьсанд нөхөр нь сонирхон анхаарвал урам орсон балчир хүү ирээдүйн зохиолчийн “сэтгэлийн хий”, зохиох туурвих бяцхан галыг өдөөж өгсөн гэлтэй. Мөн балчир оюунд ирээдүйн зохиолч бууж байсан нь сонин.

Түүнчлэн зохиолч уран бүтээлч хүний сайн муу зовлон жаргалын нэг “төрсөн хүүхэд” бүтээл номын эхний хэлэлцүүлэг шүүмжийг уншигчид хийдэг гэдгийг”...цуг төгссөн бидний арав гаруй хижээл улс, «Нэг ангийн хүүхдүүд» хэмээн нэгэн удаа сумын наадмаар аминчархан уулзсан...нөхдийн хэн нэг нь «Говийн өндөртөө» чи хүн цүлсдүүлсэн байдаг шүү. Ухаан нь хамар Жамбаа гэж эгэл нэгнийг гаргууд панзчин болгож бичсэн байна лээ. гэхэд зохиолч палхийн гайхаж, «Хамар Жамбаа гэж бодит хүн байдаг юм уу» гэвэл «Байхаар барах уу» гэгцгээв. хэмээснээс тав алдсанаа бичсэн байдгаас

үзвэл хэдийгээр зохиолч сонин содон хэмээн дүрээ бичдэг ч бодит амьдралаас л дүр урган гардаг гэдгийг батлах мэт болжээ. Бас ч нэг нутаг усныхан төсөө сэтгэдэг гэхэд хилсдүүлэхгүй болов уу. Мөнхүү Мангар Дамдинг би байгаа юм гэх хүн ч гарч байсан нь дээрхийн жишээ гэлтэй.

Зохиолчийн тэр бүр хүнд анзаарагдаад байдаггүй “монгол хүний жудаг” болох...ахмад хүний нөмөр нөөлөгт орж ...явснаа дурссэн нь хүний тусыг санаж талархаж чаддаг тэр дундаа ахмадуудаас суралцдаг байснаа “ЗҮҮНХАРААД БОЛСОН УУЛЗАЛТ” дурсамж тэмдэглэлд тодорхой өгүүлсэн нь буй. ”Би одоо боддог юм. Над шиг шальдар хүүхдийн цээжинд асч ядан байсан уран зохиолын авьяас, зүтгэл хичээлийг тухайн үедээ Сэнгээ гуай асааж өгсөн юм... Анхныхаа халтар хултар шүлгээ уншин танилцаж ахар богино хугацаанд боловч түүний дэргэд уран зохиолын нэгэн цэрэг нь болон ажиллаж явсан надад, түүний тухай сэтгэгдэл, тод дурсамж яриа зөндөө байдаг ч...” Зүүнхараагийн уулзалтыг цохон тэмдэглэсэн нь уран бүтээлийн замд эргэлт буцалтгүй оруулж өгсөн их ачийг санасных ч байж болох талтай ажээ. ”Сэнгээ гуай манай өнөөгийн утга зохиолын залгамж үеийг өсгөн бойжуулахад чин санаа өвөрлөн ажиллаж байсныг...цохон” санаж дурсан бичсэн нь одоогийн зарим ”би” гэсэн нөхдөд нэгийг бодоход тустай буюу. ХЭМЭЭНЭ.

Эгэл даруухан “говийн их монгол” хэмээн үеийн зэргийн нөхөр С.Эрдэнийн үг зүгээр ч нэг үг бус уу.

НОМ ЗҮЙ

1. С.Дашдооров “Зүүнхараад болсон уулзалт” 1986 он
2. С.Дашдооров “Өөрийн учир” 1995 он
3. ”Монголын-Уран Зохиолын Дээжис” Боть.39, 1998 он

2015.11.09 УБ хот

ШУУРГАНААР ТӨРӨГСӨД

/Өгүүлэл/

Ахмад найруулагч, зохиолч Цэмбэлийн Ням-Осор

Түвдэнгийн Бор. Энэ хэн бэ? Манай Монголын ард түмний сэтгэл зүрхэнд мөнхрөн үлдсэн. Ялангуяа залуу үеийнхний маань бахархал тэмцлийн туг БНМАУ-ын баатар бүсгүй. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын МХЗЭ-ийн үүрийн дарга асан халхын домогт баатар бүсгүй юм. 1963 онд Хөвсгөл аймгийн соёлын ордны тайзан дээр энэ бүсгүйн дүр амилан боссон юм. Энэ нь ардын уран зохиолч, төрийн шагналт С.Дашдооровын “Шуурганаар төрөгсөд” жүжиг байлаа. 1950-60-аад оны үед Монголын залуучуудыг социалист эх оронч пролетарийн интернационалч үзлээр хүмүүжүүл гэсэн уриа лоозон дэвшүүлж эвлэлийн байгууллага олон хэлбэрээр суртал ухуулга хийж залуучууд ч идэвхтэй хамрагдаж байсан юм. 1946 онд хуралдсан МХЗЭ-ийн 11-р их хурал дээр маршал Чойбалсан хэлсэн үгэндээ: “Хаана бадрангуй эх оронч үзэл, идэрчүүдийн цог золбоо, амь биеэ үл хайрлах газар байна тэнд МХЗЭ-ийн гишүүд хамгийн түрүүнд нь байдаг байсан” гэж онцолсон байдаг. Тиймээ тэр үнэн. Яг тийм байсан. Жишээ нь эх орон тусгаар тогтнолынхоо төлөө харийн булаан эзлэгчдийн эсрэг халуун амь, бүлээн цусаа үл хайрлан тэмцэж баатарлагаар амь үрэгдсэн хилчин баатруудын аймшиггүй чин зориг хатуу тэвчээрийг ухуулга ярианы гол сэдэв болгон хэлж байсан. Яг энэ үед зохиолч С.Дашдооров “Шуурганаар төрөгсөд” гэдэг жүжгээ бичиж, баатар охин Борын амьдрал тэмцлийн үнэн явдлыг уран сайхны уран дүрээр тодруулан гаргаж ирсэн нь жинхэнэ цаг үеэ олсон, сэдвийн зөв сонголт байсан юм. Цаг үеэ өргөн харж зохиолын сэдвийг ингэж оновчтой сонгоно гэдэг бол зохиолчийн билгийн мэлмий хурц, мэдлэгийн цар хүрээ ямар өргөн байсны жишээ юм. 1930-аад оны их хэлмэгдүүлэлтийн жилүүдэд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Хятад Монголын хилийн ойролцоо байсан айлуудыг албадан хил давуулан урагш нүүлгэх бусармаг үйл ажиллагаа явуулж байсан хилийн дээрэмчдийн өөдөөс сумын эвлэлийн үүрийн дарга Т.Бор тэргүүтэй залуучууд зориглон босож хувьсгалт ухуулгын ажлыг ард олны дунд маш хүчтэй зохион байгуулж байсан. Тухайн үед Монголын төр, засгаас бүх нийтийг хамтралжуулах алдаатай бодлого явуулж байсныг дээрэмчид овжин ашиглан ардын засаг та бүхний мал хөрөнгийг хураан авч байна. Тэр шунахай аюулаас өрсөж улсын хил даван нүүцгээ. Тэнд тайван жаргалтай, сайхан амьдарцгаа хэмээн хилийн дээрэмчид ард олныг ятган үймүүлж байхад Бор тэргүүтэй эвлэлийн гишүүн залуучууд дээрэмчдийн ятгалганд үнэмшиж эх нутгаа орхин харийн нутаг руу бүү нүү гэсэн дайчин

ухуулгыг ард нийтийн дунд явуулж олны итгэлийг хүлээсэн эгэл ардын охид, хөвгүүд байлаа. Ингэж нүүлгэнэ нүүлгэхгүй гэсэн эсрэг тэсрэг хоёр тэмцэл өрнөж хэн нь хэнийгээ вэ гэсэн мэсгүй тулалдаан үргэлжилж эвлэлийн гишүүн залуучуудын тэмцэл амжилт олж дээрэмчдийн бусармаг үйл ажиллагааг таслан зогсооход хүрч байсан учраас дээрэмчид юуны түрүүн Борыг баривчилж хороох хуйвалдааныг сэм далдуур явуулж байхад нь урвагч Бажаа (Мажигсүрэн) дайснуудад нууц мэдээ дамжуулж Борыг баривчлуулж хориод элдвээр тарчлаан зовоовч түүний мятрашгүй эх оронч хатан зоригийг мохоож чадахгүй болохоороо тэнд байдаг тугийн цохио хэмээх зуугаад метр өндөр хадан цохион дээрээс түлхэн унагааж алтан амийг нь хороож хорон санаагаа гүйцээсэн байдаг. Аймшиггүй эх оронч энэ баатарлаг охины дүрийг зохиолч С.Дашдооров “Шуурганаар төрөгсөд” жүжгийнхээ гол баатар болгон дэвшүүлж тавьсныг Хөвсгөл аймгийн соёлын ордон өөрийн тайзнаа хамгийн түрүүнд амьдруулж тоглосон юм. Жүжгийн тоглолт сайн болсныг хоёр баримтаар хэлье.

Улсын баатар Борын дүрийг жүжигчин О.Лхагваажий бүтээсэн билээ.

Бор (Лхагваажий) - Тугын цохион дээрээс унаж нарт хорвоогоос үүрд халин одохын өмнөх мөчид тэнгэр өөд хараад “Хөх тэнгэр, алтан дэлхий, эх орон минь залуу халуун арван найман нас минь баяртай. Би амьд шүү, амьд. Муу сайн дээрэмчид та нар маргааш үхнэ. Хувьсгалт залуучуудын эвлэл манд..”. гэнгүүт мандтугай гэдэг үгийг нь гүйцэд хэлүүлэхийн завдалгүй цохион дээрээс түлхэн унагаахад Борын эх оронч сэтгэлийн тэр их очийг хөгжмийн эгшиг гүйцээн нир хийн нижигнээд үзэгчид яанаа гээд дуу алдан босож байсан юм. Зохиолчийн үзэл санаа зохиолд нь заавал шингэсэн байдаг. Тэгвэл С.Дашдооров зохиолчийн өөрийнх нь үзэл бодол жүжгийн энэ туйл хэсэгт байгаа. Үүнийг жүжигчний уран чадвараар амьдралын үнэнийг урлагийн үнэн болгож чадсан байна. Өөр нэг жижиг хэсэг гэвэл малчдын хурал дээр хувьсгалт ухуулга хийж байсан сумын зарлага Сайнбуян (жүжигчин Сандагдорж) “дээрэмчдийн үгэнд үнэн юм нэг ч байхгүй. Та нар тэдний ятгалганд үнэмшиж эх орноо орхин гарвал насан туршийн харамсал болно” гэсэн үгийг урвагч Бажаа сонсоод: “Чи муу нохой зайл, эсгий хийх газар нохой хэрэг байхгүй, амь мэнд дээрээ сүүлээ хавчаад яв” гэхэд Сайнбуян: “Би зарлага ч гэсэн засгийн төлөөлөгч шүү” хэмээн мөчөөгөө өгөхгүй үзэлцэж байгаа хэсэг нь өхөөрдмөөр бөгөөд цоглог үйлдэл байдаг. Ер нь жүжгийн сайн зохиол анхны уншилтаар өнгө төрх нь босоод ирдэг. Тийм бол “Шуурганаар төрөгсөд” жүжгийн өнгө нь булингар татсан зэвхий саарал дүр нь бөөн улаан шуурга байсан. Өнгө дүр нь ийм тодорхой жүжгийн нэвтрэн гарах санаа

ээрэг ба эсрэг дүрүүдийн үйлдэл нь үзэгдлээс үзэгдэл, хэсгээс хэсэгт өссөөр байгаад туйлдаа хүрдэг. Тийм тод шугам, хурц шийдэлтэй жүжгийн амьдрах хугацаа урт, хавтсанд дарагдах нь бага байдаг. “Шуурганаар төрөгсөд”-ийг Хөвсгөл аймгийн соёлын ордны тайзан дээр тоглож байхыг МХЗЭ-ийн Төв хорооны нарийн бичгийн дарга Сүрэнжав үзээд их л сайшаан таашаалтай хүлээн авч жүжигчидтэй гар барин баяр хүргээд “Боломж гарвал та нөхдийг хотод урьж энэ жүжгийг чинь бүгд хурлынхаа гишүүдэд үзүүлэхийг бодно” гэж билээ. Тэр нь ч тэгээд бүтээгүй л дээ. Харин миний бие нэг удаа хот орохдоо жүжгийнхээ рекламанд тавьсан зургуудаа авч яваад С.Дашдооров зохиолчид үзүүлэхэд С.Дашдооров зургуудыг нэг бүрчлэн үзэж суухдаа том хар матруушиг гансандаа тамхи нэрж аваад асааж утааг нь таатай нь аргагүй уртаар үлээгээд цаасан дээр бичсэн дүрүүд минь тайзан дээр ямар жавхаатай гараав. Яг л мөн дөө үгүй энэ муу урвагч Бажаагийн байж байгааг. Жүжиг минь үзэгчдийн таашалд сайн хүрсэн бололтой их баярлалаа. Хөөрхий муу Бор минь гээд шүүрс алдаж байж билээ. С.Дашдооров зохиолч уран зохиолын бүх төрлөөр зохиолоо туурвиж байсан ховор авъяаслаг зохиолч байсан нь “Шуурганаар төрөгсөд” жүжгээс харагдаж байна. Жишээ нь үргэлжилсэн үгийн хүүрнэл зохиолд бол Бандгаа ламтан хилэгнээд нүүр ам нь үрчилсэн атгын чинээ болж суухад жижигхэн ооч сахал нь ишигний сүүл шиг годгонож байлаа гэх мэтээр баатруудынхаа нүүр царайг ийм тийм болж байна гэж бичдэг бол жүжгийн зохиолд тэгж бичихгүй дүрийн нүүр царайны хувирал нь жүжигчний дотоод сэтгэхүйн үйлдлээр аяндаа гараад ирдэг юм. “Шуурганаар төрөгсөд жүжгийг бүхэлд нь юмуу, бүлэг хэсгээр нь задлан үзэх юм бол дүр болгонд нь өөрийн гэсэн санаа, өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн аль аль нь шингэсэн байдаг онцлог бий. Ер нь “Шуурганаар төрөгсөд” жүжигт илүү буюу саарал дүр байхгүй. Харин олны хэсэгт давхардсан үг бий. Жүжгийн эерэг дүр Бор, Сайнбуян эсрэг дүр хилийн дээрэмчид Гэлэгсамбуу, хувилгаан лам Ганжуур, урвагч Бажаа нарын дүрд өгөгдсөн үйлдлүүд нь ил тод ойлгомжтой үзэгчдэд бахархах буюу жигших сэтгэлийг хэзээ ч мартахааргүй хадаж өгдөг. Чухам Т.Бороос бусад дүрүүд нь бодит юмуу уран сайхны дүр юмуу гэдгийг тухайн үед зохиолчоос нь лавлаж мэдээгүй гоомой шийдэл надад бий. Ер нь сайн зохиолын аль ч төрөл ялгаагүй хэзээд бэлэн гэдэг шиг аль ч нийгмийн үед үзэл санаа, ач холбогдол нь тухайн нийгмийнхээ байр суурьтай уялдаатай. Хэзээд бэлэн байж л байдаг. 1950-60 оны үед тоотой хэдэн зохиолчийн тоотой хэдэн жүжиг төвийн театруудаас хэтэрдэггүй байсан. Тэгэхэд С.Дашдооровын “Шуурганаар төрөгсөд” гараас гарангуут аймаг руу зочилж хөдөөгийн хөдөлмөрчдөд соёл урлагийн

таашаал хүртээж соён гэгээрүүлэх үйлсэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Хагас зуу гаруй жилийн тэртээ бичсэн тэр зохиолын, тэр онцгой чухал үүрэг, ач холбогдол нь зах зээлийн шилжилтийн энэ ээдрээтэй үеийн савалгаан дээр улам ч тодрон эх оронч үзлийн туг, уриа дуудлага болон гялалзаж байгаа юм биш үү. Одоо “Шуурганаар төрөгсөд” театрын тайзан дээр гарч ирэх юм бол эх оронч минь, газар шороо минь гэсэн тэмцлийг улам дэврээж залуучуудын эх оронч хүмүүжилд тодорхой хувь нэмэр болох нь эргэлзээгүй. “Шуурганаар төрөгсөд” жүжиг энэ чанараараа 1950-аад оны үеийн нэрийн хуудас болсон цөөн жүжгүүдийн сор нь байсан гэвэл зохилтой. Тэр цагт шуурганаар төрөгсдийг үзэж арван наймхан настай зоригт охины баатарлаг үхлийг харж сэтгэл өмөрч зүрх шимшрэн бөөн бөөн нулимс унагаж байсан тэр үеийн үзэгчид шиг үзэгчид одоогийн аль, ямар. жүжиг дээр байдаг бол? Тэр үзэгчдийн нулимс бол эх орны нулимс хайр, харуусал, бас бахархлын нулимс байсан юм. “Шуурганаар төрөгсөд” жүжгийг кино болгон гаргаж байсан нэг үе бий. Тэр нь тэгээд удаа ч үгүй чимээгүй болсон. Одоо кино үйлдвэрийн алтан санд байж л байгаа. Энэ олон телевизийн дэлгэцээр хааяа ч болов гаргаж баймаар байна. Яруу найрагч юмуу, үргэлжилсэн үгийн зохиолч хүн жүжгийн сайн зохиол бичиж болдог туршлага Ардын уран зохиолч, Төрийн шагналт Сормууниршийн Дашдооровын арга барил, чадал чансаанд байж л байсныг зохиолч нөхөд маань анзаарч буй бизээ. Миний бие “Шуурганаар төрөгсөд”- ийг судалж найруулан урлагийн тайзанд амьдруулж, үзэгчдэд хүргэсний хувьд уул жүжгийн тухай өчүүхэн дурсамж өгүүлэл бичлээ. Энэ бичвэр минь уран зохиолын бүх төрлөөр туурвиж байсан Дашдооровын уран бүтээлийн судлалд бага ч болов хувь нэмэр болоосой гэж хүснэм.

ДУТУУ АЛХАМЫГ ТАНЬ ДҮҮРГЭХ ГЭЖ ҮЛГЭР ҮҮССЭН БОЛОВ УУ?

СУИС-ТУС-ийн Урлаг судлал-2

Оюутан Өлзийгийн Оюунгэрэл

Монгол хүний зүрхэн бэлэгдэл нь дундуур биш дүүрэн бус уу?

Уран зохиолын зүрхэн тарни нь уламжлалаас бүтэх үлгэр бусуу?

Амар тайван амьдрал гэдэг айдасгүй цаг үеийг хэлнэ хэмээн би боддог. Тэгвэл бид амгалан тайван байдалд байна уу? эсвэл айдасын бараан үүлэнд нөмрөгдөж байна уу? хэмээх асуулт урган гарна. Бид хувьдаа өөрт оноогдсон үүргээ биелүүлэн хэв журмыг сахин хэн хэндээ хал палгүй явж чадваас Монгол шиг амгалан орон хаана ч үгүй ээ. Тэр ч үүднээс өөрсдөдөө эс бөгөөс одоогийн төрийн тэргүүн гэгдэх тархны судас нь нарийсчихсан улсад талархан шагших биш бидэнд энх амгалан эх орныг бүтэн үлдээхийн тулд халуун амь бүлээн цусаа урсган тэмцэгч хүмүүсийн төлөө бид одоо ч залбирах ёстой.

Тэдгээр хүмүүсийг болоод тэр үйл хэргийг нь их бага хэмжээгээр уран сайхны хэлээр болон яриан хэлээр бидэнд үлдээсэн уран бүтээлчдийн бүтээлийг дэлгэрүүлэн, задлан судлах нь зүйн хэрэг. Тиймдээ ч тэр хэцүү цаг үеийн хэсгийн хэсгийг үүдэл болгон авч зохиол бүтээлдээ шингээсэн зохиолч С.Дашдооровийн олон сайхан бүтээлүүдээс нь бага хэмжээний өгүүллэгийг сонгон авлаа.


1. Өгүүлэмжийн дарааллын онцлог:

“Үлгэрийг дутуу ярьдаггүй юм” \1989 оны наймдугаар сар\

-Шөнийн тас харанхуй дундуур гурван морьтон нэн болгоомжтой цувран явж байлаа хэмээн ажиг, сүжиг хослосон өнгө аясаар эхлэнэ. Ямар нэгэн бүтээл, ямар нэг зүйл бүрэн дүүрэн онц тавихаар байна гэж байдаггүй. Алдаа оноо ээлжлэн хөвөрдөг учраас эндэгдэлтэй зүйл байгааг олж биш онцлож харахыг хичээсэн билээ.

Ер нь зохиол бүтээлийн хэмжээ жижиг, том нь чухал биш бүгд өөр өөрсдийн гэсэн үйл явдлын өвөрмөц шугамтай байдаг. Энэ өгүүллэг эхлэл-өрнөл-төгсгөл гэх хэсгүүдээс бүтсэн бср оргил гэх зүйл мэдээж ор тас

байхгүй байсан биш оргил болж чадахааргүй жижиг жижиг довууд олон байна. **Зохиолч маань санамсаргүйгээр ийм алдаа гаргахгүй. Харин оргил товойн гарч ирэхгүй байгаа нь басхүү зохиолчийн зориуд үйлдсэн далд утга санаат илэрхийлэмж байхыг үгүйсгэхгүй юмаа.** Миний бодоход үйл явдлын шугам яг энэ өгүүлэгт ийм байвал илүү цар хүрээ илэрхийлэх утгын хувьд далайцтай болов уу? хэмээн бодож байна. Зураглал:



Оргил дутмаг байснаар хүний бие мах бодиор төлөөлүүлбэл зүрхийг нь бүтээхгүйгээр бусад эрхтэнг нь хам хум хийсэн лугаа адил. Үйл явдлыг цухас дурьдвал: Халх голын байлдааны үед илүү болоод дутуу үг, үйлдэл хийх эрхгүй байсан ба олон мянган аавын хүү ээжийн охид бяр чадал, авхаалж самбаа, од хиймороороо бусдаасаа онцгойрон ялгарч байсан нь мэдээж.

2. Үйлийн дутууг үлгэр гүйцээх мэт

Дамдин Японы хэлээ амьдаар нь олзолчихоод Лувсанд яагаад инээснээ болоод тэр үлгэрийнхээ тухай ярьж өгнө. Энэ зуур Лувсан /**явья даргаа**/ хэмээн хэдэнтээ ухасхийхэд Дамдин “*үлгэрийг дутуу ярьдаггүй юм*” хэмээн үргэлжлүүлэн ярьж дуусчихаад цааш явцгаана. Харин Лувсанг явья гэхэд нь дутуу яриад орхисон бол тэрхэн мөчид баригдах ч байсан юм билүү? Дутуу алхамыг тань дүүргэх гэж үлгэр үүссэн болов уу? гэмээр л сэтгэгдэл төрлөө. Бурханы ном судрыг дутуу уншидаггүй яагаад гэвэл сүсэглэн биширч, амьд зүйл мэт бидний оюун бодолд бичигдээгүй хэрнээ хууль мэт тогтчихсон байдаг шүү дээ. Эрт цагаас л бид үлгэрээр амьдарч, үлгэрийг амтлаж, үлгэрийг мэдэрч өссөн. Тиймдээ ч бидний оюун бодолд тарни мэт хүндэт байр суурийг эзлэж, эрхэмлэн дээдлэж дутуу уншиж басхүү дутуу ярих ёсгүй мэт санагддаг болжээ. Үлгэрээ бурханы судар ном мэт хүндэтгэж,

итгэж чадваас бидний үл ялиг дутмаг үйлдэл, саад тотгортой бүхэн бүтээд ч байх шиг.

Тэгвэл энэхүү зохиолд Халх голын байлдааны талбарт Олзвой гэгч гайхалтай тагнуулч дарга, цэрэг нарын хайр хүндэтгэлийг хүлээгээд байлаа.

Харин Олзвой шиг бусдын хайр хүндэтгэлийг хүлээх хүсэлд автсан хүмүүс олон байвч түүн дотроос мөрөөдөөд л суух биш зүтгэж байгаа нь тагнуулын ахлагч, бага дарга Дамдин, түүний туслах Лувсан болон отрядаас авсан газарчин нар Олзвойн нэгэн адил тагнуул хийж амьд хэл олзлох зорилго тээн Японы хилрүү сэтгэл шулуудана. **Дамдин, Лувсан, Газарчин нарын хувьд Олзвой бол бүрэн гүйцэт агууламжтай төгс гэж дүгнэж болохуйц үлгэр ба өөрийн цогцлоосон үлгэрийнхээ гол дүрийн баатар нь юмаа. Тиймээс Олзвойн гайхалтай үлгэрийн олз омогтой ба эрсдэлтэй ч амжилт дагуулсан төгсгөлийн үр дүн нь тэр гурвын бас нэгэн шинэхэн үлгэрийг эхлүүлэх сэдэл болж байгаа ч юм шиг.** Тэд сэм сэмхэн явсаар Японы хилийн харуулын байранд ирэхэд харуулын цэргүүд архидах ба тэдгээрийн дарга бие засах гэж гараад хагас согтуугаасаа болж Дамдинд хөтлөгдөн морь харах замаа заалгаж байна хэмээн бодож байтал бусдын гарт орсноо сая нэг ухааран мултрахаар оролдоход нэгэнт оройтжээ. Лувсан, Дамдин нарын барьж ирсэн амьд хэл, Японы 23-р дивизийн гол хүч явган цэргийн хоёр хороонд танк. хуягт ганц ч ширхэг байхгүй тухай өчснийг дээд командлалынхан бусад мэдээ сэлттэй тулгаж баттай болгоно. Ингээд Дамдин Лувсан хоёр эх орондоо үнэлж боломгүй том гавьяа байгуулж байгаагаар дуусна.

Гэтэл энэ сайхан баяртай зэрэгцэн зам зааж явсан эрд ялалтанд нь атаархах сэтгэл төрнө. Хэн хэнээ мэдэлцээгүй харин танилцаж сайн нөхөрлөсөн бол одоо шагнагдаж байгаа даа хэмээн сэм шүүрс алдаж, газарчилж байхдаа Дамдин болоод Лувсан хоёрыг ийн гавьяа байтугай баригдаж өөрийг нь замчилсан хэмээн хам хэрэгт оруулчихвий хэмээн хаширлаж, нэр усаа хэлэлгүй явсан боловуу? гэмээр. **Тиймээс ч үлгэр дотор үлгэр яваад байх шиг мэдрэмж төрлөө. Яагаад гэхээр Олзвойн баатарлаг бүрэн гүйцэт үлгэр нь эдний хувьд сайн үлгэр жишээ нь юм. Харин Олзвойгоос Лувсан, Дамдин нар сэдэл авч тэр сэдлээ үргэлжлүүлэн хөгжүүлэн бүрэн төгс үлгэр болгох уу? эсвэл дутуу орхих уу? гэдэг асуулт гарахад тэд амжилттай сайхан төгсгөж чадсан.**

Тэгтэл Замчилсан эр тэднийг тэрхүү үлгэрээ амжилтгүй төгсгөнө гэж Дутуу бодсон. Тэрхүү дутмаг бодлоосоо болоод тэр хоёрын цогцлоосон үлгэрт багтаж чадаагүй боловч эцэст нь дутуу бодсон бодлоо гүйцээж

тэдэнтэй илүү дотно, хэрэг явдалд нь чин сэтгэлээсээ хандаж, аминчлах үзэл гаргаагүй бол өдийд эдний адил бас өөр нэгэн хүмүүсийн үлгэр жишээ авахуйц төгс үлгэр болох байжээ хэмээн бодолхийлнэ. Тиймээс сайн явахад садан төрөл олон, муу явахад сүүдэр ч таниас үргэнэ гэдэг үг биелэлээ олох шиг.

Өрнөл хэсгийг оновчтой гаргаж хүний сэтгэл зүйг байгаль болон байгалийн үзэгдлүүтэй холбож дүрслэсэн нь уншихад хялбар байсан ба үгийн сонголт зөв авч мөр хоорондын холбоос бие биедээ уусах уусалтыг энэ өгүүлгийн нэгэн хэсэгт дутмаг оруулсан байх шиг. Жишээ нь:

“Дамдин Япончуудын ярьж байгаа яриаг ойлгон хүд хийтэл инээж, үүнийг Лувсан гайхаж Дамдин дарга намайг тарни уншиж байгааг мэдчихээл шоолж байгаам байхдаа хэмээн гомдлон бодно. Үүний дараагаар Японы хил доторх байшинд хэдэн хүн байгааг хоолойн өнгөөр нь тооцоолох хооронд, үүл болоод тэнгэрийн байр байдал дүрслэгдэж”, Лувсангийн бодол илэрхийлэл дуусаагүй байтал Дамдин аавынхаа ярьж өгч байсан үлгэрийг бодон инээнэ. Хэдий энэ үйл явдлын зангилаа хойно тайлагдсан ч нарийвчлан бодож үзвэл Лувсан болон Дамдингийн бодолхийллийн дундуур холбоос болгож тэнгэрийн байр байдлыг дүрслэсэн юм шиг гэвч огт авцалдаагүй мэт тул өөр ямар нэг холбоос орж ирсэн бол төгс болох байсан болов уу.

Тэрхүү тэнгэрийг дүрслэхдээ: **“Тэнгэрийн дорно хаяа еиймийн тэнд гэгээ орж байгаа мэг авч чийг даасан үүлс ширүүхэн салхи л гарахгүй бол нимгэрч ходолтлоо өдий мэт”** хэмээн дүрслэсэн нь Лувсангийн бодлыг дуусгаж, Дамдингийн үлгэрийг эхлүүлэн бодогдуулах холбоос огт биш. Харин бие засах гэж гарч ирсэн Япон хэлийг салхи хэмээн үзэж, тэр салхи болох Япон гарч ирснээрээ хий чимээ чагнан яах ийхээ мэдэхгүй байсан тэдний чийг даасан үүлэн бодлыг үргээж өгсөн нь тэр салхиар төсөөлүүлж буй Япон юм. Тиймээс Лувсангийн үлгэрийг эхлүүлэх холбоос биш харин энэ тэнгэрийн дүрслэл нь өөр үйлдлийн тодотгох холбоос юм. Өмнө Лувсан Дамдинг дурсан бодолхийлэхдээ “Ном эрдмийн мөр хөөсөн, дээрээ бодолтой доороо суурьтай” хэмээн зан байдлын тодотгосны дараа тэр аюултай агшинд аавынхаа ярьж өгсөн үлгэрийг бодоол инээж л байдаг. Ингэж инээснээрээ өмнөх Лувсангийн Дамдинг дүгнэсэн дүгнэлтийг эрс няцааж байх шиг. Гэвч энэ нь өөрөө далд утга байхыг үгүйсгэхгүй. Өөр орны хүн энэхүү өгүүллэгийг уншвал өмнөх үгүүлсэнтэй ижил яасан хачин нөхөр вэ? Очиж очиж ийм үед гэж бодох нь лавтай. С.Дашдооров зохиолч нь уран бүтээл бүртээ Монголынхоо аж байдал хүмүүсийнхээ сэтгэл зүй, ёс заншлыг гүн гэгч нь шингээдэг учраас Дамдингийн энэ үйлдлээр Монгол эр хүний тайван

аядуу байдал айдас түгшүүрийг төрхөн мартаж, айдаст автан төвлөрөхгүй байгаа ухаанаа цэгцлэх гэсэн утга байж болох бөгөөд гярхай дүрслэсэн нь олзуурхуштай.

Д.Намдагийн “Тэмцэл” жүжигт “ханцуйндаа л залбирч явна даа” хэмээн ардууд болон Жалцан өгүүлдэг. Харин энэ өгүүллэгт Лувсан “**тарни номоо сүүдрээсээ ч нуух юм**” хэмээн өгүүлэн байгаа нь тухайн үед шашныг гадуурхан шоовдорлож байсан үеийг Тэмцэл жүжгийн Жалцан, Үлгэрийг дутуу ярьдаггүй өгүүллэгийн Лувсан нараар төлөөлүүлэн буулгасан нь ижил төстэй юмаа.

Байгалийн дүрслэлийг хүний сэтгэл зүй дотоод ертөнцтэй нь холбосон мэт хэсгүүд нь гайхалтай ба уран зохиолын тойруулал зүйрлэл адилтгал гэх төрлүүд байсанг тайлал болгон сонордуулбал:

1. *“Дээрх тэнгэр харлан зузаан нимгэний нь таахын аргагүй үүл тунаж будаа мэт шиеэрээ борооны тусал үл мэдэг савирч эхлэв”*- хэдий амьд хэл олзлоно хэмээн зориг шулуудан гарсан ч гэлээ барьж ирэхүү? баригдаж тэндээ -есөн эрүү шүүлтэнд унаж, арван найман тамын зовлонд тарчилах уу? гэх үл мэдэх бодол нь яг харласан үүлний нимгэн зузааныг таахын аргагүй байгаатай адил ба адилтган зүйрлэж байна. Будаа мэт бороо тусагнан гэхээр адис тэдний зүрхэнд үе үе мэдрэгдэж байхтай адил байж болох. Будаа гэхээр ариун цагаан гэгээн мэт өнгө үзэгдэвч, үл ялиг хатуу нь адис, айдасын аль нэг нь тэдэн дээр бодохыг хүсээгүй байхад бодогдох бодол шиг л
- ❖ *“Нэгэн санахад, харанхуйн дунд итвэрээ бороон дор, тэр аливааг сонордон чагнаж байгаа бус харин газар дэлхий тэр хоёрын зүрхний айзам, санаа бодлы нь ажран налайх мэт”*-
Тэнд байгаль дэлхий болоод Дамдин, Лувсан гурваас өөр хэнч үгүй ба байгаль налайн амгалан байгаач тэдний сэтгэл түгшүүртэй, тэнцвэргүй бодол хөврөн байгааг тэд өөрсдөө төдийлэн мэдрээгүй тийм байдалтай байгаагаа ч мэдрэх сөхөөгүй байхад ганцхан байгаль дэлхий тэдний юу бодож юунаас имээн байгааг цор ганцаараа чагнах мэт.
- ❖ *“Зовхи өргөн харвал зүүн зүг тэнгэрийн хаяа үл ялиг цайрах мэт”*- энэ өгүүлбэр гарахын өмнө тэд тамхны утаа авч хаана байгааг нь болон дууных нь өнгөөр нь хэдэн хүн байгааг нь мэдэх боломж гарч байгаан тэдний хувьд өмнө нь үүл бүрхэж тас харанхуй байсан бол одоо тэдний сэтгэлд нар гарч байгаа мэт л
- ❖ Япончууд болон бусад оронд дайн тулаан болох үед хэрээ шувуу

дуугарахад төдийлөн тоохгүй. Харин монголчууд бидний тэнүүн ухаан далд ухамсар илүү хөгжсөн ба амьдралын жам ба араатан амьтны жам ёсыг судлаагүй хэрнээ цусанд нь орших уламжлалт сэтгэлгээг тэрхүү хэдэн мөрөөр дүрслэсэн нь нэн оновчтой.

- ❖ Морь гэх амьтан Эхлэхдээ ч төгсөхдөө ч эзэндээ ээлтэй, эгнэгт ухаантай, соргог гэх ухагдахууныг энэ өгүүллэгээр улам батлах шиг боллоо.
- ❖ *“Шүүмжлэлээс хол байх ганц л арга байдаг, юуч хийхгүй, юуч ярихгүй ба хэнч биш байх” гэж \Аристотель\ хэлсэн байдаг. Тэгвэл жижиг ч бай том ч бай хийж тууривсан бүтээл бүр нь алдаа оноо амжилт бахдалыг авчирч, хэлсэн нэг үг нь олон үгийн цогц нийлэмж мэт ийн уран сайхан байх нь ярих, яригдах, дурсах дурсагдах, шүүх шүүмжлэгдэх зүйлтэй байна гэдэг хүмүүний орчлонд би байсан шүү хэмээн тодоор тамгалсантай агаар нэг буй зай. Шүүмж эрэгцүүлэмжээ нэгтгэн дүгнэхэд нэрт зохиолч С.Дашдооров нь ахуй амьдрал, уламжлалт ёс заншил, Монгол гэх орныг бусад мэдэхгүй, мэдсэн ч мэдэрдэггүй тийм хүмүүст уран зохиолын яруу баялаг өвөөр дамжуулан сэвшээ хонгор салхны үнэр, сэржигнэн асгарах горхины чимээ, өвгөд хөгшдийн ариун уламжлал, алхахад өндөлзөм газар шороог үнэрлүүлж, сонсуулж үзүүлсэн мэт мэдрэмжийг бүх уран бүтээлдээ оновчтой буулгаж чаддагаараа ховорхон бөгөөд үнэт эрдэнэ мэт хүмүүн бөлгөө. Нэрт зохиолч С.Дашдооров мэт дүрслэж үл чадах ч бусад зохиолч бүтээлчид маань их бага хэмжээгээр өөрсдийн бүтээлдээ эх орныхоо ариун тансаг өв, дахин давтагдашгүй гайхамшигт уламжлал, зан заншил гэх зүйлсийг зохиолын шигтгээгээ болгон хатгаж шингээвээс жинхэнэ уран зохиолын хөрсөнд болон уншигчдын оюуны хөрсөнд буухдаа үлдэцтэй байж болох болов уу? хэмээн бодолхийлнэ.*

**ЗОХИОЛЧ С.ДАШДООРОВЫН ДЭЛГЭЦИЙН УРЛАГТ
ЭЗЛЭХ БАЙР СУУРИЙН АСУУДАЛД
”ИХ ЗАМЫН ЭХЭНД” КИНОНЫ ЖИШЭЭН ДЭЭР/**

Бямбасүрэнгийн Хишигсүх /МУИС/

Утга, соёлын нэрт зүтгэлтэн, ардын уран зохиолч, төрийн шагналт Сормууниршийн Дашдооров, Монголын дэлгэцийн урлагийн хөгжилд чансаатай хэд хэдэн бүтээлээрээ өөрийн байр суурийг эзэлсэн уран бүтээлч юм. Тэрээр “Гурван найз” /Т.Нацагдорж, М.Цэдэндорж нарын хамт., 1957/, “Эрдэнэ Хайрханы эзэн хэн бэ?” /Т.Нацагдорж, М.Цэдэндорж нарын хамт., 1958/, “Талын цуурай”/1967/, “Өндөр ээж” /1967/, “Нар хиртсэн жил” /1974/, “Эх бүрдийн домог” /С.Эрдэнийн хамт., 1975/, “Хайрхан Өндөр хаа байна” /Чехасловактай хамтран., зохиолч Т.Нацагдоржийн хамт., 1978/, “Тэнгэрийн муухай арилдаг” /1981/, “Саруул талын ерөөл” /1984/ зэрэг арав гаруй кино зохиолыг бичиж туурвисан нь үзэгчдийн хүртээл болжээ.

С.Дашдооров, зохиолч С.Эрдэнийн “Буцааж авах эрх”¹ туужаас сэдэвлэж “Их замын эхэнд” \1978\ хэмээх кино зохиолыг бичсэн юм. Бид энэ удаад “Их замын эхэнд” киноны өгүүлэмж, үйл явдал, дүр, дэвшүүлсэн асуудлыг задлан шинжилж өгүүлэхийг зорьсон болно.

Хоёр ангитай энэхүү уран сайхны кино 170 минут үргэлжилдэг, хар цагаан дэлгэцийн бүтээл юм. Киноны ерөнхий найруулагчаар Б.Сумхүү /МУУГЗ/, хөгжмийн зохиолч Ц.Намсрайжав /МУАЖ/, зураглаачаар Ж.Асалбай, зураачаар О.Мягмар нар ажиллажээ.

Киноны дүрүүдийг танилцуулъя.

1. Гол дүр:

Хөхөө буюу Хөх чоно – С.Дамдин /МУГЖ/

Янжин буюу Янжинлхам – Д.Ариунаа /МУСТА/

2. Дүрүүдэд:

Мэргэн гүн Цогтбилигт – Д.Найдан /МУГЖ/

“Цоохор” хэмээх данжаад – Б.Мижиддорж /МУГЖ/

Нутгийн өвгөн – Н.Цэгмэд /МУАЖ/

Хөхөөгийн анд нөхөр - Р.Дамдинбазар /МУГЖ/

1 С.Эрдэнэ.”Уянгын туужууд”.УБ.,1986

Баяртын пүүсэн дэхь хаягийг сольж хадах хэсэгт гардаг туслах дүр - Ё.Цог /МУГЖ/

Хөхөөгийн аавынх нь анд - У.Осор /МУГЖ/

Дамбий түшмэл - Н.Дугарсанжаа /МУГЖ/

Магсар /Ардын Засгийн түшмэл/ – Б.Пүрэв /МУГЖ/

Хөхөөгийн анд нөхөр – Н.Дагийранз /МУГЖ/

Монголын кино урлагийн хөгжлийн түүхэнд гарсан судлаач, шүүмжлэгчдийн бүтээлээс нийт хоёр зуу гаруй уран сайхны шүүмжийг найруулагч Н.Ганхуягийн /МУУГЗ/ эмхэтгэсэн, “Мотор дуугарлаа” /Монголын киноны шүүмж/ ном 2015 онд хэвлэгдэж гарсан. Энд “Их замын эхэнд” киноны талаархи шүүмж ердөө хоёр байна. Кино судлаачид уг бүтээлийг гэмт хэргийн, адал явдалт, түүхэн сэдэвтэй гэх зэргээр тэмдэглэсэн байна.

Энэхүү бүтээлд зохиолч С.Дашдооров, монгол ахуйг тод томруунаар дүрсэлж өгүүлснийг найруулагч тун соргоогоор мэдэрч, дэлгэцийн урлагтаа үзүүлсэн нь зохиолч, найруулагч хоёрын гар, сэтгэл нийлж сайхан бүтээл төрүүлжээ. Киноны зураг авалт бүтэн жил гаруй үргэлжилсэн байна.

Ойрмогхон “Их замын эхэнд” уран сайхны киноны гол дүрүүд болох Хөхөө буюу “Хөх чоно”-ын дүрийг бүтээсэн жүжигчин С.Дамдин /МУГЖ/, Янжин буюу Янжинлхамын дүрийг бүтээсэн дуучин, жүжигчин Д.Ариунаа /МУСТА/ нартай уулзах завшаан надад олдсон билээ.

Энэ өдөр билгийн тооллын хөхөгчин хонин жилийн намрын адаг улаан нохой сарын шинийн дөрөвний улаан бар өдөр /аргын тооллын 2015 оны 10 сарын 17-ний өдөр/ байлаа. Өмнөх долоо хоногийнх нь мягмар гарагт би жүжигчин С.Дамдин гуайн утсыг олоод түүн рүү залгаж “Хөх чоно гуайтай ярья..” гэж хэлчихээд машид санаа зовж, “... үгүй ээ, Дамдин гуайтай ярих гэсэн юм” хэмээгээд өөртэй нь уулзаж ярилцах хэрэг зоригоо хэлэхэд тэрээр “...тэгж болноо, хүүхээ, би өнөө маргаашдаа зураг авалттай, тав дахь өдрөөс ярья” гээд утсаа таслав. Дараа нь би Ардын Дуу Бүжгийн Эрдмийн Чуулгын дуучин Д.Ариунаа гуай рүү залгаж ярихад маш сайхан хүлээж аваад, “... уг нь Хөхөөтэй хамт суугаад ярилцвал их сайхан байх байх даа..” гэснээр бид уулзах өдрөө товлоод С.Дамдин гуайд хэлэхээр тохиролцлоо. Ингээд бид гурав тухайн долоо хоногийнхоо бямба гарагт өглөөний 10.00 цагт УДЭТеатр дээр уулзацгаахаар тохирлоо. Миний бие урлагийн томчуултай уулзахаас жаахан гэрэвшисэн гэх үү дээ, Р.Оюунбат багшийгаа хань татахаар утсаар холбогдов. Зүгээр ч нэг хань татсан хэрэг биш л дээ. Учир нь, дуучин,

жүжигчин Д.Ариунаа бол нэрт соён гэгээрүүлэгч Жамцын Бадраа /МУУГЗ/-гийн цомнолыг нь бичиж, алдарт Д.Лувсаншарав хөгжмийг нь туурвисан “Сүнжидмаа” дуулалт жүжгийн Хүрээний сайхан бүсгүй Сүнжидмаагийн дүрийг 1981 онд бүтээсэн бөгөөд энэхүү Жамцын Бадраа аругайн гарын шавь бол ардын урлаг судлаач, доктор Равжаагийн Оюунбат хэмээх нэрт шанзчин энэ эмэгтэй юм. Тиймээс багшийнхаа бүтээлийг тайзнаа амьдруулахад дуучин Ариунаагийн дуулсан “Сүнжидмаа”-гийн дүрийг хэрхэн бүтээсэн нь бас сонин, сайхан байх болов уу, үг яриа нийцэж нийлэх нь гарцаагүй ээ, гэсэн сэтгэлийн үүднээс хамт очсон нь үнэхээр сайхан уулзалт, үнэн сэтгэлийн халуун дулаан, сонирхолтой, дотно сайхан яриа өрнүүлэхэд хүргэсэн.

Ер нь бол Хөхөө буюу “Хөх чоно” /С.Дамдин/, Янжин буюу Янжинлхам /Д.Ариунаа/ нартай уулзаад ярилцаж суухдаа бид хэд хэзээний л танилууд мэт дотно сайхан сэтгэгдэл төрж суусан нь санамсаргүй тохиол, учрал биш байсан.

“Их замын эхэнд” кино олны хүртээл болсноос хойш гучин долоон жил өнгөрсөн байна. Ингээд уг киноны гол дүрийн жүжигчидтэй уулзаж ярилцсан бүтэн зургаан /10.00-16.00/ цагийн ярианаасаа бусадтай хуваалцамаар санагдлаа.

Би: “Их замын эхэнд” киног бүтээж байх явцад, бүтээл дуусаад уран сайхны зөвлөлөөр хэлэлцэж дуусахад хүртэл С.Дашдооров гуай та хоёртой ойр дотно харьцаатай байсан болов уу?

Дамдин: Очих нь, очиж байсан. Намайг Драмын театрын жүжигчин байхад “кино урлаг” гэдэг юмтай анх холбож өгсөн хүн бол С.Дашдооров гуай юм. Яагаад гэвэл би анх удаа дэлгэцийн урлагт хөл тавьж С.Дашдооров гуайн “Өндөр ээж” /Р.Доржпалам гуай найруулсан/ киноны Өндөр ээжийн хүүгийн дүрийг бүтээсэн юм. Энэ дүр бол “Их замын эхэнд” кинонд тоглохоос өмнө юмаа. Дашдооров гуай, Сумхүү найруулагч хоёр аль аль нь надад дүртэй холбоотой тэг, ингэ гэж юу ч хэлж байгаагүй. “Өөрийнхөөрөө л тогло..,” гэдэг байсан. Дашдооров гуайн сууж байгаа, ярьж байгаа, мах огтлоод идэж байгаа, байр байдал нь ерөөсөө л нэг говь үнэртсэн хүн, говийн хүн, нэг л тийм сайхан гүндүүгүй сайхан эр хүн байсан даа. Би Дашдооров гуайд их хайртай. Би бол хангайн хүн л дээ.

Ариунаа: Хөгжмийг нь бүр үндэсний найрал хөгжим хөгжимдсөн. Дашдооров гуай хаанаас нь ч харсан монгол эр хүн байсан. Шүдийг нь харахаар их гоё ирийсэн, ёстой тос даасан сайхан бор царайтай монгол хүн

байсан даа. Анхны зураг авалтын үеэр биднийг гэртээ нэг урьж дайлсан юмаа. Анх зургийн талбай руу явж байхад Дундговийн Хулд суманд биднийг нэг дайлж цайлсан, их сайхан яриа хөөрөөтэй хүн байсан даа.

Би: Кино зургийг голдуу хаана авсан бэ? Хэр удаан үргэлжилсэн бэ?

Дамдин, Ариунаа: Өмнөговийн Булган, Номгон, Хавцлын ам гээд газруудад, говийн нутагт авсан юмаа. Зураг авалт жил гаран үргэлжилсэн.

Дамдин: Сумхүү гуай, чамд проб хийсэн үү? /Ариунаагаас асууж байна/, надад бол проб хийгээгүй ээ. Шууд л зураг аваад эхэлсэн. Хөхөөгийн дүрийг илүү сайхан амьдруулах өөр олон жүжигчин байсан болов уу. Дамдингаас өөр сайхан хүн олж магадгүй гэж бодож байсан байх. Зураач Мягмар гуай, Асалбай нар театр дээр ирээд гэнэтхэн, “та маргааш нөгөөдөр зурагтай шүү”, гээд “уул нь би таныг сонгочихсон байсан юмаа”, гээд л шууд зургандаа орсон доо.

Ариунаа: Надад проб хийсэн. Өмнө нь их олон хүн проб хийлгэсэн байсан.

Би: анцхан өдрийн дараа л зургандаа орсон хэрэг үү.

Дамдин: Би ямар кинонд тоглох вэ? гэсэн чинь “Та нэг шилийн сайн эрийн дүрд тоглоно л гэж байна.” гээд зохиолын нэгээхэн хэсгийг өгөөд л шууд маргааш нь зураг авч эхэлсэн дээ. Тэр хэсэг нь Хүрээнд орж ирээд Ганданд мөргөж байх даа, битүү далд утгатай үгсээр ярилцаад “Амьтан хүний сиймхийгээр ахыгаа дагаад яв..,” гэдэг дээ, тэр хэсгийн зургийг эхлээд шууд авсан юм.

Би гэдэг хүн Дашдооров, Сумхүү гэдэг хоёр хүний буянаар “Хөх чоно” гэдэг тэр сайхан эр хүний дүрийг бүтээсэн, одоо намайг хөдөө гадаа хаана ч явсан, ямар ч айлд орсон ширээ засаад л, дээшээ суулгаад л хүндлээд л байдаг юм, их сайхан шүү. “Хөх чоно”-ын уг дүр намайг ингэж л олонд таниулсан сайхан дүр болж амьдарсан юм даа.

Би: Ариунаа эгчийн хувьд тэр том язгууртан, гүн /Цогтбилигт мэргэн гүн/-гийн ганц охин, тэр том язгууртны гал голомт дээр өсөж өндийсөн охины дүрийг бүтээхэд хэцүү, халшрах үе байсан уу?

Ариунаа: Надаас их хол амьдрал байсан, би чинь найман хүүхэдтэй айлын том охин. Би монгол ахуйгаа их сайн мэддэг, идээ цагаагаа чухам ёстой яаж л бол яаж боловсруулчихдаг байсан. Бас би моринд их сайн байсан даа. Энэ их чухал байлаа. Кинонд тоглоод дуусахад би яг 20 нас хүрч билээ.

Би: Та, хүний ганц хүү юм уу?

Дамдин: Тийм ээ, би ижийтэйгээ л хамт амьдарч байсан, хүний ганц хүү.

Би: “Их замын эхэнд” киног би байнга үздэг, ерөөсөө уйддаггүй юм. Хөхөөгийн дүрийг харах болгонд “яг л нэг сайхан монгол эр хүн”- ий бүхий л шинжийг Хөх чонын дүрээс олж хардаг даа. Одоо тийм даацтай дүр их ховор болж дээ. Нэг тийм жижигхэн, жол, ядмаг “дүр”, өөр хоорондоо их ялгарахааргүй болсонд сэтгэл дундуур байдаг.

Ариунаа: Тийм ээ, Хөхөө бол хүмүүст тийм “сайхан эр хүн”-ий шинж төрхийг харах гэсэн хүслийг төрүүлсэн дүр шүү дээ. Хөхөөгийн дүр бол ёстой л сайхан “монгол эр хүний дүр дээ”.

Би: Та киноны туршид гурван удаа л дээлээ сольсон байдаг. Ялангуяа тэр одтой дээл танд их сайхан зохисон байдаг. Бас таны унаж давхидаг тэр шийр цагаан алаг морь их сайхан хүлэг байдаг. Ялангуяа тэр элсэн хөмөг рүү хар хурдаараа давхиад ордог, тэр хэсэгт их сүртэй байдаг.

Дамдин: Тийм, тэр ёстой сайн морь. Тэр нутгийн Дамдин гэдэг айлын хурдан морь. Тэр шийр цагаан алаг морь бол маш зоригтой, тэр элсэн хөмөг рүү шууд давхиж ороод, ерөөсөө эргэж буцах, орохгүй зогсох энэ тэр ёстой гараагүй. Орой нь л Дамдин гуай хүрээд ирдэг, за, Дамдин гуай та дахиад хэзээ зурагтай вэ? Би хэдийд морио бэлэн байлгах вэ? гээд л. Дамдин гуай морио тоглуулсандаа их баяртай байсан, Сүүлд би нэг бригадаар явж байхдаа Дамдин гуайнд очсон. Тэгэхэд “Миний алаг морь ч сайхан тоглосон, та ч сайхан тоглосон” гээд л бөөн баяр болсон доо. Их сайхан хүмүүс байлаа. Тэр одтой дээл бол өмнө нь нөгөө “Алтан өргөө” киноны гурван хүү байдаг даа, Ёроо, Ёмбоо, Сүмбээ гээд., тэр гурвын ахынх нь өмсөж тоглосон тэр дээл шүү дээ.

Би: Нэг сайхан хэсэг байдаг юм аа, би тэр хэсгийг үзээд ерөөсөө уйлахгүй байж чаддаггүй юм. Уг нь бол хүн уйлахаар хэсэг огт биш л дээ. Тэр гүнгийн охины гэрт буюу Янжингийн байгаа хэсэг. Та нэг хар дээлтэй суучихсан. Номын багш гүнгийнхээ зараалаар дахиад Хүрээ явахынхаа өмнөх хэсэг. Янжинд хандаад “.., миний ингэж жингийн зам отоож, яваа зөв ч юм уу, буруу ч юм уу, нас явж ч байгаа юм уу, намба сууж ч байгаа юм уу, сүүлийн үед гэрийн утаа үнэрлэж суух юмсан гэж бодох боллоо..,” гээд. Тэр хэсгийн тэр гэрийн доторхи байр байдал, тулганд асаж байгаа гал, Янжингийн сонсоод сууж байгаа байдал төрх, киноны хөгжим гээд л их сайхан байдаг.

Ариунаа: Тэр бас их гоё хэсэг л дээ. Үнэхээр нэг нэг нэгийгээ нэвт шувт ойлгосон, ямар ч илүү дутуу хөдөлгөөнгүйгээр нэг нэгийгээ таньж мэдсэн сэтгэлтэй хоёр хүний байдал төрхийг түүнээс илүү яаж үзүүлэх вэ дээ.

Ялангуяа монгол хүний хувьд их ойр, дотно сайхан байдал бол тэр л дээ.

Дамдин: Тэр хэсгийн зургийг ганц л удаа авсан юм.

Би: Асуулгүй өнгөрч боломгүй бас нэг хэсэг байнаа. Хөхөө, Янжин хоёрын орондоо байгаа хэсэг. Тэр хэсэгт та хоёр тэврэлдэх юм уу, бие биеэ үнэрлэж үнсэж болоогүй юм уу? Бас тэр гэрийн доторхи тавилга сэлт, нам тайван байдал, уянгалаг хөгжим гээд их сайхан зохицсон санагддаг юм.

Дамдин: Тийм ээ, тэр их сайхан хэсэг шүү. Би сүүлд эргээд харахдаа тэгж тэвэрч, үнсэлдэж үнгэлдээгүй нь /монгол хүн бол үнэрлэж үнсдэг байсан/ болж дээ гэж бодсон. Учир нь тэр шилийн сайн эр, тэр холын их үйлд зорьсон эр хүн зүгээр нэг шалдар булдар зан гаргаад л үнсэж үнгээд л нялуураад байх нь тун зохиомжгүй л дээ. Орчин үежчих гээд байсан.

Ариунаа: Яг тэр хэсгийн зургийг авчихаад Сумхүү найруулагч маш их баярласан. Яагаад гэвэл миний хувьд их хэцүү хэсэг байсан. Тэр хэсгийн дубль зургийг авахуулах гэж хоёр гурван өдөр зарцуулсан. Би тэр зассан оронд орж чаддаггүй. Нас бага байсан болохоор ичиж зовоод тийм зураг авахуулах их хэцүү байсан даа. Харин тэр хэсгийн арын засалт, хөгжим үнэхээр их гоё шүү.

Би: Бас нэг сонирхолтой хэсэг байдаг. Хөхөө Хүрээ явах гээд Янжин үйтэнхуар дээл өмсчихсөн /Хөхөөг дагаж Хүрээ явах гээд/, сар гарахад хөтлийн цаана морьтойгоо ирж удаан хүлээгээд зогсож байдаг. Янжин Хөхөөд хандаж “Хүрээнд их олон сайхан хүүхнүүд байдаг гэсэн..” гээд хайртай хүнээ харамлаад байгаа сэтгэл, гэгээн гуниг мэдрэгддэг. Тэгэхэд Хөхөө ийн хариулдаг: Сайхан хүүхэн олон ч санаанд нийлэх нь ганц.. гээд явж одоход Янжингийн нүдэнд үл мэдэг нулимс цийлэгнээд, чимээгүй үлддэг. Сар дээр гарчихсан, уянгын өнгө аястай хэсэг.

Ариунаа: Тэр ёстой гоё хэсэг шүү. Тэр үед Хөхөөг дагаж Хүрээ явах гээд амьхандаа гоёж гоодож, үйтэнхуар дээл өмссөн байгаа нь тэр. Уг нь дагаад явчих санаатай аль эрт бараг сар гарахад ирээд хүлээж байсан нь тэр шүү дээ...

Бидний яриа дуусахааргүй байсныг хэлэх юун.

Үнэхээр агуу хэрнээ эгэл даруу уран бүтээлчдийн бүтээсэн “Их замын эхэнд” хэмээх бүтээл нь Монголын кино урлагт зүй ёсоор томхон байр эзэлнэ.

Кино эхлэхэд тэрэг мөрлөсөн олон хөлийн алхаа \нэгдүгээр анги\, морин туурай, давхиан дунд \хоёрдугаар анги\ хөгжмийн аялгуу алсалсаар.

Зохиолч Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романаар хийсэн бүрэн хэмжээний гурван ангит кинонд шилийн сайн эр Цахиур Төмөрийн дүрийг эс тооцвол Монголын шинэ цагийн кино урлагт Хөхөө буюу “Хөх чоно”-ын дүр бол их өвөрмөц, сонирхолтой, сайхан дүр билээ. Зохиолчийн ур ухаан, найруулагчийн өвөрмөц шийдлүүд, хүнд хэцүү зураг авалтууд, өөрийн эрхгүй өндөлзөж дуу алдмаар хэсэг, эрс огцом тавилт, уянгын хэсэг гэхчилэн дутуу юмгүй бүтээсэн байдаг. Жүжигчин С.Дамдин ч “Хөх чоно”-ын дүрийг маш чадварлаг бүтээсэн байдаг.

Найруулагч Б.Сумхүү гярхай, холыг харж “Хөх чоно”-ын дүрд жүжигчин С.Дамдинг тун оновчтой сонгож чадсан. “Сайхан Монгол эр хүн”-ний бүхий л хэв намбыг өөртөө шингээсэн энэ дүрд жүжигчин Дамдингийн дуу хоолойны өнгө, алхаа гишгээ, морины эмээл дээрхи суудал, хурдан морины давхил, хэц өндөр хадан дээрээс бугуйл шидэх, тамхилж байгаа байдал, өөрийн эрдэм номын багш /Мэргэн гүн Цогтбилигт/-тайгаа харьцаж байгаа төрх, багшийнхаа ганц охин үзэсгэлэнтэй сайхан төрсөн хэрсүү, ухаалаг бүсгүй Янжин буюу Янжинлхамд өгсөн ариун нандин хайр, түүнийгээ буй бүх байдал төрхөөрөө бүрнээ илэрхийлж байгаа сэтгэлийн илрэл, говийн баян бүрд, элсэн хөмөг, аян жингийн хүнд зам, анд нөхдийн итгэл, нөхөрлөл, харийн хар санаатнаас нутаг орноо хамгаалах чин зориг, тэвчээр хатуужил, андын тангарагтаа чинхүү үнэнч, цэгц шулуун, шударга зан чанар, зорьсон их үйл хэрэгтээ нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэх хичээл зүтгэл гээд бүхий л зүйлийг цогцоор нь гаргаж чадсан байна.

Тухайлбал, монгол нутагт шинжилгээ хийж, “лууны яс” хэмээх дэлхийд хосгүй ховор, үнэ цэнэтэй олдворыг хайж олох, цуглуулж авч явахаар зорин ирж буй харийн “эрдэмтэн” гэгддэг Робинсон, Батлер /С.Эрдэнийн туужид бол далайн дээрэмчний удам гэдэг/ нарыг хүлээн авч уулзаж байгаа тэр хэсэгт байгалийн өвөрмөц тогтоц бүхий хадан агуй, нууц жим замаар явж уужим нуурын эрэгт тэднийг хүлээж суугаа Хөхөөгийн дүр байдал, тэдний хэрэг зоригийг сонсож мэдээд тэдэнд амар амгаланг ерөөж, тэдний бэлэг болгож барьсан хүйтэн зэвсгийг /хурдан буу/ “би алуурчин биш ээ, ав шувуунд ахдах эд байна..” хэмээгээд буцаан өгч байгаа хэсэг, шинжээчдийн арай залуу нь болох омголон догшин, бүдүүлэг зан авиртай Батлертай харьцаж байгаа байдал, энэ нь алмас хэмээх “цасны хүн” гэж андууран олзолж ирсэн хүний амь насыг хороосныг улай гарсан газарт олон тас эргэлдэж байгааг хараад юу болсныг нягталж, шинжээчид дээр явж очоод, Хөхөө: “Та бүхнийг хүйтэн зэвсэг гаргаж, хүний амь бүрэлгэсэн гэж сонслоо, энэ бас тоогүй. Халуун зэвсгээ хураалгаад нэн даруй орон нутаг руугаа тэмцсүгэй. Та нар энэ олсон

зөөсөн зүйлээрээ Монголын нэрийг мандуулна, гэж хэлж байсан удаатай. Хожмын өдөр, хойдын явдалд сонсогдох биз. Аян замдаа сайн яваарай..,” хэмээгээд хадгалж байсан буу зэвсэг зэргийг нь хураан авч, эр хүн шиг хэлэх гэснээ эрс шулуухан хэлж, хэлсэн амандаа хүрч байгаа байдал зэрэг нь зүгээр нэг шилийн сайн эр төдий биш холыг харсан, маргаашийн сайхан амьдралд тэмүүлсэн, аливаа юмны наадах цаадахыг ухаарч эргэцүүлсэн эр чадал, эрдэм ухаан ид жагссан идэр эрийн дүр байдлыг товойлгож өгсөн болно.

Энд онцолж нэг зүйлийг хэлэхэд найруулагч, зураглаач нар хээрийн зураг авалтдаа газар орны байдлыг үнэхээр гайхалтай сонгон олж, зургаа авч чадсан явдал /ялангуяа дээр өгүүлсэн хэсэг/ юм. Үүнийг кино урлагт “натур сонголт” гэдэг бөгөөд газар орны байдлыг гярхай ажиглаж, сонголт хийсэн нь “шилийн сайр эр”-ийн дүр төрх, үйл хэрэг, төлөв байдалд машид нийцэж зохицсоноос гадна, бүхэлдээ “Их замын эхэнд” киноны үйл явдал, өгүүлэмжийг дэлгэцийн урлагт товойлгож, тодруулж гаргахад их чухал зүйл болсон, гэж үзэж байна.

Хөхөө, Янжингийн эцгийнх нь буюу багшийнхаа зараалаар Хүрээг хэдэнтээ зорьж, тухайлбал, Цогтбилигт мэргэн гүний дээдсийн үүх түүхийг бичсэн, хошуу нутгийн зураг, хаана, ямар эрдэнийн чулуу, ямар эмийн ургамал байгаа гэх зэргийг нарийн тэмдэглэж бичиж үлдээсэн, үнэт чухал, ховор судар, “цоохор” /Мижиддорж., МУГЖ/ данжаадын гараар орж гадагшаа алдагдах гэж байсныг их эрсдэл дунд хэрхэн олж авч, хадгалуулж /Цогтбилигт мэргэн гүний нутгийн хүн хэмээх түшмэл Дамбийгийн гэрт Хүрээнд хадгалуулсан байсан/ байгаа, улмаар хувьсгалын их хэргийн үнэн мөнийг ойлгон /Магсар, Николай болон бусад нөхдийн дэмжлэг туслалцаатайгаар/ ухаарч, уг үйл хэрэгт нэгэн үзүүрт сэтгэлээр гар бие оролцож байдаг.

Хөхөө буюу “Хөх чоно”-ын дүрийг тодруулахад түүний сэтгэлтэй бүсгүй Янжин буюу Янжинлхамын дүрийн шугам ихээхэн чухал байлаа. Хот Хүрээнээс алс холд амьдран суух, угсаа залгамжилсан язгууртан, гүн /Мэргэн гүн Цогтбилигт/-гийн гал голомт дээр төрж, өсөж өндийсэн энэ бүсгүй бичиг эрдэмд багаас суралцсан, ухаалаг хэрсүү, үзэсгэлэнтэй сайхан төрсөн бөгөөд, ялангуяа түүний эрх танхи гэмээр боловч моринд эрэмгий байдал, цэвэр булбарай царай төрх, ааль намба, алхаа гишгээ, харц байдал зэрэг нь язгууртан монгол эмэгтэйн хэв шинжийг өөртөө шингээсэн сайхан дүрийг бүтээснийг дуучин, жүжигчин Д.Ариунаагийн тоглолтоос тод харагдаж байна. Тухайлбал, Хөхөөг Хүрээ яваад ирсний дараах сэтгэлтэй хоёрын харилцан ярианы хэсэг байна. Үүнд: Янжин: “..Хөхөө, чи Хүрээ

яваад ирснээсээ хойш нэг л өөр болсон юм шиг., аавтай үг зөрөөд л..” гэхэд Хөхөө: “.. тэр магадгүй ээ, аавыг чинь би бичиг ном эрдэм зааж өгсөн ачтанаа гэж боддог, яваандаа багш бид хоёрын дунд ан цав гарах шиг болсон, аав чинь удам угсаагаа өмөөрдөг байлаа..” гэхэд Янжин: “Тэгвэл би тэрний ганц охин, надтай зам байтугай заяа нийлнэ, гэж яаж бодоов?” хэмээн асуухад Хөхөө: “Багш бид хоёрынх бол номын далай, чи бид хоёрынх бол сэтгэлийн далай..” гэхэд Янжин: “Чи тэгээд төрийн төлөө явж байгаа хэрэг үү?” гэхэд Хөхөө: “Түмний төлөө явж байгаа болохоор тийм юм уу даа. За, явъя даа хө” гээд орноосоо өндийж байдаг. Янжин дээр кадр алгуур очиход Янжингийн “буугаа” гэх зөөлөн дуу гарч Хөхөөгийн “энийгээ ч юунд мартаж вэ хө..” гэсэн хариулт сонсогдоно. Янжингийн: “Үүр цайх яагаа ч үгүй байна..” гэх дуунаас сэтгэлтэй хүндээ хоргодсон сэтгэлийн их уярал хайр илэрч, Хөхөөгийн: “Явъя даа, хө. Нар мандахад эхний даваан дээр зогсож байх сайхан байдаг юм. Алив, миний хонгор. Сайн сууж байгаарай.” гэж хэлээд явж байгаа тэр хэсгийн байдал, харилцан яриа, сэтгэлд их ойр, дотно уяралтай санагдана. Энд Хөхөө, Янжин нарын дотоод сэтгэлийн ертөнц, эр, эм хоёрын хэн нь хэнийгээ хэдийнээ таньж мэдсэн, бүрнээ итгэж хүлээсэн, нэг хүн мэт болсон нарийн холбоог жүжигчид энгийн хэрнээ харц, дуу хоолойны өнгө зэргээр тун чадварлаг бүтээсэн байна.

Ийнхүү Хөхөө Их Хүрээг зорьж өдөр хоног нэлээд алгуурладаг. Энэ хооронд тэрээр Хүрээнд орж ирээд усан борооноор Дамбий түшмэлийнд бууж улмаар баривчлагдаж, мунгинаж явсаар сая хувьсгалын их үйл хэргийн үнэн мөнийг ухаарч Ардын журамт цэргийн хамтаар нутаг орноо зорьж байна. Нутаг орондоо түүнийг хүлээн байгаа Янжингийн их хүлээлтийн хэсгийг, Хөхөөгийн итгэлт сайн анд /сорвит/ нөхрийн /МУГЖ Осор/ хамт өндөр дээр холыг дурандаж суугаагаар үзүүлнэ. Дурангийн үзүүрт торолзох бараа тодорч тэдний суугаа газар өөд чиглэн нэгэн хүн давхин айсуу. Янжин бүсгүйн, хайрт хүнээ хүлээсэн сэтгэлийн их догдлол ийн илэрч, “Хүлээсээр байгаад нүд хөхөрчлөө, та нэг хар даа ” хэмээгээд дурангаа хажуу дахь хүндээ өгөхөд цаадах нь дурандаж харснаа: “Цаадах чинь мөн байна” гэхтэй зэрэг бүсгүйн “Хөхөөгөөс өөр хэн байх вэ, тосоод очъё” хэмээн догдолсон, хүсэмжилсэн, мөрөөдсөн, санагалзсан сэтгэлийн хөг аяс бүхий дуу хоолойн өнгө, нүдний харц байдал тун үнэмшилтэй бөгөөд үнэхээр нэг хайртай хүнтэйгээ уулзахын түмэн баяраар сэтгэл нь бялхаж байгаа залуу бүсгүйн төрх бэлхнээ цогцолж, тэрээр морины хар гүйхээр хайртай хүнээ тосоод давхин очиж байна. Хөхөө, Янжин хоёрын учран уулзаж байгаа тэр мөч киноны оргил хэсэг, үзэгчдийг өндөлзүүлсэн, огшоосон дүрүүд жүжигчдийн

ур чадвараас гадна, найруулагчийн мэдрэмж, зураглаачийн ур чадвар давхар давхар тод томруун харагдана

Зохиолын үйл явдал туйлдаа хүртэл хурцадсан бас нэг өгүүлэмж бол Хөхөөг Хүрээ явсан хойгуур Цогтбилигт мэргэн гүний ганц охин Янжинг гэрээс нь хулгайлан авч одсон хэрэг болно. Энэ нь “цоохор” данжаадын шунахай сувдаг сэтгэл, мөнөөхөн ховор, үнэт судар хаана байгааг мэдэх гээд зогссонгүй Янжинг барьцаалан авчирч, улмаар Хөхөөг хаачсан болох, бүр түүнийг ирүүлж /Янжингаар худал үг бичүүлж/ барин авч Бээжинд хүргүүлэх /энэ нь хятадын жингийн цувааг олон удаа уулгалан довтолж, тонож дээрэмдсэн явдалд ял асуулгахаар/ эс бөгөөс хороох зорилгоор хорон муухай санааг агуулж, мөнөөхөн худал үг бүхий захиагаа Янжинлхамд харийн эрдэмтний бэлэглэсэн эрдэнийн чулуун шигтгээт бөлзөгний хамт хийж, элчийн хамт Цогтбилигт мэргэн гүний гэр өргөөнд хүргүүлж байдаг. Ингэхдээ “цоохор” данжаад элчээр зарагдаж явах гэж байгаа бүдүүн тоймын эрд хандаж “цаад хөгшин чөтгөр чинь хашир гэж жигтэйхэн, бас их ёсорхуу.., ёс алдаж булайгаа чирэв ээ..” гэж хэлж байгаа нь Цогтбилигт мэргэн гүний дүрийг тодруулж өгөхөд их чухал хэсэг байдаг. Охиноос нь ирсэн гэх зурваст “Хорон муу хүмүүсийн гарт ороод үйл тамаа эдэлж байтал нэгэн сайн санаат эр авран хамгаалж, нуун асарч байна. Хөл хугарсан тул явж чадахгүй. Хөх чоныг явуулж даруй намайг авахуул” гэсэн захиаг уншиж, бөлзөгийг таньсан гүн эцэг нь хором ч атугай магнай нь тэнийж суухад Хөхөө өнөөх бичгийг авч үзээд дотроо “Янжин намайг Хөхөө л гэх учиртай даа..” гээд элчийн тамхилсан хөөргийг авч тамхилангаа бүх учрыг мэдэж, үл мэдэг мишээгээд “Багш ах, соёрхвол би түр өөр газарт очиж алжаал тайлъя. Элчийн захиаг бүрэн ойлгож мэдлээ. Би хамт явъя.” хэмээгээд гарч явна. Ингэж Хөхөөгийн үнэн итгэлт сайн нөхрийн сонор соргог /Дамдинбазар., МУГЖ/, авхаалж самбаатай, сайхан сэтгэлийн үрээр \аянчин жинчиний буурчийн газар элч эрийг үдэж, хувцас хунарыг нь засан янзалж, улмаар хөөргийг нь гаргаж үзээд “Манай эзэн таныг сайн нягталж шалгаарай гэсэн шүү, энэ болохгүй ээ, их баян хүний хөөрөг байна, сэжиг авч мэднэ, харин энэ бол гээд урд Хөхөөгийн өөрт нь өгч байсан цоохор шаазан хөөргөөр сольж өгч байдаг”.

Киноны бас нэгэн чухал санаа бол эх нутгаа дээдлэх, газар шороогоо хамгаалах, язгуур соёл, ахуй зан заншилаа эрхэмлэх үзэл байх бөгөөд монголын говьд тэмцэн ирж \хятадаар дамжин монголд ирсэн\ “лууны яс” хэмээх үлэг гүрвэлийн ясыг эрж хайх, олж авахаар ирсэн харийн хоёр этгээдийн байр байдал болно. Тухайлбал, “Бид дараа дахиж ирэхээр бол зөвхөн эрэл хайгуул шинжилгээний ажлаар төдийгүй, энэ улсын хувь

заяаны эрэл хайгуулыг бас давхар хийх хэрэгтэй. Энэ мөнгөнд дургүй, гэнэн бүдүүлэг улс Оросыг дагаад явчихвал бидэнд ашиггүй, бас хятадуудад ч итгэх хэрэггүй” гэх зэргээр ярилцаж байдаг. Нөгөө нэг нь дээр өгүүлсэнчилэн “цасны хүн” хэмээх “алмас” гэж уул хадаар гэр хийж бүгсэн /шинжээчдийн ажилд тусалж байгаа нутгийн ардын нэгний өгүүлж буйгаар бол Улиастайн шоронгоос оргосон нэгэн сайн эр уул хадаар тэнэж явдаг тухай яриа/ сахал, үсэндээ баригдсан нэгнийг зуны төөнөм говийн халуунд шонд хүлчихсэн байхад нутгийн хоёр ард ярилцаж байгаагийн нэг нь болох өвгөн /МУГЖ Н.Цэгмид/: “Энэ шинжилгээний ангийнхан чинь ер хаашаа янзын улс вэ? булш, хүүрээс ч цэрвэж сэжиглэхгүй юм. Өөдтэй ч улс биш дэгээ. Бид чухам юугаа ухуулж, төнхүүлж, тонуулж байгаа юм, бүү мэд. Бас тэгээд танай их эзэн Чингис хааны чинь булш хаана байна? зааж өгвөл их шан харамж өгнө, гээд байгаа юм шүү. Өөдтэй ч улс биш дэг ээ” гэх буюу эсвэл шонд хүлэгтэй байгаа олзны хүнд аяга хүйтэн юм уулгаж, хүлгийг нь огтлоод, суллаж тавьсан нутгийн ардыг дөрвөн гадас газарт шаагаад дөрвөн мөчөөр нь тэлээд хээр хөдөө хаячихсан, дээгүүр нь улай үзсэн мэт тас шувууд эргэлдээд” түүнийг аварч суллахад: “энэ шинжилгээний ангийнхан ч хүн биш юм даа” гэж хэлж байдаг зэрэг хэсгүүд байна.

Уг бүтээлээрээ хөндөж тавьсан энэ мэт асуудлыг өнөөдөр ч гэсэн эргэцүүлж бодмоор. Учир нь, үндэсний уламжлал, өвөг дээдсийн ёс заншил, язгуур соёл мартагдан бүдгэрч, хэт харьжиж байгаа эдүгээ цагт дээрхи мэтийн хандлага газар авч байгаа нь нууц биш бөгөөд энэ нь үндэсний аюулгүй байдлын түвшинд хүрч яригдах чухал асуудал мөнөөсөө мөн бөгөөд, аюулын харанга даруй мөн болно.

Нэрт уран бүтээлч С.Дашдооровын зохиолоор, найруулагч Б.Сумхүүгийн бүтээсэн “Их замын эхэнд” кино нь өгүүлэмж, дүр, дүрслэл, хэл, найруулга, дэвшүүлж тавьсан асуудал, уран бүтээлийн далайц цар хүрээ, зохиолч, найруулагч, зураглаач, зураач, жүжигчид, өмсгөл зүүсгэл, тайз засал, /гүнгийн гэр өргөөний эрхэмсэг байдал, идээ будаа элбэг баян ширээ засал, зоог барих монгол ёсон, “цоохор” данжаадын шавар тагц, аянчин жинчиний дэн буудал, элчин дипломатын газар, Николайн Хүрээн дэхь гэр байшин, эгц цавчим хадан уул, элсэн хөмөг, цэлийсэн тал, шөнийн саран, морьдын хөлөөр босох тоос, хадан агуйн байр байц, газрын тогтоц гэх мэт/ гээд иж бүрнээрээ Монголын кино урлагийн хөгжлийн түүхэнд үзэгдэл болсон давтагдашгүй, цогц бүтээл болж чадсан билээ.

**ДООРОВ НАЙРАГЧ ДОРНОДЫН УТГАЗОХИОЛЫН
“ШКОЛЬ”-Д “ХҮЛЭГ” НАЙРАГЛАЛАА
“МАСТЕРСКАЯ” ХИЙСНЭЭРЭЭ ХИЧЭЭЛ ЗААВ**

\Тэмдэглэлийн дэвтэрт үлдсэн агшин\

Д.Хүдэрмөнх

Анхны юм бүхэн хэдэн жарныг нэвт гийгүүлэх,авшгийн гэгээг сэтгэлд мөнхөд үлдээдэг ариун сургамж сургаалтай ажээ. Залуу насны дорнод монголын гэрэлт өдрүүд сэтгэлд амилж, он цагийн нугалаасны ард үлдсэн домогт талын энгүй уужмаас газрын тосны хөгжлийн туяа сацарч байх шиг тийм өдрүүдийн нэгэн бол 1985 оны 7 дугаар сарын 11 юм. Ардын хувьсгалын яруу алдарт 65 жилийн ой, Аймгийн утгазохиолын нэгдлийн түүхт 50 жилийн ойд оролцож,залуу зохиолчдын зохиол бүтээлтэй танилцаж, зөвлөгөө заавар өгөхөөр МЗЭ-ийн Хорооны үргэлжилсэн үгийн зохиолын секцийн эрхлэгч Төрийн соёрхолт, МХЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч С.Дашдооров, ууган зохиолч өдгөөгийн Ардын уран зохиолч Б.Бааст нар Дорнод аймагт ирсэн байв. Аймгийн утга зохиолын нэгдлийн гишүүд гэх Д.Одонхорлоо, Д.Нанжидгүнтэв, Ч.Жамьян, Д.Дашдорж бид хэд хоёр эрхмийг онгоцны буудалд газардснаас нь хойш эхийгээ дагасан төл шиг хөл хэрээтэй, хүзүү холбоотой явцгаана. Чойбалсан хот зүүлт чимгээ зүүсэн үзэсгэлэнт бүсгүй шиг өнгө жавхаа нэмж, наадамчин олон, талын ганган цэцэгс шиг алгалан намирч 65 жилийн ойн баярын жагсаал үерийн ус мэт халиган бүтэн цаг гаруй урсаж, наадам эхэллээ.

Аймгийн захиргааны урилгатай утгазохиолын нэгдлийн гишүүдийг төлөөлж Б.Бааст, ахмад зохиолч нэгдлийн гишүүн Ш.Банзрагч, Ш.Цэнд-Аюуш, Д.Дашдорж нар аймгийн дарга нартай зэрэгцэн төв асарт суухаар явцгааж, Дооров найрагч, Нанжид, Жамьян бид хэд “Дөл” сонины ажилчдын байран дэх Ш.Банзрагч гуайн умгар байранд үлдэв. “Дөл” сонины ажилчдын байрнаас наадмын талбай 500 метрийн зайд байх тул, наадам хөтлөгчийн дуу чанга яригчаар цуурайлж,юу болж яаж байгаагийн өрнөлтийг мэдэхэд бидэнд төвөггүй байлаа.

Ширээн дээр идээ ундаа өрж, шилэн хундага хүртэл тавилаа. Зочноо ая тухтай амруулах гэж бид хэд эрвийх дэрвийхээрээ хөдлөнө. Үдэш нь аймгийн төвөөс 40-өөд километрт орших хүүхдийн “Энх” зусланд “Яруу найргийн цэнгүүн” зохиож, утга зохиолын нэгдлийн түүхт 50 жилийн ойн хүрээний ажлын нээлтийг хийж, Аймгийн удирдлагууд оролцооос гадна “ямаа” боож зочдоо хүндэтгэхээр Л.Хэрээ, Ж.Цэрэнпунцаг тэргүүтэн одсон байв. Нанжид

маань “Хэрлэн” гэх дөрвөлжин шилтэй тунгалаг архи задалж, Хан-Ууландаа сэржимдээд хундаглаж Дооров гуайд дээжийг нь барив. Ёсрохуу найрагч ёслолоо гүйцээгээд үндсэн гаансаараа эрээн гялгар хүүдийтэй тамхинаасаа нэрж утаа савсуулснаа “Би “Хүлэг” гэдэг нэрэнд нэн дуртай. Миний сэтгэлд ойрхон байдаг “Хүлэгч найрагч” гэж хааяа нөхдүүд урам хайрлахад үнэн зүрхнээсээ баясч, хамгийн том шагнал хүртэх шиг болдог. 1967 оны 12 сар юмсан. Москва шинэ жилийн уур амьсгалд хэдийн умбаж, тэр том хот тэр аяараа цэнгэл цэнгүүнээр дүүрсэн байлаа. Горькийн сургуулийн оюутан бид нутгаа санагалзах нэгэнтээ онгодын цагт би

“Ургах нарны түрүүчийн гэгээг

Таанын шүүстэй амтлан чавчилсан

Унаган хээрлэг морио дурсав

Унах нарны сүүлчийн туяаг

Талын тоостой сүлэн цацалсан

Шил-цагаан хээрлэгээ санав” гэсэн мөрүүдийг онгодын зарлиг, хүлэг моридынхоо төвөргөөнөөр бичсэн шүү. Яагаад ч юм бэ “Хүлэг” ямагт надтай хамт давхиж, хурдалж яваа мэт санагддаг юм. Найрагчийн минь торгон агшин онгодын хур үүнийг нотлох буйзаа. Манай улсын алдарт шүүмж судлаач, Горький төгссөн Барын Цэдэв нэгэнтээ миний тухай шүүмждээ “Хүлэг” заяатай найрагч” гэж дуун алдсан агаад үүнтэй санаа нийлэх зүйл амьдралд минь олон тохиолдсон юм. Отгонтэнгэр мөргөж сүйрсэн онгоцноос, зусландаа унах зээрд морио хүнээр харуулах гэж яаран очиж тушаагаад нислэгээс хоцорсноо “Хүлэг”-тэй холбож бодох нь бий. Зарим нь биеэ дөвийлгөлөө гэж гоочилж юуны магад. Гэвч тохиол холын болсон явдлуудыг өөртэйгээ цуг аваад тэнгэрт халих нь харамсалтай мэт санагдахын учир та нарт хэлж байгааг минь ойлгоорой.

“Хүлэг”-гээ би төрийн шагналд хүрэх мундаг найраглал бичиж байна ч гэж бодоогүй. Тэр оны 12 дугаар сард шүлэглэсэн хэсэг бусаг нэвсийсэн олон хуудастай болов. Хэн нэгэнд л уншиж үг сонсмоор санагдаад болдоггүй. Уншаад үзэхэд болоод байгаа мөртөө, нэг л юм дутаад байх шиг. Тэгтэл 12 дугаар сарын дундуур Лунчарскийд туршлага судлахаар очсон багш Л. Ванган, жүжигчин Гэндэн хоёр ирлээ. Бид хэд нутаг усаа санагалзан, ганц нэг шил пиво хоослож сууж байгаад Ванганд нөгөө бөөн цаасаа, уншаад өгөөрэй гээд өгөв. Маргааш нь сургуулийн жижүүрийн утсаар “уншлаа, чи ирж ав” гэж байна. Хичээл таруут л тийшээ дэгдэв. Ванган “Их сайн найраглал болж. Миний бодлоор эхлэл, төгсгөл нь алга. Тиймээс сайн, муугийн алийг

хэлэхгээд байгаа нь ойлгогдсонгүй. Өөрөөр хэлбэл төгс төгөлдөр болсонгүй. ”Мастерская” гэдэг нь алга гэв. Ванган аргагүй л агуу ертөнц юм даа. Өнөө дутаад байсан юмыг маань яг хэллээ шүү. Түүнээ оллоо гэж бөөн хөөр байрандаа ирэв. Одоо цаасан дээр бичихэд саадгүй гэж баярлав. Яруу найраг бол эхний мөр бадгаас л дараагийн дүрслэл хэм хэмнэлээ буюу амь орон амьсгалж амьдарч эхлэх шиг санагддаг юм. Магадгүй энэ нь зохиолоо эхэлж чаддаггүй миний муу тал ч байж мэднэ. Би “Хүлэг”-ээрээ их магтуулсан. Магтаалд онгирдог ч үгүй, баярладаг ч үгүй. Яагаад гэвэл миний энэ гол санааг маань олоод хэлчихээсэй гэсэн юмыг маань ямарч судлаач олж хэлж чадаагүй. Гэтэл би бол найраглал гэж юу байдгийг хийгээд байгаа хүн гэж өөрийгээ ойлгодог. Ванган багшийн сургаалаас хойш би найраглалын амин сүнс болсон ийм л санаа хэлнэ гэдгээ урьдаар боддог болсон.

Онгодоороо цаасан дээр шууд бичих сайхан ч амин сүнс нь болох санаа гарч ирдэггүйг мэдсэн. **Тухайлбал “Хүлэг” найраглалд миний хэлж байгаа санааг хэн ч нээгээгүй. Би тэнд адгууснаас дор хүн олширч байна гэдгийг л хэлэх гэсэн юм.** гээд босож, хүрэмнээсээ “Хүлэг” номоо гаргаж ирээд унших нь :

... Харин нэг юм хэлэхэд
Хайртай сайн хүлгээ харсангүй
Олон жил боллоо доо
Хазаар жолоогоо өргөж
Халуун хөлсий нь үнэртсэнгүй
Олон хоног боллоо доо
Адууныхаа билчээрт ижилдсэн
Анд зарим нөхдийнхээ аашийг бодоод
Хээрлэг морио нэг дурсах юм
Аймгийнхаа хязгаарт танилцсан
Аавын зарим үрсийн мөсийг бодоод
Хүлгийнхээ тухай бодолд автах юм
Хээр хөдөө унагасан ч
Хаяж орхиод явчихаагүй
Хээрлэг моринд минь
Тэд хайртай болгосоор л байна даа?
Хэл яриа мэдэхгүй ч

Хээр хаяад явчихаагүй

Хээрлэг мориндоо би

Улам ч хайртай болсоор байна даа| -За ийм л байгаа юм. Хүн чинь өөрөө өөрөөсөө их юм олдог юм шүү. Ванган багшийн сургаалаас хойш нэг хэсэг өөрийнхээ хоёр түүврийг л уншаад байдаг болсон. Ёстой Лениний зохиолоос илүү уншсан даа. Тэнд дулимагдуулсан санаа ч байх шиг. Тэгж л “Хүлэг” найраглал бичигдсэн юм. “Хүлэг” найраглал миний номд байсан юм билээ. Залуу зохиолчид та нарт бас нэг зүйл нэмж хэлэхэд бидний өмнөх үеийн зохиолчид бол “зохиолч” гэдэг мундаг сайхан юм гэдгийг бидэнд төрхөөрөө хэлснээс биш “зохиол” гэдэг чинь тийм сайхан шинжлэх ухаан шүү гэдгийг нээж өгөөгүй юм. Харин бид л зохиол гэдэг чинь ийм бүхэл бүтэн шинжлэх ухаан гэдгийг та нарын үеийнхэнд ойлгуулж, амтлуулсан шүү. Иймээс ч 60-аад оныхон бид бол энэ хойч үе өмнөх үеийн гүүр болж байгаа юм. Бидний өмнөх үе бол биширлээр дээрээс сурталдсан заавраар бичиж байсан. Тийм болохоор жинхэнэ утга зохиол бий болоогүй. Бидний үе бол утга зохиол гэдэг чинь сэтгэмж мэдрэмж, онгодоороо бичдэг хэний ч хараат бус түүнийг шүүж, судалж үзэхэд нэгэн том шинжлэх ухаан болдог зохиолыг хөгжүүлэх, дэлхийн тавцанд гаргах гэж мэрийж зүтгэж ирлээ.

Залуучууд та нарын үе бол өөрсдөө л мандана. Түүгээрээ дэлхийн энд гэрэлтэн гэгээрч Монголын утга зохиолыг хөгжүүлэх биз гэж би боддог. Түүнээс биш хар амиа бодож, зөвхөн би л “зохиолч” шүү гэж өөрийгээ хаацайлд явах юм бол хаана ч хүрэхгүй. Хар амиа бодох үеээс хөндийрч, эх орон, ард түмэндээ бүх дуу хоолойгоо зориулах хэрэгтэй. Хар амиа бодно гэдэг бол зохиолч хүнд тэвчишгүй тийм ухагдахуун гэдгийг ямагт санаж яваарай гэснээр Монгол улсын ардын уран зохиолч, Төрийн шагналт С.Дашдооров гуайн ярианы тэмдэглэл дуусаж, баяр ёслолын үйл ажиллагааны тэмдэглэл үргэлжилсэн байв. Би баярын тухай биш Дооров найрагч “Хүлэг” найраглалаа хэрхэн бичснийг л өөрийнх яриснаар нь задалж хэлснийг бичих гэсэн болохоор эл дурсамжаа өндөрлүүлэв.

2015-11-1

“АРДЫН АВЪЯАСЛАГ ЗОХИОЛЧИЙН АМЬДРАЛ, УРАН БҮТЭЭЛЭЭС ТӨРСӨН БОДРОЛ, ТЭМДЭГЛЭЛ”

**Өмнөговь аймгийн Манлай суман дахь ардын баатар, партизан
Д.Нанзадын нэрэмжит ЕБС-ийн багш Б.Хүрэлбаатар**

Учрал хагацал, уярал баясал хөвөрсөн уртын урт их замыг түшин амьдарч, ирэх бүхэнтэй золгож, ирж буцах олон олон хүмүүнийг ижий сэтгэлийн энэрэл хайраар тосон угтаж, үдэн гаргадаг Догоо ижийн тухай өгүүлэх “Өндөр ээж” зохиолыг сумын дунд сургуулийн бяцхан сурагч байхдаа уран зохиолын номын хуудаснаас шимтэн уншиж сууснаа өнөө би дурсан санав. Өр зөөлөн “Өндөр ээж”-ийн талаар өгүүлэх энэхүү зохиолын тухай мэдэхгүй хүмүүн утга зохиолд хайртай Монголын ард түмний дунд цөөн буйзаа.

Өгүүлэн буй “Өндөр ээж” хэмээх энэхүү зохиолыг оюун билэг, онгод авьяасынхаа хурц торгон мэдрэмжээрээ туурвин бүтээсэн зохиолч болбоос Монгол улсын Ардын уран зохиолч, Төрийн соёрхолт Сормууниршийн Дашдооров буюу.

Улаан цурав нялххан болж унаж төрсөн хөрст эх газар нь хүртэл түүнд уярал ухаарал хайрлаж, ухаан бодол цэлмээм сайхан нутаг- Дундговь аймгийн Дэлгэрхангай сум буюу дээр нь гарахад дэлхий ойрхон харагддаг хэмээгдсэн Дэлгэрхангай уулынхаа хараа барааны газар “Шорвогийн овоо” хэмээх газарт хүй тасран хүмүүн заяатай золголдсон ажгуу.

Ачлал төгс аавынх нь алдар нэр болсон Сормуунирш хэмээх Монголд ховорхон энэхүү нэрийг Төвдийн шашны тэргүүн 13-р Далай лам Түвдэнжамц Монголын говь нутгаар туулан өнгөрч ахуйдаа адис жинлав хүртээн номын их багшийн маань сүнс байна хэмээн билэгшээж энэхүү нэрийг хайрласан түүхтэй ажээ.

С.Дашдооров агсан Монголын утга зохиолын абшиг шүншигт номын гэрэлт өргөө Монголын Зохиолчдын Эвлэлийн хорооны үргэлжилсэн үгийн зохиолын зөвлөлийн эрхлэгчээр ажиллахын зэрэгцээ “Монгол найраглал”, аугаа их “Говийн өндөр”, “Дуут хонгор манхан” зэрэг романуудаа туурвин, “Өндөр ээж”, “Эх бүрдийн домог”, “Гурван найз”, “Нар хиртсэн жил” зэрэг киноны уран бүтээлүүдийг хамтран бүтээлцэж үгсийн урлагийн ид шид, яруу гайхамшгийг харуулан үргэлжилсэн үг, шүлэг найраглал, тайз дэлгэцийн бүхий л төрлөөр ур авьяас, ухаан билгээ сорьсон нэрт зохиолч,суут соён гэгээрүүлэгч явжээ.

Тэрээр даахин сэвлэгнээс нь эхийнх нь сүү арилж амжаагүй балчирхан бага зургаан настайдаа Ар Халхын ариун дагшин хурдны өлгий нутаг

Алтан- Дарьгангын шилийн сайн эр Тоорой банди буюу Нанзад баатрын тухай зохиолыг сонордон сонсоод машид таашаан сонирхож байсан хэмээн өгүүлсэнтэй бас тааралдав.

Учрыг үл ухах балчирхан бага настай ч гэлээ хожмын суут зохиолч болох зөн совин, онгод авьяасынх нь бяцхан гэрэлт зул зүрх сэтгэлийнх нь нууцхан гүмд сүүмэлзэнхэн байсан ч юмсан уу даа.

Их зохиолч С.Дашдооров хэмээх эгэлгүй авьяаст эрхэмсэг энэ хүмүүн эрдмийн гэрэлт, эртний түүхт их Монголын оюуны их талбар утга зохиолын номун ертөнцөд бие намхан ч сэтгэл нь аугаа өндөр чин сэтгэлийн нинж энэрэнгүй үлст хэний ч үл анзаарам говийн намхан бор Догоо ижийн дүрээр энэрэл нигүүслийн уянгын торгон мэдрэмжийг бидэнд үлдээсэн авьяастан буюу.

Түмэндээ хүндлэгдсэн Төрийн соёрхолт эрхэм зохиолч С.Дашдооров ахайтан бол эртний ерөөлт, эрдмийн абшигт их Монголын утга уянгын гэгээн ертөнцөд үргэлжилсэн үг, шүлэг найраглал, тайз дэлгэцийн хэмээсэн хөтөлгөө морьтой дарцаглаж, манай уран зохиолын суу билэгт хүмүүс болох их эрдэмтэн Л.Түдэв, цог жавхлант яруу найрагч М.Цэдэндорж агсан зэрэг их хүмүүстэй уянгат найргийн замд дөрөө харшуулж явсан их зохиолч, эрхэм анд нь явжээ.

Авьяас билэгт Ардын уран зохиолч энэ хүмүүний анд нөхдийн хүрээлэл нь хүртэл манай эх орны утга зохиолын хүрээлэлд Монголын үргэлжилсэн үг богино өгүүллэгийн их мастер хэмээн алдаршиж “Өвгөн шувуу”, “Наран тогоруу”, “Хайрын нарсан төгөл”- өөрөө өгүүллэг зохиолын төрөл зүйлд өөрийн гэсэн өвөрмөц өнгө аястай уянгын хэц татсан Сэрүүн Галттайн билэгт хөвүүн Сэнгийн Эрдэнэ баавай агсантай хүртэл мөр зэрэгцэн киноны уран бүтээлд хүчээ сорьж явсан байнам.

Хүмүүний амьдрал гэдэг унаж босох уруудаж өөдлөх гээд бодоогүй бодол, болзолгүй хүсэл олонтаа тохиодог нь хорвоогийн жам ажгуу.

Ах дүүгийн барилдлагаат, анд нөхдийн найрамдалт алтан- Москвад суралцаж ахуйдаа Халимагийн их зохиолч Давид Кугультинов буюу “Хөхөлдэй” хэмээгчид ааг омогшилт Монгол найрагчийн алганы амтыг үзүүлсэн хэргээр намаасаа хүртэл хасагдаж үзжээ.

Хонгор багахан хорин дөрөвхөн насандаа “Монгол” хэмээх ирт найраглалаа туурвиж таанын цагаахан толгойгоор тайвшранхан анирладаг, хялганын туяхан аясаар намилзанхан долгилдог Монголын их талд өнгө тансагаараа бардамхан нумрах үзэмж гуа солонгоор нэрлэгдсэн “Талд татсан

солонго” хэмээх яруу үгсийн тунгалаг номоо дорнын их найрагч Бэгзийн Явуухулан гуайгаар адислуулан хэвлүүлж асан хувьт нэгэн хүмүүн ч бас л тэр байв.

Монгол улсын Төрийн соёрхолт, Ардын уран зохиолч С.Дашдооров агсны нутгийн хүмүүн, домог шивнэсэн сүмэн өвст дорнын аглагхан их хээрийн аниргүй шөнийн талд адуу янцгаахуйн төгөлдөр торгон мэдрэмжийг бидэнд сануулсан их зохиолч Монгол Улсын Төрийн шагналт, Соёлын Гавьяат Зүтгэлтэн Долгорын Нямаа гуай нэгэнтээ:

“Миний бие 1966 оны зун Москвад сургууль төгсөж ирээд С.Дашдооровтой нэг өрөөнд орж, 1967 оны наймдугаар сар хүртэл сууж байснаа дурсан санах шаардлагатай боллоо. С.Дашдооров 1967 оны нэгдүгээр сарын 1-нээс уран бүтээлийн чөлөө авч бичгийн жижиг ногоон машинаа тожигнуулан зай завсаргүй сууж юм бичээд байдаг болов. Түүний юу бичээд байгааг би нэг их сонирхсонгүй. 1967 оны нэгдүгээр сарын 5 –ны өглөө эрт Булган аймгийн Могод суманд газар хөдөлсний улмаас үе үе чичирхийлэл мэдрэгдээд байсан боловч Дашдооров ширээнээсээ боссонгүй. Тэр үед манай гэргий тулгар биетэй байсан учир гзар хөдлөхөөс айгаад Дооровыг бараадан хажууд нь хааяа очиж суух үед ч нөгөө юмаа бичээд үг солих завдалгүй суудаг байсан гэдэг юм. Нэг өдөр шинэ зохиол гараас гарснаа хэлээд надад уншсан нь “Өндөр ээж” тууж байв. Сайхан гэдгийг хэлэлтгүй. Энэ туужийг сонсоод хүүхэд байх үеийн нэгэн явдал санаанд минь орлоо. Хүн эмнэлэгийн техникумд суралцаж байсан 1956 оны үед би намар сургуульдаа явах гээд Дундговийн төвд замын унаа хайж байтал хотын дугаартай “полу” тэрэг тааралдлаа. Түүн дээр сууж нар шингэхээс арай өмнөхөн аймгийн төвөөс хөдөлдөг юм байна.

Би тэвшин дээр ганцаараа суугаад кабины арын цонхоор харж явтал жолоочийн хөлийн тус газар хоёр гурван жижиг бидонтой юм харагдлаа. сүүлд мэдэхнээ тэр нь Монгол архи байжээ. Жолооч нэг удаа бууж “морь харах”- ыг нь анзаарвал хөл дээрээ тогтож чадахгүй гуйвагнаад байв. Ямар сүрхий амьтантай таарч орхив доо гэж бодоод миний сэтгэл түгшиж эхэллээ. Гэхдээ эзгүй хээр газар буугаад хоцролтой биш.

Шөнийн харанхуйд Дэлгэрцогт суманд хариугүй дөхөж явтал тэрэг маань нэг өндөр юман дээгүүр үсрээд гарах шиг боллоо. Радиотор нь урагшаа бүлт үсэрсэн харагдав. Тэгээд аяархан салгалуулсаар яваад Дэлгэрцогт суман дээр очиж хонов. Өглө жолооч машин хоёрын бие хоюулаа муудсан учир явах шинжгүй байлаа. Би өөр унаа хайж яваад Оросын эрлийз жолоочтой уулзаж нэг өвгөнтэй цуг “монхор ногоон”- ы кабинд сууж явах боллоо. Тэгээд Цахиуртын гэх суурин дээр ирээд ганц бие эмгэнийд бууж цай уулаа. Тэр

суурин угаасаа ганцхан айлтай нь тэднийх ажээ.

Бид гуравт мөнөөх эмгэн борцтой сайхан хоол хийж өглөө. Замд хоол ундгүй ядарч явахад ивгээл тусламж үзүүлсэн тэр эмгэн санаанаас гарсангүй. “Өндөр ээж”-ийг сонсоод энэ түүхийг С.Дашдооровт ярьж өгвөл түүний зохиолын баатар мөнөөх эмгэн болж таарлаа. Тэгээд ийм зохиолыг ийм богинохон хугацаанд бичгийн машинаар шууд биччихэж болдгийг анх удаа хараад Дашдооровын авьяас чадварыг үнэхээр биширч хүндэтгэхэд багадмаар санагдаж байв. Хоёр долоо хоногийн дотор биччих шиг болсон гэж хожим нь оюутнуудад ярьдаг байсан. Гэтэл зохиолчийн өөрийнх нь дурсамжинд тэмдэглэснээр “... ийнхүү гурван жил шахам тарих толгойд маань эргэлдэн шаналгаж явсан зүйл гурван долоо хоногийн дотор цаасан дээр бууж нэг мэдэхнээ би “төгсөв” гэсэн үг тавьж суув” гэсэн байх юм гэжээ”

Өндөр ээжийн дайнд явсан хүү Гомбожав гэсэн нэртэй байдгийн цаад учрыг эндээс ойлгож болно. Үеийн нөхөр найрагч Д.Гомбожавын дурсгалыг хүндэтгэхийн хамт зохиолд нэг дутагдаад болж өгөхгүй байсныг өөрийнхөө амьдралаар “хэлж” мухардлаас гаргасанд буян санаж явсных бизээ. Зохиолчийн шинэ тууж төдхөн “Цог” сэтгүүлд хэвлэгдэж Монголын Радиод ажиллаж байсан миний бие уг зохиолоор радио зохиомж өргөн нэвтрүүлэгт оруулсан нь хэдэн жилийн өмнө “Алтан фондоос” хэмээн явж байгаа нь радиогоор сонсогдож л байна” хэмээн эрхэм андыгаа дурсан өгүүлсэн байх ажээ.

Аж төрөхүйн гүн ухааныг алхам бүртээ шингээсэн амгалан төгөлдөр ашдын билэгт амар жаргалангийн өлгий нар үнэртсэн налгархан их Монголын говьд хүмүүн болж эх орныхоо утга зохиолын ертөнцөд өөрийн гэсэн арилан баларшгүй өвөрмөц зам мөрийг үлдээсэн их зохиолч С.Дашдооров таны мөнхийн эх орныхоо оюуны баясал, сэтгэлийн гэгээрэлд оруулсан харамгүй хувьв хишигт тань гүнээ талархан баясаж буйгаа илэрхийлж түмэнтээ мэхийсүү.

Монгол улсын Төрийн шагналт, Ардын уран зохиолч С.Дашдооров агсны зохиол бүтээл бол бүхэлдээ эх орон, ижий говь, элгэн түмнээ хайрлан хүндэтгэх өрөвч нинжин, өр зөөлөн сэтгэлт Монголын их говийн хүмүүний оюуны их хур байлаа. Түний зохиол бүтээлийн дундаас хүмүүний сэтгэлийн нандин утсыг хөндөж байгаль ижийн үзэсгэлэн, хүмүүний сэтгэлийн гуа сайхныг хамтатган сүлэлдүүлж харуулсан нь нэн соньхон мэт ээ. Их зохиолчийн бүтээл туурвилыг шимтэн суухуйд хүмүүний сэтгэлийн тэртээгээс энэрэн нигүүлсэх, бодь сэтгэл төрөн муу мууххайг уусган бөхөөж сайн сайхныг үүсгэн сэхээх мэт тийм л төгөлдөр эрхэмсэг мэдрэмжийг төрүүлсээр л байх ажээ.

Монгол улсын Төрийн соёрхолт, Ардын уран зохиолч С.Дашдооров агсны оюун гэгээрлийн хурц торгон мэдрэмж, хур арвин авьяас билгээрээ туурвин бүтээсэн гайхамшигт зохиолуудын эх орон, эх нутаг, говь нутгийн тухай өгүүлэмжүүдийг нь таалан болгоовоос сэрэл мэдрэмжийн минь тэртээгээс ийм л уяралтай хийгээд ухаарал хайрлам “УЯНГЫН ЗУРАГЛАЛ” тодрон гэрэлтэх авай.

Эх орны маань энхийн өглөөг уринхан даллах мэт их талын сувдрах мөнгөн зооноос говийн галт наран баясанхан мишээх нь юутай үзэсгэлэн төгөлдөр билээ. Эрхэс тэнгэрт хөшиглөх зэсэн улаан, цэнхэр манант, алтан шаргал гээд үүнийг бичигч мөхөс миний хувьд үгээр дүрслэн үзгээр тэрлэн үл хүчрэх үй түмэн өнгө хувирлаар солонгорох үүлсийн бараа ч юутай үзэмж төгс үзэгднэм бэ?. Үүнээс цааш үй түмэн өнгө хувирал, үзэмж тансаг нь тоолж үл барам, тоймлож үл чадам олноос олон буйг та бид хэрхэн илэрхийлж чадахсан билээ. Хүй цөглөж, хүмүүн болоход намайг тоссон “Эх орон” хэмээгчийн хичнээн аугаа их төгөлдөр эрхэмсэг болохын өчүүхэн нэгэн илрэлийг дүрслэн өгүүлэх л гэж мөхөс нэгэн би бээр зүдэнхэн суунам.

Ийм л эрхэмсэг төгөлдөр байгаль ижий таныхаа үрс нь болсон бид чинь үргэлжид нандигнан хайрлаж билгүүн их оюуны цэцээрээ мэдрэн догдолж чаддаг ч бил үү дээ. Торойх бараа, торох саадгүй аяс намуун, амгалан цэлгэр хөдөө буйдын толгод думд нааданхан өссөн миний бие талын тэртээх тэнгэрийн хаяанаас урган гэрэлтэх нарны түмэн цацраг ийм үгээр урлахад ур дутам, үзгээр тэрлэхэд бяр цуцам үзэмж гуагаар мандан гэрэлтдэгийг өнөөг хүртэл яагаад анзааран болгоож яваагүй юм бол оо.

Ийн мөхөс бичээч миний үзэг барьчихаад үгээр урлах гэж зүдэнхэн суугаа эрхэмсэг тансагийн дээд эх орон таны төлөө хичнээн ч олон эрэлхэг хөвгүүд, эрэмгий охид аж амьдралаа зул болгон өргөснийг хэн ч тоолж эс мэднэ. Эмээлт хүлгийн нуруунаас буухын ч завдалгүй эх орон Монгол таны төлөө тэмцэж унагасан хөлс, урсгасан цус бүхэн нь ирээдүйн үрс биднийг л эх оронтой нь үлдээх гэсэн эцэг өвгөд та бүхнийхээ мөнхийн суу алдрын тань өмнө тэргүүнээ мэхийн гүнээ хүндэтгэн буйгаа илэрхийлсүү?

Өглөөн наран өөдөөс мандах амгалан цагаар аавын гэрээс гарч нүдээ анилдуулан ингэн зэлнээс наашлах ижийгээ харчихаад тосон гүйж явсан балчирхан бага насаа өнөө би дурсан санаад тийм гэж хэлэхийн аргагүй уяралтай хийгээд бурханлиг мэдрэмжигий өөр хаа нэгтэй олж мэдэрсэн гэж үү? гэдэгтээ эргэлзсээр л байнам.

Таанын толгой цагааширч, тараг айраг дэлгэрэх намар оройн цагаар аясын салхин хацар илбэх тааламжит цагийн сайхныг хүй цөглөж, хүмүүн

заяатай золголдсон эх нутаг минь танаасаа өр хаана мэдрэн догдолж чадахсан билээ. Намуухан зуны үдэш саах зөрүүлж нутгийн айлын зүгт хургаа тууж явахдаа зүйлийн цэцэгт эх нутгийнхаа хөрсөн дээр нь хөл нүцгэн гүйж явсан минь л хамгийн гэгээн тунгалаг дурсамж болон үлдсэн ажгуу.

Бие биедээ буруу санадаггүй, буй бүхнээрээ биесээ дайлдаг хүмүүнлэг чанар, ёс суртахууны дээдийн дээд эрхэмсэг болоод эгэл энгийн Монголын ард түмний үр сад нь болж хорвоод ирсэн ховорхон хувь заяандаа ч түмэнтээ талархнам, би. Он цагийн тоосон дунд улам бүр алсран холдсоор л буй балчирхан бага насны минь аниргүй намуухан, ариун гэгээн дурсамжийг сэдрээн орой ухаант, дорой оюунт мөхөс миний бодоход үүрийн гэгээнээр биднийг дуудан сэрээдэг байсан ааван ээжин хоёрынхоо холч мэргэн ухаан, хойчоо ббодсон санааг нь өнөө л ухан ойлгох аядаж сууна уу даа.

Үүрийн гэгээ туяарч, өглөөн наран зүүнээс мандах цагаар ижий минь биднийг дуудан сэрээж илчит дорнын наран гийгүүлэнхэн мандахыг харан баясах хувьт тохиолыг үрс бидэндээ үлдээж л явсан байнам бус уу. Өмөг түшигт ижий аав хоёрын минь тоонотоо өргөж, тулгаа тулсан өлгий нутаг өмний цэнхэрхэн говь нутаг мину. Таныгаа би орхиж яахин чадахсан билээ. Ариун номын шимийг хүртэж ардын багшийн шавь болохоор аавтайгаа цуг зорьж мордсон наран ивгээлт, номын гэрэлт өргөө минь ч энэ л эгэлхэн газарт эх орны үүдэн босго налгархан говь нутагт л буй. Үе тэнгийн багачуудтай үерхэн тоглож, үймж шуугьсан сурагч нас минь нэг л мэдэхэд он цагийн эрхээр урсан өнгөрсөн нь нэгэн бодлын гуниг төрмөөр ч ертөнцийн зүй тогтол, хорьж үл хүчрэх хорвоогийн жам ёсыг яалтай билээ л.

Аяс намуун салхин сэвшээтэй, агь таанын үнэрт талын бэлчээрт нь дураар тоглонхон өсөж, унаж босох, онож алдах нь алагласан их амьдралын их замаа эхлүүлсэн эх сайхан нутаг таньдаа үрс бүхэн бүхэн нь хайртай байдаг нь арга ч үгүй юмсан уу даа.

**С.ДАШДООРОВЫН “БУУЖ МОРДОХ ХОРВОО” ЗОХИОЛЫН
ДҮР, АГУУЛГА, УТГА САНАА, УРАН САЙХАН, МОНГОЛЫН
УТГА ЗОХИОЛЫН ХӨГЖИЛД ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР,
НЭРТ ЗОХИОЛЧ Т.ЮМСҮРЭНГИЙН “НУТГИЙН ЦЭНХЭР
ЗЭРЭГЛЭЭ” БҮТЭЭЛЭЭС ЯЛГАРАХ ОНЦЛОГ**

**Доктор, профессор Балжингийн Тогооч
/ МЗЭ, МСНЭ-ийн гишүүн, зохиолч, сэтгүүлч /**

Сормууниршийн Дашдооров Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Шорвогийн Хөх овооны бууцанд 1935 оны 3 сарын 9-нд төрсөн гэж явдаг. Багшийн сургууль, Москва хотын Горькийн нэрэмжит Утга зохиолын дээд сургууль, дээд дамжаанд суралцаж төгссөн¹. Зохиолчдын хороон дээр болдог гурав дахь өдрийн ажилд Л.Түдэв, Д.Маам нартай С.Дашдооров байнга очиж, Д.Сэнгээ, Ч.Лхамсүрэн нарт шүлгээ уншиж, засуулдаг байжээ.

Сургуулиа төгсөөд багшлахаар явах тухай тэр үеийн МЗЭ-ийн дарга Б.Жаргалсайханд түүнийг танилцуулахад, “Утга зохиол “сонины гурван дугаараас зуу, зуун ширхэг өгч, очсон газраа худалдаг гэж өгсөн байна². Дундговь, Өмнөговь аймагт 1961 – 1963 онд ажилласан 2 жилдээ “Товийн өндөр” роман, “Хүлэг” найраглал, “Өндөр ээж” “туужаа туурвиж, уншигчдын танил болоод байлаа.

С.Удвал дарга түүнийг Монгол кино үйлдвэрийн ерөнхий редактораар ажиллуулахаар хүсэлт гаргасан нь зохиолчийн уран бүтээлийн ертөнцийг нээж, киноны салбарт 1971 – 1979 онд “Эх бүрдийн домог”, “Нар хиртсэн жил” кино зохиолууд бичжээ. Зохиолчийн уран бүтээлийг үнэлж, “Товийн өндөр”, “Өндөр ээж” зэрэг шилдэг бүтээлээрээ 1975 онд БНМАУ-ын төрийн шагнал, 1997 онд “Ардын уран зохиолч” цолоор шагнасан байна.

Дунд сургуулийн уран зохиолын хичээлийн хөтөлбөрийг анхааран үзвэл, С.Дашдооровын дээрх хоёр зохиол хасагдаад, “Хүлэг”, найраглал бүтнээр, харин “Бууж мордох хорвоо” хэсэглэн орсон байх юм.

“Товийн өндөр” романы Дамдины дүр бол хүн хүнээ хайрлах, ахмадаа хүндлэх, залуусаа дэмжих уламжлал, сайхан сэтгэлийн дээдээр үлгэрлэж, нэгэн үеийнхний итгэл найдвар болсон билээ.

¹ № Зандраабайдий Х. “Монголын зохиолчдын намтрын лавлах” УБ 2008 он. хууд 73

² “ХХ зууны монгол зохиолчид Сормууниршийн Дашдооров” цуврал. эмхтгэсэн Д.Төрбат, ерөнхий редактор Х. Сампилдэндэв, Доктор, профессор С.Байгалсайхан, УБ 2004. хууд 19, 130 - 159

2004 онд төрийн шагналт зохиолч Дамбын Төрбат “Говийн өндөр”-ийн Мангар Дамдинг амилуулсан арван дүр”³ судалгааны бүтээл бичсэн нь уншигчийн уран зохиолын боловсролд чухал нөлөө үзүүлж байна.

Учир иймд одоогоор судалгааны түвшинд ороогүй байгаа, Ардын уран зохиолч С.Дашдооровын зохиолуудаас Х ангид үзэхээр сонгосон “Бууж мордох хорвоо” зохиолын агуулга, утга санаа, дүрээс хэлний онцлогийг түүвэрлэн гаргаж, зохиолчийн утга зохиол дахь дэвшилтэт хандлага, дүр, утга зохиолын хөгжилд оруулсан хувь нэмэр, үе тэнгийн, нэрт зохиолч, сэтгүүлч Т.Юмсүрэнгийн бүтээлээс ялгарах онцлогийг тодруулах, сургалтын арга барил өөрчлөгдөж буй энэ үед залуу багш нарт туршлага, гарын авлага, өсвөр, залуу үеийнхний уншлага, эх хэлний боловсрол, монгол соёлын тухай мэдлэгт дусал нэмэрлэхэд тус дэм болгох зорилгоор энэхүү үгүүлийг бичиж байна.

“Сормууниршийн Дашдооров /1935–1999/ “Түүний хүүрнэл зохиолын баатрын хэл нь тод ялгарахын дээр бичлэгт нь хошин аяс илэрч байдаг онцлогтой”⁴ гэж судлаачид үзсэн байна.

Үүнийг зохиолоос үзье.⁵

Үдийн тунгалаг зэрэглээ бөөн бөөнөөрөө цогих тэртээ урдах буурал талын дунд бөртөлзөн цаашилж яваа морьтой хүний хойноос хараа тавив. Тэгээд өөртөө ”Ангаа өвгөн ингээд явчихдаг байж... . Нутгийн нуруутай хэдэн өвгөний нэг байлаа даа.” гэж өгүүлснээ, ийш тийшээ ямар нэг чимээ чагнаж, бараа харж, сэrvэлзэн харснаа, маанийн шад бувтнан уншив.

Сумын төв орохоор яваа Самбаа ойр зуурын үг солих зуураа Төгөөг хонио тогтоож явахад нь дайран ирж, нутгийнхан” Ангаа” гэж хүндэлдэг, өвгөн Хангай бие барсаныг дуулгажээ.

Энэ мэдээ зохиолын эхлэл болж байна. Төгөө, Хангай өвгөнийг оршуулах ёслолд оролцох ёстой гэсэн бодол боловч, хөл муутай ганц хөгшин нь хоёр ачийгаа харж, мал хариулах өөр хүнгүй байгаа тухай үг дайж буй нь түүний санаа зовох шалтгаан. Өвгөний амьдад тус болж чадаагүй Төгөөгийн мэргэн санаа үйл явдлын бүрдэл буюу зохиолын **өрнөл** болно.

Төгөөг орь залуу явахад Хангай гэж нарийхан нуруундаа шар ногоон дурдан ч юм уу, бажгар өргөн гэгч ороож, хошмогтой цагаан тоорцог чихийг 3 Дамбын Төрбат “Говийн өндөр”-ийн Мангар Дамдинг амилуулсан арван дүр” /1.хууд 130–159/

4 “Ч.Жачин, Г.Нандинбилэг, С.Дулам, Б.Оюумаа “Уран зохиол IV” хууд 188

5 “Бууж мордох хорвоо” зохиол бүрэн эхээрээ “III Монголын өгүүллэг, туужийн дээж “ .хууд 34 – 44

нь сөхөн өмссөн, ануухан өндөр хар хүн байлаа. Тэр бээр адуунд хайртай, сайн морь унах дуртай, гялалзсан эр байлаа. Харсан үзсэн мал, дэл сул алдуул тааралдвал андахгүй, эрэл сурлын хүнд тус хүргэхийг нэр төрийн хэрэг мэт мөрдөн, ядарч зүдэрсэн хүнд тус хүргэхийг ариун үйл мэт баримтална. Морь малдаа ширүүн хүнд нүүр өгөх дургүй. Түүний эдэлж унасан морь хэзээд өнгөлөг, гундаж эцсэн явах нь нүдэнд үл өртөнө. Бүр хөгшид настан хүртэл Хангайг үнэхээр морь унаж, эдэлж сурсан хүн гэж магтана. Төгөө “Ийм нэг олондоо буянтай нас намбын цаг ирэх болов уу гэж боддог байжээ. Түүгээр ч үл барам Хангайд нэг их тус болж, баярлуулах юмсан гэж цээжиндээ бат санаж явсан цаг бий ажээ.

Энэ хэсгийг уншихад, уншигчид яагаад гэсэн асуулт, асуудал төрөх нь зохиолын **зангилаа** юм.

Тэр нь баян Садын хүргэн болдог жил гүү барих болж, хавийн уурга барьсан эр хүн сураг чимээ авсан л бол ёс мэт цугларч, онгон эмнэг унагыг нь барилцаж, ороо догшныг нь уургалалцан, хөл болдог эртний заншил байлаа. Баян Сад, Хангайг хармагц, хөл алдан, биеийн нь хөшөө гарсан мэт зэлний дэргэд ирүүт

-За Хангай минь, ууган унагыг минь уургална даа гэснээ урт хадагнахаа амыг түүн үрүү хандуулан барихад, харин Хангай: “Хүү чинь байна, хүргэн чинь байна. Цаадуулынхаа нэгээр уургалуул ! Адууны чинь эзэн гомдоно гэхэд

Сад хадгийг Төгөөд шилжүүлж, Төгөө ч “Хорьж болдоггүй хорин насныхаа аагийг чухам нэг гаргаж, нөгөө хадгаар мялаалгасан уурганыхаа ч эзэн, ямар уургач болж яваагаа гайхуулах шиг болжээ.⁶

Хангай таван азарга адууны унага зэллэж дууссаны дараа зэлэндээ тэлчлэн дэвхцэх унагыг харж, Сад уруу “Адуу чинь өснө өө! Энэ сүргийн чинь эдлэх эзэн нь ирсэн байна шүү “гэжээ. Энэ бол Төгөөг магтсан үг байлаа.

Төгөө гэрийн бараа ил газар малаа хариулах дургүй. Нэхэн санавал, энэ занг өнөө Хангай өвгөн сургасан аж. Баян Садын хүргэн болоод хоёр жил болж, адуу малд явахдаа гэрийн зүг дурандан харах дуртай байв. Хэн хэдийд манайд бууж, хэдий хэр болов? Гэрийн яндангаар утаа гарч байна уу? Үгүй юу? гэж анан сууна. Нэг удаа Ангаа өвгөн хаана хүрч явсан юм гэнэт гарч ирээд:

6 “Бууж мордох хорвоо” зохиол бүрэн эхээрээ “III Монголын өгүүллэг, туужийн дээж “ .хууд 39

-За хүү минь тогоо шанагаа манаад л, тоононыхоо утааг дурандаж сууна уу? Битгий тэгж бай. Зүдэг /- Амьтны зовох, яданги, дорой./ гэдэг юм. Малд яваа эр хүн холыг харж явдаг юм. Наад зах нь гэхэд чамайг эхнэрээ хардаад энд тэндээс харуулдаж суудаг гэж тоглоом болгоно. /хошин яриа/ Гэрийн эзэн гэдэг чинь гурван давааны /өндөр- **уран ихэсгэл**/ чанадахыг байг гэхэд, гурван гүвээний /Намхан – **багасган харьцуулсан зүйрлэл** / чанад санаа бодлоо бэлчээж явдаг юм. гэж сургажээ.

Самбаа, Төгөө хоёр багаасаа нэг нутаг уснаа айл саахалт явсан, жаран нэгний жилээ ардаа хийгээд явж буй. Харин Хангай тэднийг залуус гэдэгсэн. Өвгөд хөөрөг зөрүүлэн, үг яриа ч нийлэмжтэй.

Самбаа: ...Бид чинь энэ уусан ус, суудаг нутгаасаа хэзээч уйдаж, чилж байсангүй. Түүн шиг энэ настай буурлуудаа ч бас ад шоо үзэж байсангүй өсөж, өдий хүрч дээ хө ... Ангаагаа нутаглуулахад нь очиж, ёс төр гүйцэтгэлцэн бараа больё гэж шийдээд шогшиж явна даа. гэхэд,

Төгөө: ... Төрийн нуруу төвшин хүн явж дээ. Энэ малд ч мөн нүдтэйсэн гэж бахархана. Энэ дарга нар бага хүүхэд, өндөр настан хоёрын ажлыг үзэх биш, тэр жил далан насан дээрээ нэгдэл, амины нийлсэн хорин хоёр эмнэг тэмээ сургачихсан байсан гэдэг шүү. хэмээн аль сайхан дурсамжаасаа сэтгэлээ онгойтол ярихын зэрэгцээ ажлаа бодоцгоож, салж явахын тэмдэг болгон, дахин хөөргөө зөрүүлэн босч билээ...

Энэ нутгийнхан талийгсдаа Хөх өндөр хэмээх өнчин өндрийн өвөр налуу энгэрт нутаглуулдаг. Хангай өвгөний тухай бодол ер санаанаас гарахгүй. Тийм их ачтай, нэр төрийг нь өргөж, гэгээн сургаалаа хайрласан хүнээ амьдад нь баярлуулж чадаагүй гэх бодол түүнийг эзэмдсээр ажгуу.

Төгөө солгой гарынхаа алгыг дээш харуулан, эвэршиж бацарсан таван хуруугаа эрхийнээс нь эхлэн, хэдэнтээ дарж тэнийлгэн, өдөр гараг, жилийн тооцоо хийв.⁷

Тэгээд маргааш юм байна. гэж өөртөө өгүүлэн, хоёр хэсэг яваа хонин сүргийнхээ алийг түрүүлж эргүүлэхээ шийдэж ядан явахдаа нэгэн мэргэн санаа олов.

Зохиолын үйл явдал шийдвэрлэх үед тулсан энэ мэргэн санаа бол зохиолын **туйл** юм.⁸

Төгөөг нялх бага голдуу хонио хотондоо зугуухан дөхүүлэн ирэхэд, хөгшин нь “Сувай хонио яачихаад ирж байгаа нь энэ вэ? гэж гайхан асуухад

⁷ “Бууж мордох хорвоо” зохиол бүрэн эхээрээ “III Монголын өгүүллэг, туужийн дээж “ .хууд 37

“Өнөө шөнө хээр хонуулья гэж бодлоо хө” гэжээ. Ингээд өвгөнийг өөд болсон тухай дуулгаж, нөгөө гэнэт төрсөн мэргэн бодлоо ч бас ярьжээ. Тэд үдэш нь шар тос хайлан, зулын гол ороож, мөнх галын бяцхан тасархайг Ангаа өвгөнд зориулан өргөсөн.

Өглөө бараг үүрээр Төгөө, хээр орхисон сувай хониныхоо барааг харахаар морио барин мордов. Хонь нь бараагүй. Хорголоор нь оршуулгын цувааны чигт бэлчсэнийг баримжаалав. Ачааны машин, ахиад нэг машин, бас нэг хөнгөн тэрэг гарч ирлээ.

Өнөө цуваа далд орсноо моторын дуу нь ойртоход Төгөө мориндоо мордон эргэж дэргүүлэв. / Ямар нэг хүнийг хөдөөлүүлэх газар хүн тосч байдаг ёсгүй аж./ Харин замдаа хөөж хөдөлгөсөн адуу нь Хөх өндрийн зүүн сэрвээн дээр гарч яваа харагдана. Тэгснээ мориныхоо амыг татан бүр биеэрээ эргэж Хөх өндрийн чиг хараа тавив. Хонь нь мөнөөхөн зам дээгүүр нь гардаг хүрэн нурууны наад бутат гүвээн дээгүүр хоёр жигүүр тэлэн бэлчиж байгаа харагдав. Төгөө хониныхоо барааг харж, санаа амарсан мэт шүүрсэн алдаж, дотор цайн баясчээ.

Туйлаас шийдэл үрүү шилжих үйл явдлын бүрдэл буюу Төгөө өвгөний мэргэн санаа хэрэгжиж буй нь зохиолын **тайлал**. Нэг хоногийн дараа Самбаа ирж, Ангаа өвгөнийг хэрхэн нутаглуулсан тухай яриа дэлгэн, хөөрөг зөрүүлэн тамхилалцаж саатав.

-Хөөрхий Ангаа буянтай хүн байсан нь үнэн байна. Үгүй ээ хө, өвгөнийг хөдөөлүүлэх гээд Хөх өндөр үрүү явж байтал Хүрэн нурууны ард яг улаан зам дээр олон хонь налайж байх юм. Бас тэгээд яг чимээгүй газар дээр нь баахан адуу байж байдаг гэж байгаа... гэж баяртайгаар сонирхуулав. Самбаа бас,

- Өвгөний сүүлчийн замд халуун хошуутай мал дараа дараагаар дайралдлаа гэж зөндөө баярлан бэлэгшээж байна билээ. Хэр шүү дээ, тийм явдал ховор байдаг юм гэнэ билээ . гэж ярьжээ. Энэ яриа Төгөөд тун таатай санагдаж байлаа.

Төгөө: Өвгөний замд хонь, мал байлгая гэж бодсон минь онож. Хөөрхий өвгөнийг амьдад нь баярлуулж чадаагүй хүн би, үлдэж байгаа улсыг нь бага ч болов баярлуулсан бол болох нь тэр. Хэн намайг тийн хичээснийг мэдэв л гэж. Бас мэдүүлээд ч яах билээ гэж бодож суув. хэмээсэн Төгөөгийн бодлоор, түүний сэтгэхүйн дотоод хөдөлгөөний шинэчлэлийг тод гаргасан зохиол төгсөнө.

“Халуун хошуут малаар үгүй болоочийг үдүүлж буй энэ аугаа их монгол

ухаан Дооров ахаас гарах нь аргагүй юм⁹ МЗЭ-ийн шагналт Э.Хархүү дурсамждаа өгүүлсэн байна.

Өөд болоочоо хөдөөлүүлэхэд халуун хошуут мал тааралдвал бэлэгшээн үзэх монгол ёс заншлыг гүйцэлдүүлэн, ид залуу насандаа үлгэр дуурайлал болсон Хангай өвгөний ачийг хариулна хэмээн сэтгэлээ цайлгаж байгаа Төгөө өвгөний зүтгэл бол монгол ёс заншлаа дээдэлсэн, хүн чанартай малчин хүний дүр байна.

Зохиолын уран сайхан, хэлний яруу хэрэглүүрээс.

А. Өвөрмөц хэли

1. Суугуул нутгийн бараа ил, сүрэг малын бэлчээр нийлэн явдаг.
2. Манайхан Ангаагийн л амыг харж байсан даа –үгийг дагадаг.
3. Нэр заргүй-Олонд дуурсаагүй.
4. Түмэнд нүүрийн буянтай – Бусдад хүндлэгдсэн.
5. Наад яс үсээ эвдэж – Ойчиж бэртэх
6. Бага хүүхэд, өндөр настан хоёрын ажлыг үзэх биш- үнэлж мэддэггүй
7. Сэтгэл ханан, царай тавиран- санаа амрах
8. Магнай тэнийтэл нь - их баярлах
9. Сэтгэл нь тавгүйрхэн хямарч – эвгүй таагүй болох
10. Хөл болдог – Олноороо цугларах
11. Төгөө адуу малд явж байхдаа гэрийн бараа ил холын хяр овоон дээрээс гэр рүүгээ дурандах дуртай байжээ. Тийн дурандаж суухад нь Ангаа хос морьтой дэвэлзэн газраас ургах мэт – гэнэт гарч ирэх
12. Цээжин дотор нь ороод үзсэн юм шиг- сайн мэдэх
13. За хүү минь тогоо шанагаа манаад л, - цай хоол хийж байна уу гэж харах
14. Зүдэг гэдэг юм- Амьтны зовох яданги дорой¹⁰
15. бэмбэн түгшиж явснаа – айх
16. Морин толгой алдахгүй уурга шидэхийг нь – чадамгай уургалах

Б. Адилтгал

1. Бид чинь уусан ус, суудаг нутгаасаа хэзээ ч уйдаж салж байсангүй. Түүн шиг настан буурлуудаа ч бас ад шоо үзэж байсангүй өсөж, өдий

9 “Утга зохиол судлал, шүүмж “УБ 2015 хууд 13

10 Я.Цэвэл Монгол хэлний товч тайлбар толь УБ 1966 он, хууд 289

хүрч дээ.

2. Төгөөгийн цээжинд ассан баярын гал унтрах шиг хор шарын утаа цээжинд нь уугин баагих мэт.
3. Төлөх ёстой өрөө төлөөгүй хүний мөсгүй зан гаргасан мэт
4. Далай цагаан хонь налайж харагдахаар нь

В. Ойролцоо нэр

Харсан үзсэн мал; дэл сул алдуул; эрэл сурлын; гундаж эцсэн явах; унааширч гундсан; сольж юүлж; онгон эмнэг; ороо догшин; шоолж сонжсон; тэлчлэн дэвхцэх;

Г. Төлөөлөл

Юм үзэгдлийг адил төсөөгөөр нь жишдэггүй, харин хоорондоо ямар ч төсөөгүй зүйлийг гадаад дотоод аль нэг шалтгаант холбоо буюу харилцан шүтэлцлээр нь хамааруулж, нэгийг нь нөгөөгөөр орлуулж хэлэх, нэгэн янзын уран яруу хэрэглүүрийн **аргыг төлөөлөл** гэнэ.

1. Шар тос хайлан, зулын гол ороож, **мөнх галын бяцхан тасархайг** Ангаа өвгөнд зориулан өргөжээ.
2. Өвгөнийг хөдөөлүүлэх гээд Хөх өндөр үрүү явж байтал, хүрэн нурууны ард яг **улаан зам дээр олон хонь налайж** байдаг юм байна.
3. Бас тэгээд, яг чимээгүй газар дээр нь баахан адуу байж байж байдаг байгаа...
4. “За ямай, хөөрхий өвгөнийг амьдад нь баярлуулж чадаагүй хүн би, үлдэж байгаа улсыг нь бага ч болов баярлуулсан бол болох нь тэр.

Өвгөний замд хонь мал байлгая гэж бодсон минь онох нь онож “.. гэсэн Төгөөгийн бодлоор¹¹

Д. Зүйрлэл

А) дааганаас нь аваад азарга, морьдыг нь хүртэл шинжиж байдаг зантай, адуунд хайртай, сайн морь унах дуртай, гялалзсан эр байлаа.

Эдгээр тоочсон, энгийн зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрүүд ямар хүнийг сайн адуучин, гялалзсан эр хүн гэх тухай цогц ойлголт өгч, нутаг усныхаа тийм хүнийг зэрэгцүүлэн бодох сайхан зүйрлэл болж байна.

Б) Хавар эрт гарсан хурга эцэг эхээ даган цайвалзан гялбалзах нь өлбөн дунд цацсан сувд мэт өнгөлөгхөн харагдана.

11 “Бууж мордох хорвоо” зохиол бүрэн эхээрээ “Ш Монголын өгүүллэг, туужийн дээж “ .хууд 44

В) Үдийн тунгалаг зэрэглээ бөөн бөөнөөрөө цогих, тэртээ урдах буурал талын дунд ...

Өгүүлбэрийн гишүүдээр зурах дасгал дадлага нь хэл найруулгат ямар чухал болохыг суралцагчид сайтар ойлгохгүй байгааг энэчлэн сайхан найруулгатай зохиолоос сонгон оруулж байвал зохистой. Оюутан сурагчаар эх зохиолоос хэлний яруу хэрэглүүр элбэг өгүүлбэрийг олуулан, ажиллуулж, монгол хэл, уран зохиолын хичээл хоорондын холбоог сайтар хангах чухал байна.

Мөн яруу найргийн төрлүүдээс сайн цээжлүүлэхэд тэдний үгийн баялаг эрс нэмэгдэх ач холбогдолтой. Номыг их уншихын тус нь, яруу тансаг хэлнийхээ дүрслэлийг онож сонгосныг амтархан уншиж, сэтгэлийн цэнгэл эдэлсний учир үгийн баялаг нь нэмэгдэж, ярих, бичих чадвар нь гойд сайжирдаг болохыг Д. Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч, Болор цомын хоёр удаагийн эзэн, яруу найрагч Баярхүүгийн Ичинхорлоо, ”Сорхугтани хатан”, “Бат хаан” романаараа олны талархал хүлээсэн Бямбаагийн Сарантуяа, Хүүхдийн зохиолын “Гран при” шагналт Бат-Эрдэнийн Ганчимэг, Жадамбын Сайнжаргал нарынхаа хүүхэд ахуй цагийг сайн мэдэхийн учир бахархан дурсч байна.

Е. Сургаал үг.

Наад зах нь гэхэд чамайг эхнэрээ хардаад энд тэндээс харуулдаж суудаг гэж тоглоом болгоно.

Ямар нэг хүнийг хөдөөлүүлэх газар хүн тосч байдаг ёсгүй аж.

Ардын уран зохиолч С.Дашдооровын энэ өгүүллэгийн бусад зохиолчдын бүтээлээс ялгарах онцлогийг нэгэн цаг үед төрж, бүтээлээ туурвисаар байгаа сайн зохиолчийнхтой харьцуулбал бодит байдалд дөхөх болов уу? Түүнээс биш энэ талаар эрс зөрүүтэй зохиолчийнхтой зэрэгцүүлбэл эндүү ташаа байх магад. Нөгөө талаас өглөөнөөс нойрсох хүртлээ санаандаа бүтээлээ бясалгаж явдаг зохиолч нөхдийнхөө бүх номыг уншсан гэсэн мэт утга хэтийдсэн хэрэг болох буй заа.

Монголын зохиолчдын эвлэлийн нэрэмжит шагналт Түндэвийн Юмсүрэн 1937 оны 7 сарын 1-нд Говь–Алтай аймгийн Чандмань суманд төрсөн. Үргэлжилсэн үгийн зохиолч, нийтлэлч орчуулагч . 1963 онд МУИС төгсч, сонин сэтгүүлийн газар олон жил ажилласан.” Буурал аав минь “шүлгээр нь хийсэн дуу ихэд алдаршжээ.” Голын харгиа” УБ 1969, “Уулын голын шуугиан” УБ 1974 зэрэг олон номууд нь нийтийн хүртээл болсон.¹²

12 Х.Зандраабайдий. “Монголын зохиолчдын намтрын лавлах, УБ 2008 он. хууд 73, 203

Т.Юмсүрэн. Нутгийн цэнхэр зэрэглээ

(өгүүллэг)

“Дондог хонио туусаар Баян даваан дээр гарч ирэв. Алсыг ажвал Шаахарын Садарга талаар зэрэглээ эрвэлзэн наадаж, түүнээс цааш өвөр, энгэр бэл нэлдээ бараантана. Өнөөдөр тэр урин цагийн бүлээн салхийг сөрөн алхаж, үлгэрийн цэнхэр зэрэглээг сэтгэл догдлон харж, адуу малын янцгаах, хурга ишигний майлаан чагнан, ирж яваа цагийн түмэн аялгууг сонсон, сэтгэл нь туйлгүй ихээр догдолно.” гэж малчин хүний амьдралын нэг өдрийг зураглан өгүүллэг эхэлнэ.

“- Дөчин нас гэдэг, даваан дээр гарч ирсэнтэй адил юм даа” гэж нэгэн зохиолч бичсэн байна. Би одоо амьдралын даваа, Баян даваа хоёулан дээр нь зэрэг гараад иржээ гэж бодов. Тэгтэл “- Чи энэ даваан дээр гарч ирэх гэж нэлээд их мацсан шүү” гэж шивнэх шиг болов.

-Тийм ээ, амьдралын даваанаас цааш улам өндөр уул өөд өгсөнө. Харин Баяндаваанаас цааш нам уруу орно гэж санана. Эндээс зохиолын **зангилаа**: Дондогийн дөч хүртэлх амьдралын туулсан зам **өрнөл** болж үргэлжилнэ. Дондог Эрдэнэмаа хоёр өнгөрсөн өвлийн хэцүү, хатууг арайхийн давж, малаа төллүүлж дуусаад отроос буцаж яваа нь энэ. Түүний нөр их хөдөлмөр, үзэл бодлыг өгүүлсэн зохиолын уран сайхнаас дурдая.

1. Ойролцоо нэр

Хуйлран жирийх нь, баяр баясал

2. Адилтгал

Үлгэрийн цэнхэр зэрэглээ

3. Зүйрлэл

Дөчин нас гэдэг даваан дээр гарч ирсэнтэй адил юм.

Дэлхий, нэвсгэр цагаан нөмрөг доор нуугдав.

Нулимс мэлмэрч, усан зэрэглээ татан юм бүхэн бүдгэрэх шиг болов.

4. Өвөрмөц хэлц

Биеэ оторлосон- биеийн амрыг харах

Олон хоног малтай ноцолдон ядарсан ядрал дээр нь сэтгэл үрүү нь **хүйтэн мөс чулуудав.** – урам хугарах

Буруу ишилсэн сүх шиг- зөрүүд

Хүний сайн муу үг даахтай болоод- утга учрыг мэдэж тэвчээртэй хандах

Өдөр шөнөгүй хурга зөөн амлуулсаны хүчинд-эхэд нь хөхүүлэх

Хүү нь нэг л **гэм хийсэн аятай хулгаж байснаа**, сайн гээд доош харав.
- айсан дүртэй

5. *Цэцэн үг*

Зөөлөн нь хатуугаа давдаг.

6. *Уран давталт*

Дондогийн харж буй зүгт хаврын цэнхэр зэрэглээ эрвэлзэн, ойр орчинд нь хурга ишиг майлалдаж унага даага янцгаах чимээ сонсогдоно. Энэ бүх өнгө аяс, хөг аялгуу сэтгэлд нь улам улмаар хоногших агаад ер бусын баяр баясгалан хөгжөөх шиг санагдав. Дондог хотоос ирж буй хүү Шаахарын тал хоёроо ээлжлэн харж инээмсэглэн зогсоно. Энэ өдөр өөрөөс нь илүү жаргалтай хүн хаана ч үгүй юм шиг санагдана.

7. *Яриа*

- Хамт ирсэн дүү нь: Ах сургуулиасаа хөөгдчихсэн. Архи уугаад хүнтэй зодолдсон гэнэ.

8. *Егөөдөл*

- Чамайг би архичны сургуульд явуулсан билээ үү?

Дондог дув дуугүй доош харан суусаар. (**зохиолын туйл**)

... Сургуульд сурч байна гэж суурин газар биеэ оторлосон энэ амьтан, малыг яахаар нь чаая гэдгийг ч мэдэхгүй... Одоо чухам юу хийлгэх билээ... гэж санааширч байснаа

Хонь л хариулж дээ гээд өөдөөс нь харвал хүү нь

Аав аа, би наймаа хийнэ гэв.

Дондог өөдөөс нь удаан ширтсэнээ -Архины наймаа хийх үү? (**ёгтлол**) гээд, харцаараа хоргоов.

Хүү нь гөлөлзөн нүүрээ буруулан доош харлаа. Дондогийн нүдэнд нулимс мэлмэрч ирэв. Энэ үед Шаахарын талаар усан зэрэглээ татан юм бүхэн сүүмэлзэн бүдгэрэх шиг болов. хэмээн зохиол төгсөнө.

Үүнээс үзэхэд “Бид ямар их хөдөлмөрийн хүчээр буянт малаа өсгөж, хүүдээ зардал явуулж байлаа даа, эрдэм номтой сайн хүн болгоно гэсэн хүү

яаж байна даа” гэж бодон Дондогийн сэтгэл хямарсаныг хэн ч гайхахгүй.

Хорвоог нулимстай нүдээр харж байгаа Дондог бол үүргээ биелүүлж чадалгүй буцаж буй цөөнгүй оюутны ар гэрийнхний амьдралын төлөөлөл юм.

МЗЭ-ийн нэрэмжит зохиолч Т.Юмсүрэн “Нутгийн цэнхэр зэрэглээ” “өгүүллэгийн эхлэл, төгсгөл хоёрын байгалийн зураглалыг уран давталт хийж, дүрийн онцлогийг тодруулан, тулгамдаж буй шүүмжлэлтэй сэдвийг гярхай ажиглан сонгосон байна .

Дондогийн бодол, егөөдөн ярих яриа, ажилсаг хөдөлмөрч чанарыг товойлгон гаргаад, гадаад төрхийг нь үзүүлээгүй бол, зохиолч С.Дашдооров Хангай өвгөний гадаад төрхийг нүдэнд харагдтал зураглаад, үг яриа, үйл хөдлөлийг нь

Төгөө, Самбаа нарын яриа, бодлоор тодруулан дүрсэлснээр сэтгэл хоношим дүр бүтээжээ.

Эдгээр зохиолууд сайн малчин хүний адуучин, хоньчин хүмүүсийн амьдралын сэдэвтэй боловч, үйл явдал, утга санаа нь өөр тул хэлний яруу хэрэглүүр нь ижил дүрслэл ховор, зөвхөн зэрэглээг Т.Юмсүрэн : Эрвэлзэн наадаж, үлгэрийн цэнхэр гэсэн бол С.Дашдооров: зэрэглээ бөөнөөрөө цогих гэж нэг удаа дурджээ.

ДҮГНЭЛТ

1. Ардын уран зохиолч, төрийн шагналт Сормууниршийн Дашдооров үгээр урлахын гайхамшгийг “Бууж мордох хорвоо” зохиолдоо гурваас дөрвөн хүний дүрд шингээн гаргахдаа ихэвчлэн тэдний яриа, үйл хөдлөлөөр нь зурагласан.

2. Нэрт зохиолч Т.Юмсүрэн, С.Дашдооров нар буянт малдаа хайртай, хоёр малчин өвгөний дүрийг өөр утга санаанд зангидан, дүрсэлсэн боловч, зохиолын өгүүлэмжийг тодотгохдоо байгалийн зураглал, уран сайхны яруу хэрэглүүрээс С .Дашдооров өвөрмөц хэлц, ойролцоо нэр, төлөөлөл илүү хэрэглэдэг байжээ.

3. Зохиолчийн утга зохиолын хөгжилд оруулсан хувь нэмэр бол, судлал шүүмжийн бүтээлээс байнга суралцаж, бүтээлчээр хөгжүүлэн, амьдралыг гүнзгий судлан бичдэг байсан гэж үзэх үндэслэлтэй юм.

4. С.Дашдооров түрүү үеийн бичгийн мэргэдийн “яриа” хэлбэрийн уламжлалыг 1960-аад оны сонгодог реалист арга, найруулгуудтай хослуулан туурвидаг байсан нь түүний бүтээл, кино зохиолуудаас тодорхой харагдаж байна.

1960-аад оны судлал, шүүмжлэлд уран зохиолын хэлний цэвэр ариун байдал, түүнийг зөвөөр хэрэглэн хөгжүүлэх тухай нэлээд өргөн хүрээтэй хөндөгджээ. “Хүн бол насан туршдаа хэлд ордог. Хүн өсөж мэдлэг нэмэх тутам хэл нь баяжиж байдаг юм.” гэсэн санааг Л. Түдэв дэвшүүлж, “Бичиг соёлын өвөөс шамдан суралцаж, зохиолын аль ч төрөлд уран цэцнээр утга санааг илтгэн, яруу тунамалаар бичих нь” манай зохиолчдын хойшлуулшгүй эзэмших зүйл болсныг Х. Пэрлэй онцлон өгүүлсэн байна. “Зохиолын өгүүлэмж, түүний амин сүнс нь “Уран хэл, утга нэвтэрхий “байхад оршино гэж Г.Ринчинсамбуу бичжээ.¹³

Орчин үеийн цахимжсан эриний 21-р зуунд ч утга зохиолд цөөхөн хүн өөрийнхөө дотоод амийг хадгалсан бүтээлээрээ үлдэнэ. Насаараа утга зохиолын амьдралд үйгдэж, таньж олж харсан, Соёлын гавьяат зүтгэлтэн Л. Одончимэд “Авьяас бол хүн болгонд заяадаггүй, худалдан авч болдоггүй бурханы хишиг.” хэмээн гүн ухааны гаргалгааг зүгээр ч хэлчихээгүй болов уу! Энэхүү бүх билэгт авьяастнуудын олон өнгөний тусгал эрт, эдүгээтэй нийлээд Монголын утга зохиолын ертөнцийн эрдэнэсийн сан, үндэстний оюун санааны дархлаа ХЭЛ-ХИЛ, бичиг соёлоор дамжин улс оршихуйн үндэс бүрдэж байгаа юм.¹⁴ гэж МЗЭ-ийн шагналт зохиолч Б.Энхтөр бичсэн байдаг.

Мөн тэрбээр ”Монгол хүний, нүүдэлчин хүний мөн чанарыг харуулсан зохиолуудыг бодлоготойгоор хөрвүүлэх, орчуулах нь харь орны дээвэр дор байгаа монгол угсааны хүнд монголоороо үлдэх эд нь тусална гэж бодож байна.

Миний санаа бол эхлээд монгол хэлтэн, үндэстэндээ, монгол хэлээ мартсан ч гэлээ монгол угсаатандаа танигдах ёстой, хүндлэгдэх ёстой гэдэг л үзэл, хэрэв тэгж чадвал хүссэн хүсээгүй дэлхий таныг анхаарах болно гэж л хэлэх гэсэн юм” гэжээ.

Орчин үеийн шүүмжлэгчдийн үзэл санаа, онолын ойлголтын тухай уншиж, 1960-аад оны үеийн зохиолын шүүмжүүдтэй зэрэгцүүлэн, талархахын хамт зарим талаар зүрхшээн бэргэвч, сэтгэлд хоногшсон сайхан зохиолтой

С.Дашдооровын бүтээлийг уншигч нь улам олон болоосой, залуу үеэ эх хэлээ хайрлах яриа бичгийн соёлтой болоход нь зохиолчид түүний бичлэгийн арга барилаас суралцан, залуу багш нар монгол хэл, уран зохиолын хичээлийн

13 “МЗЭ-ийн 3-р их хурал 1962 он С. Лувсанвандан, Ц. Мөнх, Д. Цэнд Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх УБ 1967 хууд 496-497”

14 60 жилийн ойн уралдааны судлал шүүмжийн бүтээлийн цоморлиг. “Утга зохиол судлал шүүмж “УБ 2015 Б.Энхтөр хууд 35, 36- 37

залгамж холбоог сайтар хангаж, эх хэлний дархлаагаа хадгалах сайн уншигч, эх зохиогч олныг төрүүлэхэд бага ч атугай тус больё, энэ нь үзэг нэгт нөхдийнхөө өмнө хүлээх үүрэг хэмээн энэ үгүүллийг хичээнгүйлэв.

Мэргэн уншигч ТА таалан болгооно уу .

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. “ХХ зууны монгол зохиолчид Сормууниршийн Дашдооров“цуврал, эмхтгэсэн Д.Төрбат, ерөнхий редактор Х. Сампилдэндэв, Доктор, профессор С.Байгалсайхан, / хууд 19/
2. Дамбын Төрбат “Говийн өндөр”-ийн Мангар Дамдинг амилуулсан арван дүр” / хууд 130–159/
3. “Ч.Жачин, Г.Нандинбилэг, С.Дулам, Б.Оюумаа “Уран зохиол IV“, хууд 188
4. “Бууж мордох хорвоо“зохиол бүрэн эхээрээ “III Монголын өгүүллэг, туужийн дээж “хууд 34 – 44
5. Х.Зандраабайдий. “Монголын зохиолчдын намтрын лавлах, УБ 2008 он. хууд 73, 203
6. Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” УБ 1966 он, хууд 289
7. С.Лувсанвандан, Ц.Мөнх, Д.Цэнд” Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх “УБ 1967 он. Хууд 496 – 497
8. 60 жилийн ойн уралдааны судлал шүүмжийн бүтээлийн цоморлиг. “Утга зохиол судлал шүүмж “УБ 2015 хууд 223, Б.Энхтөр хууд 35, 36- 37
9. Г.Батсуурь. “Уран зохиолын дэд асуудлууд “ УБ 2014 хууд 159, 161
10. 60 жилийн ойн уралдааны судлал шүүмжийн бүтээлийн цоморлиг. “Утга зохиол судлал шүүмж “УБ 2015 Б.Энхтөр хууд 35, 36- 37

“ГОВИЙН ӨНДӨР”-ИЙН ГОЛ ХҮМҮҮС

Төрийн шагналт зохиолч Дамбын Төрбат

Монголын шинэ үеийн утга зохиолын хөгжлийн наяд жилийн түүхэнд 300 гаруй роман гарсанаас айргийн тавд багтах “Говийн өндөр” романы гол баатарт зохиолчийн өөрийн төрх бага бус шингэснийг зохиолчид нэг биш удаа тэмдэглэсэн ажээ.

Төрийн шагналт яруу найрагч О.Дашбалбар “...Эндээс “Говийн өндөр”-ийн мангар Дамдинг би олж үзнэм. Гадаад төрх нь мангардуу болхи ч, таван гүвээний чанад таана таслахыг сонсох хөдөөгийн хөвгүүн эх газартайгаа ямар нарийн холбоотой вэ? ...”Говийн өндөр”-ийн Дамдин Дашдооровын зан төрхийг өөртөө хадгалж буй хэдий ч, зохиолч хийгээд зохиолын баатар хоёрыг ялгаж, салгаж ойлгох хэрэг заримдаа гарна” гэж хэлсэн байна. (“Залуучуудын үнэн” №99 /7520/ 1988 он)

Төрийн шагналт зохиолч Д.Гармаа: “...Зохиолч зохиолынхоо баатруудтай адил төсөөтэй байх нь ховор үзэгдэл боловч би Дооровыгоо романых нь дур булаам баатар мангар Дамдинтай харьцуулан боддог билээ. Хүнлэг сайхан сэтгэлтэй Дамдингийн олон шинж Дооровт маань бий” гэж өгүүлсэн билээ.

Нэг. Мангар Дамдинг амилуулсан арван дүр “

...Романы гол баатар Дамдин говь нутаг, голомтондоо аав ээжийнхээ гар дээр өссөн цайлган сэтгэлтэй гэнэн хонгор залуу юм. Дамдины дүр бол гэрэл гэгээтэй цэвэр тунгалаг дүр юм. Амьдрал тэр чигээрээ түүнд гайхал бишрэл болсон байна. Тэрбээр алхам тутамдаа шинэ юм таньж мэдэх агаад үнэндээ ч мэддэг юмаар маруухан эр юм. Зохиолч баатраа амьдралын янз бүрийн нөхцөлд учруулж яаж өсч өөрчлөгдөж байгааг нь тодорхой үзүүлж байна...” гэж Висс. Бильдушкинов (“Гадаадынхан Монголын уран зохиолын тухай” номоос 9-р тал) өгүүлсэн байдаг. Нээрэн л, мангар Дамдинд амьдрал тэр чигтээ гайхамшиг юм. Ер тэр өөрөө ариун гэгээн, гэнэн томоогүй, басхүү дэврүүн бадрангуй эр. Романы тэргүүн дэвтэрт хөдөө бяцхан суурингийн мэдэх юмаар маруухан эр гардаг бол дэд дэвтэрт хот хэмээх олны хөлийн газарт өөрийн дураар төөрч үлдсэн мань хүн их амьдралтай хөл нийлж ядаж яваа хөгтэй, гунигтай, уяралтай учрал тохиолыг энгийн агаад уран дүрсэлсэн байдаг. С.Дашдооровоос өөр хүн бол эвлүүлэхийн аргагүй баатрууд нь саланги, хурц үйл явдлын сонин зангилаа байхгүй ч бүх зүйлийг нарийн хэлхэж зангидаж өгсөн нь ажиглагдана. Үүнийг Висс. Бильдушкинов: “... Зохиолын ихэнх хэсэг нь олон бие даасан, бүрэн бүтэн тууриудыг угсарч

залгасан бөгөөд зарим үйл явдлууд өөр хоорондоо үл холбогдсон янзтай байна” гэж өгүүлээд нэг их нарийн юмыг анзаарсан байдаг. Энэ бол зам. “... Зохиолч эдгээрийг хэлхэж холбох өгүүлэмжийн холбоосыг өвөрмөц сонин арга хайж олжээ. Тэрбээр уг зохиолын олон явдал бүхнийг цөмийг замд нь холбож өгчээ. Тэдгээр зам нь хол ойр, их бага янз бүр байна. Зарим нь айлын хотноос малын билчээрт, эсвэл нэгэн хотонд хүрээд төгсөнө. Зарим нь бүр хол одож, хот орон нийслэлийн зүг зална. Зохиолын баатрууд бараг цөмөөрөө замд гарч байна. Зам тэднийг салгаж, зам тэднийг уулзуулна. Хамаг сонин мэдээлэл замаас гарна. Тэр сониныг тэсгэлгүй хүлээж тэр нь нэгээс нөгөөд, гэрээс гэрт дамжина. Зам баатруудыг бодолд оруулж, замд учирч тохиолдсон нь ор сураггүй болохгүй, зарим үед баатруудын хувь заяанд шийдвэрлэх нөлөө үзүүлнэ. Роман замаас эхэлж замд төгсөж байна” (мөн тэнд 10-р тал) гэжээ. Ийнхүү бид мангар Дамдинг зүглэсэн замаар алхаж түүнийг амьд, сонин, содон дүр болгосон арван хүнтэй уулзая!

1. *Тогоо*

“Дүүрэн ачаатай нэг машин талын харгуй замаар довтлон явсаар Ханцуй бутны урд налуу сайхан арыг өгслөө” гэж роман эхэлдэг. Энэ машины жолооч Тогоо бол “кабиныхаа хаалгыг эртэйхэн хааж халхгар өмдөө шулхагнуулан алхалж, чамин хийцтэй тамхиныхаа хайрцгаа товхийтэл нээж, тамхи гаргаж нөхдөө дайлах дуртай хүн аж”. Тэр говийн наранд дуниарсан сумын төвд жин үдээр ирсэн тул хүнгүй мэт нам гүмд ганцаардасхийн байтал “...хаанаас хэдийд ч хүрээд ирсэнийг бүү мэд, өндөр нуруутай, толгой нүцгэн залуу машины хажууд инээмсэглэх аятай марзайн зогсож...” байх нь 500 нүүр бүхий 30 орчим хэвлэлийн хуудас хоёр дэвтэр романы гол баатар мангар хэмээх Дамдин аж.

Том романы баатар маань уншигчтайгаа “...томдсон гэмээр бөмбөгөн ултай ажлын хар өмсөж, хөгшин хүний хийцтэй шар даалимбан дээлэн дээр, хүрэн даалимбан бүс бүслэн...” ирж танилцаж байна. Уншигч бид гол баатраа Тогоо жолоочийн нүдээр л харж буй хэрэг шүү дээ. “Жолооч түүний ноомой царай, зузаан уруул, хуруу илүү ургасан үстэй хоохгор толгой, хир даганд харласан хүзүү шилийг нь ажин дотроо -Маанаг золиг байхаа даа чи... гэж бодсон” төдийгүй машины хойгуур урдуур орж, ачаа руу нь нэг өнгийж, кабин руу нь ч нэг шагайж энэ тэрийг сонирхоход нь “хуруу гарын хумс урттай “компани” биш байгаадаа гэж сэжиглэн -Чи юугаа эрээд байсан юм бэ? Чиний юм ердөө байхгүй наана чинь... хэмээн загнаж байна. “-Та... гэж хүндэтгэн дуудсанд нь илт ичингүйрэн зовсон бололтой хэлэх үгээ олж цөхөн

толгойгоо ч нэг илж, шилээ ч нэг маажиж хачин этгээд загнадаг...” энэ эрээс “...аргалын утаа хир хөлс ханхалахад жолооч сэжиглэж хөндийрөсхийн...” байтал нярав худалдагч нар ирдэг. Тэд “Энэ их ачаагий чинь яаж буулгана аа” гэж халширсанаа хураалттай ноосны хажууд тамхилж суугаа залууг хармагцаа, -Аа! Чи энд байгаа юм уу. Энэ чинь нэг үг дээ. Харин чи ингэж байгаад галдаж орхив оо. Тэгвэл танайх бууриараа нүүж ирээд ч давахгүй өрөнд орно вий... гэж дээрэнгүй өгүүлэхэд нөгөө нь -Эднийхээс ер юугий нь авах вэ дээ! гэж доромж “давс үйж” байна.

Ингээд гол баатар маань ачаа буулгаж эхлэхэд “...нөгөө хоёрын хэн нь ч дэм тус үзүүлсэнгүй, тэр ч байтугай хар хөлсөө асгаруулан гүйж, аахилж, бүдэрч сандарч явахад нь тэр хоёр ядаж хайрцагны буланд гар хүрсэнгүйд...” жолооч зэвүү нь хүрнэ. Чухам эндээс гол баатар маань Тогоогийн нүдэнд зөв харагдаж эхлээд “...зайлуул хаа газар ийм нэг нэргүй зарц байх юм даа” гэсэн үнэлэлт авдаг бол төдхөнөө цэнхэр дээлт худалдагчаас дээгүүр сэтгэгдэл төрүүлсэнийг зохиолч хөөрхөн хошигнож өгүүлсэн байдаг. “... Жолооч нөгөө залуугийн хойноос харлаа. Тэрүүхэн зүүн хойно байгаа шохойдсон, шохойдоогүй хэдэн навтгар байшингийн урдуур орох янзтай алхалж яваа харагдав. Тэгээд -Хэн гэдэг юм бэ? гэхэд цэнхэр дээлт -Намайг уу? гэхэд -Үгүй үгүй түүнийг... гэж нөгөө залуугийн хойноос эрүүгээ өлийн заав. Цэнхэр дээлт өөрийгөө өндөрт өргөн дөвийлгөх ч гэсэн юм уу (жолооч өөрийнх нь алдар нэрийг асуугаагүйд хорсож атаархсан ч юм уу) мэдсээр байж. -Аа, мань мангар уу... гэснээ нярав руу хандан, -Должингийн мангарыг чинь хэн гэдэг билээ гэв. -Дамдин гэдэг юм гэж цаадах нь хариу өчлөө” гэж байдаг юм. Энэхүү жолооч Тогоо романд гол дүр биш боловч түүний нүдээр бид баатраа харж буйгаараа их ач холбогдол бүхий дүр мөн. Зохиолч баатраа шууд зураад, дүрслээд эхлэхийн оронд дам баатрын нүдээр дамжуулж үзүүлсэн нь зөв шийдэл болсон юм. Гол баатрыг маань өөрийнхөө нүдээр харж дургүйцэх, ад шоо үзэх, өрөвдөх, хайрлах сэтгэлийнхээ өнгөөр амьд мэт зурж өгсөн Тогоо жолооч романд цөөхөн гарна.

Зохиолч хэрэгтэй нь газар шигтэгсэн байдаг. Нэгд. Дамдин төөрч мунгинаад хотын цэцэрлэгт хэвтэж байхад залуу хос үнсэлцэж, бүсгүй нь цахилгаанд цохиулсан мэт цочин, -Согтуу хүн унтаж байгаа юм уу даа гэдэг. Тэгэхэд зохиолч “Чухам энэ үед -Таминь ээ Самбуу даргынхыг заагаад өгөөч гэж Дамдин хашгирсан бол хөтлөөд очих хүн нь Гэрэл “Хүүе сайн уу” гээд тамхилах хүн нь Тогоо байлаа” гэж уулга алдсан байдаг (I дэвтэр)

Хоёрт. Самбуугийнхан жимсэнд яваад Дамдин орох газар үгүй болж, барилгын манаачийнд хоноод Ням гаригийн өглөө Сэлбийн эрэг дээр очтол

Тогоотой таардаг. Мань эр дал мөр алгадаж “Танихгүй байна уу” хэмээн дуу алдан дотносоход Тогоо таньж ядан байвч, түлхүүр багаж дөхүүлж дугуйгаа нөхөхөд нь туслах зэргээр дороо ойртон танилцах үес түлхүүрийн хайрцган дотроос гэрэлийн хугарч нугарсан зургийг олж хайрлах, харамсах сэтгэл төрдөг. Тогоо харин, -Нөгөөдөх чинь... хэд бүжиглээдэхсэн чинь наалдаад ирсэн. Томоогүй юм даа. Хэ-хэ-хэ... гэж суух нь бий. Ийн хайр дурлалын зам огтлолцсон нь залуу улсыг хөндийрүүлсэнгүй харин ч ойртуулсан бололтой. (II дэвтэр)

Гуравт: Тэргүүн дэвтэрийн эхэнд “талын харгуй”-гаар довтолгон ирж мангар Дамдингийн гадаад төрхийг гайгүй сайн харуулж өгсөн Тогоо жолооч уг дэвтэрийн төгсгөлд “...Должин хөгшиний гэрт ирж бас нэг баярт явдал болжээ. Жижигхэн гэрт бензин тосны хярваслаг үнэр ханхлуулсан залуухан эр хоймор сууж цаасан иштэй тамхи савсуулан татаж суусан нь...” Тогоо байв. Тэрвээр нийслэл хотоос бичсэн түүний захидлаар дамжуулан Должин хөгшинд төдийгүй уншигч бидэнд Дамдины дотоод сэтгэлийг нээж өгөөд сууж байгаа нь тэр ээ! (I дэвтэр)

Дөрөвт: Дамдин радиогоор улс орон даяар ярьж бөөн баяр болоод хэндээ хэлдэг юм билээ гэж дэвэлзэж байхад Тогоо барилгын банз сэлт аччихсан, дэргэдээ уруулаа нэг их улаанаар буддаг бор хүүхэн” суулгачихсан давхин ирж “мандаж буйд нь баяр хүргэж”, басхүү “танай сум машинтай болсон байна билээ” гэж баярт сураг сонсогдог. Үе үехэн зам тэр хоёрыг хэрэгтэй газар нь уулзуулж байдаг бөлгөө

2. *Шалаа Намжил*

“Должингийн мангар”-ыг арван таван настай байхад нь “шинэ тутам сонсогдсон боловч шимтэй сайхан санагдах” үгийг хэлсэн хүн бол шалаа Намжил. Уг нь “хэзээ л бол хүүхэд загнаж зандрах тул Дамдин түүнийг муу хүн гэж боддог байжээ. Тэгээд ч түүний нүүр царай, нүдний харц дандаа л уур омгоор гэрэлтэж байдаг шиг санагддаг байжээ”. Гэтэл үгүй аж. “Дамдин элдэв наадмыг үүсвэрлэн даруй өөрчлөн... толгойгоороо зогсоно, хоёр гараараа явна, эсхүл годройтон үсрэнэ... Энэ бүгддээ ядраад ирэхийн алдад хураасан ноосон дээр харайн гарч салхи сөрөн зогсоод -Хүүе, хүүе Дамчаа гуай... гээд дуулж эхлэж, “хүүе хүүе” гэхээр хүмүүс өөрийгөө дуудав хэмээн эргэж харахад нь Дамдин “Дамчаа гуай” хэмээн дуулах аядан алиалж байснаа аргагүй ядарч ходоод хоржигноно. Гуанзанд очно доо. Дүүрэн хүн. Манай гэнэн баатар хэн нэг хүн хуушуураа баралгүй орхиж юу магад хэмээн горилхийлж байтал “...хөлс гоожуулсан нэг бүдүүн авгай, хоолондоо цадсан

янзтай тавгаа урдаасаа зайлуулан түлхэж...” Дамдин тэсч чадалгүй дөхөж очин авах гэтэл, -Хүүе ядаг хүүхэд вэ энэ чинь... хэмээн бөөн дуу шуугиан үүсгэсэн нь хөөрхий манай баатрын “...тархи руу аянга цахилгаан буух шиг болж...” гуанзанд байсан хүмүүс “...Хулгай хийж байна уу”, “Тэнэг өвчтэй юм, хоолы чинь булаах вий” гэлцдэг. Энэ хүнд байдлаас Дамдинг аварсан хүн бол шалаа Намжил. Тэрвээр -Хүүе, тэр жаал! Нааш ир! гэж дуудсан төдийгүй “-Хөөе, Жамаадоржоо. Ахиад хэдэн хуушуур өгөөч” хэмээн нэмж хуушуур авч Дамдинд өгдөг. “...Өвгөний өгсөн хуушуурыг Дамдин амтархан үмхэж, түүний өгөөмөр өглөгчийг гайхан баярлаж...” байхад шалаа Намжил: -Хүү минь бишгүй л том болж дээ. Одоо муу эхдээ тус болохыг бод! Ажил сур! Алийн болгон ингэж явах вэ дээ... Аа! гэж хэлсэн нь “шинэ” мөртлөө “шимтэй” сонсогддог. Шалаа Намжилын дүр бол Дашдооровын зохиолд олонтаа таарч байдаг говийн хөх өвгөдийн нэг агаад нэрмэлд дуртай, амархан халдаг, халамцахаараа баахан дэгсдүүхэн ярьчихдаг ч тэр нь гэм хоргүй тийм л өвгөн. Гэхдээ “мангар Дамдин” хийгээд түүний ээжид уул шиг түшиг дээ. Ер ч нутгийнхан тэгж үзэх агаад нэгдэл байгуулахдаа хүртэл шавар шохой, төмөр модны ажилд сайн, ажил төрөл хөөцөлдөхдөө шамдангуй гэж”... шалаа Намжилыг аж ахуйн эрхлэгчээр сонгодог. Яагаад шалаа хоч авсан билээ! “...Шалаа Намжил шатар тоглохын хэнээ шалж л байвал болох нь тэр гээд, шалсаар хожигдож байдаг ажээ. Эсвэл айрагтай айлд буувал, хүүхэд ч голохгүй хуруу гаргачих гэж гуйна. Олон хүн хожих гэж, шалах нь хэцүү. Тэгээд шалаа Намжил алдар авчээ” гэж зохиолч тодорхойлсон нь бий. Амьдрал нь хир зэрэг өвгөн бэ дээ. Зохиолч “...Намжил өвгөн гэртээ гурвуул, хөгшин тэнхлүүн. Хүү нь хорь гарсан, хоршоонд манаач хийнэ. Амьдрал тааруухан гэхдээ хоосон хонодоггүй хоёр иддэггүй айл билээ” гэжээ. Тэгээд Цогзол, Жамъян мэтийн чинээлэг эрс наймаа ярихдаа өвгөнийг үл тоох бөгөөд өвгөн ч хирээ мэдэж Цэвэлжид мэтэд сонин хачныг ярьж хэлнийхээ загатнааг гаргаж байдаг хөөрхөн хэсэг бий. “...Шалаа Намжил архинд баахан халан дуу чангаран үг олон болж, ярианы хэнхэг нь хөдөлж хэлээ загатнуулан байв. Гэтэл цаадуул наймаанд шимтэн түүнийг эс анзаарсан тул Цэвэлжидийг хань татан яриа дэлгэжээ. -Хөөе хээн, уржнан би Алтан-Овоод хонь туув даа. Тэгэхдээ хотоос хойш нэг нэгдэл үзсэн юм. Бяртзаануудын (Партизан) нэгдэл гэнэ билээ. Би бүр шохоорхоод нэг бяртзаантай уулзаад... Өө одон гэж энгэр дүүрэн! Маршал шиг л юм. Нэгдэлийнхээ тухай надад яриад... Түүнээс хойш би нэгдэл байгуулах гэж бодох болсон юм. Мань Данжуурыг танина биз дээ. Бид хоёр уулзахаараа нэгдэл л гэж ярих... Тэгээд яахав одоо байгууллаа. Цогзол маань ч орлоо. ...Аймгийн дарга элтээр хурал дээр мань хүнийг сайн

гэж... бас бяртзаан гэсэн шүү! гэж ярьдаг билээ. Гэхдээ мань өвгөн “давс үйсэн” нь мэдээж.

Нэгд: Алтан-Овоо (Дарьганга руу) хонь туусан хүн хот орсон нь юу л бол

Хоёрт: Дарьганга орсон хүн Бяртзаан (Партизан) нэгдэл орсон нь юу л бол

Гуравт: Данжуур мань эрийг тоож нэгдэл ярьсан нь ортой л байх. Гэхдээ хужир нь ихэдсэн байх... гэх мэт. Харин шалаа Намжил хүний хувьд сайн. “Шалаа Намжилынх жингийн артелийн өв хөрөнгө болох зуугаад бага мал хариуцан авч нөгөө Дамдингийн эх Должингийнхтой айлсан сумын ойролцоох зүүн цохион дунд буужээ” гэж буй нь уг дүрийн хүн чанарыг сүрхий тодруулж өгсөн юм. Тэр ч байтугай ганц хүү нь сураггүй алга болсон эхийн зовлонг нимгэлж “Чи нэгдэлд орчих” гэж ятгаж явдаг билээ. Ер нь зохиолд чимэг нэмсэн дүр. Өвгөний ярианд шохоорхон сонссон Цэвэлжид орой өвгөнөөсөө “Бяртзаан гэж юу вэ” гэж асуухад Цогзол бодож бодож, -“Аян жингийн тэн сайн өргөдөг аливаа юманд бяраа зааж явдаг хүнийг бяртзаан гэдэг гэж инээдмийн хэр нь сонин тайлбар өгөхөд нь чимээгүй чагнаж хэвтсэн Өлзиймаа тэсэлгүй инээд алдан хөнжилдөө элгээ хөштөл хөхөрчээ”

3. Цогзол

“-Дамдин хаачаав -Суман дээгүүр яваа байх -Юу хийж явдаг юм бол доо -Мэдэхгүй Цогзол минь. Өглөө гараад орой ирдэг юм. -Тэгж дэмий тэнэж явахын оронд хөдөө гарч гэдсээ цайлгаж явмаар юм...” гэж манай баатрын тухайд их л өөриймсөг өгүүлдэг хүн бол Цогзол. Түүний унасан морь нь: “... суман зээрд зүсмийн бие галбир тэгш нэгэн сайхан морь...” Түүний тохсон эмээл нь: “...Эмээлийн бүүрэг оготор намхан, уужим суудалтай, хуучивтархан шар ширэн гөлөмтэй, гэвч баавар даруулга бүрэн, хийц маяг нь гоёмсог, оломцог шинэ, ганзага бүрэн. Түүний өмссөн хувцас нь: “...Улаан одончуу дээл өмсчээ. Дээлийнх нь дал мөр хавиар өнгөө алдан ухаарч гандсаны дээр энгэр нударганы эмжээр тасам сэмэрч урагджээ. Ногоон арьстай хар булигаар гутал хөл дүрээд асар удаагүй бололтой. Түүний төрх нь: “...Шанаа өргөн, уруул зузаан тосорхог, чих том, чухамдаа буян жаргал оршсон хүний байр төрхтэй бөгөөд луу хүрхрэх мэт өтгөн бүдүүн дуу хүнгэнэж гарна. Нутаг хонхортоо нэр хүнд бүхий энэ эр чинээлэг нэгэн боловч дэлхийгээс баян хүнгүй хэмээн бозлого намнана. Ур хийц хэлбэр нь чадварлаг хээнцэр бол агар ч гэлгүй хусуур цацлын халбагыг үнэ хайрлалгүй авна. Гурван азарга адуутай. Зээрд голцуу тул “өсөх малын зүс нэг” гэж билэгшээнэ. Өөрөө урт

уурга баривч морь уургалахдаа маруухан. Тэгсэн атал өөрийнх нь адуу ороо дагшин болж буйд баясан “эсөх адуу ороолдог, барагдах мал жороолдог” гэж үзнэ. Ийм хүн “Должингийн Мангар”-ыг сургалжээ. Гэтэл Должин, Цогзол хоёрын сууж буй нь “уулын бүргэд, талын болжмор хоёр зэрэгцэн” суугаа адил аж. Энэ сүрлэг хүн гол баатрын маань амьдралын замд бага бус үүрэг гүйцэтгэдэг юм.

”Тэгээд Дамдин аймгаас ирсэний дөрөвдэх өдрийн өглөө Цогзолын тамга бүхий шижээргүй байрын шар хээр үрээ уначихсан Хашаатын хөх овооны хөтлөөр зүүн зүг оджээ” гэж бий. Энэ зам хөвүүнийг алс тийш хөтөлж буй нь энэ ээ.

Нутгийн Жамъян гэгч эртэй цуг хонь тууж хот орох, наадмын өмнө үнэ хүргэж борлуулах тухай ярьж байсаар Цогзол -Дамдинг аваад явъя гэж санаж байгаа. Эхэд нь ч хэлсэн юм, газар үзэж юм сурч яваг... гэхэд гол баатар маань жигтэйхэн баярлаж “...зүрх нь яг л одоо явах гэж байгаа юм шиг нэг их баяраар цалгиж цохилох...” үес Жамъян: -Үүнийг авч явах гэж үү дээ, нэмэр болох юм уу даа... гэхэд Дамдин голдоо ортол гомдож “ямар шинжгүй эр вэ” гэж дотроо хараасан төдийгүй -Аль вэ? Хэн! Гал аваад өгөөч... гэхэд “...Дамдин дуртай дургүй шавар зуухны үнс сийчиж хэргээр хорголын цог хямсаадан...” очиж тамхиа асаах гэхэд нь золтой л духы нь хайрчих шахсан агаад “...дараа нь бас л зориут хорголын цог бут үсэргэж өвөр дээр нь унагаж” өшөөгөө авдаг билээ. Жамъян ийн цааргалсан ч Цогзол хүүг аваад явдаг нь алсын харгуйд хөтөлсөн хэрэг төдийгүй “замдаа туушран гарах үес олон адуу дайралдсан”, мөнхүү “хоёр дахь өдөр нь сүрэг цагаан зээр зам хөндлөн гарч өвөрт орсон нь...” зохиолчийн хувьд тэрхүү бяцхан аянчдын харгуйг зөгнөсөн төдийгүй гол баатрынхаа хол одсон “харгуй дардан зам”-ыг ерөөсөн бизээ.

”Дамдин их гэдэстэй гүжир хээр морь унаж, оонын хүзүү хуйвтай урт бургасан шилбүүр барьж хонь туун...” хотыг зорих замд юу эс тохиолдох билээ. “...Аадар бороо эцэстээ дуутай ширүүн бороогоор солигдоход...” гялбаа цахилгаан байн байн тас бууж, хоньд үргэж хуйлран сандаргахад муу Дамдин орь ганцаар “...шилбүүрийнхээ хуйвыг тачигнуулан аманд нь хоргоож” байхдаа хамры нь уг шархиран, нүд дүүрэн нулимс мэлтэрч “... Ингээд үхчихвэл намайг хүн өрөвдөн ярих болов уу?” гэж боддог. “Тэгтэл майхнаас Цогзол “Чайг... Чайг... Чайг... хаая!” гэж хашигран гарч ирэхэд” “Дамдингийн сэтгэл амсхийж... харин инээмээр болж өгвөл дуулмаар” болдог. Гэтэл мань Цогзол Дамдингийн нөмөрсөн улаан одончуу цувнаас баахан сэжиглэж “...Ийм содон өнгө тэнгэрийн дуу цахилгаанд осолтой юм гэдэг” гэж бодно. -Чи жаахан цаашаа зогс! гэдэг төдийгүй “Аянгын хүрээ

гэж байдаг юм гэдэг. Гэрийн буурин чинээ байдаг юм гэнэ лээ” гэж санан “Хоорондын зайг барагцаалж, авснаа баараггүй нь дээр хэмээн санаж хажуу тийшээ нэг алхам арагшилж зогслоо” гэж байдаг нь үнэн бас уран шигтгээ шүү. Ямар ч сайн хүн гэлээ аюул тулахад амиа л бодно доо. Тэгсэн хир нь усан бороон дунд, тэнгэрийн дуунд хоньтой хөөцөлдөж яваа Дамдинг хараад -Аргагүй гүжир хүн дээ гэх үгэнд нь хайрласан аяс бий. Ер нь Цогзол дүнгэр хүн шүү!

Гангын даваа өгсөхөд хонины наймаачин хятадууд тосож ирэх үес Цогзолын нарийн ухаан зарж буй хийгээд гал нийлж гарсан Жамъян замын хүнс гээд хатсан боорцог төдий хар хүүдийтэй бүх замыг туулж байхад дотроо уурсавч, гаднаа үл гарган “баян хүний нүнжиг зааж” байгаа сэлт аргагүй л Цогзол мөн дөө” гэх бодол төрүүлнэ. Ер нь Цогзолын дүр бол 1950-иад оны эхэн үеийн чинээлэг хувийн аж ахуйтаны нийтлэг дүр болж чадсан юм. Бяцхан аянчдын багаас Дамдин оргон алга болсныг охиноосоо дуулаад, -Та нартай уулзсангүй юу? гэхэд -Үгүй чих! Одоо тэр олж ирэхээсээ өнгөрсөн! гээд “өөрийн эрхгүй тэчъяадин хийх юмаа олж цөхөхдөө хажуудаа байсан гудсан дээрх шороог нудрагаараа хам хумхан гүвж цомцойн суув” гэж бий. Сэтгэлийн тух алдах нь энэ. Тэгэхэд баг нэгт Жамъян: -Тэр мангар эргэж ирэхгүй ээ! гэх буюу -...Ээ дээ, ийм мангар хүн, хүнийг нэг л өдөр ална шүү... гэхэд Дамдин хөвүүний тухай нэг ч муу үг цухуйлгадаггүй нь хүн чанар юм даа. Тэр ч байтугай Жамъян -Цаадахын чинь хувцас хунар байна уу гэхэд Өлзиймаа “алга” гэвэл Жамъян -Хөөе та минь тэгвэл юм хумаа бүртгэж үзье! Магадгүй цаадах чинь юм хум аваад талийж өгсөн байж болзошгүй хүн шүү... гэхэд Цогзол “Тийм” гэж хэлээгүй л хүн.

Цогзол алдсан хэдэн атны эрэлд явж байгаад санаандгүй Галсандоной өвгөнийд буутал, тэднийд цугласан эрс мань эрийг цаашлуулж найрласан дүр эсгэж дуулалдаж, улмаар говийн найрын дэгээр зургаан хул айрагаар нийлэхэд ер тэвдэлгүй уучихдаг билээ. Ингээд найр яг дундаа орж байх үес сумаас дуудлага ирж Цогзол мордоход ард нь үлдэгсэд “шагнах гэж дуудаа вий” гэхэд нөгөө хэсэг нь “хонь зарлаа гэсэн шийтгүүлээ вий” гэх буюу “багийн сул тэргүүлэгч тул дуудаа байх” гэлцэн үлдэхэд Цогзол өөрөө гэртээ ирж дулаан хувцас хунар өмсөнгөө эхнэрт “...Дамдин л хөөгөө цацах шиг байна” гэж хэлдэг. Хүний хүүхэд дагуулж яваад алга болгочихсон гэх гэмшил түүний цээжинд сүүмэлзсээр байсан хэрэг ээ. “Цогзолынх дэлгэр зуны дунд сарын нохой өдөр гүүгээ барьж” нутгийн олноо дайлж цайлан бужигнаж байхад -Тэмээтэй хүн ирлээ! гэдэг -Должин авгай шив дээ. Тийм л байна л даа гэхэд Цэвэлжид (эхнэр нь) -Хүүе яадаг билээ, нээрээ тийм байна гэж сандархад

“Үрс өндөрлөж хөл сийрсэн хойно Цогзол, Дамдингийн сураггүй болсон тухай аль болохоор энгийн өгүүлэхийг хичээж, бас хөгшиний сэтгэлийг нэг их зовоохгүйсэн гэж байдаг л хүчээрээ учирлан” байдаг нуруутай эр юм. Манай гол баатар Дамдинг тодруулахад их тулгуур болсон дүр юм даа.

Монгол эрийн зангаар билэг боддог нэгэн. “Нүүх нутаг дээр идээ цагаа энэ тэрийг асгах цээртэй зүйлийн нэг. Харин буух нутаг дээр айраг цагаа асгавал өлзийтэй зүйлийн нэг гэж бэлгэшээдэг” гэтэл нэгдэлд орохоор нүүсэн өдөр тэмээний ачаа харгалдаж, айрагийн хөхүүр шахан айраг асгархад Цогзолын сэтгэл аягүй болдог. Эл ёрын бодол мартагдах аядаж байтал. Галсандоной өвгөн “...танай имтэй нүдэнд торохоор хэдэн ирэг туучихлаа гэнэ хөө...” гэж хов зөөдөг. Энэ нь хамар Жамба, сэтэрхий Бямба хоёр өөрийн туранхай хониор Жамъянгийн хариуцаж асан нэгдлийн сүргээс тарган ирэгийг сольж аваад хот руу явчихсаныг хэлсэн хэрэг. Мань Цогзол тэр дороо Жамъянгийн дүү бууж, дараа нь хонийг нь шүүрдэж үзээд өөрийн тарган хоньдыг зүсээр нь үгүүлдэг. Буцаж явах замд нь нэгдлийн наадмаар хүнсэнд хэрэглэх мал тууж явахад “ховдог” хочтой сэрх нь ч байдаг. Ийн нэгдэлд сүжиг алдарч “...Нэгдэл рүү нүүдэг өдөр айраг асгарсан юм аа” хэмээн харамсаж нэгдлээс гарахаар шийднэ. Энэ бол Цогзолын дүрийн тэсрэлт юм. Малаа хайрлах ясны малчин хүнээс л гарах ааш аяг юм. Нэгдлээс гарч яваа мөртлөө нэгдлийнхний хураасан гурван нуруу өвсөн дээр хүний үхэр найрлаж буйг хараад уухайлан очиж хөөж байгаа нь ч аргагүй л Цогзол. Тэгээд ч романы тэргүүн дэвтэрт Цогзолын дүр “...Нэгдлээ уул гэж нэрлэсэн маань тийм ч учир утгагүй юм биш. Уулын нөмөр түшиг гэж их бий. Тэгвэл, нэгдэл ялгаагүй л нэгэн их уулын чинээ түшигтэй, уулын дайтай бат зүйл болно” гэсэн өөрий нь яриагаар өндөрлөдөг. Өөрөө ч нөмөр ихтэй уул шиг дүр.

Романы хоёрдугаар дэвтэрийн төгсгөлд “...Хөтөч хүний унасан хар атны цагаан магнай, овооны үс нь нэг их танил юм шиг харагдав. Тэр тэмээ ч машин жолоодож яваа Дамдинг танимгайрах мэт чихээ дэлдэгнүүлэн харж байв. Ахиулан ажвал...” Цогзол байдаг. Тэр Дамдины хоёр хацрыг үнсээд -Ваа тархи... гэснээ эргэж хамт явагсад руугаа харж, “...эрүүгээ өргөн бахтайгаар -Энээ та минь, энийг хараач... гэж хашгирав” гэж бий. Энэ дуунд хөвүүнээр бахархсан сэтгэлийн аяс тод дуулддаг агаад өврөө уудлан том түрийвчээ гаргаж, -Дураараа тархи даа. Оргоод алга болдог... гэж өгүүлэн хорин тавтын бор дэвсгэрт гаргаж -Хотод байгаа хүн... өөрөө л боов чихэр авч ид дээ... Гуанз мундах биш гээд сарвайв” гэж өгүүлжээ. Өнчин хүүг өөрийнх шиг санан харж хандаж явсан сайхан сэтгэлт Цогзолын дүр энэ романы гэрэлт нэгэн шигтгээ юмаа. Ер нь Цогзолын эх дүр бол тухайн үед амьдарч асан

Чагцал гэдэг хүнээс үүдэлтэй гэлцдэг юм. “...Зохиолын нэг гол дүр Цогзол бол монгол ард хүний хамаг дөмөг шинжийг шингээсэн дүр юм. Хэдийгээр баян чинээлэг ч гэсэн Цогзол нэгдэлд орохоор эргэж буцалтгүй сэнхэрч шийдэж байгааг зохиолч их аятайхан өгүүлжээ. Иймээс ч түүний дүр романы хамгийн үнэмшилтэй дүр болсон юм. Цогзол бол монголын ард түмний олон үеийн турш хуримтлуулсан үнэт чанарыг агуулсан дүр билээ. Хамгийн гол нь тэр ёс суртахууны туршлагаа ирээдүйн үеүддээ залгаж уламжлахыг эрмэлзэж байна. Ажил хөдөлмөргүй хүнийг говьд сэтгэхийн аргагүй юм. Цогзолын мах цусанд шингэсэн хөдөлмөрч чанар нь ялж байгааг бид харж байна” гэж Висс.Бильдушкинов энэ дүрийг онцлон тэмдэглэсэн нь бий.

4. Данжуур

Данжуур бол насны хувьд Цогзолтой ойролцоо ч арай л өөр дүр. Данжуур нь баг суманд жингийн нэгдлийн дарга гэх мэт хариуцлагатай алба хашиж явсан нутаг усандаа нэр хүндтэй өнөөгийн бидний ярьдгаар “нийгмийн идэвх” сайтай хүн юм. Тэр жингийн артель санаачилж, нэгдэл үүсгэж Цогзолыг ятгаж, уламаар анхны хурлаар нэгдлийн даргаар сонгогдон -Ер нь ганц Данжуур энэ нэгдлийг хөгжүүлэх бус, та бидний хамтарсан хүчин чадал хөгжүүлэх юмаа гэж! Тийм учраас та нөхдийг миний ажилд болбоос их туслана гэж итгэж байна... гэж үг хэлэн ажилдаа орж байна. Зохиолч “... Данжуур дарга хэзээний албархуу зантайг хэлэх үү, хуучин булигаар ширэн цүнх зүүж, түүндээ нэгдэлийн гишүүдийн бүртгэл, данс нэгдлийн дотоод дүрэм, жингийн артелийн хөрөнгө хорь гучаад тэмээ, агт, таван зуугаад бага малын бүртгэл сэлт баахан цаас харандаа хийж зав муутайхан морин дэл дээгүүр шогших болов оо” гэж тодорхойлжээ. Мань эрийг хоршооны даргаар ажиллаж байхад нь бичиг хэргийг шинэ үсгээр хөтлөх болж гурилын баримт дээр элс цохож Данжуур нэрээ “Доншуур” гэж гаргагдахаар татлачихсан явдал бий. Ер нь улсад их бага албан ажил хийгээд дэвшиж, буурч явсан нэгэн аж. Харин ямар ч ажил хийсэн нойр хоолоо мартан зүтгэнэ. Нэгдэл байгуулаад зоог шагшуурын дэрс хадах, Баянгийн ард шаваг хадах гээд завгүй шогшиж, зарим үед найр хэсээд явчихсан хадланчидаа цуглуулж ирэх гэж яваад “чихээ мушгиулж айргаар шахуулах” явдал ч гарна.

Гэвч Данжуур амьдралыг өөдрөгөөр харж “Энэ бол хамтын хүчний давуу тал” гэж баяртай хүүрнэж явдаг агаад романы тэргүүн дэвтэрийн “Шинэ айл” хэмээх хоёр дугаар ангид буюу манай гол баатарын хот оргоод явчихсанаас хойш гарч ирсэн Данжуур гуайн зам, романы бүр төгсгөлд Дамдины замтай огтолцох бөлгөө. Данжуур мал нийгэмчлэх гэж баадантай бичиг бүслэн

довтолгож, мөнхүү Цогзол нэгдлээс гарах гэж таваргахад хойноос нь чавхдан аргадаж явсан зүтгэл мань эрийг МАХН-ын их хуралд төлөөлөгчөөр оролцох итгэл найдвараар шагнасан юм санж. Энэ үед мань эр их хурлын төлөөлөгч олонд баяр хүргэж буй залуус дунд Дамдин явж байхыг хараад “Яамай даа” гэж баярласан төдийгүй -Энэ гайхалтай чинь уулзах учрах ёстой юм сан. Гэвч “...Ядахнаа санаанд нь Дамдингийн нэр орж ирсэнгүй. Ганцхан “Должингийн мангар” гэдэг л нэр орж ирээд, “Ваа халаг гэж! Хэн билээ дээ” гэсээр хоцордог юм. Гэвч эрж сурсаар яваад олж ирдэг ээ! Гол баатар маань хоёр нөхрийн хамт амьдардаг “26” тоот хаалганы дугаарыг ажин зогсосхийтэл чацархаг нэгэн залуу год үсрэн гарч, Данжуур түүнтэй золтой л мөргөлдсөнгүй “... Ямар юмаа зүүсэн хүүхэд вэ? Хоёр пүүгийн ширмэн годил барьсан юм уу даа” гэж бодон хаалга татгал, өөрөө чухам “хоёр пүүгийн ширмэн годил”-доо дэлсүүлэх нь тэр. Данжуур -Хүүе! Та минь... нам төр минь... хэмээн дуу алдаж учрыг олж ядан харвал Дамдин урд нь хурган хуц шиг дагдагнан хөхөрч байлаа. Дамжуур мэндийн оронд -Яаж байгаа хар шидэл вэ? гэж хараал тавин уурссан...” төдийгүй мөнөөх тэртээ говиос нандигнан тээж ирсэн зүйлээ “... Ав наадахаа! Чиний юм. Эх чинь явуулсан юм” гэж хатуурхдаг билээ. Гэвч төдхөнөө уур хилэн нь намдаж “...-Дүрсгүй золигнууд... Үнхэлцэг хагалчих дөхсөн шүү гээд дарсаа аягалж барихад. Мань гуравт дуслын төдий шахуу аягалан амсуулж, бүгдийг нь өөрөө уух зуур, аанай л их хурлынхаа тухай нэг дурсаж, томоотой байхыг нэг сануулж, хол газрын хүмүүс хоорондоо эвтэй үерхэх сайхан хэмээн сургаж нилээд халжээ”. Энэ сайхан сэтгэлт насжуу эр “...Хэд хоногийн дараа Дэлгэрхангай сумын төвөөр ...Дамдинтай уулзсанаа нутгийн хэдэн хүнд сонирхуулан ярьсан нь жимсний архий нь “коньяк” өгсөн хэмээн, ядмагхаан хөгжимдсөний нь “хүн уярч уйлтал хөгжимдсөн” гэнэ хэмээн яльгүй давстай яриа” тараасан байлаа. Эл сургийг сонсоод элгээ бэтгэртэл санасан ижий нь яаж баярлаа бол оо гэж уншигч бид урдаас нь баярламаар шүү! Данжуурын эх дүр нь зохиолчийн нутагт амьдарч, бүтээж явсан луу Ганжуур гэдэг хүний дүр гэлцдэг агаад зохиолчоос лавлахад “... гэхдээ нэмсэн, хачирласан зүйл бас бий” гэж билээ.

5. *Базаржав*

Романд дүрслэгддэг 50-иад оны дунд үес монголын хөдөө нутгийн жалга бүхэнд байсан залуу хүний дүр дээ. Зохиолч энэ хүний тухайд “...Уг нь Базаржав хэтэрхий гэнэндээ алдаж яваагаас биш хэдэр зөрүүддээ биш. Хүлгийн дөрөөнд хөл жийж эхэлсэн тэр үед хөдөө нутгийн зарим залуу эрдэм сурлага гэж шимтэхийн оронд ээж, аавын буян мал сүргээ адуулан, эрэгтэй

нь бол урт уурга, хурдан морь гэж эмэгтэй нь бол торгон дээл, тохитой ханьтай болохыг чухалд үздэг байлаа. Олонхи эцэг эх ч тэгж үр хүүхдээ уруу татдаг байлаа. Тэгж яваа хүн нэгэн үе чухам жаргалаа эдэлж яваа юм шиг байлаа” гэж өгүүлдэг. Мань хүнийг арван зургаатайдаа барилгын чулуу бэлдэж байхад сумын захиргааны дарга Давгахорлоо гэгч хөлчүү давхин ирж буруу шаардлага тавиад баахан адарсан тул “зоогийн чулуу зоон дээр чинь үүрүүлэх хуна...” гэж занаж, хэлсэндээ ч хүрч хоёр сар албан журмын ажил хийлгэсэн юмсанж. Үүнээс хойш Базаржав “...нөгөө даргад уурласан уур омгоо дээл хөөргөж өмсөх, дэлий нь зассан морь унаад айлын найр хэссэн хэгжүүрхлээр тайлах болжээ...” Энэ ертөнц дээр түүнийг гэх ганц хүн бол ээж нь. Бүрхэд авгай “...Хуруу зузаан ултай монгол гутал эсгий оймстой өмсөөд зуны халуун өдөр... ботготой ингээ тууж ирээд... ахиад хонио хураахаар явдаг...” гэж зохиолч уулга алдсан агаад хөөрхий эх бачимдах үедээ “...Үр байвч зарах заяагүй зөнөг толгой” гэж өөрийгөө хараавч үрдээ хир үл халдаана. Романд Базаржав гол баатартай яггүй эрт, “Мангар Дамдин” хэмээх бүлэгт зам огтолж ирэх агаад “...Дамдин хийх юмаа олж цөхөн, дэмий л дээш тэнгэр ширтэн тэрийн хэвтэж, үүлний дүрс агшин зуур хувирахыг ажиглан цагийг нөхцөөж байв. Тэгтэл толгой гудайн үүрэглэж байсан морь нь чихээ хайчлан соохогхийж...” тэр зүгт харвал “нэг морьтой хүн давхиулан ирж яваа” нь Базаржав байдаг. “...Базаржав өвдөг дээгүүрээ татсан оодон дээл өмсөж, өргөн гэгчийн шар дурдан бүс хар цавиараа шахам сулбархан бүсэлжээ. Оодон дээлийн ханцуй урт, бас нудрагатай, түүний хувцалсан нь учир мэдэх хүнд бол нүдэнд хүйтэн харагдмаар, гэвч өөртөө тааруулж эзэндээ тохируулж яваа нь тэр ажээ” гээд зохиолч “...хавийн нутгаар ад үзэж, аавын цээж гэж хоч зүүсэн...” гэж тодорхойлсон аж. Хувцас ийм этгээд төдийгүй санаж, бодож явдаг нь Дамдингаас басхүү хахь өөр аж. Түүний ярих нь:

Б:-Цогзолын охин сургуулиасаа ирсэн үү?

Д:-Тэгсэн. Б:-Мөн хөөрхөн болж гэх шиг билээ. /Дамдин толгой дохих төдийд/... Чи оролдов уу хөө.

Д:-Үгүй...(шивнэв гэж бий)

Б:-Дүүрсэн цус! Гал биш, ус биш яадаг юм бэ?

Д:-Болохгүй ээ! Яаж болох вэ? (Нээрэн л айлын тогоо онгойж, цагаа горьдож байгаа хүн яаж болох вэ?)

Б:-Дүүрсэн цус, юунаас нь айдаг юм. Ингэхэд чи бүсгүй хүнтэй хавьтсан уу? (Дамдин хулчигнан дуугүй газар шагайв)

Б:-Наад насаа хог дээр хая! Энэ хэдхэн үгээс чухам нас нь дүрэлзэж, цус

нь буцалсан залуу эрийн дүр төрх ургаж гарна. Чингээд өөрийн эргүүлсэн, элдэвлэсэн бүсгүйчүүдийн тухай ярьдаг бөгөөд “...Дамдин хүү! (Энэ үгэнд их ёвироо нуугдаж байна) Тэгэхээр чи над нэг тус бол. Би Өлзиймааг эргүүлбэ...” гэж тулгаж “Надаас чамд” нөгөө тал дээр “Маш нууц” гэж бичсэн сүржин захидлаа муу Дамдингаар дамжуулдаг ч түүнийг нь Өлзиймаа: -Нэг муу бэлхийж халхайсан юм уу! Хм! гээд галд шидэж орхидог билээ. Манай гол баатартай ингэж уулзах бөгөөд сүүлд “...Базаржав яг хэлсэнээрээ мөнөөхөн захидлын хариуг авахаар гурав хоногийн дараа ирсэн аж. Тэгэхэд бүх үнэнийг өчжээ. Базаржав яриаг дув дуугүй сонсож байснаа ихээр санаа алдаж, -За яахав. Хайрласан болохоос хар санаагүй юм сан даа гэж гунигтайхан өгүүлээд салж явжээ” гэж дурсамж төдий өгүүлээд өнгөрдөг бөгөөд харин романы дэд дэвтэрийн 11-р бүлэгт зүүдэнд нэг ирнэ дээ. “...Дамдин энэ хот айлаас мордсон сайн таних авч нэр өгч чадахгүй мөртөө зэрэгцэн давхихыг харж, алаг морьтой яваа хүний ар бүсэнд нь гялалзах, тамхины мөнгөн цохилуур сэлтийг харж, цайвар саарал дээл цагаан шар бүсий нь хүртэл ажив. Хэн иймэрхүү явдагсан билээ гэж Дамдин бодсоор, морий нь хазаар булаан нэг тонгосхийн хөшилдөхөд нь булигаар монгол гутал дээр сарьс шигтгэн ширж урласан угалз бүхий оймсны нь харааг сая таньж...” -Базаржав... хэмээн хашгирах гэсэн боловч хоолой гарсангүй. Ийн хоёр залуугийн зам холдож оддог авай. Манай гол баатартай харгуй зам төдий олон хавьтаагүй ч романы тэргүүн дэвтэрийн “Шинэ айл” бүлэгт Базаржавын өрөвдөм, уярам, хайрлам олон үйл явдал гардаг агаад “...ишигний шийр шиг гаанс” зууж явдаг энэ эр Өлзиймаагийн төдийгүй уншигчийн хайрыг татаж чадсан дүр болсон юм.

6. Өлзиймаа

“Должингийн мангар” хэмээх гол баатрын маань сэтгэлийн гэрэл болсон гурван залуу бүсгүй романд дүрслэгддэг. Анхдагч нь Цэвэлмаа зохиолч: “... Дамдин сумын хүн эмнэлэг дээгүүр очиж тэнд өдрийг өнгөрөөх дуртай. Тэнд л байвал Дамдингийн сэтгэл өег сайхан байдаг ажээ” гэж өгүүлнэ. Мань эр сувилагч бүсгүй нарыг инээлгэж хөхрүүлж, алчууры нь булаан зугтааж байвал болдог аж. “тэр дундаас Цэвэлмаатай энэ тэр үг сольж байвал”, мөнхүү “...илгэн түрийвчээ Цэвэлмаад гарган үзүүлж бичигтэй, бичиггүй цаас, хуруун чинээ будгийн харандаанууд, калибрын хэдэн сум, киноны билетын тасархай, захидлын марк зэргээ аминчирхан сонирхуулж...” байвал басхүү “Цэвэлмааг ямар нэгэн ажил хийлгэж байвал өөртөө хайртай дуртайн тэмдэг” гэж ойлгосоор иржээ. Зохиолч өөрөө “...Хөөрхий Дамдингийн зүрхэнд хайр дурлалын гал өрвөлзөн эхэлсэн нь тэр буюу...” гэж сүүрс

алдсан нь бий. Энэ сайхан сэтгэлт бүсгүй нь 1954 оны 5-р сарын 14-нд аймгийн клубт тоглосон сумын уран сайханчдын концертонд дуулж уламаар шалгаран “...морин толгойтой нэг дарга” авч үлддэг билээ. Зохиолчийн яриа дурсамж зэргээс тааварлан бодоход ойр дөт өссөн чацуут нэгэн МУГЖ Цэвэлсүрэн энэ хүний эх дүр байж магадгүй гэж таамгалдаг юм. Энэ тухай Х.Зандраабайдий “Заяа дутсан бурхад”-даа цухас дурдсан нь бий. Хөөрхий Дамдин “...Цэвэлмаагийн толгойд ойртон үсийг нь үнэртэхэд нэг л сайхан...” гэж дурсан, “...алчуурыг нь булаан зугтахад уурладаггүй инээж байдаг”-ийг бодон “Цэвэлмааг харамнан бухимдаж” нутагтаа ирдэг аж. Үүний дараахан Цогзолын ирж, тэдний охин хуучин танил Өлзиймаатай учирдаг ч Базаржавын захиаг зөөж дэрэн доогуур нь шургуулсаныг бүсгүй олж, -Чи бичсэн үү? Энэ чиний юм уу... гэж “шаралхуу янзтай хирнээ эгдүүцсэн өнгөөр” асуудаг хэдий ч эл “гэгээн сэжиг”-ийн цаана “Дамдин захиа өгч мэднэ” гэсэн сэтгэлийн горь байсныг илтгэж байгаа юм. Даанч манай хүн өөрийгөө цаг ямагт дор үзэж, дорой амьтан гэж тооцсоор ирсэн ядмаг хүмүүжил нь Өлзиймаа, Дамдин хоёрын дунд хэрэм болсон аж. Романд өгүүлж буй 50-иад оны үеийн хөдөөгийн залуу бүсгүйн нийтлэг төрхийг биедээ агуулсан Өлзиймаагийн дүр “Шинэ айл” бүлэгт сүрхий тод дүрслэгдсэн юм. Зохиолч: “...Үнэндээ гэхэд Дамдин, Өлзиймаа хоёр багын түншүүд” гээд арваад жилийн өмнө Цогзолын хурга ишигийг хариулж бор гэдсээ тэжээж байхад “Өлзиймаа зургаан настай зээрийн янзага шиг зэрэвгэнэсэн охин байж” Дамдин мориндоо дүүрэхийг шаардах, эсвэл үүрч тоглохыг гуйх агаад “... Хэрэв төвөгшөөвөл, -Чи том болоод надтай сууна гэснээ мартаа юу. Одоо л үүрэхгүй бол хожим чамтай суухгүй шүү гэж айлгана”. Ийн өссөн хоёр хот орох хол замд дөрөө нийлж явахдаа: “...Ө:-Дамдин! Чи цай уухгүй юу? Хүйтэн юм залгил даа. Дамдин:-За хө, аяар болох уу даа...” гэр мэт өөриймсөг хэдий ч ойр зуурын ярианаас үл хэтэрнэ. Харин зам хамтрагч Жамьян насаа мэдэхгүй элдэвээр аашилхад Өлзиймаа: -Дамдин! Босоорой! Цайныхаа халуунд уу! гэж дуудаж сэрээх мэтээр гол баатраас тусламж эрдэг хэдий ч мань эр өөрийгөө дор үнэлдэгээс болж үерхлээс хэтэрсэнгүй гэхдээ л хотод шингэсэн Дамдин анхны захидлуудынхаа нэгийг ээждээ, нөгөөг Өлзиймаад хаягласаныг бодоход дотнын хүн мөн бөгөөд мөнөөх цэцэн мэргэн захидал нь “...Өчүүхэн муу Дамдингаас бат итгэлт, баатар зоригт, бадрангуй хувьсгалч үеийн нөхөр, үлэмжийн дотно Өлзиймаа болоод...” гэж эхэлдэг юм. Харин Өлзиймаагийн нүдээр гэхэд тодорсон дүр бол Базаржав даа. Дургүйлхсэн нь: “Шинэ айл” ангийн эхэнд Цогзолынх гүүгээ барих сургаар Базаржав давхин ирж “Хөрш нутгийн эрэлчний захиж орхисон гурван морь худлаа сураглан”

ирж, “тогоотой аарц шүүхэд нь уутны ам барьж”, “чагтны арьс томоход” ч туслан хонь холболцон өдөр өнжинө. Тэгээд “морио чөдөрлөн тавьж” хоноод “шөнө нь хэд дахин Өлзиймаагийн хучлага хөнжлийг самардан, бугуйныхаа арьс, гарынхаа арыг шалбартал чимхүүлж, долоовор хуруугаа булгартал мушгиулжээ” гэж бий. Гэвч бүсгүйн энэ дургүйлхэл мөнөөх захиа шатаасан зэвүүцлийг бодвол арай зөөлөн ээвэргүү агаад өглөө нь Базаржав “-Сайхан мэдээрэй” гэхэд бүсгүй аальгүйтэн, -Мэдээд ч яах юм билээ дээ гээд инээжээ” гэж өгүүлсэн билээ. Ажигласан нь: Ийн зэвүүцэл аажмаар намжин сэмхэнээ, ажиглалтад шилжсэн харьцаа Базаржав зэлний гадас түгжин зэл татаж, гэрт нь хөхүүрийн цах түгжин мөнхүү тумай байдсан гүү, мах боосон унагыг бяраан уургалах сэлтэд илэрлээ олж уран дүрслэгдсэн юм. Тэгээд “...Базаржав, Дамдингаар өгсөн захидлыг сураглаж, чамайг хотоос ирэхийг хүлээж цөхөж байсан гэж худлаа өгүүлэв. Өлзиймаа тэрүүнд үнэмшиж, -Тэгсэн үү? гэж дуу алдан жоготой инээмсэглэжээ” гэж байдаг. Эр хүний 13 мэх гэж энэ дээ. Тал өгсөн нь: Адууны билчээрт залуу хос ийн ярилцана.

Б:-Би чамайг жаахан дөхүүлж өгөх үү?

Ө:-Яах юм бэ?

Б:-Зүгээр, хамт жаахан явъя л даа, сайхан юм.

Ө:-Юу нь сайхан байдаг юм бэ?

Б:-Чамтай л хамт байхад!

Ө:-Худлаа! Яршиг дээ.

: -Яршиг ч биш ээ, нээрэн шүү! /Тэр хоёр адуугаа орхин зүүн тийшээ эргэв/

Б:-За би буцъя даа. /гэж гунигтайхан өгүүлнэ/

Ө:-Манайхаар ч хүн багтаж ороод л байдаг юм даа.

Б:-Тэр ч тэгэлгүй дээ. Би хүн ордоггүй айл гээгүй шүү дээ. Харин ааваас чинь айгаад байна... За би буцъя даа. Эл ярианд өнөө “насаа хог дээр хая” гээд даналзаж явсан Базаржав их л тогтуун болж, “бэлхийж халхайсан юм” гээд захидлыг нь шатааж байсан Өлзиймаа их дөлгөөн болж их хайрын ид шидийг үнэн дүрсэлсний уран ач холбогдол илэрч байна. Энэ мэт дургүйлхсэн, ажигласан, тал өгсөн, өрөвдсөн сэтгэлийн олон өнгө аяс дээр хос залуугийн хайр дурлалын хөгжмийг эгшиглүүлсэн нь уншигчийн сэтгэлд хүрсэн байна. Нэгдүгээр дэвтэрийг төгсгөлд дүр дүрийн яриа гарахад Өлзиймаагийн монологийн оронд “...Хажуу газар ургадаг нь Хайлаас модны жам юмаа Хадмын гэрт очно гэдэг нь Бүсгүй хүний заяа юм аа” гэж дууны бадаг байх нь дүрийн хувь заяаг бүтэн шийдсэн хэрэг ээ!

7. Жамъян

“Товийн өндөр” роман монголын уран зохиолд мэндэлж байх тэр үед дүрийг зөвхөн хар, цагаан өнгөөр л зурдаг байв. Сайн талын баатар огт алдахгүй. Муу талын дүр бол огт цагаан үйлс бүтээдэггүй байв. Харин С.Дашдооровын роман ямар нэг хэмжээгээр энэ дутагдлаас зайласхийж чадсан бөгөөд үүний нэг нотолгоо бол Жамъянгийн дүр юм. Энэ бол сайн хүн биш. Магадгүй бидний дунд байдаг олонхийн нэг. Романы тэргүүн бүлэгт гол баатрын дургүйг хүргэн хүргэн гарч ирдэг билээ. Гэвч хот орох хол замд гараад л Дамдин “бараг эвлэрсэн гэж болно” гэж зохиолч өгүүлжээ. I. Жамъян Цогзолтой дөрөө харшуулан замын айлаар бууж мордон нэрмэл эргүүлнэ. Халамцуухан ирэхдээ айлын тавган дээрээс ааруул өвөртлөн ирж -Цангаж байна уу? Цангахад исгэлэн юм сайн байдаг юм... гэж бузгайрхан Өлзиймаад өгнө.

II. Аян замд аадар ширүүн бороо дайрхад Жамъян майхнаас толгойгоо үл цухуйлгана. Тэнгэр дуугарахад хашиграхаас өөр идийг үл үзүүлнэ. Тэгсэн атал “чоно борооноор” гэгчээр “...Тэнгэр дуугарах бүр бал тусан унах мэт чихээ даран навтасхийн чичрэх...” Өлзиймааг эелдэгхэнээр тэврэн авч, “... хатуу гэгчийн шалзан хөх”-ийг нь тэмтэрч суудаг тэнгэргүй эр.

III. Жамъян замын хүнс хийнэ гэж төлөг шүдлэн хоёр тууж гарчээ. Эхний өдөр Жамъян, -За хөө, би шүдлэнгийнхээ амыг барих уу? гэхэд Цогзол, -Зэрэг, зэрэг олон юм нядлаад яахав, сүүлд бол...” гэжээ. Үүнээс хойш Жамъян даанч ажиггүй царай гаргаж, хүнсгүйдсэн Цогзол арга буюу нэг хонь төхөөрөхөд “-Өө харла гэж дээ, миний төлөгийг унагахгүй яагаав... гэж ниргэсэн хойно хашгирдаг” ер нь л хунчир эр. “Бас үдлэх юм уу, цайлах бүр Жамъян: -Аль вэ наадахаасаа идэж үз! Аягандаа хийж дэвтээгээд ид. Цайндаа хий! гээд хатаж орхисон хөх ааруултай хүүдий нөхдийнхөө өмнө тавина. Тэд, Жамъянгийн хүнс нүнжиггүй тул үл авна. Жамъян өөрөө ч идэх нь бага. Харин Цогзолын шуумааз руу суугаагаараа дөхөн ухаж, нүнжигтэй сайхан шар тосонд чанасан боорцог, амталж хольсон цагаан тос, тарган махнаас нь цохиж алдана. Үүний учир Жамъянгийн аяганы хийц хорсон ч үгүй, нэмэгдсэн ч үгүй билээ” гэжээ.

IV. Энэ мэт Цогзолын нөмөр нөөлөгт явж хот хүрээ орж хонь мал борлуулсан нь олон атал нэгдэл байгуулах хурал дээр шүүмжилж сүйд хийх дөхдөг хуншгүй нэгэн. Нэгдэлд орохоос өмнөхөн хамар Жамба шалж байгаад Цогголоос хэдэн сайхан морийг нь хямдхаан авчихсан юм санж. Жамъян үүнийг үнэрлэж мэдээд, нэгдэлд нэр олох гэж үг хэлдэг. Ж:-Бид нэгдэл байгууллаа. Сайхан хэрэг! Гэтэл манай зарим маань мал нийгэмчлэх сургаар сайн сайн морь, малаа хүнд зарж эд бараа болгож байна. Энэ бол

нэгдэлээс малаа буруулж байгаа хэрэг! Өөрөөр хэлбэл хувиа хичээж байна. Д:-(Данжуур):-Жишээ баримтаар яриарай! (Зохиолчийн тайлбар:-“Тэгэхэд Жамъян, Цогзол руу хулгай нүдээр харахад Цогзол дув дуугүй газар ширтэн суулаа)

Ж:(зориг орж) –Жишээлбэл Цогзол байна. Цогзол, хамар Жамбад гурван сайн морио зарсан... Харин нөхрийг “худалдсан”-ны буянд өөрөө сүрхий дэвшиж “бригадын дарга” болдог. Сонин дүр шүү. Хөөрхий... Цогзол Жамъян руу муухай харж, хүмүүс рүү хулганан инээмсэглэхийв. Гэвч тэр нь инээмсэглэлт биш арчаагүй ярвайлт болжээ.

Ү.Гэтэл өөрөө бас хийхгүйг хийдэг эр ээ! Сэтэрхий Бямба, хамар Жамба хоёрын ятгалгад автаж Цогзолынхоос нийгэмчилсэн /нэгдэлд өгсөн/ тарган иргийг хэдэн туранхай хониор сольж орхисон явдал бий. үүнийг Галсандоной өвгөнөөс сонссон Цогзол “...-Чи хамар Жамбатай хонины наймаа хийгээ юү? гэхэд...” авгай нь эр нөхрөө өрөвдөж харин Жамъян зохиолчийн дүрсэлснээр “...хоёр шанааны нь судас луг луг лугшиж, гарын нь алга ус болтлоо хөлөрч...” суудаг. Сонин эр шүү! Гэхдээ зохиолч романы гол баатрын тоонд оруулж тэргүүн дэвтэрийн төгсгөлд “Жамъянгийн яриа”-г оруулсан агаад үүнд: “... За хө саяны нэг хурал чинь ч буруу тийш нь хэлтийлгэх дөхлөө шүү. Тэр Цогзолын шүүмжилж байгааг!.. Би сээ Амбаа, хамар Жамба хоёртой хонины солио хийгээд сэтгэлээр ч унаж явсан маань үнээн!” хэмээн гайгүй сэхээрэх аятай болж иртэл, мань эрд сиймхий гарч нэгдэл гуанз гаргах болж, бас бага сургуулийн дотуур байранд нэгдэлийн гишүүдийн хүүхдийг хооллох болж Жамъян өнөө солионы хэдэн туранхай хонио өгч амарчээ. Чингээд зогссонгүй. Мөнөөх сээ Амбаа нарт өгсөн ирэг сэрхээ тийш нь өгсөн хэмээн ов мэх зохиож “...Нэгдлийн гуанзны хэрэгцээнд зуу гаруй хонь өгөх байлаа. Би тэгвэл ирэг, сэрх оруулаад жараад л мал өгсөн. Дөчин хэдэн толгой малыг хүн өгөх үү, та минь. Аан! Үгүй шүү дээ. Тэгвэл энэ чинь нэг талаар аривлан хэмнэлт биш үү? гэж ярьсан. Мал бригадын даргаар ч хэвээр үлдсэн. Зайтай эр.

8. *Должин*

Романы хошин аяс бүхий өгүүлэмжийг хамгийн ээвэргүү зөөлөн, ээлтэй дулаахан болгож буй дүр бол ижий юм. Зудны жил насны үдэд ханиа алдаж, хар буудал дээр ганц хүүтэйгээ хаягдаж зовлон үзсэн энэ эжий тэргүүн дэвтэрт дөрвөн удаа, дэд дэвтэрт дурсамж /Дамдин Данжуур нарын/-д хоёр удаа дүрслэгддэг хэдий ч уншигч бидний нүдэнд харагдаж, сэтгэлд хоногштол амилсан дүр юм. Дэд дэвтэрт /бүр төгсгөлд/ Данжуурын дурсдагийг саная л

даа. “Шалаа Намжилынх Должин хөгшнийхтэй айлсан Цогзолын бууцанд буусан байлаа”... нэгдлийн дарга Данжуур нэгдэлийнхээ ерөнхий конторт даарч тэсэхээ байгаад “...Шалаа Намжил өвгөнийд хоймрыг нь эзлэн сууж, даарсан гараа аргалын галд өлчин дулаацаж, хамартаа тулам шинэ хагалсан цагаан тос аяга дүүрэн овоолж халуун цай очиж...” суутал Должин хөгшин орж ирж дорой дуугаар мэндлээд “...Задгай галд нүүрээ туяаруулан хэсэг чимээгүй сууснаа хэд дахин хоолойгоо засаад, -Данжуур гуай... гэж дуугарав” гэдэг. Ингээд дарга, эжий хоёр ярих нь: До:-Би... Би... /зогисох мэт болсноо хэдэн хэлхээ нулимс энгэр рүүгээ унагаж/ /Дамжуур баахан тух алдаж гэрийн эзэгтэй рүү харахад нь Шалаа Намжилын авгай “...Тийм зайлуул, Их зовж яваа юм...” гэж битүү утгатай үг хэлж. Данжуурын дотор “...За тэгнээ тэр! Өнөө мангар хүү нь хотод ангайж яваад машин тэргэнд дайруулж осолдоо болов уу, нэг бол муу хүмүүстэй нийлж хэрэг төвөгт орсон нь гарцаагүй бий” гэсэн бодол хар аяндаа орж иржээ”.

До:-Би муу, “зулзага”-аа алдчихаад...

Да:-Ор сураггүй байсаар байгаад тэр үү? Үгүй бас тоогүй яа!

До:-Та л нэг сумын төвийнхэнд сайн хэлж өгмөөр байна.

Да:-Тэгье дээ! Тийм гай зовлон учраад байхад хэлэлгүй яах вэ?

До:-Тийм дарга минь! Сургуулийн хүүхэд даанч төрхгүй байна.

Да:-Чухамаа чухам. Ингэж биднийг хагацал үзүүлэх юм гэж ер бодсонгүй.

Да:-Яаж аваад өнгөрөөв ээ.

До:-Тэнэж яваад... Тэгээд төрхгүй хүүхэдтэй дайралдаад цохиулчихаж дээ.

Да:-...Лавтай юм биз дээ. Дамын үг дамжигтай байдаг шүү. /Шалаа Намжилын авгай яриан дундуур орж: -Тийм хөөрхий... Малд нүдтэй, амь албаны энэ малыг чинь дагаад явдаг хачин ухаантай амьтан байгаа юм гэж хачир нэмнэ/

Да:-Та нар тэгээд сайн хэл сураг сонссон юм байгаа биз дээ.

До:-Нүдээр үзээд ирж байхад чинь... Хүзүүвч нь энэ. Хөөрхийгөө тэгээд сүүлий нь огтлоод л орхилоо /Данжуур “Уваа муугаас зайлуул” хэмээн дуу алдаж “хо... хо... хо” хөхрөв/ гэж бий. Сайхан шигтгээ шүү! Должин авгай “зулзага” нэртэй нохойгоо хэлмэгдсэн тухай ярьж, Данжуур Дамдин тэнэж яваад алагдсан тухай ташаа бодож байна. Дамдингийн тухай нутгийн олны ойлголт ер “маруухан” байсаныг эвтэйхэн дүрсэлсэн хэсэг юм шүү!

I. Роман эхэлэхэд “...Сумын төвийн ойролцоо зүүн дэнжийн боржин цохио, оройн нарнаа цайрдсан мэт гялалзаж байх нь бас үзэмжтэй. Хууччуудын ярихыг сонссвол зуны цагт тэр цохион дунд зуншихад осолтой тэнгэрийн дуу их, аянга цахилгаан буух олон гэлцэнэ” гэх бөгөөд тэнд Должин эмгэний “үнхэлцэгийн чинээ бор гэр” бий! Зохиолчийн дүрсэлснээр “Должин нуруу намхан, хорчгор туранхай”. “Будаг нь хуурч харласан модон тагштай” нэгэн агаад нутгийн зарим нь Должинд аянга цахилгаан зайлуулдаг ид шид бий гэж шивэр авир хийнэ.

II. Должингийнх ядуу. Эр нөхөр Лочин нь ч нэг их баян тарган байсангүй. Жин тээж хоол залгуулдаг нэгэн байснаа мичин жилийн их зуднаар өвчний учир бурхан болсон аж. “...Должин хөгшнийх ишиг шүдлэн их бага нийлсэн хориод ямаатай, сүү сааль ховор зэвэрхэн тул нутгийн таних мэдэх хүн сумын төвд ирэхдээ Должингийнх идээ цагаа ганзагалан авчирч өгдөг ажээ. Должингийн хэдэн ямаа нь өглөө саалгаад л толгой хандсан зүгтээ бэлчинэ. Орой нар жаргах үед хотондоо майлалдан гүйж ирнэ. Хөдөө бэлчээрт хүний хонь малтай нийлэвч сүргээрээ ялгаран гадаага ирнэ. Хүмүүс Должинг зөрүүд, малыг нь жожиг гэлцэнэ” гэж бий. Хаа газар өөрөө ядуу ч хүнд хоргүй эгэлхэн улс байдаг даа. Гол баатрын минь ижий тийм л нэгэн.

III. Должингийн хэдэн ямааг эзэн эмгэнийхээ хэл мэддэг гэж хэлцэх ч бий. Хүний эх л болсон хойно доо, “мангар” хочит манай баатарт савхин гутал худалдан авч оронд нь хоёр ямаагаа барьж өгчээ. “...Тэгсэн нөгөө хоёр ямаа нь тэдний хотонд тогтдоггүй, хонь малтай нь ижилсдэггүй, нутаг харьж ижилдээ гүйж ирээд их л зовоожээ. Сүүлдээ нөгөө хүн цөхрөх тунирхах зэрэгцэн наймаагаа буцаая тэгэхэд нь нөгөө хоёр ямаагаа учир зүггүй харааж -Ахиад та хоёрыг гүйгээд ирвэл хэдэн мөчий чинь хугачина вий, хараарай. Улаан цуу ямбуу*... гэж аашлаад буцаан явуулжээ. Үүнээс хойш ямаа ч эргэж гүйсэнгүй. Харин “...Должин хөгшний хэдэн ямаа эзнийхээ хэлийг мэддэг” гэлцэх болж.

IV. Хэдийгээр нутаг даяар “Мангар Дамдин” гэж хочловч ээж нь хүүгээрээ үргэлж бахархан, говийн ард олны дунд домог болон тархсан алдарт бөх “Идэр Дампил”-тай зүйцүүлж бодно. “...Должин сайн сайхан гэсэн бүхнээ сурган хэлнэ. Ахмад хүний дэргэд их үг хэлж болохгүй, тэгвэл “аавын цээж” гэж муу хэлнэ. Айлын тогоо өнгийн зогсвол ховдог гэнэ. Айлд ороод хүний амрыг нь эрж бай. Яаран хоймор руу нь битгий гар! Хүн хишиг өгвөл алгаа сайхан тосож бай...” гэх мэт ижийн сургаалыг хүү ч яг баримтлан явахыг чармайна. Магадгүй гол баатрын өөрийгөө дорд үзэх этгээд үзэл эндээс ч үүдэлтэй байж мэднэ.

Ү.Гол баатар маань ер нь гэр орондоо байдаг хүн үү? гэж уншигч та асууж болно. Тэгвэл романы турш Дамдин төрсөн гэртээ хоёрхон удаа ордог. Нэгдэх нь: “...зөв гэхэд буруу, буруу гэхэд хэцүү оринготсон хоолойгоор Энгэрийн гурван хайлаас Эн чацуу ургажээ. Энэ миний сэтгэл Гэнэн хачин төржээ...” гэж дуулсаар ирэх агаад “өдрийн цайнаас базааж тавьсан аягатай будаан дээр Цогзолын авчирч өгсөн хурууд өрөмнөөс тавьж” өгөхөд

Д:-Аймаг явах юм байх аа!

Должин:-Ямар хэргээр тэр вэ?

:-Уран сайхны ажлаар...

Должин:-Цогзол гуай нь ирээд явлаа даа. Хүүгий минь гэртээ аваачих гэнэ дээ, зайлуул

Д:-Аймгаас ирээд больё...” гэдэг. Тэгэхэд хөөрхий ээж “...нэг хэсэг дув дуугүй сууснаа сэмхэн босож авдран дээрх бяцхан хүрдээ эргүүлж, итгэл хийморийн дөрвөн шад ном амандаа бувтнан уншжээ” гэж бий. Хоёр дахь нь: Зохиолчийн дүрсэлснээр харвал “...Аян замаас буцаж ирэхэд албан ажлаас огцорсон мэт нэг л сонин, нэг л хачин. Дамдин гэртээ хоёр, гурав хонов. Энэ зуур ээждээ аймагт үзэж харснаа шагшран өгүүлж нөгөө худалдан авчирсан зурагт хуудас, сэтгүүл, номын зургийг хайчлан авч, сонин дээр үйлийн гурилаар наан, бор гэртээ чимэг гэж хоймор талдаа өлгөв. Нэгэн зүйлийг нэмэхэд Дамдин тэр зураг сэтгүүлээ аймгаас шагнасан юм гэж ээждээ хэлчихсэндээ үе үе бантан санаа зовниж, аймаг руу цуг явсан хүн илчилж хэлэх вий гэхээс айж, хоёрт уг зүйлийг худалдан авахаар хэдэн төгрөг зээлдүүлсэн хүн мөнгөө нэхэж ирэх вий гэж эмээнэ” гэж бий. Эжий, хүү хоёрын амьдралыг илүү дутуугүй зурсан нь энэ.

VI.Ээжийн өрөвдөлт зураг бас нэг бий. Цогзолынх үрсний найр хийж байхад хөөрхий Должин тэмээтэй ирдэг билээ. “...Должин хөгшин аанай л хөл нүцгэн, харин хүрэн даалимбан тэрлэг өмсчээ... ..Должин тэр заасан газар сууж, “Сайн л байна даа” гээд хүмүүсийн дундаас хэн нэг хүнийг нүдээрээ эрж хайв. Гэвч олсонгүй бололтой. Тэгтэл цай идээ амсуулж үрсний мах хувь өгөв. Цогзол, -За Должин гуай минь ярих юм их бий. Дараа л больё. Та хол юманд очих уу -Энэ зуур даа хүү минь... гээд өмнө нь тавьсан шаазантай мах гэдэс бувар бувар зажлан иджээ...” гэж дүрсэлсэн нь үрээ алга болгочихсон айлд ирээд буй атал ийм хүлцэнгүй хүн байдаг аа гэж бодмоор ч говьд ийм эхцүүл бий. Гэвч нарлаг говийн намхан бор эжийд үртэй хүний жаргал захидлын хамт ирдэг бөгөөд тэргүүн дэвтэрийн төгсөлд “...Түүнээс хойш Должин авгай гэртээ байхдаа хааяа нэг салхи хөдөлж, гадаах нарны

гэрэл мэлсхийн гэрийн эсгий үүд дэвэн хөдлөхүй тийшээ сандран харж -Хүн ороод л ирэх шиг санагдах юм. Хүү минь нэг л өдөр үүдээ сэвхийтэл татаад орж ирнэ дээ гэж жаргалтай тайван гэгч нь өгүүлж суудаг болов оо” гэж зохиолч хүүрнэсэн аж.

Тэргүүн дэвтэрт хамар Жамба, сэтэрхий Бямба, Галсандоной, Цэвэлжид зэрэг өөр өөрийн өнгө төрх бүхий олон дүр байдаг юм. Тэд, ялангуяа “Шинэ айл” дэд ангид их л тод, томруун дүрслэгдсэн тул гол баатар нэг их үгүйлэгдэхгүй байгаа нь зохиолчийн ур авьяастай холбоотой билээ. Хөдөө аж ахуйд 1950-60-аад оны үед өрнөсөн нэгдэлжих хөдөлгөөнийг амьдрал дунд нь буцалж байж 1961-62 онд бичсэн тэргүүн дэвтэр ийн өндөрлөж байна. Харин “Хол мөртөө ойр хот хүн хоёр” дэд дэвтэрт зохиолч манай оронд шинээр төрж гарсан ажилчин ангийг дүрслэх зорилго тавьжээ. Энэ зорилгодоо ч амжилттай хүрсэн юм. “...Ер нэгдүгээр дэвтрийн ихэнх баатруудын (Данжуур, Шалаа Намжил, Должин зэргийн) дүр аятайхан болсныг тэмдэглэх нь зүйтэй Монгол амьдралын гүнзгий мэдлэг, түүнийг эрхэмлэн дээдлэх, хүн ардаа хайрлах сэтгэл эхний дэвтэрийг дэд дэвтрээс илүү үнэмшилтэй, уран сайхантай болгоход тус дөхөм болжээ” гэж Висс. Бильдушкинов дүгнэсэн байна.

9. Гэрэл

Энэ бол чухам романы ялангуяа дэд дэвтэрийн гэрэл гэгээ болсон бүсгүй. “...Чүдэнзний галд бүсгүйн царай бүдэг бадаг гэрэлтэн залуугийн нүүр тодрон харагдав. Бүсгүй нь дөнгөж арван найм есөн нас хүрч яваа болов уу гэмээр махлагдуу хүүхэн байлаа. Үсээ хоёр салаа сүлжиж, цэнхэр эрээн даавуун даашинз өмсчээ. Нүүр хацартаа оо энгэсэг тавьсангүй, харин үснийхээ үзүүрт, улаан тууз зангиджээ. Үүнийг үзвэл, хүүхдийн ааш зангаас асар холдоогүй гэнэн хонгор ажээ” гэсэн зохиолчийн тодорхойлолттойгоор Гэрэл бүсгүй романы босго алхаж байна. 1950-иад оны үеийн залуу охидын төрх намбыг өөртөө шингээсэн эл бүсгүй Тогоо /бидний мэдэх жолооч/-той зугаалж яваад оройтсон зэмтэйгээр манай баатартай учрах гэрэлт өглөөгөө угтана. Ээж: -Дүүгээ сэрэхээр сүүгий нь өгнө шүү. Гэрэл: -Мэдсэн, ээж ээ! Харин та нар эрт ирээрэй Аав: -За хэзээ ч ирсэн чи л хүн шиг байж үзээрэй... Радиоогоор “Дунайн долгио” гэдэг урьхан аялгуу хангинав. Гэрэл өөрийн эрхгүй амандаа даган аялж, ганцаар бүжиг эргэв”. Гэгээ мэт энэ бүсгүй “Должингийн мангар”-ыг алхам тутамд нь өршөөж, өмөөрч, өөриймсөж байдаг. Зохиолч: “Дамдинг Самбуугийнхан өөр өөрийн ертөнцөөр угтаж авчээ. Гэрэл охин бол гэртээ хүнтэй болсонд машид баярлан, ...элдэг дотноор

харилцан хөдөөний гэж гадуурхалгүй энэ тэрийг асууж, лавлаж ярилцсан нь ...”талтай сайхан санагдаж идээших тух өгчээ”. Тэр ч байтугай “хааяа хуйвалдан дүүгээ асран суудаг байсан албанаас чөлөө зай гарган, торноос мултарсан шувуу мэт” “...нимгэн даашинзны хормойг дэrvүүлж одно”. Эл гэнэн цайлган нөхөрлөл аажмаар үерхэл болж, алстаа хайр сэтгэлийн мөнхийн холбоо болоход хэд хэдэн гол алхам гарна.

1. Нэг удаа мань хоёр Туулын гол руу очиж усанд орох агаад Гэрэл юм угааж, голын усанд жараахай мэт сэлжээ. Дамдин тэгэхэд үзээгүй юмаа үзэж “...бүсгүй хүн ийм илэн далангүй нүцгэн шахуу, олны өмнө усанд орж наадна” гэж зүүд зөндөө санаагүй ч, бүсгүйн “...туяхан бэлхүүс, даруулган чанадаас товойх бяцхан хөх, нүцгэн бие хийгээд урнаар шумбан наадах хөдөлгөөний нь бишрэн бахадсан нь тоймгүй” “...Тэгээд -Ёстой хөөрхөн хүүхэн гэдэг л энэ. Гэрэл байх шүү. Базаржавт энэ тухайгаа ярьж гайхуулах сан. Муу солиг чинь бас “Чи оролдсон уу” гэж асуух байх даа” гэж боддог. Энэ бол хоёр залуу хүний зам нийлэх эхний алхам юм шиг.

2. Дээрх алхамын үед “...Гэрэл надад зургаа ч өгдөггүй байгаа даа. Гуйгаад үзвэл яадаг бол...” гэж боддог. Чингээд түүний хувьхан заяаны зам аяндаа мань эрийг хөтлөж “...Нэгэн өдөр гэр зуур байснаа Гэрэлийн өрөө рүү тэв тав гишгэлэн оров. Гэрэл нөгөө номоо шагайж суулаа. Тэrvээр толгой татаж, Дамдин өөд хараад -Та ном уншдаг уу... гэв Дамдин -Унших нь уншинаа. Төрхөөрөө ч муу даа...” гэж өгүүлдэг. Манай баатарын сэтгэлд ном биш нутагтаа аваачиж гайхуулах Гэрэлийн зураг л эргэлдэж байсан тул номын тавиур дээр тавьсан Гэрэлийн хэд хэдэн зургаас нэгийг авч баахан үзсэнээ -Энэ зургаа надад өгчихгүй ээ... гэж гуйна. Гэрэл яаж зөвшөөрөх вэ. Манай хүн л болсон хойно. “-За тэгвэл, гуйгаад авч болдоггүй юм бол гуядаад авна даа гэсэнээ Гэрэл рүү харж ха... ха... ха... хөхрөн нөгөө зургий нь авч өвөртлөн... Гэрэлээс зугтаж бүдүүн дуугаар пар пар хөхрөн, шал доргиулан гүйв”. Гэтэл гай болж Дамдинд угаас төдгүй Гэрэлийн эх аяга дүүрэн цай барьж явсан нь таарч “...эргэн эргэн харсаар хаалга дэлгэн год үсрэн гарч ирснээ галын өрөө рүү ухасхийсэн нь...” Гэрэлийн эхтэй халз мөргөлдөж, цайгий нь асгаж, аяга шаазангий нь хагалж орхив. Гэрэлийн эхийн -Барагтай л байгаарай! Ичихгүй юу чи! Ийм юмтай марзаганаж суух аа! гэх дуун хаалганы цаанаас тачигнан байхад мань эр Гэрэлийн зургийг олзлон авсандаа баясан тайтгарч байна.

3. Дээрх зоригтой хэдий ч эрсдэлтэй алхамын нилээд хойно. Дамдин хотоор тэнэж, тэнэж “...хаалга татвал нарийн хоол бэлтгэж байх бололтой үнэр ханхалж примус шуугьж байв. Гэрэл галын өрөөнөөс гарч ирснээ, ханцуй шамлаастай гараа урдаа барин, -Өө Дамдин гуай ирлээ! гэж

олзуурхсан янзтай дуугарав. Гэрэлийн эх чанадаас нь “Ашгүй! Ашгүй!” гэх нь дуулдав” Эзэгтэй ингэж сайхан загнаж буй нь түүнийг гар хурууны үзүүрт зарах ажил мандсан хэрэг. Нээрээ ч тийм байв. Нарийн хоол хийж их л хөл хөөрцөг болж байтал гадаа нь “зургаан дугуйт машин хүнгэнэн ирж, тэдний гал тогооны халз зогсож, жолоочийн бүхээгээс дан элгэвчтэй нэг хүн үсрэн буухыг Дамдин цонхоор харав”. Тэр хүн бол домогт Дандар баатар байдаг. Баатар Самбуу хошуучийнд дайлуулж цайлуулаад мордохын цагт “...Самбуу Дамдины явж ирсэн түүхийг ярьж амжив. Тэрвээр Дамдин руу инээмсэглэн харж, мөрөн дээр нь зөөлөн алгадаж, -Чи нэг юм бодооч дээ! Хөөрхийг.. гээд гарлаа” Түүнээс хойш ч зарим орой Самбуугийнхан Дамдинг яах тухай яриа болоход Гэрэл идэвхтэй оролцож “...-Аав аа! Сургууль курст оруулчихаж болдоггүй юм уу. Тэгвэл догь шүү дээ гэж санал өгүүлэх нь манай хүнийг тээршаах биш харин ч ханьшаах маягтай нь гуравдахь алхам юм даа.

4.”...Дамдин өнгөрснийг эргэн санаж сэтгэл багахан гуньж санаа алдаад нэг эргэвэл, хаалга аяархан нээгдэх шиг болж чийхрав. Лавлан харвал Гэрэл үүдний дэргэд сүүтийн гараа цээжиндээ эвчихсэн зогсож байв. Дамдин гайхасхийн хоолой засаж ядаад өндийтэл Гэрэл, -Дамдин гуай, Та унтаагүй байна уу гэж шивнэн асуув. Дамдин, -Үгүй байна гэвэл -Би айгаад байна. Орой эжий хулгайч дээрэмчний тухай ярьсан юм. Ганцаараа унтах гэсэн нь айгаад байна гэв. ...Дамдин, -Би яах вэ? гэвэл -Та миний өрөөнд унтахгүй юу... гэж үнэхээр айж эмээсэн аргадаж гуйсан аялгаар өгүүлэв”. Дамдин “... төвөгшөөн азнаж, удаанаар эвшээж” аягласан ч дотроо дуртай л байсан хэрэг агаад өрөөнд нь очсон хойноо мань эр. “...Би айгаад байна гэв. Гэрэл гайхсан янзтай -Юунаас? гэж шивнэн асуухад -Мэдэхгүй ээ! гэж хүчлэн хэлсэнээ гараа хөнжил доороосоо аяархан гаргаж Гэрэлийн гараас атгаж авав. Гэрэл гараа булааж ч авсангүй. Зөвхөн “Яаж байгаа юм бэ?” хэмээн шивнэсхийв... Дамдин хүзүү сунган сэм сэм Гэрэл рүү ахиж өөрийн мэдэлгүй нүд, уруул, дайралдсан газраа үнсэхэд бүсгүйн зөөлөн гар мөр лүү нь түлхэсхийж -Яаж байгаа юм бэ? Би хашгирна шүү! гэж чихэн дор нь шивгэнэж байлаа. Ийм нэг санамсаргүй хэрнээ санаа сэтгэлээс гаршгүй явдал айсан нэг, амгаланг сахигч хоёрын дунд болжээ”.

5.”...Хоолны дараа Гэрэл, Дамдинтай аяга таваг угаан байхдаа -Манайх хөдөө гарах байх аа. Аав сая тийм юм ярьж байна. Үнэн юм уу, худал юм уу мэдэхгүй. Нэг бол ээжийг цаашлуулж ярьсан юм уу... Хөдөөгийн хүмүүс их сайхан гэсэн тийм ээ! Би ч сургуулиа төгсөөд хөдөө л сууна. Яадаг юм... хэмээн Дамдин руу харж толгойгоо нэг л өхөөрдөм бөнжигнүүлэн өгүүлэв. Дамдин Гэрэлээс ийм үг дуулахад тун таатай байв. Тэгээд нөгөө өрөө тийш

чимээ чагнан, гэтэж амраглан хайрлахын увидаст автан Гэрэлийн дэргэд очиж мөрөөр нь тэврэн авбал, Гэрэл долоовор хуруугаа гозойлгон уруулын тус газар авчирч -Болохгүй шүү, би хэлсэн шүү дээ, чамд... гэв. Гэрэлээс “чамд” гэсэн үг анх удаагаа сонсоход Дамдингийн сэтгэл таатай байв”. Ийн залуу хосын сэтгэлийн хаалга бие биеийн зүг цэлийтгэл нээгдэж байх агаад Гэрэлийн хүсэн мөрөөдөж асан “...Хаа холоос давхиж ирэн түүнийг авах хангал хүлэгт баатар...” эр бол Дамдин болох нь алхам алхамаар тодрон байх аж. Гэрэлийн дүр бол романы дэд дэвтрийн турш манай баатарын дүр төрх, царай зүсийг төдийгүй сэтгэл санааг нь товойлгон дүрсэлхэд гол үүрэг гүйцэтгэж байна.

10. Самбуу

Энэ дүр романд бага зай эзлэж дүрслэгддэг хэдий ч хөдөөх хөвүүний сэтгэл зүрхийг нийслэл хотын зүг даллан дуудаж, Яармагийн дэнжээс оргох шийдвэр гаргахад нь гол нөлөө үзүүлсэн дүр юм. Яагаад ч юм бэ, говийн бор хөвүүн хот ороод Самбуу даргын очиход яавч намайг хөөхгүй гэх их итгэл найдварыг өвөрлөн ирдэг нь энэ дүрийн эхний зураг болж уншигчийн сэтгэлд тусч байна. Уг нь шалиггүй юм санж. Самбуу дарга говийн аймагт урлагийн бригад ахлан очиж, унаа тэрэг саатсаны улмаас хот айл, баг бригадад жүжигчид тарж тоглохоор болжээ. Энэ үед хаа газар эмээл хазаар эрдэнэ болдог газар даа. Самбуу даргад эмээл дутах үед мань Дамдин тус болж муу ч гэхнээ эмээл олж тусалсан төдийгүй морийг нь эмээллэж өгсөнд талархаж зүгээр л, -Хот орвол манайд очоорой... гэсэн аж. Энэ л үгээр гэрэлт дэнлүү хийж түм түжигнэж, бум бужигнасан газар ирэх агаад хотыг хөдөө нутаг шигээ санаж, -Самбуу даргынх хаана байдаг юм бэ? хэмээн сураглаж явдаг билээ. Мангар Дамдины энэ эрэл чухам “үнэн мангар” хүний ажил мэт санагдах боловч сайн сэтгэлийн үзүүрт сүү гэгчээр зах дээр эрж яваа хүнтэйгээ халз учирдаг. Чингээд, -Олоод авсанаас хойш салдаггүй хэрэг ээ... хэмээн навсайтал дагасаар гэрт нь ирдэг төдийгүй “эзэгтэй”-д хялалзуулан цэхэлзүүлэн гал тогооны өрөөг өмчлөн оройд хуйлсан гудсаа дэвсэн нойрсож, өглөө нь хураан авч толгой хоргодно. Ийн байсаар аз болж Дандар баатар зочлон ирж, -Чи нэг юм бодооч! Хөөрхийг... хэмээн Самбууд сануулснаар, баатарын маань зам мөр улам ч саруулсаж, албан журмын хөдөлмөрт дайчлагдан одохын даваан дээр Самбуу тус болдог төдийгүй байр сууц өгөхөд нь ч далдаас ярьж хөөрч дэм өгдөг аж. Романд дүрслэгдэж буй 50-иад оны үеийн цэргийн албан хаагчийн нийтлэг дүр болсон. Самбуу хошууч хожмоо улс даяар явуулсан нам засгийн бодлогын дагуу хөдөө аж ахуйг

хөгжүүлэхээр одно. Ер тухайн үеийн эвдрээгүй монгол эрийн амгалан төрх, залуу хойч үедээ өөрийн хүний гэлгүй санаа тавьж аль болохоор л дэмжин тусалж байдаг нөмөр нөөлөгтэй хүний дүр болж чадсан юм. * * * Романы дэд дэвтэрт Жамбал арван, Чогдов, Бэхтөр, “шар” зэрэг өвөрмөц дүр олон бий. Тэр бүхэн гол баатрыг тодруулах оролцогчийн маягтай дүрслэгддэг ч бүгд л өөр өөрийн зан чанартай, өөр өөрийн амин зуулгатай амьд хүмүүс болж чадсан байна. 1960-аад оны үед хэвлэгдэн гарч уншигч олныг байлдан дагуулсан цөөн романы нэг “Говийн өндөр” романы гол баатар мангар хочит Дамдины дүр дээрх арван дүрийн тусламжтайгаар тун ч амьд, сонин, басхүү хошин инээд хавчуулсан сайхан дүр болсон юм. Харин эл романыг дагнан судалсан нь энэ хир үгүй агаад Л.Түдэв зохиолчийн үнэлсэн “нарийн ширийн шигтгээ”-г нарийвчлан судлах аваас чухам яндашгүй далай мэт бүтээл билээ. Зөвлөлтийн судлаач Висс. Бильдушкинов “Романы гол баатар Дамдин говь нутаг, гал голомтондоо аав ээжийнхээ гар дээр өссөн цайлган сэтгэлтэй гэнэн хонгор залуу юм. Дамдины дүр бол гэрэл гэгээтэй цэвэр тунгалаг дүр юм. Амьдрал тэр чигээрээ түүнд гайхал бишрэл болсон байна. Тэрбээр алхам тутамдаа шинэ юм таньж мэдэх агаад үнэндээ ч мэддэг юмаар мариухан эр юм. Зохиолч баатраа амьдралын янз бүрийн нөхцөлд учруулж яаж өсч өөрчлөгдөж байгааг нь тодорхой үзүүлж байна. Чухам ийм баатар сонгож авсанд “Говийн өндөр” романы шинэтгэл оршино. Жинхэнэ ард зөвхөн монгол хүнд л байдаг зан чанар өвөрмөц шинжийг зохиолч энэ залууд шингээжээ. Урьд өмнө монголын бүхий л утга зохиолд Дамдинтай ижилхэн дүр нэг ч гарч байсангүй. Чухам ийм учраас монголын утга зохиолын түгээмэл бөгөөд хамгийн сонирхолтой дүрүүдийн нэг нь болжээ. Урьд өмнө хэн хүний мэдэх зүйлийг, утга зохиолд тусгахын хэрэгцээгүй гэж бодож байсан зүйлийг зохиолын гол өгүүлэмж болгон урнаар дүрслэн үзүүлсэнд зохиолын гол өгүүлэмж болгон урнаар дүрслэн үзүүлсэнд зохиолын онцлог оршино” гэж дүгнэжээ. Монголын ард түмний уран сайхны сэтгэлгээнд өөрийн тод мөрийг үлдээсэн төрийн шагналт, ардын уран зохиолч С.Дашдооровын “Говийн өндөр”-гол хүмүүс зөвхөн эл хэдээр үл зогсоно. Ер нь амьд дүрийн цомог болсон роман шүү.

Тайлбар:

1. С.Дашдооров. “Говийн өндөр” 3, 4, 128, 247
2. С.Дашдооров. “Говийн өндөр” 148, 150, 154, 156, 161, 198, 217
3. С.Дашдооров “Говийн өндөр” 57, 106, 116, 141, 149, 151, 169, 307, 312, 213, 223-р (МУЗД-40-р боть)
4. С.Дашдооров. “Говийн өндөр” 120, 130, 133, 153, 179, 183, 185, 190, 211, 212, 392, 404, 405, 417 (МУЗД-40-р боть)
5. С.Дашдооров. “Говийн өндөр” 39, 49, 57, 67, 74, 136, 137, 140, 180, 182, 209, 211
6. С.Дашдооров “Говийн өндөр” /МУЗД 40-р боть 157, 172, 175, 195, 214, 215, 216/
7. С.Дашдооров /МУЗД 40-р боть “Говийн өндөр” 18, 19, 22, 24, 25, 33, 111, 182, 198, 424-р тал

**САЙХАН ХҮҮХНҮҮДИЙН ДУНД
САЛХИ ШИГ ХУЙЛАРЧ ЯВСАН
СОРМУУНИРШИЙН ДАШДООРОВ**

Л. Туяа

*Уран шүлгэнд би дуртай
Уянга яруу найрагт би дуртай
Ур айзам цогцолсон
Увдист яруу найргийн хорвоод
Үнэн голоосоо би дуртай
Сюй Сюй Сингапурын зохиолч*

Зохиолч нөхдөө Дооров дурсаж байна

Уран бүтээлч нөхөдтйгээ хамтарч мөн чиг сайхан зохиолуудыг бичснээс гадна, дотно үерхэж явсан сайхан нөхдөө сэтгэлдээ дурсан их найрагч С.Дашдооров маш “гоё” шүлгийг туурвин мөнхлөн үлдээжээ.

“Зовлон жаргал” гурамсан роман, “Энхтайваны манаа” тууж, “Номын сангийн ном”, “Хуягт загас”, “Хар ишиг”, “Хоёр охин” зэрэг олон зохиолч бичсэн зохиолч Цэрэнжавын Уламбаярт зориулан “Зохиолч Уламбаярын булшинд өргөсөн цэцэгт хэлхсэн шүлэг” хэмээсэн тун ч нямбай нягтлан бичсэн чин сэтгэлийн илэрхийлэл болох гүн ухааны эмгэнэлт шүлэг, төрийн шагналт зохиолч Сэнгийн Эрдэнэд зориулсан “Сутай цагаа нБогд” гэсэн уянгын нэгэн сайхан шүлгийн өмнө “Аян замын дөрөө нийлж, энд ирсэн Сэнгийн Эрдэнэ найздаа” гэсэн ишлэл оруулж бичсэн нэгэн сайхан шүлэг бий.

Ялангуяа Ц.Уламбаяр зохиолчид зориулсан энэхүү шүлгийг уншиж байхдаа сэтгэл догдлон бас эмзэглэн шаналж байхад минь аугаа их яруу найрагч А.С.Пушкинд зориулан эмгэнэн гашуудаж бичсэн М.Ю.Лермонтовын “Шүлэгчийн үхэл” шүлэг, мөн Дооровын сайн анд нөхөр яруу найрагч М.Цэдэндоржийн зүгээс сэтгэл шаналан эмгэнэн гашуудаж бичсэн, 19.. оны 9 дүгээр сарын 21-ны нүгэлт өдөр халамцуухан явж байгаад Төмөр замын техникумын өмнөх засмал зам дээр осолд орж машинд дайруулан нас нөхчсөн яруу найрагч, нэрт орчуулагч Доржийн Гомбожавын гэгээн дурсгалд зориулан найрагчийн зүгээс сэтгэлийн гүн эмгэнэлийг шаналан байж зүрхнээсээ эмгэнэн гажуудаж туурвисан “Нөхрийг дурснам” кэрэг

шүлгийн мөр бадаг өөрийн рэхгүй сэтгэлд урган буух нь юутай эмгэнэл вэ?

Намайг ахлах ангийн 8-10 дугаар ангид хичээл орохдоо Ц.Уламбаяр, Д.Гомбожав гэсэн хоёр их зохиолчийн намтар уран бүтээлийг заах үед доорхи хоёр шүлгийг уншин өгч, нэмэлт тайлбар хийх үед бүх сурагчид нүдэндээ нулимс цийлэгнүүлж, зарим нь өөрийн эрхгүй уйлчихдаг юм.

Яруу найрагчид бурханаас заяасан агуу их авьяасынхаа хүчээр эрхэм уншигч авхайн сэтгэлийн нарийн мэдрэмж бүхий утсыг уяруулагч агуу их билгийн авьяастай лут хүмүүс билээ.

За одоо Дооров гуайн сэтэлийн их шаналал дунд бичсэн “Зохиолч Уламбаярын булшинд өргөсөн цэцэгт хэлхсэн шүлэг”-ийг авч үзье. Манай зохиолчид Ц.Уламбаяр гуайг Умбаа зохиолч, Умбаа гуай, Умбаа минь гэж хүндэтгэн дуудаж бас авгайлдаг юм. Энэ нь их зохиолчид хүндэтгэл үзүүлсэн хэрэг юм.

Сурагчид, багш намайг Умбаа гуайн намтар уран бүтээлийн тухай хэн ярих вэ гэхэд минь бүнд гараа ярс ярсхийтэл өргөдөг нь маш сайхан тун чиг бахархмаар байдаг сан. Бас Дооров гуайн Умбаа гуайд зориулсан шүлгийг хэн унших вэ гэхэд л бүгд бас гараа ярс ярс өргөдөг билээ.

Тэгээд л бүгд онц авна. Онц дүн авсандаа улам л урамшиж, хичээлдээ идэвхтэй оролцоно. Сурагчид бүгд гараа ярс ярс өргөцгөөх нь тэдний сэтгэлд зохиолч Дооров Уламбаяр гуай хоёр амьд байна гэсэн үг ээ. Хүүхдүүд Дооров, Уламбаяр гуай хоёрын зураг хөргийг хараад л шууд таньдаг нь тэдний зүрх сэтгэл нь тэр хоёр их зохиолчтой хамт байна гэсэн үг билээ. 1970-80-аад оны үед хичээлийн программд Ц.Уламбаярын “Энхтайвны манаа” туужийг заадаг байсан юм. Харин одоо заахаа больсон. Яасныг нь би мэдэхгүй ээ.

Харин Дооров, М.Цэдэндорж, Д.Гомбожав нарыг заах нь байтугай сурагч ч байдаггүй байлаа.

Би төлөвлөгөөт програмаас гадуур хулгайгаар сурагчдад сэм сэмхэн зааж, захиарл, намын үүрийн дарга, хичээлийн эрхэлэгчийн өрөөнд мөн ч олон удаа номхон зогсож зэмлүүлэн, үзэл суртлын хичээл заалган тархи толгойгоо угаалгадаг байлаа.

Тэглээ гээд би засраагүй ээ. Эцэс сүүлдээ би ажилгүй болж багшийн ажлаас чимээгүйхэн хөөгдсөн билээ.

Үзэл суртал ноёлсон, тийм л хатуу цаг үе байлаа. Харин сайн тал нь сурагчид маань хохироогүй, харин ч бусад ангийн сурагчдаас мэдлэгээрээ хамаагүй хол тасархай байсан. Сурах бичгээсээ давж хальсан өргөн дэлгэр, чамбай сайн мэдлэгтэй болцгоосон билээ.

Эдгээр нэр бүхий сайхан зохиолчдоос эс зааваас нүглийн цаад нүгэл болох байх.

Дооровын Уламбаяр зохиолчид зориулсан шүлэг бол философийн гүн утгат бүтээл яах аргагүй мөнөөсөө мөн гэж дүгнэх ёстой.

Манай зохиолчид ер нь гүн ухааны нарийн нягт дүрслэлтэй шүлэг туурвидаг байсныг манай болон гадаадын судлаач эрдэмтэдийн зүгээс огт ажиглаагүй өнгөрсөн гашуун явдал болсон байна гэж үзэх ёстой.

Анд дотно найз нөхдөө дурсаж сэтгэл зүрхийг шимшрүүлэн эмзэглүүлсэн, гүн ухааны лут сайхан шүлгийг С. Дашдооров. М.Цэдэндорж хоёр бүтээж, үгэн хөшөөг босгосон мундаг яруу найрагчид юм аа.

Тийм ээ. Хоёр их яруу найрагч нар маань номын анд сайн нөхдөө ийнхүү эмгэнэн дурсаж, хоёулаа хүний орчлонд хэдийгээр маш богинохон насалж амьдрах гэлээ олон он цагийн турш үргэлжлэн амьдрах гайхамшигтай сайхан мундаг, “маш гоё” зохиолуудыг олноор бичиж цэнхэр гаригийн уншигч авхай нар бидэндээ мөнхлөн үлдээгээд тэнгэрт халин одсон чухамхүү С.Дашдооров зохиолчийн яг өөрийнх нь бичсэнээр “Бууж мордох хорвоо” нь болсон.

Эх Монголынхоо уудам цэлгэр нутгийнхаа ариун хөрс шороондоо “Бууж ирээд л буцаж мордоод л” хоромхон зуур үүрд явчихлаа даа, эд нар маань

Зохиолч яруу найрагч С.Дашдооров, М.Цэдэндорж хоёрын зүгээс үзэг нэгт нөхдөө дурсан эмгэнэн гашуудсан дурсгалын агуу шүлгийг тогтоон уншсанаа дараа одоогоос яг 178 жилийн тэртээ Оросын их яруу найрагч А.С.Пушкиний зүрх эмгэнэлтэй зогсоход яруу найрагч М.Ю.Лермонтовын уур хилэн бадарч гашуудлын эмгэнэлт “Яруу найрагчийн үхэл” гэсэн шүлэг туурвисан нь сэтгэлд өөрийн эрхгүй буун ирж, үйл явдал нь нүдэнд харагдах мэт болсон нь соёлт уншигч авхай нарын сэтгэлийн утсыг хөдөлгөн удирдах мэт болно.

1. *Дооров гуйан охиндоо зориулсан гоёхон шүлгээс улбаалан хүүхдийн чамин сайхан шүлэгтэй танилцсан минь*

Дэлхийн сонгодог зохиолч нар өөрсдийн хүү, охиндоо зориулан маш мундаг зохиолуудыг бичиж өөрсдийн үр хүүхдээ уран бүтээлдээ мөнхлөн үгэн хөшөөг дуурсгасан байдаг билээ.

Найрагч С.Дашдооров гуйа энэ уламжлалаас хол зөрсөнгүй харин нэгэн ийм гоё шүлгийг бичсэн нь миний анхааралд өртөж, сурагчдад зааж цуужлүүлэн сэтгэл зүрхийг нь уяруулж заримдаа бас уйлуулдаг ч явдал бий.

С.Дашдооровын охиндоо зориулсан тэр шүлэг нь Миний баяцхан

Маралгоо юм. Энэ шүлгээ монгол ардын ерөөлийн хэлбэрт оруулж дахилт тэр чигтээ ерөөл байгаа нь зохиолчийн урлан бүтээх чадвартай холбоотой ажээ. Үлгэрлэвэл Мишээж сууна уу? Инээж сууна ? Алиалж л байна уу? Наадаж л байна уу? Мишээж яваарай. Баясаж яваарай. Өнхөрч байна уу? Тарвалзаж л байна уу? гэх мэтээр хооронд нь жишиж жижиг хүүхдийн дүрийг амилуулан ирж уншигтай учран байгаа мэт сайхан сэтгэл төрүүлж байгаа нь ардын ерөөлийн уламжлалыг шигтгэж хийсэн юм.

2. *Яруу найрчийн Од шүлгийн тухай*

С.Дашдооров найрагч жинхэнэ монгол сэтгэлгээгээр од гаригийн тухай сонин мөр үгийг гайхамшигтай сонголттой шүлэг бичсэн нь Од гэсэн шүлэг юм. Одны тухрай хоёр өөр янзаар утга уянгын дүрслэлтэй бичсэн аж. Эхний удаа 1961 онд бичсэн Од шүлэгтээ монгол ахуйг ингэж тусгаж шүлэглэжээ.

Тэртээ гялалзах зүүний үзүүр шиг одод

Дээшээ тийшээ өргөсөн ээжийн минь сүүний дусал уу?

Хан тэнгэрийн хязгааргүйд шингэн наалдаад тэр нь

Хаш эрдэнэ мэт гялалзаж байгаа юм уу?

Алсын алсад гялалзах түм буман одод

Аавын гэрийн тооноор бутарсан очис уу?

Хурмаст тэнгэрийн алс асаж наалдаад тэр нь

Хурц аранзал туяагаа цацрааж байгаа юм уу?

гэсэн содон мөрүүдэд ээжийн минь сүүний дусал, аавын гэрийн тооноор бутарсан очиж гэсэн монгол хүний зүйрлэн хэлж чадаж уянгалаг сэтгэлгээг гаргасан нь тун чиг гайхалтай.

Зөвхөн монгол найрагч л ингэж яруу сайхнаар маш гоё зүйрлэн сэтгэж чадна.

Яруу найрагч 1960 онд Одод шүлэгтээ энэ санаагаа гүнзгийрүүлэн тун ч нямбай бичсэн нь Монголын хээр талд адуун сүргээ налайн хариулж гүн шөнө тэнгэрийн оддын гялалзах жирвэлзэх тэр л хөв хөх тэнгэрт байгаа юм шиг сэтгэгдлийг уншигдад төрүүлнэ.

С.Дашдооровын Одод шүлгийг Д.Нацагдоржийн Од шүлэг, Оросын яруу найрагч С.А.Есенины Одод гэсэн шүлгүүдтэй харьцуулан авч үзвэл гурван өөр цаг үе, гурван өөр орчин гурван өөр арга барил, сэтгэлгээ харьцуулахад бас сонин, бас чиг гайхамшигтай байх болов уу?

3. Дуу хуурын өлгий нутаг Дундговийнхон

Гайхалтай сайхан байгальтай энэ нутгийг Дундговь аймаг гэнэ. Энэ аймаг Монголдоо алдартай биш бүр дэлхийд алдартай төдийгүй дэлхийг сөнөөх хүртэл айлган цочоож байсан түүхтэй ажээ. Тэр жил Дундговь аймагт том бас үл мэдэгдэх биет унасан аж. Төмөр бүтэц бүхий энэ зүйл ч солир байсан бөгөөд дэлхийг шуугиулж эрдэмтдийг алмайруулсан аж.

Дундговиос оюуны чадалтай олон мундаг улс төрөн гарчээ. Ерөөлч магтаалч Бавуугийн Гэлэгбалсан, Буддын гүн ухаантан түүхч Ш.Дамдин болон орчин үеийн зохиолчдоос С.Дашдооров, Д.Батбаяр, С.Буяннэмэх нар мөн энэ сумынх. Түүнчлэн Долгорын Нямаа, Х.Зандрабайдий, С.Надмид, Д.Төрбөт, М.Жавгаа, Б.Чойгдон, Т.Дэнчингунгаа нар юм. Эдгээр зохиолчдоос Монгол улсын төрийн шагналтан, ардын уран зохиолч, соёлын гавъяат зүтгэлтэн төрсөн. Энэ нутагт төрсөн С.Дашдооров Дэлгэрхангай уулан дээрээс дэлхийн юмс харагдана гэж шүлэглэж байжээ.

С.Дашдооровын зохиолоос улбаалан дэлхийг харж болно. Ном зохиолоос нь улбаалан дэлхийг таньж болох мэт сэтгэгдэл төрүүлдэг.

Сурагчид Дооров гэснийг минь их асуудаг юм аа. Энэ нь монгол хэлэнд байх хүндэтгэлийн их ёсорхуу хэллэг. Та үүнийг хүндэтгэлийн нэртэй ном судалгаанаас олж үзэж болно. Хүний нэрийг, ахмадаа хүндэтгэж ингэж дуудаж хэлдэг.

Сайхан хүүхнүүдийн дунд

Салхи шиг хуйларч явсан

Сормууниршийн Дашдооров

9, 10 дугаар ангийхан нир хийтэл инээлдэх аж. Би хичээл дээр сайхан бүсгүйчүүдтэй Дашдооров гуайн хэрхэн орооцолдсныг ярьж өгч байгаа нь тэр л дээ. Уншигчдын хүсэлтээр нэгэн сурвалжлагч Дооровоос ярилцлага авчээ.

-Таны зохиолд гардаг энэ олон хүүхнүүд чинь нэг л хүн үү? Гэж асуужээ.

Айлын хүүхэн Алигэрмаа, дуулим талын Дэнсмаа, Эгийн голийн Эгиймаа найз гээд хөөрч өгөх юм гэсэнд С.Дашдооров гүндүүгүй эрхэн зангаараа “энэ олон хүүхний учрыг би өөрөө ч яг учрыг нь олдоггүй юм” гэсэнд хүмүүс нир хийтэл инээлдэн хөхрөлджээ. Ер нь Дооров юмыг шулуухан хэлчихдэг бодох санах юмгүй хүн байв.

С.Дашдооровын ном зохиол, өгүүллэгийг олноороо уншиж байгаасай.